

П.Одсүрэн, Б.Гэрэлсайхан, Н.Даваасүрэн, Ц.Дашдолгор

# МОНГОЛ ХЭЛ

## IV

Ерөнхий боловсролын сургуулийн  
4 дүгээр ангийн сурах бичиг

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамны  
зөвшөөрлөөр хэвлэв.

Долоо дахь хэвлэл

СУРГУУЛИЙН НОМЫН САНД ОЛГОВ.  
БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО.

Улаанбаатар хот  
2020 он

DDC  
371.32  
M-692

Монгол хэл IV: Ерөнхий боловсролын сургуулийн 4 дүгээр ангийн сурах бичиг.  
(Одсүрэн П., ба бус; Ред Өнөрбаян Ц, Мягмаржав У., -УБ.2014. -152х)

Энэхүү сурах бичиг нь “Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулиар хамгаалагдсан бөгөөд Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамнаас бичгээр авсан зөвшөөрлөөс бусад тохиолдолд цахим болон хэвлэмэл хэлбэрээр, бүтнээр эсхүл хэсэгчлэн хувилах, хэвлэх аливаа хэлбэрээр мэдээллийн санд оруулахыг хориглоно.

Сурах бичгийн талаарх аливаа санал хүсэлтийг [textbook@mecs.gov.mn](mailto:textbook@mecs.gov.mn) хаягаар ирүүлнэ үү.

© Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам

ISBN 978-99973-69-25-3

## ГАРЧИГ

1. Ярих чадвараа хөгжүүлье.	5
2. Номтой нөхөрлөцгөөе.	11
3. Зохиолын гол санааг ойлгож уншъя.	19
4. Гол санааг ойлгож, үндэслэлтэй таамаглаж суръя.	31
5. Бахархсан утгатай захидал бичигчгээе.	41
6. Баримт, нотолгоотой ярьж, бичиж сурцгаая.	45
7. Үйл явдлыг өрнүүлэн зохион бичье.	53
8. Монгол аман зохиолоос суралцъя.	63
9. Шүлгийн утгыг ойлгон уран уншъя.	73
10. Учир шалтгааныг олж, тайлбарлах аргад суралцъя.	83
11. Уриалга бичиж сурцгаая.	91
12. Урилга бичиж сурцгаая.	93
13. Зөв, хурдан, ойлгож унших чадвараа хөгжүүлье	97
14. Төсөөлөн бодож, үлгэр зохиоё.	107
15. Сэтгэгдэл, мэдрэмжээ илэрхийлэн бичье.	119
Үгийн утгын тайлбар	151
Хэлц үгийн тайлбар	152

## ТАНИХ ТЭМДЭГ



Унших чадвар



Хэл зүйг хэрэглэх чадвар



Сонсох, ярих чадвар



Зөв бичих дүрэм



Бичих чадвар



Би юу сурсан бэ?

## ДӨРӨВДҮГЭЭР АНГИЙН СУРАХ БИЧГИЙН АГУУЛГА

№	Нэгжийн нэр	Суралцахуйн зорилт буюу эзэмших чадвар
1	Ярих чадвараа хөгжүүлбэ.	 Цэг, таслалыг зөв хэрэглэн бичих
		 Сэдвийн хүрээнд яриагаа төлөвлөж бэлтгэн, ойлгомжтой илэрхийлэн ярих
2	Номтой нөхөрлөцгөө.	 Номын танилцуулгын зорилго, бүтцийг тайлбарлах
		 Уншсан номыг танилцуулж бичихдээ сэтгэгдэл, мэдрэмжээ илэрхийлэх
		 Сэдвийн хүрээнд яриагаа төлөвлөж бэлтгэн, ойлгомжтой илэрхийлэн ярих
		 Зөвлөсөн өнгө аясыг илтгэх үг, хэллэгийг оновчтой хэрэглэн, өгүүлбэр эх зохиох
3	Зохиолын гол санааг ойлгож уншъя.	 Уншсан эхийн бүтцийн холбоо хамаарлаас гол санааг ойлгосноо харуулах
		 Үйл явдлыг өрнүүлэн, утгын уялдаа холбоотой богино өгүүллэг зохиох
		 Харин, ийм учраас, цаашилбал, үүнээс гадна, яагаад гэвэл, үүнээс болж, ба, бөгөөд зэрэг холбох үгсийг хэрэглэн, өгүүлбэр, эх зохиох
		 Уншсан эхийн бүтцийн холбоо хамаарлаас гол санааг ойлгосноо харуулах
4	Гол санааг ойлгож, үндэслэлтэй таамаглаж суръя.	 Эхийн үйл явдлын төгсгөлийг үндэслэлтэйгээр таамаглах
		 Балархай эгшгийн эгшигжүүлэх, зөөлрүүлэх үүргийг мэдэх, зөв бичих
		 Сэдвийн хүрээнд яриагаа төлөвлөж бэлтгэн, ойлгомжтой илэрхийлэн ярих
		 Харин, ийм учраас, цаашилбал, үүнээс гадна, яагаад гэвэл, үүнээс болж, ба, бөгөөд зэрэг холбох үгсийг хэрэглэн, өгүүлбэр, эх зохиох
5	Бахархсан утгатай захидал бичигцгээ.	 Захидлын зорилго, бүтцийг тайлбарлах
		 Өгсөн бүтцийн дагуу утгын уялдаа холбоотой бахархсан утгатай захидал бичих
		 Балархай эгшгийн эгшигжүүлэх, зөөлрүүлэх үүргийг мэдэх, зөв бичих
		 Харин, ийм учраас, цаашилбал, үүнээс гадна, яагаад гэвэл, үүнээс болж, ба, бөгөөд зэрэг холбох үгсийг хэрэглэн, өгүүлбэр, эх зохиох
6	Баримт, нотолгоотой ярьж, бичиж сурцгаая.	 Эхэд ашигласан баримт ба өгүүлэгчийн үзэл бодлыг ялгах
		 Сонины мэдээний зорилго, бүтцийг тайлбарлах
		 Өгсөн асуултын хүрээнд үйл явдлын товч мэдээ бичих
		 Хэлэлцүүлгийн явцад бусдын санаа бодлыг анхааралтай сонсож дүгнэх
7	Үйл явдлыг өрнүүлэн зохион бичье.	 Ойролцоо утга, эсрэг утгатай үгийг найруулгад оновчтой хэрэглэн өгүүлбэр, эх зохиох
		 Уншсан эхийн бүтцийн холбоо хамаарлаас гол санааг ойлгосноо харуулах
		 Үйл явдлыг өрнүүлэн, утгын уялдаа холбоотой богино өгүүллэг зохиох
		 Ж, ч, ш-ийн дараа “и” бичдэгийн учрыг мэдэх, зөв бичих
8	Монгол аман зохиолоос суралцъя.	 Хэлэлцүүлгийн явцад бусдын санаа бодлыг анхааралтай сонсож дүгнэх
		 Уншсан эх дэх танил биш үгийг тайлбар толь бичгээс олж, агуулгыг ойлгох
		 Бүтцийн дагуу үлгэр зохиохдоо баатрын гадаад дүр байдлыг дүрслэн бичих
		 Ж, ч, ш-ийн дараа “и” бичдэгийн учрыг мэдэх, зөв бичих
9	Шүлгийн утгыг ойлгон уран уншъя.	 Шүлэг дэх хоёр зүйлийн ижил төстэй шинжийг харьцуулан адилтган дүрсэлснийг тайлбарлах
		 Хурд, дууны өнгөө тохируулан урнаар уншиж, шүлгийн утгыг ойлгосноо харуулах
		 Шүлгийн хэлбэрийг дуурайж зохион бичих
		 Ойролцоо утга, эсрэг утгатай үгийг найруулгад оновчтой хэрэглэн өгүүлбэр, эх зохиох
10	Учир шалтгааныг олж, тайлбарлах аргад суралцъя.	 Уншсан эх, үлгэр, өгүүллэгийн бүтцийн хэсгүүдийн учир шалтгааныг тайлбарлах
		 Хэлэлцүүлэгт шинэ санаа нэмж оролцох, бусдын яриаг дуустал хүлээцтэй сонсох
		 Эх, өгүүлбэр зохиохдоо хэлц үгийг утгаар нь зөв хэрэглэх
		 Уриалсан өнгө аясыг илтгэх үг хэллэгийг оновчтой хэрэглэн, өгүүлбэр, эх зохиох
11	Уриалга бичиж сурцгаая.	 Уриалгын зорилго, бүтцийг тайлбарлах
		 Бусдыг сайн сайхан зүйлд уриалж, бүтцийн дагуу уриалга бичих
		 Хэлэлцүүлэгт шинэ санаа нэмж оролцох, бусдын яриаг дуустал хүлээцтэй сонсох
		 Уриалсан өнгө аясыг илтгэх үг хэллэгийг оновчтой хэрэглэн, өгүүлбэр, эх зохиох
12	Урилга бичиж сурцгаая.	 Урилга зэргийн зорилго, бүтцийг тайлбарлах
		 Хүндэтгэлийн үг хэрэглэн, бүтцийн дагуу урилга бичих
		 Хатуу, зөөлний тэмдгийн тусгаарлах үүргийг мэдэх, зөв бичих
		 Ойролцоо утгатай үгийг найруулгад оновчтой хэрэглэн өгүүлбэр, эх зохиох
13	Зөв, хурдан, ойлгож унших чадвараа хөгжүүлбэ	 Уншсан эхийн бүтцийн холбоо хамаарлаас гол санааг ойлгосноо харуулах
		 Дуудлага ижил зарим үгийг утга, бичлэгээр нь ялгаж, өгүүлбэрт зөв хэрэглэх
		 Хэлэлцүүлгийн явцад бусдын санаа бодлыг анхааралтай сонсож дүгнэх
		 Эх, өгүүлбэр зохиохдоо хэлц үгийг утгаар нь зөв хэрэглэх
14	Төсөөлөн бодож, үлгэр зохиоё.	 Уншсан зохиолын баатрын гадаад дүр байдлыг ургуулан бодож төсөөлөх
		 Бүтцийн дагуу үлгэр зохиохдоо баатрын гадаад дүр байдлыг дүрслэн бичих
		 Зохиолын баатруудын харилцан ярианы утгыг ойлгосноо жүжиглэн үзүүлэх
15	Сэтгэгдэл, мэдрэмжээ илэрхийлэн бичье.	 Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсэгт баатруудын зан чанар, үзэл бодолд гарсан өөрчлөлтийг харьцуулах
		 Уншсан зохиолыг танилцуулж бичихдээ сэтгэгдэл, мэдрэмжээ илэрхийлэх
		 Зохиолын баатруудын харилцан ярианы утгыг ойлгосноо жүжиглэн үзүүлэх
		 Эх, өгүүлбэр зохиохдоо хэлц үгийг утгаар нь зөв хэрэглэх





## ЯРИХ ЧАДВАРАА ХӨГЖҮҮЛЬЕ.

Энэ бүлэгт ярих зүйлээ төлөвлөж, бэлтгэж, илэрхийлж сурна. Өөрийгөө танилцуулан ярьж, бичиж чаддаг болно. Бичихдээ цэг, таслалыг зөв хэрэглэж сурна.



### Өөрийгөө хэрхэн танилцуулж байгааг судлан уншицгаая.

- 1 Сурагч Эрдэнэ, Энгүүн хоёрын аяллын тухай бичсэн танилцуулгыг уншъя. Ялгаатай ба ижил талыг ажиглая.



А. Миний нэрийг Энгүүн гэдэг. Би аавтайгаа зуслангийн арын ууланд гарч аялсан тухайгаа танилцуулъя. Уул өөд өгсөхөд хэцүү байсан ч зүтгэсээр уулын оройд гарлаа. Ууланд аялахад маш сайхан, хол ойрын зүйл тод харагдаж байсан. Би тэнд хад дамжин гүйж, бас чулуугаар дүрс эвлүүлж тоглосон юм. Гэртээ ирээд, ууланд явсан тухайгаа ээждээ ярьсан. Ээж маань аяллын тухай миний яриаг сонсоод, магтсан.

Б. Миний нэр Эрдэнэ. Би 4-р ангид сурч байна. Би та нарт уулын аялалд явснаа танилцуулъя. Миний нагац эгч долоо хоног бүр найзуудтайгаа ууланд аялдаг. Би дагаж явсаар аяллын багийн хамгийн хамгийн бяцхан, бас хамгийн идэвхтэй гишүүн болоод байгаа шүү. Бид хэцүү бүхнийг давж туулна гэж аяллын багтаа “Өгсүүр” гэсэн нэр өгсөн юм. Тэд, намайг өхөөрдөж, “Өгсүүр” багийн “Өөдөсхөн гишүүн” гэж дууддаг.

Би Богд уулын орой Цэцээ гүний оргилд гарсандаа баярладаг. Тэр оргилын орой зориуд засчихсан юм шиг тэгшхэн байсан. Бас зөөлөн салхи сэвэлзээд, ой мод, цэцэгсийн үнэр ямар сайхан байсан гээч. **Тэр үед эх орноо хайрлах сэтгэл улам улам төрж байлаа.**

Үнэндээ би нэлээд ядарсан. Уул руу өгсөхөд гайгүй, уруудах хэцүү байдаг. Аялагч ах эгч нартаа төвөг болохгүй юм сан гэж их хичээсэн дээ.

Аав намайг чи ууланд яваад их хурдан өсжээ гэдэг. Ууланд явахаар **их ажигч, бас тэвчээртэй болдог** юм байна лээ. Би аялахдаа зургийн аппаратаар өнгө өнгийн цэцэг, мод, өвөрмөц тогтоцтой хадны зураг сонирхож авсаар гэрэл зургийн цуглуулгатай болсон. **Уулын аялалд явснаас хойш би сэтгүүлч болохоор шийдсэн юм. Би аялах дуртай.**



## 2 Танилцуулгыг харьцуулан ярилцъя.



1. Энгүүн, Эрдэнэ хоёр юуг танилцуулав?
2. Тэдний хэн нь тодорхой танилцуулж чадсан бэ?
3. Хэн нь зорилготой танилцуулсан бэ? Яагаад?
4. Зураг харуулж, танилцуулах нь ойлгомжтой байхад нөлөөлсөн үү?
5. Эхээс танил биш үгийг олж, толь бичгээс хараарай.
6. Цэг, таслалыг ямар зорилгоор хэрэглэсэн байна вэ?

Та нар өөрийнхөө давуу сайн талыг мэддэг ч илүү сайн мэдэхийг хүсэж байна уу? Өнгөрсөн хугацаанд мэдээгүй, илрүүлээгүй эрхэм нандин зүйлүүдээ шинээр нээн илрүүлэх нь маш гайхалтай хэрэг юм.

## 3 Найзууд аа! Өөрийгөө нээн илрүүлэх аялалд гарцгаая.

1. Би ....-гээр эхэлсэн 10 өгүүлбэр бичээрэй.

Би .....

Би төрийн дуулал сайн дуулдаг.

Би .....

Би зураг зурах сонирхолтой.

2. Бичсэнээ найз нартаа уншиж танилцуулъя. Хүүхдүүд юу чаддагийг сонсьё.



3. Өөрийгөө нээх аялалд оролцсон найзууддаа урмын үг хэлцгээе.

<i>Найзын минь магтаал, урмын үг:</i>	<i>Найздаа хэлэх миний үг:</i>
Өөрийгөө нээх аялалд оролцсон чамайг зураг зурах авьяастайг улам сайн мэдлээ. Чамд баяр хүргэе. Авьяасаа хөгжүүлээрэй.	Миний найз .....

## Сэдвийн хүрээнд яриагаа төлөвлөж, бэлтгэж, илэрхийлж ярьцгаая.

### 1 Найзуудынхаа юу танилцуулж байгааг сонирхъя.

#### Би сонирхдог зүйлээ танилцуулъя.



Намайг Нямсүрэнгийн Маргад гэдэг. Би 4 дүгээр ангид суралцдаг. Аав ээж, 3 дүүгийн хамт амьдардаг.

Би сагс тоглох дуртай. Өдөр бүр байрныхаа найзуудтайгаа тоглохдоо олон бөмбөг сагсанд оруулж, дотроо маш их баярладаг. Баярлах тусам би улам хичээдэг.

Миний хүндэлж явдаг сагсчид өндөр биш ч хамгийн сайн нь. Би тэдэн шиг хурдтай, хүчтэй байж, Монголын төдийгүй Америкийн үндэсний сагсан бөмбөгийн холбооны тоглогч болно гэж мөрөөддөг.

Мөрөөдөлдөө хүрэхийн тулд өдөр бүр гүйж, өндөр үсэрч, хоолоо сайн идэж, эрүүл байх нь чухал гэж бодож байна. Би мөрөөдөлдөө заавал хүрнэ.

#### Би мөрөөдлөө танилцуулъя.

Чи өөрийгөө Мөнх-Оргилтой ярилцсан гэж төсөөлөөрэй.

.....: - Чиний хүсэл мөрөөдөл юу вэ?

А. Мөнх-Оргил: Би хөл бөмбөгчин болох сон гэж боддог. Харин чинийх?

.....: .....

Чиний хүсэл мөрөөдлөөс би чамайг ямар хүн болохыг мэдэх юм байна.

А. Мөнх-Оргил: Тийм шүү. Болох л юм.

.....: За тэгвэл, чи өөрийгөө бидэнд танилцуулаач.

#### Би хөл бөмбөгчин болохыг мөрөөддөг.



Миний нэр Мөнх-Оргил. Би багаасаа спорт сонирхдог байсан ч намайг жижигхэн биетэй болохоор хөл бөмбөг тоглож, амжилт гаргана гэж хэн ч төсөөлөөгүй. Сургуулийнхаа хөл бөмбөгийн дугуйланд ороход аав минь намайг дэмжсэн. Тэгээд л би хичээх болсон.



Би сургуулийнхаа хөл бөмбөгийн талбайд очих дуртай. Тэнд найзуудтайгаа уулзаж, нэг баг болон тоглодог. Манай багийнхан эвсэг, нөхөрсөг, авьяаслаг хүүхдүүд шүү.



Би 9 настайдаа “Дуулиан - 2020” тэмцээний шилдэг довтлогчоор шалгарч, Монгол улсын Ерөнхий сайдын нэрэмжит шагнал хүртэж, Унгар улсад зочилж, Итали улсын “Милан” багийн урилгаар сурагчдын хамтарсан сургалтад оролцсон.



Би өвлийн хүйтэн, зуны халуунд олон цагаар бэлтгэл хийдэг ч шантардаггүй. Яагаад гэвэл миний хамгийн дуртай зүйл, бас хүсэл мөрөөдөл минь биелж байгаа болохоор тэр. Тэгээд л тэмцээн болох мөчийг догдлон хүлээдэг дээ. Ирээдүйд дэлхийд нэртэй тамирчин болно доо.

## Ярилцъя.

1. А.Мөнх-Оргил өөрийнхөө юуг танилцуулав?
2. А.Мөнх-Оргил танилцуулгадаа өөрийн давуу талыг гаргаж чадсан уу?
3. Эхэд байгаа “төсөөлөөгүй, шантардаггүй, догдлон хүлээдэг” гэсэн үгс нь ямар санааг гаргахад чухал байсан бэ? Яагаад?
4. Уншиж байх үед цэг, таслал ямар үүрэгтэй байгааг анзаарав уу?

- ② Хүүхдүүд ээ, дээрх хоёр хүүхдийн танилцуулгыг эргэцүүлээд, өөрийнхөө танилцуулгыг бэлтгээрэй.

## Танилцуулгаа яаж төлөвлөх вэ?

Хэнд, юуг танилцуулахаа сонгоно.	Танилцуулах зүйлийнхээ юуг тодотгож, дэлгэрүүлж ярихаа төлөвлөнө.	Өөрийнхөө онцлог байдлыг илэрхийлнэ. Ямар үг хэрэглэхээ сонгоно.
Би .....		

Тухайлбал:

1. Хүсэл мөрөөдлөө танилцуулах яриагаа төлөвлөө.
  - Миний нэр...
  - Миний хүсэл мөрөөдөл бол...
  - Мөрөөдөлдөө хүрэхийн тулд би ийм зүйлийг хийдэг. Цаашид ийм зүйл хийхийг хүсэж байна. Миний сайн тал бол... Энэ сайн чанар маань намайг мөрөөдөлд минь хүргэнэ гэдэгт би итгэдэг.
  - Би хүсэл мөрөөдөлдөө ингэж хүрнэ. Мөрөөдөлдөө хүрснээр би ийм хүн болно. Ингэж сайхан амьдарна.
2. Танилцуулгадаа хэрэглэх зүйлийг цуглуулж, бэлдье.
3. Төлөвлөгөөгөө бусдад ярьж, харилцан санал солилцоорой.

### САНАМЖ

Зорилготой танилцуулахын тулд сайн төлөвлөх нь чухал.



Ярилцахдаа:

- Үгээ тод хэлэх
- Бусдад ойлгомжтой илэрхийлэн, сонирхолтой ярих
- Бусдын ярьсныг дуустал хүлээцтэй сонсох, сонирхсон зүйлээ тодруулж асуух.



## Зорилгодоо тохируулан, өөрийн танилцуулгаа бичицгээе.

**Бичих санаагаа олж, төлөвлөө.**

**Санаагаа цэгцэлж, зөв байрлуулъя.**


**Сонгон ажиллая.**

**А. Би хүсэл мөрөөдлөө танилцуулж бичье.**

- Танилцуулгыг дараах дэс дарааг баримтлан бичнэ.  
Өөрийн хүсэл сонирхлыг эхлэл хэсэгт  
Хийсэн зүйлээ болон юу хийхээ гол хэсэгт  
Мөрөөдөлдөө яаж хүрэхээ төсөөлөн төгсгөл хэсэгт бичнэ.
- Дараах хоёр хэсгээс сонгон, санаа авч бичээрэй.

<i>Эхний өгүүлбэрийг ажиглаад, түүнтэй адил өгүүлбэрээр эхэлж бичээрэй.</i>	<i>Эхний өгүүлбэрийг бичихдээ өөртөө асуулт тавьж эхлээрэй.</i>
Миний хүсэл мөрөөдөл бол...	Миний хүсэл мөрөөдөл юу билээ?
Сонгон хэрэглэх үгс: ирээдүйд, зорилго, сонирхол, илүү ихийг, заавал, шаргуу, цагийг үр бүтээлтэй өнгөрөөх, хүсэл гэх мэт	Сонгон хэрэглэх үгс: хичээнгүй эмх цэгцтэй, хичээл, зүтгэл, мөрөөдлөө биелүүлэхээр гэх мэт

**Б. Би найзаа танилцуулж бичье.**



Танилцуулгаа бичихийн өмнө дараах асуултыг бодъё.

- Найзуудаасаа хэнийг танилцуулах вэ?
- Танилцуулах болсон шалтгаан нь юу вэ?
- Найзынхаа юуг онцолж танилцуулах вэ?
- “Найзаар минь намайг таньдаг” гэдэг шүү дээ. Та хоёрын адил болон ялгаатай тал юу вэ? Юун дээр санаа нийлдэг вэ?
- Найзаасаа юуг сурч авав? Найзтайгаа юу ярилцдаг вэ?

**Бичсэнээ хянаж сайжруулъя.**

	Бататгая.	
	тийм	үгүй
Хэнд, юуг танилцуулахаа төлөвлөсөн үү?		
Өөрийнхөө зан чанарын онцлог байдлыг гаргаж бичсэн үү?		
Танилцуулах гол зүйлийг ойлгомжтой, дэлгэрэнгүй бичиж чадсан уу?		
Өөрийн төлөвлөж ярьсны дагуу дэс дараатай бичиж чадсан уу?		
Алдаагүй зөв бичиж чадсан уу?		
Цэг, таслалыг зөв хэрэглэсэн үү?		





## Цэг, таслалыг зөв хэрэглэн бичицгээе.

### Цэгийг зөв хэрэглэх дасгал

Бид өмнөх ангид өгүүлбэрийн төгсгөлд цэг тавьдаг гэдгийг үзсэн шүү дээ. Одоо бид өөр ямар тохиолдолд цэг тавьдгийг ажиглая. Дараах 2 тулгуур дохиог хараад, дүгнэлт гаргаарай.

1. Өглөө эртхэн босож хэвшье.
2. Дасгал тогтмол хийе.
3. Шүдээ сайн угааж суръя.
4. Өглөөний цайгаа ууж заншъя.
5. Хичээлдээ хоцролгүй очиж суръя.

Би А.Мөнх-Оргилын тухай танилцуулгыг уншаад маш их бахархсан.  
Монголын анхны Олимпын аварга Н.Түвшинбаяр, анхны сансрын нисэгч Ж.Гүррагчаа нар Булган аймагт төржээ.

Цэгийг өгүүлбэрийн төгсгөлд тавихаас гадна .....

Цэгийг өгүүлбэрийн төгсгөлд тавихаас гадна .....

### Таслалыг зөв хэрэглэх дасгал

① Ямар тэмдэг байх вэ? Сонгож тавиарай.   !  ?

1. Найзууд аа  зуны амралтаа сайхан өнгөрүүлсэн үү
2. Би зун Хөвсгөл далайд очиж, сайхан амарлаа
3. Далайн усанд хамаагүй орж болохгүй шүү
4. Ээ  ямар гоё вэ

#### ДЧРЭМ

Бусдад хандаж хэлсэн үгийн дараа таслал тавина.

② Тодруулсан үгсийг хэлэхэд юу ажиглагдаж байна вэ? Ямар тэмдэг хэрэглэх вэ?

1. Манай оронд Хөвсгөл Увс Буйр Өгий зэрэг нуур байдаг.
2. Хэнтийн нуруунд баавгай үнэг чоно гөрөөс буга шилүүс зэрэг амьтад нутагладаг.
3. Туулай үсэрч дэгдэж харайж явдаг амьтан.

#### ДЧРЭМ

Тоочсон үгсийн хооронд таслал тавина.

③ Дараах өгүүлбэрийн утгыг тайлбарлая. Таслалаар юуг ялгаж байна вэ?

1. Төмөр, сүхээр түлээ хагалав.  
Төмөр сүхээр түлээ хагалав.
2. Дархан, хот руу автобусаар явлаа.  
Дархан хот руу автобусаар явлаа.

#### ДЧРЭМ

Үйлийн эзнийг тодруулахдаа таслал тавина.

### Би юу сурсан бэ?

Өөрийгөө шалгах асуулт	Хамгийн сайн чаддаг болсон зүйл	Цаашид яаж сайжруулах вэ?
Танилцуулах зүйлээ яаж төлөвлөж, бэлтгэж, илэрхийлэх вэ?		
Ямар нэгэн зүйлийн тухай танилцуулахдаа өөрийгөө илэрхийлж сурсан уу?		
Цэг, тэмдгийг яаж зөв хэрэглэх вэ?		
Чамд ямар бэрхшээл байна вэ?		



## НОМТОЙ НӨХӨРЛӨЦГӨӨЕ.

Энэ бүлэгт номыг ойлгож унших аргатай болно. Уншсан зохиолын сэдвийн хүрээнд яриагаа төлөвлөн, ойлгомжтой илэрхийлэн ярьж сурна. Номын болон уншсан зохиолын талаарх танилцуулга бичихдээ сэтгэгдэл, мэдрэмжээ илэрхийлж, бусдадаа ном уншихыг зөвлөж, уриалж сурна.



### Ном унших аргатай болъё.

#### 1 Утгыг ойлгон уншъя.

Өндөр ууланд шат шүү, ном тань  
Өргөн далайд сал шүү, ном тань  
Харанхуй мунхагт зул шүү, ном тань  
Харгуй замд газарч шүү, ном тань  
Бөглүү замд хүнс шүү, ном тань  
Яарахын цагт үл орхих найз шүү, ном тань  
Ямар ч үед хулгайд үл автах эрдэнэ шүү, ном тань

*(“Элдэв сургаал оршвой” хэмээх зохиолоос)*

### ЭРДЭМ НОМЫН ТУХАЙ МЭРГЭДИЙН СУРГААЛ

Ухаантан мэргэд хэдий эрдэмтэй боловч  
Улам улам мэргэжихийн тулд ном судар цуглуульюу.  
Аливаа мэргэд эрдэм сурахад өчүүхэн зовно  
Амраа харж дэмий суувал мэргэн үл болъюу.  
Эрдэмгүй тэнэг зарим муу хүн  
Эрдэмтэй хүнд дэмий харшлан атаархана.  
Аль хүнд ямар эрдэм байна  
Алимад түүгээрээ нэр алдрыг олно.  
Өөрийн мэдэл оюун хурц боловч  
Үргэлжид мэргэд номыг үзтүгэй.

*(“Сайн үгт Эрдэнийн сан Субашид” хэмээх зохиолоос)*

#### 2 Утгыг тодруулан ярилцъя.

##### 1. Эхний хос мөр дэх утгыг ойлгохын тулд:

- Ухаантан мэргэд гэж ямар хүнийг хэлэв?
- “Хэдий”, “боловч” гэсэн холбох үг ямар утгыг тодотгосон байна вэ?
- Ухаантан мэргэд ном судрыг цуглуулдгийн учрыг юу гэж ойлгож байна вэ?
- “Ухаантан мэргэд байж ахин мэргэжих”-ийн учир юу вэ?
- “Улам” гэсэн үгийг ямар зорилгоор хоёр удаа давтав?
- Хүмүүс ямар зорилгоор ном худалдан авдаг вэ? Гэрийнхнээсээ, найзуудаасаа сурвалжилга хийн, ярилцаарай.

**2. Хоёр дахь хос мөрийн утгыг ойлгохын тулд:**

- а. Яагаад “Мэргэд эрдэм сурахад өчүүхэн зовно” гэсэн бэ?
- б. “Амраа харж суудаг хүн” гэж ямар хүнийг хэлж байна вэ?
- в. “Дэмий суувал мэргэн болохгүй” гэж юу гэсэн үг вэ?

**3. Гурав, дөрөв, тав дахь хос мөрийн утгыг тодруулах асуулт зохион ярилцаарай.**

**4. Сургаалд ямар асуудлыг чухалчилсан бэ? Сонгоё.**

- Ном судар цуглуулах нь чухал.
- Эрдэмтэй боловч улам илүү суралцах нь чухал.
- Эрдэмтэй хүнд атаархахгүй байх нь чухал.
- Эрдэмгүй, тэнэг хүн болохгүй байх нь чухал.
- Улам улам сайн сурч, эрдэмтэй болохын тулд эд хөрөнгийг биш, номыг сонгох нь чухал.

**5. Яагаад чухал гэж үзэв? Ярилцъя.**

**3 Ном унших зорилгоо тодорхойлъё.**

- Номыг ямар зорилгоор уншдаг вэ? Эргэцүүлснээ илэрхийлээрэй.
- Хэр их ном уншсан бэ? Ном уншсанаар чи өөрийгөө хэр өөрчлөгдсөн гэж боддог вэ?



*Чи ямар ном унших дуртай вэ?*


*Янз бүрийн л ном уншина даа. Номын дэлгүүрт, номын санд олон янзын ном байх юм аа. Надад сонгон авч уншихад хэцүү байдаг шүү.*



**4 Хүүхдүүд ээ, та нар ямар ном уншихыг хүсэж байна вэ?**

- Үлгэрийн ном, шүлгийн ном, адал явдалтай ном, дэлхийн хүүхдийн сонгодог зохиолын ном, хүүхдийн зохиосон ном, танин мэдэхүйн ном, нэвтэрхий толь, шог хошин зохиолын ном, зурагт ном, сургамжит өгүүллэгийн ном гээд олон төрлийн ном байдаг.
- Өөр ямар төрлийн ном байдгийг сурвалжлан тэмдэглээрэй.
- Ямар ном сонгож уншдаг вэ? Яагаад?

**5 Дэлхийн хүүхдийн сонгодог зохиолтой номоос сонгон уншъя. Хамтдаа номын дэлгүүр, номын санд очоорой.**





## 1 Зөв, хурдан, ойлгож уншаарай.

### ХУЛГАНА, НОМ ХОЁР

Гэрийн хаяагаар орж ирсэн хулгана шууд л орны хөндийд навсайж хэвтсэн хүрэн цүнх рүү шургачихлаа. Цүнхэн дотор тас харанхуй. Тэнд ганц ном, хоёр дэвтрээс өөр юу ч байсангүй.

Хулгана номын булангаас өм татан хазтал ном учиргүй чанга ёолон,

- Чи яасан өрөвдөх сэтгэлгүй амьтан бэ? Өдөржин харанхуй саванд хэвтэж нэг уйдах, чамд зулгаалгаж бас нэг өвдөх мөн хэцүү еэ.

- Үгүй ер дөө, харж хандах эзэнгүй чамайг хазаж хэмлэхэд яадаг юм гээд хулгана дахин ухасхийвэл ном хатуу хавтсаа гэнэт дэлгэж, хамар дундуур нь буулгаад авчээ.

- Чадал ихтэй ном байх нь ээ. За яах вэ? Ноохойлох цаас мундсан биш гээд хулгана гарахыг завдтал ном араас нь дуудаж,

- За за битгий гомд л доо. Одоо хоёулаа эвлэрье. Харин чи миний эзнийг эрдэм номоо өөд нь татдаг болгоход туслаач гэв. Ийнхүү ном хулгана хоёр танилцан, сайн нөхөд болж, салан сурагч Онхооныг гайгүй сайн ичээж хашраахаар тохиролцжээ.

Амралтын өдөр гялсхийн өнгөрч, хичээлийн шинэ долоон хоног эхэллээ. Хонх жингэнэн дуугарч, багш орж ирэв. Онхоон дэвтрээ авахаар гараа шургуултал нэг жижигхэн юм хөдлөх шиг болов. Цочсондоо ухасхийн босвол цүнхнээс нь хулгана гараад зугтах нь тэр.

Анги дүүрэн шуугиан дэгдэж, зарим охид ширээн дээр гаран чарлаж, хөвгүүд хулганы араас хөөх гэтэл багш байсан тул яаж ч чадсангүй. Дэмий л суудлаасаа “Тэр байна, тэр байна” гэж хашхиралдана. Үйл явдал хоромхон зуур болж, ашгүй ангиас эсэн мэнд гарч амжлаа. Онхоон ичсэндээ чих нь хүртэл улайжээ. Үүнээс хойш тэр цүнхтэй номоо хаа хамаагүй хаяхаа байсан гэдэг шүү.

(О.Сундуй)

## 2 Уншсанаа ярилцъя.

1. Ном ямар байдалтай хаана хэвтэж байсан бэ?
2. Онхоон хүүгийн сул тал юу байв?
3. Хулгана, ном хоёр юу ярилцав? Тэр хоёрын шийдвэр зөв байсан уу?
4. Онхоон цүнхтэй номоо хаа хамаагүй хаяхаа больсны шалтгаан нь юу вэ?
5. Зохиолч бидэнд юу хэлэхийг хүссэн бэ? Гол санааг тайлбарлаарай.
6. Онхоон шиг хүүхэд байдаг болов уу? Түүнд юу хэлэхийг хүсэж байна вэ?

## 3 Уншсан номынхоо танилцуулга бичсэнийг анхааралтай уншаарай.

*Би энэ 7 хоногт 2 ном уншсан. Номын дэлгүүрээс хүүхдийн зохиолыг О.Сундуйгийн зохиолыг сонгож уншлаа.*


*Түүний “Хулгана, ном хоёр” зохиол нь таалагдсан, бас их юм бодогдуулсан юм. Учир нь цүнхээ хаа хамаагүй шидгэхдээ Онхоон шиг зантайгаа мэдэрсэн. Энэ зохиолыг уншсанаас хойш би өдөр өдрийнхөө хигээлийг ялгаж, цүнхээ цэвэр байлгаж, ширээн дээр тавьдаг болсон билээ.*

*Хүүхдүүд ээ, та нар ч гэсэн цүнхээ хайрлаж, ариг галтай хэрэглэж сураарай.*

*Сурагч Э.Есүйгэн*

## Хурдан унших харааны дасгал хийе.

1 дэх 1 мин ..... удаа	2 дахь 1 мин ..... удаа	3 дахь 1 мин ..... удаа
------------------------	-------------------------	-------------------------



“Би хурдан уншигч” хүснэгт хэрэглээрэй.

Сар өдөр	Уншсан номын нэр	Эхэлсэн хугацаа	Дууссан хугацаа

### 4 Унших аргатай болъё.

1. Ухаарч ойлгож унших нь чухал.

2. Өөрт хэрэгтэй хэсгийг дахин дахин унш. Уншсан хэсгээ номоос эрж олох дасгал хийгээрэй.

3. Өөрт хэрэгтэй чухал гэж үзсэнээ өнгийн харандаагаар тэмдэглээрэй.

Өөртөө худалдаж авсан ном бол дээр нь тэмдэглэнэ. Харин номын сангийн ном бол тусгай дэвтэр гарган тэмдэглээрэй. Тухайлбал:

- Дахин дахин уншмаар санагдвал **улаан өнгөөр**
- Чухал гэж үзсэнээ **ногоон өнгөөр**
- Бусдад ярьж, хэлмээр санагдсан хэсгээ **хөх өнгөөр**
- Эргэлзсэн утга агуулгатай хэсэг байвал **шар өнгөөр**
- Ойлгохгүй үг, утга байвал доогуур нь зурах гэх мэтээр ажиллаж болно.

4. Үгийн утгыг яаж ойлгож, тайлбарлах вэ?

#### 1. Ойлгохгүй үгээ сонгоё.

“Хулгана ном хоёр” эхээс “ноохойлох” гэдэг үгийн утгыг мэдэхийг хүсэж байна.

#### 2. Өөрийн ойлгосноор таамаглая.

Магадгүй энэ үг “...” гэдэг үгтэй утгын холбоотой байх.

#### 3. Толь бичгээс үгээ олъё.

Толь бичгээс “Н” үсгээр эхэлсэн үгтэй эхний хуудсыг олно. “Н” үсгийн дараа нь “о”, “х”, “о” гээд энэ үгэнд орсон үсгийн дарааллаар үгээ оллоо.

#### 4. Толь бичиг дэх утгыг мэдэж, өөрийн таамаглалтай харьцуулъя.

“Ноохойлох” гэдэг үгийг толь бичигт “Хулгана, оготны хэвтэр” гэж тэмдэглэжээ. Би энэ үгийн утгыг арай өөр ойлгож байжээ. Цаашид би зохиол юм уу ямар нэгэн номыг уншихдаа үгийн утгыг ойлгож сурна.



## 5. Ойлгогдохгүй юм уу, ойлгоход хэцүү санаа гарвал яах вэ?

- Дахин анхааралтай унших, эсвэл ойлгогдохгүй байгаа хэсгийг чанга дуугаар уншаарай.
- Утгыг тодруулах асуулт зохиогоорой.
- Уншиж ойлгосноо дахин нягтал. Юуны тухай өгүүлэв? гэж дүгнээрэй.

## 6. Ном уншиж байхдаа зохиолын талаарх бодол санаа, мэдрэмж, төрсөн сэтгэгдлээ тэмдэглээрэй.



Тэмдэглэх-  
дээ:

- Зохиолыг уншиж байхад ямар дүр зураг бодогдов?
- Өөрсдөд чинь тохиолдсон ямар нэгэн үйл явдал санаанд чинь орсон уу?
- Зохиолын баатрууд, үйл явдлуудын талаар чи юу бодож, дүгнэж байв?
- Зарим үйл явдал, баатрын үйл хөдлөл зэргийг зураг, эсвэл дүрсээр илэрхийлж болно.

### Ном уншихдаа дараах зөвлөмжийг баримтлаарай

- Чимээ шуугиангүй орчинд уншина.
- Ширээний болон цонхны гэрэл зүүн гар талаас нүүр, нүдэн дээр биш, ном дээр тусаж байвал сайн.
- Гэрэл хэтэрхий хурц биш 15-30 Вт чийдэн байвал тохиромжтой.
- Уншиж байгаа ном нүднээс 35-40 см-ын зайтай, 15 градус налуу байрлавал тохиромжтой.
- Ном уншихад зориулсан тусгай цаг гарган, төлөвлөж сураарай.
- Уншиж буй хэсгээ түр орхихоор бол номын хавчуурга хэрэглээрэй. Ихэнх хүмүүс нугалдаг шүү дээ. Тэр нь номыг гэмтээж буй хэрэг.
- Хэвтэж уншиж болохгүй.

## 5 Номоо уншиж дуусаад юу хийх вэ?

1. Хэрхэн ойлгосноо шалгах асуултыг багштайгаа хамтран зохиогоорой.
2. Үйл явдлыг дарааллуулан бичээрэй.



Бичихдээ:

- Хамгийн чухал санааг бичээрэй. Ингэхдээ зохиолоос эшлэл татаарай.
- Өөртөө юуг тусгаж авснаа илэрхийлээрэй.

3. Сонгож уншсан зохиолынхоо тухай ангийнхандаа, гэрийнхэндээ, найздаа ойлгомжтой, сонирхолтой ярьж өгөөрэй.
4. Энэ номыг уншаасай гэж хүсвэл юу гэж хэлэх вэ?
5. Унших хэрэгтэйг онцлоорой.



## Сэдвийн хүрээнд яриагаа төлөвлөн ойлгомжтой, илэрхийлэн ярьцгаая.

Уншсан зохиолынхоо сэдвийн хүрээнд ярилцъя.

1 Ярилцахын тулд хүүхэд бүр уншсан зохиолынхоо сэдвийг тодорхойлъё.



Сэдвийг тодорхойлохдоо:

- Юуны тухай өгүүлсэн бэ?
- Зохиолд ямар асуудал чухал байсан бэ? гэсэн хоёр асуултын дагуу бодоорой. Тухайлбал:  
Сайхан сэтгэлийн тухай  
Нөхөрлөлийн тухай  
Эелдэг харилцааны тухай гэх мэтээр товч тодорхойлоорой.

2 Яагаад “..... тухай” сэдэвтэй гэж үзсэнээ тайлбарлахад бэлдээрэй. Зохиолоос жишээ татаж эшлээрэй. Тухайлбал:

Чин-Ундрамын бичсэнийг уншаад, дуурайн яриарай.

*Өвдрөг сэтгэлийн тухай*  
"Толманна" зохиол нь амьгаа зүйлийг ургэлж өвдрөгөөр харж, сайхан зүйлийг бодож байхыг сануулсан. Тийм учраас өвдрөг сэтгэлийн тухай сэдэвтэй гэж би дүгнэсэн.  
Залаад гэвэл энэ зохиолд "Хэрвээ чи зүү сарын баяраар шхэр биш таял авсан бол тэдгийг хэрэглэхийгээ баярла" гэж гардал. Өөрөөр хэлбэл шхэр биш таял авчээсэндээ галдох биш харин эрүүл халтэй гэж өвдрөгөөр бодох нь чухал юм.  
Энэ зохиолыг уншвал олон хүний амьгааг үзэх үзэл өөрчлөгдөнө гэж бодож байна.



Ярихдаа:

- Өөрийнхөө сонгосон номыг бусдад харуулж яриарай.
- Анх яаж уншсан, тэр ном чиний хувьд яагаад сонирхолтой байсныг онцлоорой. Бас яагаад чухал санагддаг тухайгаа илэрхийлж болно.
- Ангийнхандаа уншиж өгөх хэсгийг сонгож бэлдээрэй.



Чин-Ундрамын бичсэнээс чи юу ойлгож авав?

Уншсан зохиолынхоо сэдвийг тодорхойлохдоо "... тухай" гэсэн үгийг хэрэглэснийг анзаарлаа. Яагаад "... сэдэвтэй" гэж тодорхойлсноо зохиолоос эшлэл, баримт гарган баталж байна. Ингэж ойлгомжтой хэлж болох юм байна гэж бодогдлоо.



3 Хүүхэд бүр сонгосон зохиолынхоо сэдвийг тодруулж, өөрийгөө илэрхийлж ярих дасгал хийгээрэй.

4 Сонгосон сэдвийн хүрээнд өөр өөрсдийн үзэл бодлыг илэрхийлж, ярилцъя.



## Номын танилцуулга бичихдээ сэтгэгдэл, мэдрэмжээ илэрхийлье.

- 1 Номоо танилцуулах карт хийгээрэй. Загварын дагуу бөглөж, зохиогчийн нэрийн эхний үсгээр, цагаан толгойн дэс дарааллаар байрлуулаарай.



- 2 Танилцуулгаа төлөвлөө.



Номоо танилцуулж бичихдээ:

- Сэтгэлд үлдсэн, онцгой санагдсан эсвэл санаанд нийцээгүй ямар баатар, ямар үйл явдал, ямар тэмдэглэл байсан бэ?
- Сонирхолтой санагдсан, сэтгэл хөдөлгөсөн аль нэг хэсгийг сонгож, номынхоо танилцуулгад хичээнгүй бичгээр бичиж болно. Мөн зургаар дүрсэлж болно.
- Гол үйл явдал юм уу, өөрт таалагдсан зүйлийг зургаар илэрхийлдэг.
- Номыг уншиж дуусаад, юу мэдэрч байсан бэ? Эдгээр асуултын дагуу бичихдээ зохиолоосоо эшлэл аваарай.

- 3 Бичих бүтцээ төлөвлөө.

Эхлээд зохиолч, хэвлэгдсэн үйлдвэр, хавтасны зургийн талаар танилцуулаарай. Дараа нь зохиол юм уу номын талаар сэтгэгдэл мэдрэмжээ илэрхийлээрэй. Төгсгөлд нь найзууддаа заавал унших зохиол болохыг зөвлөөрэй.

- 4 Төлөвлөсний дагуу дэвтэр дээрээ ноороглоорой.

- 5 Нооргоо засаарай.



Засахдаа:

### Найруулгаа шалгах өөрийн үнэлгээний шалгуур:

1. Бичсэн танилцуулга нь уншихад ойлгомжтой байна уу?
2. Ямар нэгэн үг, өгүүлбэр хасмаар байна уу?
3. Ямар нэгэн үг, өгүүлбэр нэммээр байна уу?
4. Үгийн байрлалыг солимоор байна уу?
5. Үгийг солимоор байна уу?



Засахдаа:

### Зөв бичгийн дүрмийн засвараа хийгээрэй.

1. Бичсэн ноорогт нь зөв бичгийн дүрмийн алдаатай үг байна уу? Багштайгаа хамтран олоорой.
  2. Олсон үг нь ямар дүрмийг зөрчсөнийг бусадтай хамтран хэлэлцээрэй. Ингэхдээ үгийн бүтцээр задална уу.
  3. Ямар дүрмийн алдаа хийснээ тайлбарлаж бичээрэй.
  4. Зөв болгож бичсэн үгээрээ өгүүлбэр зохиож бататгаарай.
- Жишээ нь, “Ном уншхын сайхныг энэ зохиолоос мэдэрсэн” гэсэн өгүүлбэрийн “уншхын” гэдэг үгийг алджээ. “Уншихын” гэж зөв бичих ёстой байж. Ямар алдаа гаргасан бэ? Ямар дүрэм байдаг вэ? Дараах дүрмийг уншаад, юуг алдсаныг хэлэлцээрэй.



## ДЧРЭМ

Үйлт нэрийн “-х” гийгүүлэгчийн өмнөх эгшгийг гээхгүй.  
Жишээ нь, бод+х+оос=бодохоос, ярь+х+ыг=ярихыг, чад+х+ын=чадахын

- 6 Нооргоо бусдад уншин, зөвлөж ярилцаарай.
- 7 Дахин сайжруулж, хичээнгүй хуулж бичээрэй.
- 8 Хүүхдүүдийн бичсэн номын танилцуулгыг уншаад, дээрх асуултын дагуу бичсэн эсэхийг нягтлаарай.



### Би танин мэдэхүйн ном унших дуртай.

Би “Сургамжит өгүүллэгүүд” гэдэг номыг сонгож уншсан юм.

#### Номоо танилцуулъя.

Зохиогч: Ж.Саранчимэг

Нэр: “Сэтгэлийн амин дэм”

Хэвлэсэн он: 2013 он

Энэ номд 57 өгүүллэг багтсан.

“Шинэ ертөнц” хэвлэлийн үйлдвэрт хэвлэсэн.

Энэ номыг 4 өдөр уншсан.

Энэ номд хүн буруу зүйл хийвэл ухаарч, дутагдлаа, сэтгэлээ засаж явах тухай өгүүлсэн. Хүүхэд биднийг хүнлэг энэрэнгүй, оюунлаг, ухаалаг, сайхан сэтгэлтэй сайн хүн болоорой гэж хүссэн сайхан ном юм. Үргэлжлэн гардаг гэсэн учраас дараагийн номыг олж уншина гэж бодож байна.

Сурагч Н.Билгүүн



### Би үлгэр унших дуртай.

Би үлгэрийн номыг сонгон авч уншсан. Энэ номын хавтасны зураг дээр дэлхийн бөмбөрцөг байна. Тиймээс энэ номд олон улс үндэстний үлгэр байгаа гэж бодсон учраас сонгосон юм.

Энэ үлгэрүүдээс Белорус ардын “Хүчээр биш ухаанаар дийлдэг” гэдэг үлгэр надад их зүйлийг бодогдуулсан. Энэ үлгэрт хүн өөрийн ухааны хүчээр баавгайг дийлсэн тухай өгүүлдэг юм.

#### Номын танилцуулга

1. Олон улс үндэстний 77 үлгэрүүд орсон.
2. “Шидэт өнгө” хэвлэлийн үйлдвэр
3. Хэвлэлийн хуудас: 4,04хх
4. Энэ номоо 2 өдөр уншсан.

Сурагч А.Оргил

- 9 Чиний хувьд яаж бичихээр шийдсэн бэ?

### Би юу сурсан бэ?

Өөрийгөө шалгах асуулт	Би хариулъя.	Би дахин судалмаар байна.
Номыг ямар зорилгоор унших вэ?		
Номыг зөв, хурдан, ойлгож уншиж сурсан уу?		
Үгийн утгыг яаж тайлбарлах вэ?		
Үгийн салаа утгыг хаанаас мэдэж болох вэ?		
Уншсан зохиолынхоо сэдвийг яаж тодорхойлох вэ?		
Ярихдаа ойлгомжтой, өөртөө итгэлтэй ярьж чадсан уу?		
Номын танилцуулга яаж бичих вэ?		
Ангийнхандаа уншиж өгөх хэсгийг сонгосон уу?		



## ЗОХИОЛЫН ГОЛ САНААГ ОЙЛГОЖ УНШЪЯ.

Энэ бүлэгт цогцолбор бүрийн утгыг тодруулахын тулд догол мөр гаргадгийг ойлгоно. Утгыг эргэцүүлж, эхийн гол санааг ойлгон, тайлбарлаж сурна. Үйл явдлыг өрнүүлэн, утгын уялдаа холбоотой, холбох үг хэрэглэн, богино өгүүллэг зохиож сурна.



### Цогцолбор бүрийн утгыг ойлгож уншицгаая.

#### Яагаад догол мөр гарган бичдэг вэ?

1 Хоёр эхийг харьцуулж ажиглана уу. Юугаар ялгарч байна вэ? Утгыг ойлгон уншъя.

**А Ном – хүүхдийн дотны нөхөр**

Оросын их зохиолч М.Горькийн “Ном бол ертөнцийг харах цонх мөн” гэж хэлсэн үг биднийг эрдмийн зүг даллан дууддаг билээ. (1)

Сайн номыг мэргэн зөвлөгч, сургаж заах багш, харанхуйд гэрэл, замд нөхөр, идэх хоол, уух ус гэж зүйрлэн хэлдэг. Ер нь ертөнцийн сайхныг юутай ч зүйрлэж болно. Гэхдээ ном бол хүн төрөлхтний бүтээсэн гайхамшиг дундаас хамгийн дээд гайхамшиг нь юм. (2)

Ном үзээд хүн улам ухаажин, алс холыг хардаг билээ. “Чи хэр их уншдагаа хэлбэл би чиний хэн болохыг хэлнэ” гэдэг үг байдаг шүү дээ. Ер нь уншдаггүй хүн бол хэн гэж хэлүүлэх нь тодорхой. (3)

(М.Цэдэндорж)

**Б Ном – хүүхдийн дотны нөхөр**

Оросын их зохиолч М.Горькийн “Ном бол ертөнцийг харах цонх мөн” гэж хэлсэн үг биднийг эрдмийн зүг даллан дууддаг билээ. Сайн номыг мэргэн зөвлөгч, сургаж заах багш, харанхуйд гэрэл, замд нөхөр, идэх хоол, уух ус гэж зүйрлэн хэлдэг. Ер нь ертөнцийн сайхныг юутай ч зүйрлэж болно. Гэхдээ ном бол хүн төрөлхтний бүтээсэн гайхамшиг дундаас хамгийн дээд гайхамшиг нь юм. Ном үзээд, хүн улам ухаажин, алс холыг хардаг билээ. “Чи хэр их уншдагаа хэлбэл би чиний хэн болохыг хэлнэ” гэдэг үг байдаг шүү дээ. Ер нь уншдаггүй хүн бол хэн гэж хэлүүлэх нь тодорхой.

(М.Цэдэндорж)

2 Утгыг тодруулан, ялгааг ярилцъя.

	Хариулт нь аль хэсэгт илэрч байна вэ?	
	А хэсэг	Б хэсэг
Ямар үгийг эрдмийн зүг дууддаг гэж бичсэн бэ?		
Номыг юутай зүйрлэсэн бэ?		
Ном их уншсанаар нь хүнийг таньж болно гэж аль хэсэгт бичсэн байна вэ?		
Дүгнэлт: А, Б хэсгүүд утгын хувьд ялгаагүй байна. /Эсвэл .... ялгаатай байна./		
А, Б хэсгүүд өөр юугаар ялгаатай байна вэ?		
Дүгнэлт:		

3 **Хоёр эхийг дахин харьцуулж, эргэцүүлэе.**

- Уншихад А, Б хэсгийн алинд нь утгын ялгааг тодорхой гаргасан бэ?
- А хэсэгт шинэ мөрөөс эхэлж бичсэний учир юу вэ?
- Гурван хэсэг бүрд илэрсэн утга санаа ялгаатай байна уу?

Эхний хэсэгт  
номын тухай өгүүлсэн  
үг нь эрдэм ном сурах  
хүслийг төрүүлдэг  
тухай бичжээ.

Хоёр дахь хэсэгт  
“Ном бол хүнд хамгийн их  
хэрэгтэй байдаг учраас  
гайхамшиг юм” гэж  
өгүүлжээ.

Гуравдугаар хэсэгт  
ном их уншсанаар хүн  
улам ухаажиж, өөрийгөө  
бусдад таниулдаг  
тухай өгүүлжээ.



Аан, хэсэг бүр нь  
утгаараа өөр учраас  
догол мөрөөс эхэлж  
бичсэн байна шүү дээ.

Тийм байна.  
Тэгвэл санаа бодлоо  
ойлгомжтой илэрхийлэх  
зорилгоор догол мөрөөс  
эхэлж бичдэг  
байна шүү.



**САНАМЖ**

Аливаа мэдээллийг утга агуулгынх нь зааг ялгаа, уялдаа холбоо харгалзан, тодорхой хэсгүүдэд багцлан хуваасныг цогцолбор гэдэг. Цогцолборыг бичигт догол мөрөөр ялгадаг.

**Цогцолбор бүрийн утга санааг ойлгоё.**

1 **Эхийн утгыг ойлгож уншъя.**

**САВЫН ГУРВАН ГЭМ**

Нэгэн талаас багш нь номлох, нөгөө талаас шавь нь ихэд хичээнгүйлэх сайн үйлийн барилдлага тэгш бүрдвээс сая эрдмийн хишиг хүнд тогтдог жамтай. Энэ нь цэвэр ариун, бүрэн бүтэн саванд өрөм загсдагтай адил. (1)

**Нэгэн зүйл:** Номын ширээнд багшийн урд суувч чихээр үл сонсон, өөр юм бодох нь хөмөрсөн тогоонд сүү дүүргэж болдоггүйтэй үлгэр нэг. (2)

**Хоёр зүйл:** Багшийн айлдах номыг чихээр сонсовч хагас хугас тогтоох нь цоорхой тогооноос сүү мөдхөн гоожин дусах мэт. (3)

**Гурван зүйл:** Чихээр сонсовч утгыг үл ухаарах, ухаарлаа ч буруу тогтоох нь бохир тогоонд хийсэн сүү гашлан ээдэж, өрөм цөцгий суудаггүйтэй адил. (4)

Нэгтгэн дүгнэвээс, хөмөрсөн, цоорхой, бохир гурван саванд сүү хөөрүүлж, загсааж болдоггүй. Үүн лүгээ адил багшийн номыг

Сонсдоггүй

Алдаг оног сонсдог

Сонслоо ч утгыг буруу ухаардаг шавь эрдэм сурдаггүй. (5)

(Т.Галсан)

2 **Утгыг нь мэдэхгүй үгээ сонгоорой. Багштайгаа ярилцаарай.**



### 3 Уншсанаа ярилцъя.

1. “Эрдмийн хишиг” гэдгийг та нар хэрхэн ойлгож байна вэ? Эрдмийн хишиг хүнд яаж тогтдог гэж өгүүлсэн бэ?
2. Ямар шавь эрдэм сурдаггүй гэж хэлсэн байна вэ? Хүснэгтэд тулгуурлан, ойлгосноо яриарай.

хөмөрсөн сав	цоорхой сав	бохир сав
ямар шавь?	алдаг оног сонсдог	ямар шавь?

3. Эхийг унших явцад юу бодогдож байв?

4. Зохиогч яагаад “Савын гурван гэм” гэж нэрлэсэн бэ? Юуг хэлж байна вэ? Юунд саад болдог вэ?
5. “Нэг чихээрээ оруулаад, нөгөө чихээрээ гаргадаг” гэсэн нь хэддүгээр догол мөрийн утгатай тохирч байна вэ? Яагаад?

6. Хичээж сурна гэж юу гэсэн үг вэ?
7. Та нарт “Савын гурван гэм”-ийн аль нэг нь байна уу? Хэрэв байдаг бол яаж засах вэ? Зөвлөлдөөрэй.

### Цогцолбор бүрийн утгыг яаж тодруулж сурах вэ?

1. Утгыг тодруулж байгаа хамгийн чухал гэж үзсэн үгсийг тэмдэглээрэй.
2. Утга санааг тодруулсан асуулт зохиогоорой.
3. Юуны тухай өгүүлж байна вэ? гэсэн асуултад хариулж ярилцаарай.

	<i>Чухал санаа байна гэж үзсэн үгээ тэмдэглэе.</i>	<i>Утга санааг тодруулсан асуулт зохиоё.</i>	<i>Хариулъя. (Юуны тухай өгүүлж байна вэ?)</i>	<i>Гарчиг өгье.</i>
Тухайлбал:				
1-р догол мөр	шавь хичээнгүйлэх, эрдмийн хишиг тогтох, цэвэр сав, өрөм загсах	Шавь нь ямар байвал сайн үйл болох вэ? Цэвэр ариун, бүрэн бүтэн сав гэж юуг хэлэв? Өрөм загсах үйлийг юутай зүйрлэсэн бэ? Өрмийг юутай адилтгасан бэ?	Багшийн заасныг хичээнгүйлэн сонсож байвал тэр сайн үйл юм. Тэгж чадсан сурагчийг цэвэр ариун савтай зүйрлэжээ. Тийм тогоонд л өрөм загсдаг шиг сурагчдад эрдэм тогтдог тухай өгүүлжээ. Сүүг олон удаа самарвал өрөм тогтдог шиг багшийн заасныг олон удаа эргэцүүлэн бодвол эрдэм номын утга хүнд хүрдэг байна.	Хичээнгүй хүнд эрдэм тогтдог.
Дараагийн дөрвөн цогцолборын утгыг тодруулаарай. Багаараа хамтран гүйцээн ажиллаарай.				

4 Эхийг уншаад, өөрт төрсөн бодлоо бичжээ. Эхийн гол санааг ойлгосон байна уу? Эргэцүүлээрэй.

**Надад ч бас гэм бий**

*Би зарим үед цоорхой сав шиг байдаг. Заримыг сонсож, заримыг нь сонсохгүй өөр юм бодоод л, хайхрамжгүй суудаг. Энэ нь надад байдаг нэг гэм юм. Миний гэм бусад найзуудад маань ч саад болдог байх аа. Би алдаагаа засна.*


А.Оргил

**Миний гэм**

*Би хичээл дээрээ томоотой суудаг. Манай ангийнхан бас багш маань ч намайг зөв суудаг гэж үнэлдэг. Гэхдээ би багшийн ярьж, зааж байгааг ойлгож сонсдоггүй. Иймээс надад ч бас нэг гэм байна.*

Б.Намуундарь

5 Эхийг зөв, хурдан, ойлгож унших дасгал хийе. Уншихаасаа өмнө нүдний дасгал хийгээрэй.



6 Зөв, хурдан уншсанаа үнэлээрэй.

*Зөв уншилтыг тооцохдоо 1 минутад уншсан зөв үгийн тоог нийт уншсан үгийн тоонд хувааж гаргана. Дараагийн хүснэгтэд алдаатай уншсан үгээ тэмдэглээрэй. Жишээ нь, хэрвээ чи 12 үгийг дараах байдлаар алдаж, хасалт гэж тэмдэглэсэн бол нийт 216 үгээс 204 үгийг зөв уншсан гэж тооцно. Дараа нь 204 үгээ нийт уншсан 216 үгийн тоонд хуваагаад, зөв уншилтаа үнэлээрэй. 97-100% оноо авсан бол “Чадварлаг түвшинд”, 90-96%-ийн оноо авсан бол “Хангалттай түвшинд”, 90%-иас доошоо үнэлэгдсэн бол “Хангалтгүй түвшинд” зөв хурдан уншдаг юм байна гэж өөрийгөө үнэлээрэй.*

Зохиолын нийт үг	....
Минутад уншсан үгийн тоог тэмдэглээрэй.	Хэдэн үг вэ? .....
Ямар нэгэн үгийн авиаг зөв дуудаагүй бол тухайн үгээ хасаарай.	Хэдэн үг вэ? .....
Ямар нэгэн үгийн үсгийг сольж хэлсэн бол тухайн үгээ хасаарай.	Хэдэн үг вэ? .....
Ямар нэгэн үгийн үеийг сольж хэлсэн бол тухайн үгээ хасаарай.	Хэдэн үг вэ? .....
Ямар нэгэн үгийг бүтэн биш, авиа үсгийг хэлээгүй бол тухайн үгээ хасаарай.	
Ярианы хурдаар биш, хэт хурдан буюу амьсгалаа зөв тохируулаагүй уншсан бол дараагийн удаа анхаараарай.	

7 Ойлгож уншсанаа үнэлэхийн тулд өгүүлбэр бүрт 1 асуулт зохион бие биедээ тавиарай.



## Эхийн гол санааг ойлгож, тайлбарлан ярьцгаая.

### 1 Үлгэрийг зөв, хурдан, ойлгон уншиж, догол мөрийг ажиглая.



Уншихын  
өмнө:

#### 1. Дараах үгс ямар утгатай байж болох вэ? Саналаа хэлээрэй.

- номыг **шоголд** хадгалах
- **хөл чинь дөрөөнд**, гар чинь ганзаганд хүрэх
- **гахай явган, нохой нүцгэн** байх
- **жороо** морь
- **бэлгүй** хүн
- **оньсон хөдөлгүүртэй** морь

#### 2. Хэдэн догол мөр байна вэ? Догол мөрүүд утгаараа яаж ялгарч байгааг бодож уншаарай.

### ОЮУНТӨГС ХҮҮГИЙН ҮЛГЭР

Эрт урьд цагт эрээн авдраар дүүрэн эрдэнэс алттай, хар модон шоголд хадгалдаг үлгэр туулийн өчүүхэн номтой нэг айл байжээ. Тэднийх Эрдэнэтөгс, Оюунтөгс гэдэг хоёр хүүтэй юм гэнэ. (1)

Нэг өдөр гэрийн эзэн хүүхдүүдээ дэргэдээ суулган:

- Та нарын хөл чинь дөрөөнд, гар чинь ганзаганд хүрлээ. Тийм учраас бие даан амьдрах цаг чинь болжээ. Маргааш өглөөнөөс эхлэн аавынхаа хөрөнгөнөөс аль дуртайгаа авч, аян замдаа гарч, аж амьдралаа зохио гээд юу авахыг нь асуухад Эрдэнэтөгс хоёр хүүдий дүүрэн алт, Оюунтөгс шоголтой номыг авна гэжээ. Эцэг нь хэлсэн зүйлийг нь хүүхдүүдээ өгч гэнэ. (2)

Тэгээд хоёр хүү аян замдаа гартал ах нь дүүдээ:

- “Ууя ууж болохгүй, идье идэж болохгүй, хэнд ч хэрэг болохгүй хэдэн навсархай хуудас авахаар нэг хүүдий алт авсан бол хоёулаа элбэг хангалуун явахгүй юу. Нэгэнт тэгээгүйгээс хойш өөрт оногдсон хөрөнгийг би чамтай хуваалцаж чадахгүй. Чи наад номоороо амиа тэжээж, хувиа борлуулж яваарай” гэжээ. Харин Оюунтөгс юу ч хэлсэнгүй. Тэд нэлээд явж байтал замд нь адуу хариулж яваа хүн тааралджээ. Ах нь түүнээс жороо саарал морь худалдан авч, “Чи өвөртөө бэлгүй болохоор гахай явган, нохой нүцгэн байх болж дээ” гээд давхиад явчихжээ. (3)

Дүү нь гомдсон ч үгүй, хар шоголтой номоо уншиж явтал оньсон хөдөлгүүр хийсэн хүний тухай үлгэр таарав. Түүнээс санаа авч ойд очиж, оньсон хөдөлгүүртэй морь хийгээд, түүнийгээ хөлөглөн, ахыгаа гүйцэж очвол их л гайхан:

- Ийм ид шидтэй морь ямар мөнгөөр худалдаж авав аа? гэж асуухад нь үлгэртэй номынхоо ид шидээр бүтээснээ хэлбэл үнэмшихгүй байлаа. Тэгээд тэр хоёр цааш аялж гэнэ. Гэтэл төөрчихжээ. Хамаг хоол хүнсээ барж, өлсөж үхэхийн туйлд хүрч гэнэ. Ахад нь хүүдий дүүрэн алт мөнгө байвч түүнийг идэж болохгүй болохоор яах билээ. Дүү нь хар шоголтой номоо уншвал элсэн доогуур хавж ургадаг, хүнсэнд хэрэглэдэг ургамлын тухай үлгэр байж гэнэ. Тэр ургамлыг эрж олоод, хоол хийтэл амттай сайхан болсон тул хоёулаа цадталаа идэж, алжаалаа тайлжээ. (4)

Ах нь:

- Дүү минь, наадах чинь яасан ид шидтэй сайн ном бэ? Үүнийгээ ахдаа уншуулж байгаач. Би ч бас алт мөнгөнөөсөө өгч байя гэвэл дүү нь:

- Эрдэмтэн мэргэдийн цэцэн ухааны дээжис болсон энэ ном эрдэнэс алттай зүйрлэхээргүй үнэтэй зүйл билээ. Тэгээд ч үлгэрт өгүүлж буй баялаг дуусашгүй болохоор би тантай хуваалцахаас юунд дургүйцэх билээ гэжээ. Ингээд ах дүү хоёр номоосоо бүх зүйлийг мэдэж, амар амгалан, элбэг дэлбэг амьдран сууж гэнэ. (5)

(Ш.Цэнд-Аюуш)

## 2 Уншсанаа ярилцъя.

1. Ах дүү хоёрт ямар ямар асуудал тулгарав? Яаж шийдэв?
2. Ах дүү хоёрыг хамт сайхан амьдрахад нь юу тусалсан бэ?
3. Хоёр баатрын нэрийн утгыг ажигласан уу? Яагаад дүүгийнх нь нэрээр үлгэрийг нэрлэв?
4. Уншигчдад юу хэлэхийг хүссэн бэ? Чи яаж мэдэв?
5. Эрдэнэтөгсийг дүүгээсээ ухаан муутай гэж үзэж болох уу? Эсвэл түүнд сайн тал байна уу? Жишээгээр батлаарай.
6. Уншиж байх үед ямар үйл явдал сонирхлыг чинь хамгийн их татаж байсан бэ?
7. Та нарт уншсан номоосоо Оюунтөгс хүү шиг өөрт хэрэгтэй зүйлээ бүтээж байсан тохиолдол бий юу? Тодруулж яриарай.
8. Уншсан номоосоо үлгэр дуурайл авсан хүний тухай сурвалжлан, тэмдэглэл хөтлөөрэй.

## Догол мөрд хуваасны учрыг тайлбарлая.

### 1 Харилцан яриаг уншаад, дүгнэлт хийгээрэй.

*Багш:* - Догол мөр бүр ямар тэмдгээр эхэлж байна вэ?

*Сурагч:* - Зарим догол мөр нь “-” тэмдгээр эхэлсэн байна. Ийм тэмдгээр эхэлж байгаагаараа “Ном-хүүхдийн дотны нөхөр” эхээс өөр байна.

*Багш:* - Энэ тэмдэг ямар үүрэгтэй гэж бодож байна вэ?

*Сурагч:* - Багш аа, догол мөрийг эхлүүлэхийн тулд “-” тэмдэг тавьдаг юм уу?

*Багш:* - Үгүй ээ, баатрын харилцан яриаг тодотгож, догол мөрөөс эхлэхдээ хэрэглэдэг юм шүү дээ. Түүнээс биш шинэ утга илэрхийлсэн цогцолбор эхэллээ гэж ойлгож болохгүй нь байна шүү.



Дүгнэхдээ:

- “-” тэмдгээр эхэлснийг шинэ цогцолбор гэж ойлгож байсан эсэхээ хэлээрэй.
- “Би дээрх харилцан ярианаас ..... ойлгож авлаа” гэсэн өгүүлбэрийн бүтцийн дагуу яриарай.
- Цогцолбор, догол мөр хоёрыг хэрхэн ойлгосноо илэрхийлээрэй.

## Цогцолбор бүрийн утгаас гол санааг тодруулъя.

### 1 Догол мөр бүрд юуны тухай өгүүлж байна вэ? гэдгийг тодруулаарай.

	Утга санааг тодруулах асуулт	Юуны тухай өгүүлж байгааг дүгнэж ярилцъя.
1-р догол мөр	Айлын тухай бичихдээ юу, юуг тодотгосон байна вэ?	Энэ хэсэгт эрдэм номыг биш, алт эрдэнэсийг илүү дээдэлдэг айлын тухай өгүүлжээ. Харин та нар юу гэж дүгнэх вэ?
2-р догол мөр	Аав нь хоёр хүүдээ юу гэж хэлэв? Хоёр хүү нь юугаараа ялгаатай байна вэ?	Сонгосон зүйлийг нь бодвол ах нь ... дүү нь ... хүн юм.
3-р догол мөр	Ах нь дүүдээ юу гэж хэлэв? Хэлсэн үгээс нь ямар хүн гэж дүгнэж байна вэ?	Ахын зан чанарыг тодруулсан цогцолбор байна. Ах нь ...
4-р догол мөр	Дүүгийн зан чанарыг ямар үг, өгүүлбэрээр илэрхийлсэн бэ? Дүү нь номыг уншаад л өнгөрдөг хүн үү? Эсвэл санаа авч, юм бүтээдэг хүн үү? Алт мөнгө, ном хоёрын ялгааг хэрхэн өгүүлсэн байна вэ? Оюунтөгс хүү номоос өөрт хэрэгтэй ямар санаа авав?	Энэ догол мөрд ямар санаа илрэв?
5-р догол мөр	Эрдэнэтөгс юу ойлгож авав? Дүүдээ хэрхэн хандав? Оюунтөгс хүүгийн хэлсэн үгийг юу гэж ойлгов?	Энэ догол мөрд ямар санаа илрэв?

### 2 Эхийн гол санаа нь аль догол мөрд илэрч байна вэ? Яагаад гол санаа гэж үзэв?

### 3 Дараах үлгэрийг зөв, хурдан, ойлгож уншъя.

#### АХ ДҮҮ ХОЁР

Эрт цагт ах дүү хоёр тариа тарьж амьдран суудаг байжээ. Ах нь ганцаар, дүү нь долоон хүүхэдтэй, ам бүл олуулаа. Ах дүү хоёр эв найртай, хамтран ажиллаад, ургацаа адилхан хуваан авдаг байлаа. (1)

Нэг өдөр ах нь “Тариагаа адилхан хувааж авах нь зөв үү? Буруу юу? Дүү минь олон хүүхэдтэй, ам бүл олуулаа тул их талх хэрэгтэй. Дүүдээ нэг бухал тариа нэмж өгье” гэж бодоод өөрийн тарианаас нэг бухлыг аваад, дүүгийнхээ тариан дээр нэмж орхив. Тэр шөнө дүү нь эхнэртээ хэлсэн нь,


-Ахтайгаа тариагаа яг адилхан хуваан авдаг маань буруу юм байна. Ах ганцаараа суудаг. Гэрийн ажилд нь туслах хүн байхгүй юм. Ахад их тариа хэрэгтэй тул нэг бухлыг нэмж өгье гэв. Энэ үгийг сонсоод, эхнэр нь зөвшөөрсөнд нэг бухал тариаг ахдаа нэмж өгөв. (2)

Маргааш өдөр нь үзвээс хэн хэнийх нь тариа яг тэнцүү хэвээрээ байсанд бие биедээ юу ч хэлэлгүй явцгаав. Ингэж хэдэн шөнө бие биедээ тариагаа шилжүүлсээр байжээ. Сүүлд учраа ярилцаж, хэн хэндээ туслах сайхан сэтгэлтэй байдгийг мэджээ. (3)



### Үгийн тайлбар:

Ургац-Өвс ногоо ургамлын гарц,  
ургасан байдал  
Бухал-Бага багаар овоолсон өвс



4 Зөв, хурдан уншсанаа 22 дугаар хуудсанд байгаа хүснэгтийг хэрэглэж, өөрийгөө үнэлээрэй.

5 Уншсанаа ярилцъя.

1. Ах дүү хоёр юу хийдэг байв? Хэн нь ам бүл олуулаа вэ?
2. Тэд ургацаа яаж хуваадаг байв? Энэ хэсгийг уншаад чамд юу бодогдов?
3. Ах нь дүүгийнхээ тухай юу бодов? Түүний бодол зөв байсан уу? Яагаад?
4. Харин дүү нь эхнэртэйгээ юу ярилцсан бэ?

5. Хэн хэнийх нь тариа тэнцүү байгаад байсны учир нь юу байсан бэ?
6. Тэд бие биеийнхээ ямар зан чанарыг мэддэг болсон бэ?
7. 3 цогцолбортой зохиол байна. Цогцолбор бүрт юуны тухай өгүүлж байна вэ?

8. Энэ үлгэрийн гол санаа нь аль цогцолборт илэрч байна вэ? Та нар үлгэрээс юу ойлгов? Дэвтэр дээрээ бичээрэй.
9. Та нар сайхан сэтгэлээр хандаж тусалсан явдлаа бие биедээ яриарай.



### Холбох үгийг зөв сонгон бичицгээе.

1 Холбох үгийг хэрхэн хэрэглэснийг ажиглая.

1. Яагаад зохиолч “бас” гэдэг үгийг ашигласан бэ?

Дүү минь, наадах чинь яасан ид шидтэй сайн ном бэ? Үүнийгээ ахдаа уншуулж байгаач. Би ч **бас** алт мөнгөнөөсөө өгч байя.

2. “Түүнчлэн” холбох үгийн оронд “үүнээс гадна, өөрөөр хэлбэл, үүний үр дүнд, харин, эцэст нь, цаашилбал” гэсэн холбох үгсээс сонгон, солин найруулж уншъя. Аль холбох үг хамгийн оновчтой байна вэ?

Үлгэрт оньсон хөдөлгүүрт морь хийдэг арга байсныг дүү нь уншаад, унах унаатай болжээ. **Түүнчлэн** нэгэн ургамлын тухай олж уншаад, сайхан хоол хүртэл хийж, уншсан номынхоо ач тусыг ахдаа үзүүлэв.

2 Дүрмийг уншин, ойлгосноо яриарай.



### **ДЧРЭМ**

“Түүнчлэн, бас” холбох үгс нь өгүүлбэр ба цогцолборуудыг холбоно. Эдгээр холбох үгийг өмнөх өгүүлбэрийн утга санааг цааш үргэлжлүүлэх болон санааг лавшруулахад хэрэглэнэ. Жишээ нь:

“Савын гурван гэм” эхээс ном сурдаггүй хүнийг гурван төрлийн савтай зүйрлэж өгүүлснийг олж уншлаа. Түүнчлэн амжилттай сурахын үндэс нь багшийн заасныг сайн анхаарч, сонсох явдал гэдгийг сурч авлаа.

### **3 “Ба, бөгөөд, түүнчлэн, бас, боловч” холбох үгийг зөв сонгон бичье.**

1. Санааг үргэлжлүүлж бичихдээ холбох үгээс тохирохыг нь сонгоно уу.
  - Ах нь дүүдээ “Ууя ууж болохгүй, идье идэж болохгүй, хэнд ч хэрэг болохгүй хэдэн навсархай хуудас авахаар нэг хүүдий алт авсан бол хоёулаа элбэг хангалуун явахгүй юу” гэж хэлсэн. ... “Чи өвөртөө бэлгүй болохоор гахай явган, нохой нүцгэн байх болж дээ” гэжээ.
  - Ах нь дүүгээ ийнхүү элдвээр хэлж байсан ..... дүү нь харин дуугардаггүй байв. Энэ нь түүний ахыгаа хүндэлж байсантай холбоотой.
  - “Оюунтөгс хүүгийн үлгэр” нь эрдэм номоос амьдралд хэрэгтэй маш их санааг олж авч болохыг харуулснаас гадна номоос өөрт хэрэгтэй зүйлийг бүтээж байхыг бидэнд сургасан байна гэж бодож байна.  
..... амьдралдаа хэрэг болох зүйлийг зөв сонгохыг сургасан байна.
  - Үлгэрт эрдэм ном, эд хөрөнгө хоёрыг харьцуулж гаргасан учир “Ном .... эрдэнэ” гэдэг гарчиг өгч болно. Эсвэл “Ахын шунал ... дүүгийн ухаан” гэж ч нэрлэж болох юм.
2. “Ба” холбох үгээр холбосон өгүүлбэрийг сонгон, дараах дүрэмтэй холбон тайлбарлая.

### **ДЧРЭМ**

“Ба”, “бөгөөд” холбох үгээр нэг төрлийн үг, өгүүлбэрийг зэрэгцүүлж холбодог.

3. Дээрх таван холбох үгийг яаж сонгосноо дүгнэн ярилцъя.

### **4 Дүрмийг бататгая.**

1. Холбох үг бүрийг хэрэглэн, өгүүлбэр зохион бичнэ үү.
2. Эхний өгүүлбэрийн утгаас таамаглан, өгүүлбэрийг гүйцээж бичнэ үү.
  - Нэгэн талаас багш нь номлох ба...
  - Багшийн урд суувч, сонсдоггүй сурагч байдаг бөгөөд түүнийг....
  - Багшийн ярьсныг сонсдог ч утгыг ухаардаггүй сурагч байдаг бөгөөд...



## Үйл явдлыг өрнүүлэн утгын уялдаа холбоотой богино өгүүллэг зохион бичье.

Нэгэн охин зураг зурах дуртай байжээ. Гэхдээ тэр хаана ч хамаагүй юм зурж, нэрээ бичих дуртай. Нэгэн шөнө унтаж байтал гэнэт шуугиан дэгдэв... (1 дүгээр цогцолбор)

### 1 Зургийг ажиглая. Үйл явдлыг зохион яриарай.

#### Багийн ажил



“Чи хус биш”  
гэж модод намайг  
шоолоод байна.



Нэг хэлийг  
минь өгөөд  
орхи.



Би уг нь тооны  
дэвтэр биз дээ?  
Миний тоонуудыг  
аль.



- Охин юу хийсэн болоод хөнжилдөө шургаад, тэднээс айгаад байна вэ?
- Тэд ямар учраас охинд гомдоллоод байна вэ?

#### Бичих санаагаа олж, төлөвлөө.

### 2 Бие биеийнхээ зохиосныг сонсож, гол санааг тодруулан асууя. Дараах асуултыг хэрэглээрэй.

- Зургийг хараад, ямар асуудлыг чухал гэж үзэж байна вэ?
- Зураг бүрд ямар санаа илрэв?
- Уншигчдад юу хэлэхийг хүссэн бэ?

### 3 Охины зүүдэнд болсон явдлыг зохиож ярьснаа ноороглон бичье.

Бичихдээ Д.Гармаагийн “Дэвтрийн гомдол” зохиолыг сонсоод, бичих төлөвлөгөөгөө гаргаарай.





Төлөвлөн  
бичихдээ:

- Зохиолчийн үгээс гадна өөрийн санаа бодлыг тусгана.
- Таван догол мөрд багтаан бичнэ.
- Сүүлийн догол мөрд гол санаагаа илэрхийлнэ.
- Гурван зургийн үйл явдлыг холбохдоо “тэгээд, тийм учраас, түүнчлэн, бас, харин, эцэст нь” гэх мэт холбох үгийг сонгон хэрэглэж болно.
- Цогцолборуудыг холбохдоо “харин, үүнээс гадна, өөрөөр хэлбэл, эцэст нь” гэсэн холбох үгсээс сонгоно.
- Сонирхол татах үйл хөдөлгөөн, үг хэллэг зохионо.
- Гол санааг илэрхийлсэн гарчиг өгөхдөө “ба” холбох үгийг хэрэглэнэ.

#### **Дараах асуултын дагуу төлөвлөөрэй.**

1. Охинд юу юу тохиолдов?
2. Морь, хус мод, ишиг, могой юу, юу гэж хэлж байна вэ? Охиноос юу хүссэн бэ? Тэд хоорондоо юу гэж ярилцаж байна вэ?
3. Охин хөнжилдөө шургаад байсныг ямар үгээр илэрхийлэх вэ? Зурсан зураг нь амь орж, хүний хэлээр ярихаар охин яах бол? Ямар үгээр илэрхийлэх вэ?
4. Охины зан ааш, сэтгэл хөдлөлийг ямар үгээр яаж илэрхийлэх вэ?
5. Хаана үйл явдлыг өрнүүлэх вэ?

**Сонгох үг:** дуг нойрон дунд, шөнө дундын үед, зүүдэн дунд, мэгдэн сандрах, ерөөнөөсөө зугтаад гармаар, ор хөнжил нь л хань болох шиг, өглөө хурдан болоосой, үстэй толгой арзайх гэх мэт

#### **Санаагаа цэгцэлж, зөв байрлуулъя.**



Бичихдээ:

#### **Шинэ догол мөр эхлэхдээ дараах утгыг гаргана.**

- 1-р догол мөр:** Охин юу хийх дуртай байсан бэ?
- 2-р догол мөр:** Морьтой юу ярив? Охин ямар байдалтай байв?
- 3-р догол мөр:** Хус модтой юу ярив? Охин ямар байдалтай байв?
- 4-р догол мөр:** Ишиг, могой болон тал сахалтай ахтай юу ярилцав? Охин ямар байдалтай байв?
- 5-р догол мөр:** Охин цаашид ямар хүн болохоо яаж хэлэв?

#### **Төлөвлөсний дараа дэвтэр дээрээ ноороглоорой.**

#### **Бичсэнээ хянаж, сайжруулъя.**

1. Гол санаагаа илэрхийлж бичсэн үү?
2. Баатруудын дүр байдлыг дүрсэлж чадсан уу?
3. Цогцолбор бүр утгаараа ялгарсан байна уу?
4. Өгүүлбэр болон цогцолбор холбох үгийг хэрхэн хэрэглэсэн бэ?
5. Цэг, таслалыг зөв хэрэглэсэн үү?
6. Зөв бичих дүрмийн алдаа байна уу? Хэрэв алдаатай бичсэн бол яаж засах вэ?
7. Сайжруулж хичээнгүй бичсэнээ дахин хянаж, найздаа уншиж өгөөрэй.

## Би юу сурсан бэ?

Өөрийгөө шалгах асуулт	Хамгийн сайн чаддаг болсон зүйл	Цаашид яаж сайжруулах вэ?
Ямар аргаар догол мөр болгосон бэ?		
Үйл явдлыг өрнүүлэн богино өгүүллэг зохиож чадсан уу?		
Цогцолбор бүрийн утга санааг ойлгож уншсан уу?		
Эхийн гол санааг эхлэл, гол, төгсгөл хэсгийн алинаас нь илрүүлсэн бэ?		
Гол санааг илэрхийлж ярьж, бичиж чадсан уу?		
Холбох үгийг яаж сонгосон бэ?		
Эх зохиохдоо ямар үг хэрэглэсэн бэ?		
Чамд ямар бэрхшээл байна вэ?		

### Өөрийгөө үнэлсний дараа юу хийх вэ?

1. Сайжруулах зүйлээ сонгон, багшаасаа тусламж хүсээрэй.
2. Амжилтад хүрэхийн тулд холбогдох дасгалыг ажиллаарай.

.....

Би Булган аймгийн хүн. Аймгийн төвд манай гэр хамгийн доод захад, харин сургууль хамгийн дээд захад байдаг болохоор бараг нэг цаг алхаж хүрдэг, автобус ч гэж байгаагүй. Тэр үед мөнгө төгрөг муутай байсан ч замд байдаг номын дэлгүүрээр байнга ордог, ном авч унших сан гэж их боддог байлаа. Нэг өдөр манайд аавын дүү Галсанжамц гэдэг хүн ирээд хуруу зүсэм аравтын улаан дэвсгэрт өгөөд “За, ах нь чихэр ч авчирсангүй, миний дүү ном авч уншаарай” гэв. Тэгээд маргааш нь нөгөө хорхой хөдлөөд байсан номоо худалдаж аваад, сургууль хүртлээ уншаад дуусгалаа. Ангийнхаа хүүхдүүдэд “Энэ гоё ном байна” гэсэн чинь манай ангийнхан надаас тэр номыг худалдаж авлаа. Би ном зарсан мөнгөөрөө дахин шинэ ном худалдан авч уншаад л бүтэн жилийн турш тийм маягаар номын мухлагийн бүх номыг авч уншиж билээ. Ердөө л аравхан төгрөгөөр шүү дээ. Тэр надад маш хүчтэй нөлөөлсөн. Хүүхэд байхдаа ямар талх идэж байснаа санадаггүй, харин ямар ном уншиж байснаа би мартдаггүй. Ном гэдэг бол миний сэтгэлд мөнх үлдсэн юм. Баатрууд нь ч амьд үлдсэн байдаг.

(Хүүхдийн зохиолч Ж.Дашдондог)

- 1 Эхийг утгаар нь догол мөр болгон хуваана уу. Яаж ийнхүү догол мөр болгон хуваасан бэ?
- 2 Цогцолбор бүрийн утга санааг тодруулж бичнэ үү.
- 3 Эхийн гол санаа хэддүгээр догол мөрд илэрсэн байна вэ? Яагаад гол санаа гэж үзэв? Жишээгээр батлан, тайлбарлан бичээрэй.
- 4 Эхэд гарчиг өгөөрэй.

# 4

## ГОЛ САНААГ ОЙЛГОЖ, ҮНДЭСЛЭЛТЭЙ ТААМАГЛАЖ СУРЪЯ

Утгыг эргэцүүлж, эхлэл, гол, төгсгөл хэсгүүдээс гол санааг ойлгож, тайлбарлаж сурна. Эхээс ойлгосон зүйлээ ойлгомжтой илэрхийлж сурна. Үйл явдлыг таамаглахдаа эхлэл юм уу гол хэсгээс үндэслэн, холбох үгийг зөв хэрэглэн бичнэ. Балархай эгшгийн эгшигжүүлэх, зөөлрүүлэх үүргийг мэдэж, зөв бичиж сурна.



Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгүүдээс гол санааг ойлгож уншъя.

### 1 Эхийн үйл явдлыг уншиж, ойлгоё.



Уншихын  
өмнө:

1. Дараах эх 5 догол мөрөөс бүтнэ. Гэвч хэн нэг нь 4 догол мөр болгоод биччихжээ. Уншаад, зөв болгоорой.
2. Ногоон өнгөөр тодруулсан үгийн утгыг багштайгаа хамтран тайлбарлаарай. Жишээ нь:  
**Улаан зам дээр** - “Амьтан хүний улаан зам дээр хамаагүй засчихсан гэж бичсэн тул “амьтан ч явдаг, хүн ч явдаг тэр зам дээр нь, тэр газар” гэсэн утгатай байх.

### БУСДЫН ТУС БАГАДАХГҮЙ



Амьтан хүний улаан зам дээр хамаагүй засчихсан гэнэн хөөрхий болжморын үүр. Үүрэнд гүрдгэр нарийхан хүзүүгээ өрсөлдөн сунгаж, эвэр шаргал амаа ангайн хоол горьдох дөрвөн хөөрхөн ангаахай. Ангаахайны хажуухан талд толгой нь эгц дээшээ цогнойсон алд хэрийн урт цэвдэг эрээн могой. Могойны яг дээр дэлэм хүрэхтэй үгүйтэй зайд хий агаарт дүүжлэгдсэн мэт жиргэх ганц болжмор. Гайд учирсан ганц

нөхрөө аврах арга олж цөхөн, бусад нь дэмий л хойгуур урдуур нь шумбан нисэж, нэг л жирийн бус шулганалдана. (1)

Ийм нэгэн дүр зургийг хоньчин хүү гэнэт хараад, гайхан зогтусаж, эхлээд учрыг ухаарсангүй, хэсэг зуур ажиглан харав. Хөөрхий болжмор хамаг чадлаа шавхан өөдсөн чинээ далавчаа дэвэн дэвэн зугтаж, амь гарахыг хичээвч чадал тэнхээ нь

улам барагдан, могой тэр хоёрын хоорондох зай багассаар байгааг мэдэв. “Аа, энэ муу могой гэмгүй хөөрхөн болжморыг залгих гэж байгаа юм байна шүү дээ” гэж хүү балчир оюундаа сая л ухаарлаа. (2)

Ямар ч гэсэн болжморыг аврах ёстой гэсэн далд зөн совингоороо юу ч бодсонгүй, яах гэж байгаагаа ч мэдсэнгүй, зүгээр л шилбүүрээрээ могойг ороолгочихжээ. Шилбүүрийн богинохон сур могойг ч онож **базаасангүй**, болжмор, тэр хоёрын дундах зайгаар шурхийн **ширвэн** өнгөрч, цочсон могой гулжгасхийн өвсөн дунд шургаж алга болов. Амь аврагдсан болжмор ч нисэж одов. Ийм нэгэн учрал тохиолдол болж, нэг болжморын амь аварлаа гээд хүү ч нэг их юм бодсонгүй, болох ёстой юм болдог жамаараа л өнгөрөөд, тэгс гээд ор тас мартчихжээ. Тэгтэл хэдэн хоногийн дараа хүү бас л хонио хариулж яваад, ширүүн бороонд хонь нь уруудан сандарчээ. Нэг захыг нь арай чүү тогтооход нөгөө тал нь хошууран уруудаж, ганц хүнд яагаад ч дийлдэхгүй янзтай болов. Гэтэл хэзээ, хэдийд, хаанаас гараад ирснийг бүү мэд олон зуун болжмор **сүрэглэн** нисэж ирээд, бусдыгаа уруу татагч ямаа голдуу тэвчээргүй хэдийн нүд рүү далавчаараа алганд, заримынх нь ам хамрыг тонших гэж айлган, довтолж гарав. Тийм шийтгэл авсан **төлөг, борлон** цочин огло үсэрч, бусдыг уруу татахаа больё гэх шиг ухарч харагдана. Бие жижиг ч ам бүл олон болохоор болжморын довтолгоон тэднийг хөөрхөн **дөнгөж**, хүү ч хонио уруудуулж алдалгүй, бороо өнгөрөөжээ. (4)

Хэл мэдэхгүй хээрийн бяцхан болжмор хүртэл бусдын тусыг марталгүй, хариу тус хүргэж чаддаг юм сан жээ. (5)

Гурав дахь  
цогцолбор  
хаана  
дуусах вэ?

(3.Далхжав)

Нүдэлж, зөв бичье.

засчИхсан, балчИр, тоншИх, цочИн,  
ороолгочИх, мартчИх

**Хэд хэдэн цогцолбортой эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгийг яаж ялган унших вэ? Үүний тулд цогцолборын тухай мэдлэгээ сэргээн саная.**

① **Цогцолбор бүр утгатай байдаг шүү дээ. Ярилцъя, бас бичье.**

1. Эхний догол мөрийн утга санааг зургаар илэрхийлье.
2. Хоёр дахь догол мөрд хүүгийн ямар зан чанар илрэв?
3. Болжморыг хэрхэн аварсныг гурав дахь догол мөрийн өгүүлбэрийг хэрэглэн, ярья.
4. “Сайн санааны үзүүрт шар тос” гэдэг зүйр үгийн утгатай холбон, тайлбар бичье.
5. Зохиолч бидэнд юу хэлэхийг хүссэнийг тав дахь догол мөрийг уншиж, дүгнэн бичье.

② **Цогцолбор бүрд нэр өгч болдог.**



1. Цогцолбор бүрийн нэрийг эх дэх ямар үг, өгүүлбэрээс санаа авч өгснөө тайлбарлая.

1-р догол мөр “.....”

2-р догол мөр “.....”

3-р догол мөр “.....”

4-р догол мөр “Олны хүч оломгүй далай”

5-р догол мөр “.....”

Хүүхдүүд ээ! Манай ангийн Гэрэлсүх бичсэнээ багшдаа үзүүлтэл “Сайн байна. Буруу бичсэн 5 үгийг засчихвал илүү сайн болох нь” гэж хэлсэн гэнэ. Найзад минь туслаарай.

*Дөрөвдүгээр догол мөрд “Олны хүч оломгүй далай” гэж нэр өгөө гэж бодож байна. Учир нь эхэд “Гэтэл хэзээ хэдийд хаанаас гараад ирснийг бүү мэд, олон зуун болжмор сүргэлэн нисэж ирэв. бие жижэг ч ам бүл олон болхоор болжморын довтолгоон тэднийг хөөрхөн дөнгөж, хүү ч хонио уруудуулж алдалгүй бороо өнгөрөөжээ” гэж өгүүлсэн байна.*

2. Найзын маань тайлбарын алдааг засаад, дэвтэртээ бичээрэй.
3. Гэрэлсүхийн бичсэнийг дуурайн, хэсэг бүрд өгсөн нэрээ тайлбарлаарай.

### 3 Цогцолборуудыг гурван хэсэгт хуваая.

Эхлэл хэсэг



Гол хэсэг



Төгсгөл хэсэг

Энхгэрэл ингэж хуваажээ. Тэр, эхлэл, гол, төгсгөл хэсгийг зөв ялгасан уу?

*Эхлэл хэсэгт нэг дэх цогцолборыг орууллаа. Яагаад гэвэл хүү, могойд идүүлэх гэж байсан дөрвөн хөөрхөн ангаахайгаа аврахын тулд эх нь яаж тэмцэж байгааг, бас найздаа туслах гэж хичээж байгаа шувуудын өрөвдөлтэй байдлыг харсан нь дараагийн үйл явдлуудын эхлэл нь болж байна.*

*Харин гол хэсэгт хоёр, гурав, дөрөв дэх цогцолборыг орууллаа. Яагаад гэвэл хүү, хөөрхий шувуудад тусалж, могойг шилбүүрээр ширвэн, хөөж явуулсан ч тус боллоо гэж бодоогүй. Гэтэл хэд хоногийн дараа хүү хонь хариулж яваад, ширүүн бороонд хонио уруудуулж, ганцаараа яаж ч чадахгүй байхад нь өнөөх шувууд тусалж байгаагаар үйл явдал үргэлжилж байна. Хүү, шувуу хоёр бие биедээ тусалж байгаа нь гол хэсэг болж байна.*

*Харин тав дахь цогцолбор нь төгсгөл хэсэг болно. Яагаад гэвэл “Аяганы хариу өдөртөө, агтны хариу жилдээ” бас “Бусдын хэрэг бүтвэл өөрийн хэрэг бүтдэг” гэдгийг баталж, дүгнэсэн хэсэг юм.*

4 Санамжийг уншаад, Энхгэрэлийн бичсэнийг нягталъя.

**САНАМЖ**

Эх нь хэд хэдэн цогцолбороос бүрдэг. Эхлэл хэсэг ихэвчлэн нэг цогцолбороос бүтэх бөгөөд зохиолч юу өгүүлэх гэж байгааг танилцуулдаг.

Гол хэсэгт үйл явдлын өрнөлийг бичдэг. Хоёр ба түүнээс дээш цогцолбороос бүтнэ.

Төгсгөл хэсэг нь ихэвчлэн дүгнэж бичсэн нэг цогцолбороос бүрдэг.

5 Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгийн утгын холбоо хамаарлыг тайлбарлаж бичье.

Эхлээд юу болсон бэ?

Дараа нь юу болсон бэ?

Эцэст нь юу болсон бэ?

Үүрэн дотроо байгаа дөрвөн ангаахайг урт эрээн могой идэх гэж байгааг, бас эх шувуу, түүний найзууд могойг хөөж байгааг хүү харсан.

Эхлээд юу болсноос шалтгаалж дараагийн үйл явдал өрнөсөн үү? Тийм бол тайлбарлаж бичээрэй.

Гол хэсэгт ямар, ямар үйл явдал өрнөснөөс хамаарч, зохиол яаж төгсөв?

6 Энэ хүртэл юу ойлгосноо дүгнэе.

7 Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгүүд утгын холбоотой гэдгийг дараах эх дээр батлан ярьж, бичье.

1. Эхлээд уншъя. Эхийн үйл явдал, агуулга зөв дараалалтай байна уу?

**БААВГАЙГ ШИЙТГЭСЭН НЬ**

Амьтад, тайгын эзний болхи бүдүүлэг байдлыг өөрт нь ойлгуулахыг хэчнээн оролдсон ч тэдний үгийг сонсохыг ч хүсдэггүй байлаа. Аргаа барсан амьтад түүнийг ойн шүүхэд өгчээ. Амьтад, шүүгчид баавгайн талаар зэрэг зэрэг гомдол мэдүүлж гэнэ. Олны өмнө ийм эвгүй байдалд орж үзээгүй тэр гэмээ ухаарч, ичсэндээ нүүрээ хийх газаргүй болов.

Эрт урьдын цагт хөвчийн эзэн баавгай ойн амьтдын амар тайван амьдралд тун ч их саад болдог байжээ. Тэр, аймшигтай чанга хурхирч, мод бутыг хуга гишгэж, шувууны үүрийг сүйтгэдэг байлаа.

Ойн шүүхээс баавгайд бүхэл өвөлжингөө үүрнээсээ гаралгүй унтаж байх шийтгэл оногдуулж гэнэ. Тэр цагаас хойш майга хөлт баавгай өөрийн бүдүүлэг зангийн уршгаар хүртсэн шийтгэлээ эдэлж, өвөл ичдэг болсон гэнэ.

(Орос ардын үлгэр)

2. Эхлэл хэсэгт юуг танилцуулав?
3. Гол хэсэгт ямар, ямар үйл явдал өрнөв?
4. Төгсгөл хэсэгт юуг дүгнэв?
5. Эхлэл, гол, төгсгөл хэсэг тус бүр хэдэн цогцолбороос бүтсэн байна вэ?
6. Эхлэл, гол, төгсгөл хэсгийн утгын холбоо хамаарлыг тайлбарлаж бичнэ үү.



## Балархай эгшгийн эгшигжүүлэх, зөөлрүүлэх үүргийг мэдэж, зөв бичиж суръя.

### 1) Дараах тодорхойлолтыг ойлгож уншаарай.

Бид 3 дугаар ангидаа балархай эгшгийн эгшигжүүлэх үүргийг мэддэг болсон билээ. Харин 4 дүгээр ангидаа балархай эгшгийн зөөлрүүлэх, ялгах үүргийн тухай мэддэг болно.

### Өмнө үзсэн дүрмээ сэргээн санаж бататгая.

#### ДЧРЭМ

Балархай эгшиг гэдэг нь үгийн нэгдүгээр үеэс хойш орсон богино эгшгийг хэлнэ. Учир нь үгийг хэлэхэд нэгдүгээр үеэс орсон эгшиг нь тод биш балархай хэлэгддэг байна. Тиймээс балархайшсан богино эгшигтэй үгэнд залгавар залгахад уг балархай эгшгийг гээх болон гээхгүй бичих тохиолдол байна. Энэ нь балархай эгшгийн үүрэгтэй шууд холбоотой юм. Балархай эгшиг 3 үүрэгтэй.

#### 1. Эгшигжүүлэх үүрэг

- Эгшигт гийгүүлэгчийг (м,н,г,л,б,в,р) эгшигжүүлнэ. Эгшигт гийгүүлэгчийн дараа орсон эгшигт гийгүүлэгчийг эгшигжүүлнэ. Жишээ нь, самбар, эмгэн, хэвлэл
- Заримдаг гийгүүлэгчийг (ц,ж,з,с,д,т,ш,ч,х) эгшигжүүлнэ. Заримдаг гийгүүлэгчийн дараа орсон заримдаг гийгүүлэгчийг эгшигжүүлнэ. Жишээ нь, уншиж, батажна, хадат,

#### ДЧРЭМ

Эгшигт болон заримдаг гийгүүлэгчийг эгшигжүүлэх үүрэгтэй балархай эгшгийг гээхгүй. Жишээ нь,

- Засмал-засмалаар, урлаг-урлагаас, нөхцөл-нөхцөлийн, мэддэг-мэддэгээс, асдаг-асдагийн

### 2) Сорил, дасгал ажиллая.

- Балархай эгшиг гэж ямар эгшгийг хэлдэг вэ? Зөв хариултыг сонгоно уу.
  - Үгийн нэгдүгээр үед тод бус хэлэгддэг эгшгийг хэлнэ.
  - Үгийн хоёрдугаар үед тод бус хэлэгддэг эгшгийг хэлнэ.
  - Үгийн хоёрдугаар үед маш тод хэлэгддэг эгшгийг хэлнэ.
- “Эрсдэл” гэдэг үгийн балархай эгшиг нь эгшигт гийгүүлэгчийн дараа орсон заримдаг гийгүүлэгчийг эгшигжүүлж байна.
  - Тийм
  - Үгүй
- Балархай гэдэг үгийн утгыг юу гэж ойлгож байна вэ?
 

.....

Хайлмаг, зөгнөл, цэцэг, бодож, идэш, тусад нь, урлаг, энгэр, үйлдвэр, бодит гэсэн үгсээс заримдаг гийгүүлэгчийг эгшигжүүлсэн үгийг нь олж бичээрэй. “-ийн, -ын, ы, ийг, ыг, г, аар, ээр, оор, өөр, аас, ээс, оос, өөс, ууд, нар” зэрэг залгаврыг залган холбоо үг үүсгээрэй. Холбоо үгээрээ өгүүлбэр зохиогоорой.
- Өмнөө буюу хойноо эгшигтэй бичигддэг эгшигт “м,н,г,л,б,в,р” гийгүүлэгчийг эгшигжүүлсэн үгс олж бичээрэй.

**ДЧРЭМ**

2. Зөөлрүүлэх үүрэг

- Дан гийгүүлэгчийг зөөлрүүлнэ. Ж,ч,ш-ээс бусад гийгүүлэгчийн дараа эр үгэнд орсон “и” богино эгшиг өмнөх гийгүүлэгчээ зөөлрүүлэх үүрэгтэй байна. Жишээ нь, тамир, бохир, тахил, сахил, зарлиг, амин
- Давхар гийгүүлэгчийг зөөлрүүлнэ. Дараалан орсон 2 гийгүүлэгч зөөлөрсөн байвал ард нь “и” богино эгшиг бичдэг. Жишээ нь, анги, горхи, салхи, тархи, сонгино, хонгил, гархи

**ДЧРЭМ**

Зөөлрүүлэх үүрэгтэй балархай эгшиг гээгдэхгүй.

- Тамирын охин, бохирыг угаах, тахилын ширээ, сахилыг хүрт, зарлигийг биелүүл, амины ганц

3 Сорил, дасгал ажиллая.

1. Зөөлрүүлэх үүрэгтэй балархай эгшиг нь гээгддэг.

А. Тийм

Б. Үгүй

2. Балархай эгшиг нь дан болон давхар гийгүүлэгчийг зөөлрүүлдэг. Дүрмээ дахин уншин, худлаа болохыг нотолно уу.

3. Дээрх дүрмийн жишээ болсон холбоо үгийг хэрэглэж, өгүүлбэр зохионо уу.

4. “Ажил, анчин, мөчир” гэсэн үгсийн балархай эгшиг нь зөөлрүүлэх үүрэгтэй эсэхийг ярилцана уу.

5. “Зовхи, хумхи, хамхи, урхи, хуанли, цорги, гулги, турги, банди, онги, уушги, туурви, гортиг, гантиг, янгир, мангир, шарвин” үгсийн утгыг “Тайлбар толь бичиг”-ээс мэдэн, өгүүлбэр зохион бичээрэй. Бичихдээ дараах залгавруудаас сонгоорой.

“-ийн, -ын, ы, ийг, ыг, г, аар, ээр, оор, өөр, аас, ээс, оос, өөс, ууд, нар”

4 Сорил, дасгал ажиллая.

1. Дараах үгсээс аль нь хэлний үзүүрийн “н”-тэй үг вэ?

А. хоног, энэрэх, бодно, байшин, эмийн сан

Б. эрдэнэ, алтан, худаг, хулгана, заан

В. инээ, зөнө, онох, сөнөсөн, энэ

2. Ялгах эгшиг гэж ямар эгшгийг хэлэх вэ?

.....

3. Тун-туна, эн-энэ, бөхөн-бөхнө, ялаг-ялга, шуурга-шуураг, тулга-тулаг, авга-аваг, отго-отог, дүүрэн-дүүрнэ, доголон-доголно, хашин-хашна гэсэн үгсийн утгыг тайлбарлан, өгүүлбэр зохионо уу.

4. “-ийн, -ын, ы, ийг, ыг, г, аар, ээр, оор, өөр, аас, ээс, оос, өөс, ууд, нар” гэсэн залгавруудаас зөвийг сонгон, нугас, нуга, нутаг, сан, тугал, хулгана, оготно гэсэн үгэнд залгаж, дүрмийг тайлбарлаарай.

5. Дараах үгсэд ялгах эгшиг нэмж, үйл үг болгоод, утгыг тайлбарлаж бичээрэй.

	Үйл үг болгосон нь	Ялгах эгшгийг тэмдэглэсэн нь	Утгыг тайлбарлаж бичсэн нь
дэлдэн			
өвчин			
удаан			
өргөн			
хорин			





## Эхийн үйл явдлыг таамаглан уншицгаая.

### 1 Зөв, хурдан, ойлгож уншъя.



Уншихдаа:

- Эхийн үйл явдлын дэс дарааг ажиглаарай.
- Эхний үйл явдал болоогүй бол дараагийн үйл явдал болох уу? Бодъё.
- Мэдэхгүй үгээ тэмдэглэе.

### ТАГТААНЫ БЭЛЭГ

Энэтхэгийн нэгэн жижигхэн тосгонд Кижаван хэмээх ядуу тариачин эр амьдардаг байжээ. Хэдийгээр ах дүү, хамаатан садан байхгүй ч тэр ер гутардаггүй, харин ч тосгоныхонтойгоо эвтэй байдаг ажээ. Тэр ч байтугай тосгоны ойролцоох ойн ан амьтан, шувуудтай хүртэл амархан нөхөрлөчихнө. Учир нь тэр, амьтдын хэлийг сайн мэддэг гэнэ.

Нэг удаа тэр маш их өлсөж, гэрт нь идчихмээр юм юу ч байгаагүй тул саваа модоо тулсаар ой руу явлаа. Ойгоор тэнэж тэнэж, юу ч олоогүй тул арга буюу гэрийн зүг буцав.

Гэтэл “Надад туслаач” гэх дуу гэнэт сонстов. Кижаван эргэн хартал зам дээр өд сөд нь өрвийж сөрвийсөн нэгэн тагтаа байж байх нь тэр. Тагтаа, түүнд хандан:

- Надад туслаач. Би нисэж чадахгүй нь гэж өрөвдөлтэйгөөр хэлэв. Кижаван тагтааг ихэд өрөвдөж, энгэртээ энхрийлэн тэвэрсээр, гэртээ ирж, тагтааг орон дээрээ тавив. Тэгээд:
  - Эрүүл саруул болтлоо манайд амьдар даа. Би чадах бүхнээрээ л чамд туслах болно. Харамсалтай нь одоо надад чамайг хооллочих юм алга даа гэж хэлтэл тагтаа:
  - Битгий гутар даа. Ойн гүнд манго жимсний нэгэн том мод бий. Түүний хонгилд тутарга бий. Түүнийг аваад ирээч гэв.

Кижаван ч ой руу яаран явж, өнөөх манго жимсний модыг хайсан ч олсонгүй. Арга мухардсан тариачин эр нэгэн модны хожуул дээр амрахаар суутал өнөөх мод яг өмнө нь байж байх нь тэр. Кижаван баярлан, хонгил руу нь шагайвал тэнд атгахан будаа, эргэн тойронд нь дүүрэн алт эрдэнэс байв. Тэр, эрдэнэсийг сэтгэл хангалуун ширтэн “Яагаад би эрдэнэсийг авах ёстой гэж? Өөрийгөө л гоёхын тулд уу?” гэж бодсоноо зөвхөн будааг нь аваад, буцлаа.

Гэртээ харьтал дахиад нэг тагтаа ирчихсэн байлаа. Кижаван шувуудад авчирсан будаагаа бүгдийг нь өгөхөд, тэд ч дуртай нь аргагүй идлээ. Хоёр дахь тагтаа:

- Чи яагаад өөртөө будаа үлдээсэнгүй вэ? гэхэд Кижаван:
- Санаа зоволтгүй ээ. Та нарт л хүрч байвал болно доо гэж тайван гэгч нь өгүүлэв.

Тэгтэл өнөөх тагтаа...

(Энэтхэг ардын үлгэр)



2 Эхийг үргэлжлүүлэн зохиоё.

**САНАМЖ**

Эхлэл хэсэгт дүрсэлсэн гол баатрыг эргэн саная.

**САНАМЖ**

Гол хэсэгт түүнд юу тохиолдсоныг бодоод, яаж төгсгөхөө шийдье.

Хоёр тагтаа яасан бол?

Тариачин эрд юу өгсөн бол?

Юу болсон бол?

Үлгэр яаж төгссөн бол?



Таамаглан зохиохдоо:

1. “Тагтааны бэлэг” гэж нэрлэснийг саная.
2. Хэдэн цогцолборт багтаан, юуны тухай ярихаа төлөвлөө.
3. Үлгэрийн баатруудын хэнд, юу тохиолдож болохыг таамаглая.
4. Цогцолборуудыг холбон ярихдаа “гэтэл, тэгтэл, тэгсэн чинь, тэгэнгүүт, харин, гэхдээ” гэх мэт холбох үгийг хэрэглэе.

Миний найз Хэрлэн зохиохоосоо өмнө ингэж төлөвлөжээ. Яаж төлөвлөсөн бэ? Суралцъя.

**Төлөвлөсөн нь**


Би гурван цогцолборт багтаан үлгэрийг төгсгөнө. Эхний цогцолборт тагтаа ядуу тариачинд өгөх бэлгээ авчрахаар явсан тухай, дараагийн цогцолборт тагтаа, найзуудынхаа тусламжтайгаар бэлгээ олж, тариачинд өгсөн тухай, гурав дахь цогцолборт Кижаван тагтаад тусалсны ачаар сайхан амьдарч байгаа тухай бичнэ. Тэгэхдээ тагтаанд ямар адал явдал тохиолдож болохыг дэлгэрэнгүй бичнэ.

3 Чи яаж төлөвлөв? Ангийнхантайгаа саналаа солилцоорой.

4 Үйл явдлыг таамаглан зохиосноо ярилцъя.

5 Ямар үндэслэлээр ийнхүү таамаглан зохиосон бэ?

6 Өөрийн зохиосныг багшийнхаа уншсан үлгэрийн үйл явдалтай харьцуулан сонсьё.



7 Ижил ба ялгаатай талыг тодруулаарай.



## Сэдвийн хүрээнд яриагаа төлөвлөж ойлгомжтой, цэгцтэй ярьцгаая.

### 1 Зөв, хурдан, ойлгож уншъя.



Уншихдаа:

Дараах асуултын хариултыг бодож уншаарай.

1. Яагаад өнгөөр ялгасан бэ?
2. Сон Ир хүүгийн цэцэг ургаагүйн учир аль хэсэгт тайлагдаж байна вэ?
3. “Цэцэггүй ваар” гэж яагаад нэрлэсэн юм бол? Таамаглан уншъя.

## ЦЭЦЭГГҮЙ ВААР

Эрт урьд цагт цэцэн мэргэн ухаантай нэгэн хаан амьдардаг байжээ. Нас дээр гарсан хаан үр хүүхэдгүйдээ сэтгэл дундуур байдаг байжээ.

Нэг өдөр хаан “Ерөөсөө гүрэн улсынхаа хамгийн үнэнч, шударга хүүхдийг сонгон авч үрчилье” гэж бодоод, бүх хүүхдэд цэцгийн үр тараагаад “Энэ үрнээс хамгийн гоё цэцэг ургуулсан охин, хүүгийн аль нэгийг нь үрчилж авна” гэж гэнэ.

Хүүхэд бүр үрээ суулгаад, өглөө үдэшгүй усалдаг байжээ. Сон Ир хэмээх жаал үрээ хичээнгүйлэн арчилсан ч арав хоног, хагас сар, бүр сар болоход ваартай үр нь соёолсонгүй гэнэ. Сон Ир хүүгийн арга барагдаж, ээжээсээ:

- “Яасан жигтэй юм бэ? Миний цэцэг яагаад ургахгүй байна вэ?” гэж асуужээ. Адилхан санаа зовж байсан эх нь:

- “Өөр шороонд суулгаад үз дээ” гэж зөвлөлөө. Сон Ир өөр хөрсөнд суулгасан боловч бас л ургасангүй.

Тэгсээр байтал хаан, цэцгээ үзэх өдөр болжээ. Хүүхдүүд гоё хувцсаа өмсөж, ваартай цэцгээ барьсаар гудамжинд гарч ирлээ. Хүүхэд бүр өв залгамжлах хунтайж болохыг хүсэж байлаа. Гэтэл юу болсон гэж санана. Цэцгийг харсан хааны царайд баярласан шинж илэрсэнгүй.

Хаан, байшингийн үүдэнд хоосон ваараа бариад, уйлж байгаа Сон Ирийг хараад “Чи яагаад хоосон ваартай байгаа юм бэ?” гэж асуужээ. Сон Ир нулимсаа арчин байж, үрийг яаж суулгасан, яаж арчилснаа яриад, тэр ч байтугай цэцгийнхээ ургаагүй шалтгааныг “Энэ бүхэн бусдын цэцэрлэгт тарьсан алимнаас нэгийг нууцаар авчихсаны цээрлэл байх” гэж хэлэв. Хаан хариултыг сонсоод, Сон Ирийг тэвэрч:

- “За, энэ л миний үнэнч хүү байна!” гэж гэнэ.

Хүмүүс “Хаан яагаад хоосон ваартай хүүг үрчилж авч байгаа юм бол?” гэж шуугилдахад “Олон түмэн минь ээ, хүүхдүүдэд чанасан үр өгсөн юм” гэж хаан тайлбарлаж гэнэ. Хүмүүс, түүнийг сайшаан, толгой дохиход өөр үрээр тарьсан гоё цэцэгтэй хүүхдүүдийн царай ихэд улайсан гэдэг.

(Солонгос ардын үлгэр)

Сайн санааны  
үзүүрт шар тос

Үнэнээр явбал  
Үхэр тэргээр туулай гүйцнэ.

Үг үнэн бол  
Үйлдэл үнэн

## 2 Уншсанаа ярилцъя.

1. Хааны цэцэн мэргэн ухаантайг яаж мэдэв?
2. Өөр үрээр тарьж байхдаа хүүхдүүд юу гэж бодсон бол?

1. Хаан, шударга сайн хүү үрчилж авах болсон ч сэтгэл дундуур үлджээ. Яагаад?
2. Өв залгамжлах хунтайж болохоор шалгарсан Сон Ир хүү баяртай байгаа болов уу? Түүнд ээж нь байгаа шүү дээ.
3. Хаанд хүүгээ үрчлүүлэх болсон ээжийн сэтгэл ямар байх бол?
4. Эхлэл, гол, төгсгөлийн алинд нь хамгийн гол санаа илрэв?

1. Уншиж байхдаа чи Сон Ирд хэрхэн хандаж байсан бэ?
2. Хаан, хүү хоёрын харилцааг чи хэрхэн үнэлж байна вэ?
3. Хэрвээ чи тэр хүүхдүүдийн нэг байсан бол яах байсан бэ?

## 3 Эхээс юу ойлгож авав? Ярилцъя.

Хүмүүс үнэнч шударга занг үнэлдэг.	Бусдыг хуурч мэхлэх нь ичгүүртэй.	Ямар ч шалгуур шударга байх ёстой.
.....	.....	.....

## 4 Бодол санаагаа цэгцтэй илэрхийлэн ярья.



Ярихдаа:

- Ярихын өмнө цэгцэлж бичээрэй. Бичсэнээ өөрийн болгож яриарай.
- Эхний цогцолборт ямар нэртэй, ямар үйл явдалтай эх уншсанаа хэлээрэй.
  - Хоёр дахь цогцолборт хэний хийсэн ямар үйлээс, юуг ойлгож авснаа яриарай.
  - Гурав дахь цогцолборт өөртөө ямар дүгнэлт хийж, цаашид ямар байх тухайгаа, эсвэл хэн нэгэнд юу гэж хэлэхээ яриарай.

## 5 Цэгцтэй илэрхийлэн ярих дасгал ажиллая.

- Монгол ардын үлгэрийг сонсьё.
  - Үлгэрээс юуг ойлгож сурав?
  - Сурсан зүйлээ ойлгомжтой, цэгцтэй ярихад бэлдээрэй.
  - Ярьснаа алдаагүй, зөв бичиж илэрхийлээрэй.

## 6 37 дугаар хуудасны “Уншихдаа” даалгаварт байгаа асуултад хариулж бичье.

# 5

## БАХАРХСАН УТГАТАЙ ЗАХИДАЛ БИЧИЦГЭЭ.

Бахархсан утгатай захидал уншиж, зорилго бүтцийг тайлбарлан ярьж сурна. Бүтцийн дагуу утгын уялдаа холбоотой бахархсан утгатай захидал бичиж сурна. Ингэхдээ холбох үг хэрэглэнэ. Балархай эгшгийн эгшигжүүлэх, зөөлрүүлэх үүргийг мэдэж, зөв бичиж сурна.



Захидлын утгыг ойлгон уншиж, бүтцийг тайлбарлая.

### 1 Ойлгож уншъя.

#### САЙН БАЙНА УУ? ЭЭЖ ЭЭ

*Мөрдөс зүүсэн цэргийн хувцастай ээждээ амрыг эрвэ гэж мэндгилмээр байна. Би ээждээ энэ захидлыг бичих гэж 3 жил бодлоо. Тэгээд зорил гаргаад бичихийг хүслээ. Намайг Мандахбаяр гэдэг. Би одоо 10 настай, 3 дүүтэй айлын том хүү. Аав ээж маань цэргийн хүмүүс байдаг юмаа. Бид зургуулаа амьдардаг.*

*Миний ээж хатуу ганд сахилга бат, дэг журамтай, эмэгтэй хүнд дэндүү их хүндэдсэн хэцүү ажил хийдэг ч гэсэн би ээжээрээ маш их бахархдаг юм. Нэгдүн "Мөрдөстэй эмэгтэйгүүд" гэдэг нэг цуулга уулзалт болоод, тэр үед би Сүхбаатарын талбай дээр ээжийгээ дүрэмт хувцастайгаа жагсаж явахад нь харж билээ. Цэргийн хувцас өмссөн эмэгтэй хүмүүс их гоё харагддаг юм байна лээ. Тэр дундаас миний ээж хамгийн сайхан нь байсан. Яагаад гэвэл миний ээж Арганистан, Судан гээд цэргийн ажиллагаанд зөндөө явсан болохоор энгэрээрээ дүүрэн медаль зүүгээд үнэхээр бахархмаар харагдаж байсан. "Энэ миний ээж" гээд би найзууддаа ямар олон удаа харуулсан гээг. Тэхдээ миний бодлоор ээжид маань байдаг медальнууд дотроос хамгийн гоё нь юу гээг ээжийн маань "Эхийн одонгийн тэмдэг". Энэ тэмдгийг бид дөрвийг төрүүлж, сайн хүмүүжүүлсэн гэж төрөөс өгсөн хамгийн үнэтэй медаль юм байна лээ. Ээж маань энэ одонд их хайртай. Ээжийнхээ тухай бичсэн гинь ямар гоё байна гээг. Ауд маань сэрлээд, нойр ч хурэхгүй ёстой гоё байна.*

*Тэхдээ ээж маань биднийг өсгөх гэж хэгнээн их зөвдөг гээг. Өүү нар маань жөөхон уграас байнга л ажил, гэр гэж гүйж явдаг. Ажил нь ерөөсөө тараадаггүй. Срой ажлаасаа ирэхдээ бидэн рүү байнга яарч, гүйж ирдэг байх аа. Дандаа л хөлөрсөн яарсан ирдэг. Ирэнгүүтээ л бид нарын хоолыг хийгээд л хувцас хунар угаагаад, гэр цэвэрлээд л. Ээж маань "өвдөх ч эрхгүй, үхэх ч эрхгүй" гэж бодож байгаа юм шиг санагддаг юм аа. Бид дөрөв тандаа хэгнээн их хайртайг та өдөөхөндөө мэдэхгүй байгаа байх. Яагаад гэвэл бид дөрөв арай л жөөхон байна. Тун удахгүй ээжийнхээ агийг харуулахаар том том залуугууд болно. Та минь жөөхон л хүлээгнэ.*



*Ээжээ бид тандаа маш их хайртай шүү. Та минь бидний шүтээн юм шүү. Би эмэгтэй хүнийг шүтдэг, би эх хүнийг шүтдэг, би ээжийгээ шүтдэг гэсэн тэр шүлэгд ямар дуртай гээг. Миний бичсэн шүлгийг ээжид маань заавал хургалж уншуулаарай. Өүү нар маань хуртэл хэлж гадахгүй л болохоос надтай санал нэг байгаа шүү ах эгг нар аа. Надад ийм боломж олгосон "Ээждээ захидал бичээрэй" уралдаанд баярлалаа.*

*Нийслэлийн 44-р сургуулийн 5<sup>Б</sup> ангийн сурагч Н.Мандахбаярын ээждээ бичсэн захидал  
2020 оны 01 дүгээр сарын 28*

## 2 Уншсанаа ярилцъя.

1. Захидал хэдэн цогцолбороос бүтсэн байна вэ?
2. Захидлаа яаж эхлэв? Нэг дэх цогцолборт өөрийгөө хэрхэн танилцуулав?
3. Хоёр дахь цогцолборт Мандахбаяр хүү ээжийнхээ юу юугаар бахархсан бэ?
4. Бахархаж байгаагаа ямар үг, өгүүлбэрээр илэрхийлсэн бэ?
5. Та нар хэнээр бахархаж явдгаа бие биедээ яриарай.



## Бахархсан утгатай захидал бичье.

### Бичих санаагаа олж, төлөвлөө.

1. Хэнээр бахархаж бичихээ бодоорой.
2. Захианы эхлэл хэсэгтээ ямар үг хэрэглэн мэндчилэх вэ? Төлөвлөөрэй.
3. Гол хэсэгтээ бахархаж байгаа хүнийхээ юуг онцолж бичихээ төлөвлөөрэй.
4. Захиагаа төгсгөхдөө нэр, он, сар өдрөө бичээрэй.
5. Харин, ийм учраас, цаашилбал, үүнээс гадна, яагаад гэвэл, үүнээс болж зэрэг холбох үгсийг шинэ цогцолбор эхлэхдээ хэрэглэж бичээрэй.

### Төлөвлөсний дараа ноороглоорой.

### Ноороглноо хянаж засаарай.



Засахдаа:

#### Найруулгаа шалгах өөрийн үнэлгээний шалгуур:

1. Бичсэн захидал нь уншихад ойлгомжтой байна уу?
2. Ямар нэгэн үг, өгүүлбэр хасмаар байна уу?
3. Ямар нэгэн үг, өгүүлбэр нэммээр байна уу?
4. Үгийн байрлалыг солимоор байна уу?
5. Үгийг солимоор байна уу?



Засахдаа:

#### Зөв бичгийн дүрмийн засвараа хийгээрэй.

1. Бичсэн ноорогт нь зөв бичгийн дүрмийн алдаатай үг байна уу? Багштайгаа хамтран олоорой.
2. Олсон үг нь ямар дүрмийг зөрчсөнийг бусадтай хамтран хэлэлцээрэй. Ингэхдээ үгийн бүтцээр задална уу.
3. Ямар дүрмийн алдаа хийснээ тайлбарлаж бичээрэй.
4. Зөв болгож бичсэн үгээрээ өгүүлбэр зохиож бататгаарай.

### Зассанаа дахин хуулж, хичээнгүй бичээрэй.





**Балархай эгшгийн эгшигжүүлэх, зөөлрүүлэх үүргийг мэдэж, зөв бичиж суръя.**

**1 Сурсан дүрмээ сэргээн санаж, ярилцъя.**

*Балархай эгшиг гэж юу вэ?*

*Ямар, ямар үүрэгтэй билээ?*

**2 Асуултын дагуу даалгаврыг гүйцэтгэе.**

<i>Харьцуулан уншъя.</i>	<i>Балархай эгшигийг ялган бичье.</i>	<i>Үүргийг сонгон тэмдэглэе.</i>
баг - бага буг- буга	а	А. эгшигжүүлэх Б. ялгах ✓
он (жил) - оно (бай)	....	А. эгшигжүүлэх Б. ялгах
тараг— тарга уураг - уурга	а	А. эгшигжүүлэх ✓ Б. ялгах ✓
сэрх (ямаа) - сэрэх (өглөө) бүрх (малгай) - бүрэх (тараг)	.....	А. эгшигжүүлэх Б. ялгах
сэтгэл, эрдэм, алдар	....	А. эгшигжүүлэх Б. ялгах
амтат, бодож, бусад	....	А. эгшигжүүлэх Б. ялгах
сорви, салхи, тархи таних, урив, хорих, ахиц	.....	Ямар үүрэгтэй гэж бодож байна вэ?

**3 Дээрх асуултын хариуг хамтдаа олцгооё.**

А. Багана дахь үгсийг харьцуулан хэлье. Ямар ялгаа байна вэ?

<i>Яаж хэлэгдэж байна вэ?</i>	<i>Яаж хэлэгдэж байна вэ?</i>
тарх ( сарни, бутар)	тархи (уураг)
савх (хоол идэх)	савхи ( боловсруулсан арьс)
талх ( хүнсний зүйл)	талхи (арьс элдэх багаж)
тарав (хичээл)	тарив (цэцэг)
танах (хасах)	таних (мэдэх)
..... хэлэгдэж байна.	..... хэлэгдэж байна.

**4 Цэгийн оронд тохирох үгийг сонгон бичээрэй. (сорив, харав, соров, харив)**

Тулгаа, дүүгээ дагуулаад гэртээ .....

Тэнгэрт гялалзах оддыг .....

Тамирчид хүч чадлаа ....

Дэлгэр, ундаагаа соруулаар....

**5 Цэгийн оронд тохирох эгшгийг нөхөж бичээд, уншъя. Өгүүлбэр зохиоё.**

арв...н            дорг...х            холх...            сорв...            горх...

сор...х            зор...в            хол...х            тох ...р            тар..в

## Би юу сурсан бэ?

Өөрийгөө шалгах асуулт	Хамгийн сайн чаддаг болсон зүйл	Цаашид яаж сайжруулах вэ?
Эхлэл, гол, төгсгөл хэсгүүдийн алинд нь гол санаа илэрдэг вэ?		
Эхийн үйл явдлыг таамаглахдаа эхлэл, гол хэсэгтэй холбосон уу?		
Эхээс ойлгож, сурч авсан зүйлээ цэгцтэй ярихын тулд юуг анхаарах вэ?		
Бахархсан утгатай захидал бичиж чадаж байна уу?		
Балархай эгшгийн эгшигжүүлэх, зөөлрүүлэх үүргийн тухай юу мэдэх вэ?		
Захидал ямар бүтэцтэй байдаг вэ?		
Чамд ямар бэрхшээл байна вэ?		

### Өөрийгөө үнэлсний дараа юу хийх вэ?

1. Сайжруулах зүйлээ сонгон, багшаасаа тусламж хүсээрэй.
2. Амжилтад хүрэхийн тулд холбогдох дасгалыг ажиллаарай.

### УХААНТ ДАЛАЙН ГАХАЙ

Шинэ Зеландын “Хойд арал” гэдэг газар нэгэн далайн гахай зуны дэлгэр цагаар эрэг орчмоор эргэлдэж, тэнд сэлж байгаа хүмүүстэй тоглоно. Зан сайтай энэ хөөрхөн амьтныг Моко гэж өхөөрдөн нэрлэжээ.

Нарны гэрэлд далайн ус нүд гялбуулсан нэгэн тогтуун өдөр эрэг дээр олон хүн цуглажээ. Тоглож наадах дуртай Моко ч цагтаа ирлээ. Яг энэ үед далайн эргийн гүехэн усанд хоёр халим өөөдөж, усны гүнд эргэн орж чадахгүй үхэх аюул тулгарчээ. Хүмүүс, хөөрхий амьтдад туслахаар хувингаар ус зөөн, биен дээр нь асгаж байлаа. Тэр хавийн залуус хүчээ нийлүүлэн түлхээд ч аварга амьтдыг усанд нь оруулж чадахгүй байв.

Моко нөхцөл байдлыг дор нь ойлгож, хоёр халимд өвөрмөц сонин дуу чимээ өгөн удирдсаар усанд нь оруулжээ. Хоёр халим Мокогийн дууг сонсон, биеэ мурилзуулсаар их ус руугаа орлоо. Халим, далайн гахай хоёрыг ойлголцож байхад хүмүүс бүгд дуугаа хураан, гайхан биширч байлаа. (‘‘Өдрийн сонин’’-оос 2012.08.20)

- 1 Эхлэл, гол, төгсгөл хэсгүүд утгын холбоотойг батална уу.  
Моко байгаагүй бол үйл явдал яаж үргэлжлэх байсан бэ?  
Гол хэсэг дэх үйл явдал өрнөөгүй бол юу болох байсан бэ?
- 2 “Хэрвээ Моко нэрт далайн гахай туслаагүй бол хүмүүс халимыг яаж аврах байсан бол? Таамаглан зохиож бичнэ үү.
- 3 Цэгийн оронд тохирох эгшгийг нөхөж бичнэ үү.  
хал...м, хув...н, уд...рдсаар, мур...лзуулсаар, сон...н
- 4 Нөхөж бичсэн эгшиг ямар үүрэгтэй вэ? Зөв хариуг сонгон бичнэ үү.  
А. эгшигжүүлэх      Б. зөөлрүүлэх      В. эгшигжүүлэх ба зөөлрүүлэх

# 6

## БАРИМТ НОТОЛГООТОЙ ЯРЬЖ, БИЧИЖ СУРЦГААЯ.

Энэ бүлэгт баримт, үзэл бодлыг ялгаж сурна. Мэдээний бүтцийг мэдэж, зорилгыг тайлбарлаж сурснаар үйл явдлын товч мэдээ бичиж сурна. Хэлэлцүүлгийн явцад бусдын санаа бодлыг анхааралтай сонсож дүгнэнэ. Ойролцоо ба эсрэг утгатай үгийг зөв хэрэглэн, өгүүлбэр зохионо.



### Баримт ба үзэл бодлыг ялгая.

#### Зурагт тулгуурлан ярилцъя.

① Энэ зургийг хараад, чамд ямар санагдаж байна? Юу бодогдож байна?

② Яагаад чи ингэж бодов? Ямар үндэслэлээр ийнхүү хэлж байна вэ?

Үзэл бодлоо илэрхийлэхдээ “итгэж байна, дуртай, санагдаж байна, сайхан байдаг, зөв байна, сайн байна, буруу байна” гэсэн үгийг хэрэглээрэй.

Үзэл бодлоо нотлохдоо “...ийм учраас надад бодогдсон, ...иймээс сайхан байдаг, дуртай байдаг, ...иймийн тул итгэж байна” гэх мэт тулгуур үгийг хэрэглээрэй.



#### САНАМЖ

Үзэл бодол гэдэг нь тухайн зүйлийн талаарх яригч, бичигчийн санал дүгнэлт юм. Ямар нэгэн зүйлийн тухай санал бодлоо өөрийн итгэл үнэмшлээр хэлэх нь чухал шүү.

Баримт гэдэг нь өөрийн санал, үзэл бодлоо нотлох зүйл юм. Өөрөөр хэлбэл баримт нь үнэн худлыг нотолдог. Жишээ нь:

“Манай ангийн Болд хамгийн сайн сурагч” гэж хэлж байгаа нь үзэл бодол. “Тэр бүх хүүхдэд туслахыг хичээдэг, ном их уншдаг, найз нартаа үргэлж сайхан үг хэлж байдаг” гэвэл хамгийн сайн сурагч гэдгийг батлах баримт болох юм.



## Эхээс баримт ба үзэл бодлыг ялган уншицгаая.



Уншихдаа:

- Алдарт зураач гэдгийг нотлох баримтыг хайж уншъя.
- Мэдээ бичсэн хүн зураач Пикассог үнэлснээ яаж илэрхийлснийг бодож уншъя.

### 1 Уншиж ойлгоё.

#### ХАРАНДАА ГЭЖ ХЭЛД ОРСОН ХҮҮ

Би зураг зурах дуртай, уран зургийн үзэсгэлэн үзэх бүр ч дуртай. Тэгээд өөрийн хүндэлж явдаг нэгэн гайхалтай зураачийн тухай та нарт танилцуулахаар шийдлээ.

Хорьдугаар зууны Испаний алдарт зураач Пабло Пикассо нь уран зураг, уран баримал, керамик урлал, тайзны чимэглэлийн ур чадвараараа дэлхийн сая сая хүмүүсийн сэтгэлд мөнхөрсөн уран бүтээлч билээ. Бяцхан Пикассо лапиз буюу “харандаа” гэсэн испани үгийг “пиз, пиз” гэж товчлон давтсаар хэлд орж, аав ээжийгээ гайхшируулж байсан гэдэг. Уран зургийн сургуульд багшилдаг байсан аав Бласко нь хүүгээ долоон нас хүрмэгц зургийн хичээл зааж эхэлжээ.

Нэгэн удаа хүү аавынхаа зурж байсан тагтааны зургийг гүйцээгээд зурчигжээ. Түүний зурсан арга барил өвөрмөц байсан учир аав нь хүүдээ мэхийн ёсолж, хүндэтгэл үзүүлээд, тэр цагаас хойш аав нь дахин зураагүй гэнэ.

Аав нь хүүгээ 16 нас хүрэхээр нь Мадрид хотод байдаг зургийн сургуульд элсүүлжээ. Тэр 1894 оноос эхлэн мэргэжлийн зураачийн ажлаа эхэлсэн гэдэг. Амьдралынхаа туршид 1885 уран зураг, 1228 уран баримал, 2880 керамик, 12000 хар зураг, хэдэн мянган хэвлэлийн бар, хивс урлан бүтээсэн байна. Тэдгээрээс 14 настайдаа өөрийн хайртай дүү Лоладаа зориулан зурсан “Авга эгч Пепа” гэдэг зураг нь Испаний уран зургийн түүхэн дэх гайхамшигт бүтээлээр нэрлэгджээ.

Хүүхдүүд та нарыг ч гэсэн түүний зургийг хараад, бусдын адил гайхан биширнэ гэдэгт би итгэж байна. Хүүхэд бүр багаасаа авьяасаа нээж чадвал дэлхийд гайхагдсан мундаг хүн болно шүү дээ.

(“Өдрийн сонин”-оос 2013.05.31 №138)

### 2 Уншсанаа ярилцъя.

1. Зураач Пикассог “харандаа” гэж хэлд орсон гэж уншаад чи итгэсэн үү? Яагаад?
2. Танилцуулгыг ярьж байгаа хүн эхлэл хэсэгт “гайхалтай зураач” гэж Пикассог хэлсэн шүү дээ. Чи түүнтэй санал нэг байна уу? Үнэхээр Пикассо гайхалтай хүн мөн үү? Юугаар батлах вэ?
3. Аав нь хүүгээ сайн зураач болно гэдэгт итгэдэг байсан уу? Чи яаж мэдэв?
4. Эхийн төгсгөл хэсэг дэх өгүүлбэрийг уншаад, баримт, үзэл бодол хоёрын аль нь болохыг хэлээрэй.
5. Хүүхдүүд ээ, та нарын хариулт таны үзэл бодлын баримт болж байгааг анзаарсан уу? Чиний үзэл бодлын баримт болсон гэж үзэж болох уу?



## Хэлэлцүүлгийн явцад бусдын санаа бодлыг анхааралтай сонсож дүгнэе.

- 1 Эхийг зөв, хурдан, ойлгож уншъя. Зөв хурдан уншсанаа 22 дугаар талд буй зааврын дагуу үнэлээрэй.

### НҮҮДЭЛЛЭХ ЁС

Малчид жилийн дөрвөн улирлаа дагаж, нутаг сэлгэн нүүдэг. Булаг шанд, гол горхи, нуур цөөрөмд хог хаях, сүү цагаан идээ, махны шүүс, цус дусаахыг цээрлэнэ. Нүүх өдөр, буух газраа урьдчилан товлож, цэлмэг сайхан өдөр нүүнэ. Хаана буухыг өрхийн тэргүүн мэднэ. Шинэ бууриндаа нартайд очсон байхыг эрхэмлэх тул гэргий нь өглөө эртлэн босож, цайгаа чанан, “өлзийгөө өгсөн нутаг” гэж хангай дэлхийдээ цайныхаа дээжийг өргөдөг.

Ачаалж байх үед гэрийн буурин дээгүүр морь мал гаргадаггүй. Учир нь “Ачаа хазайна. Ачаа туйлна” гэж цээрлэдэг. Тооныг хамгийн сүүлд ачна. Ачаалж дуустал тооныг гэрийн бууринаас гаргах ёсгүй. Аян замд гарахдаа гэрийн бууриа нар зөв тойрно. Гэрийн эзэн хамгийн сүүлд ачаагаа дагаж мордоно. Ачааны өмнө адуугаа, бусад малаа араас нь тууж нүүдэг заншилтай.

Гэрээ нар зөв тойруулж буулгана. Гэр барихдаа ч нар зөв тойруулан, ханаа дугуйлж, туургаа ороон, хошлонгоо татна.

Нүүдлийн замд тохиолдох айл, нүүдэлчдийг хүндэтгэж цай идээгээр угтдаг ёстой. Тэгэхдээ заавал шинэ цай чанаж өгөх бөгөөд цай халааж өгвөл “шинэ буурин дээр удаан тогтохгүй, муу ёр” гэж цээрлэдэг. Замд тааралдсан хүмүүс ачааны баруун талаар зөрж гарах ба баруун хөлөө дөрөөнөөс мулталдаг. Энэ нь бууж хүндэлсэнтэй адил гэж үздэг.

Айлын хуучин буурин дээр буухыг цээрлэдэг. Шинэ буурин дээр гэрийн эзэн түрүүлэн ирж, ачаа хөсгөө тосон авч, унаж ирсэн мориныхоо эмээлийг буурины зүүн талд тавьдаг. Шинэ бууриндаа буугаад, цай идээнийхээ дээжийг хангай дэлхийдээ өргөнө.

Аав ээжтэйгээ ижил нэртэй хүний нэрийг хэлдэггүй. “Ах захаа алдана. Амны хишигт муу” гэж үзэн, “Хэцүү нэрт” гэж дуудна. Аав ээжийнхээ эд хэрэглэлд зөвшөөрөлгүй хүрдэггүй.

(“Ёс заншлын тайлбар толь”-оос)

**гэрийн буурь** - гэрийг барих суурь ором газар

**өлзийгөө өгсөн нутаг** - ээл ивээлээ өгөх

**хошлон** - эрчтэй дээсийг хоёр, гурваар нь зэрэгцүүлэн оёсон гэрийн бүслүүр

**дөрөө** - эмээлд зүүж гишгэн мордох төмрөөр хийсэн хэрэглэл



**2 Уншсанаа ярилцъя.**

1. Малчид хэзээ нүүдэг байв?
  2. Нүүдлийн үеийн өрхийн тэргүүн, гэрийн эзэгтэй нарын үүргийг хэрхэн бичсэн байна вэ?
  3. Усанд юу юу дусаахыг цээрлэдэг байв?
  4. Замд тааралдсан хүмүүс нүүдэлчдийг хэрхэн хүндэтгэдэг вэ?
  5. Шинэ буурин дээр ирээд өрхийн тэргүүн, гэрийн эзэгтэй нарын хийдэг үйлийг хэлнэ үү.
6. Яагаад нутаг сэлгэн нүүдэг байв?
  7. Ачаалж байх үед гэрийн буурин дээгүүр морь мал гаргадаггүйн учир юу вэ?
  8. Нүүдэлчдэд цай халааж өгөх нь зөв үү?
9. Нүүдэллэх ёс заншлаас юу суралцав?

**3 Орчин цагийн нүүдэллэх ёсны талаар хэлэлцье.**

1. Хэлэлцэхээс өмнө дараах шалгуурыг харна уу. Шалгуурт тохируулж бэлдээрэй, хүүхдүүд ээ.

Хэлэлцэх чадвараа үнэлэх өөрийн үнэлгээний шалгуур	Тийм	Үгүй	Цаашид ...ингэж засна
“Нүүдэллэх ёс” эхийн утгыг ойлгосон уу?			
Хэлэлцүүлэгт саналаа нэмэрлэсэн үү?			
Одоо үеийн нүүдэллэх ёс заншлын тухай ярихдаа баримт татсан уу?			
Хэлэлцүүлгийн үеэр бусдынхаа ярьсныг анхааралтай сонссон уу?			
Бусдын ярьсныг дүгнэж чадсан уу?			

**4 Ойролцоо ба эсрэг утгатай үгийг зөв хэрэглэн, өгүүлбэр зохиоё.**

1. Дараах ойролцоо утгатай үгийг тогтоогоорой.  
Нутаг сэлгэн нүүх-нутаг сольж нүүх
2. Дараах үгсээс зөвийг сонгож, өгүүлбэр бүтээгээрэй. Утга нь өөрчлөгдөж байна уу?  
Тооныг хамгийн ..... ачна.

эхэнд

сүүлд

адагт

түрүүнд

төгсгөлд

Аян замд гарахдаа гэрийн бууриа нар.....тойрно.

зөв

буруу

**5 Дүрмээ бататгая.**

1. Эхээс балархай эгшгийн ялгах болон зөөлрүүлэх үүрэгтэй үгийг олж бичээрэй. Дүрмийг нь тайлбарлана уу.
2. Дараах үгсийг зөв болгож бичээрэй. 47 дугаар талд буй эхээс хараарай.  
Булга шанд, гол горих, махний жүүс, мал гаргадгүй, тооныг ачина, ханаа дугуулах, нүүдэлчдыг угтах ёс, ачаа хөсөгөө
3. “Морь” гэдэг үгэнд “-ны, -д, -оос, -оор, -той, -луу, -ийг” гэсэн залгавруудыг зөв залгаж бичээрэй.





## Сонины мэдээ уншиж зорилго, бүтцийг тайлбарлая.

### Ярилцъя.

#### 1 Зурагтын болон сонины мэдээг ямар зорилготой бэлтгэдэг вэ?

Үзсэн харснаа  
бусдад түгээхийн  
тулд...

Бусдад сургамж  
өгөхийн тулд...

Бусдын хийсэн сайн  
үйлээр бахархахын  
тулд...

Чи юу гэж бодож  
байна вэ?

Найзууд чинь юу  
гэж хэлэв?

#### 2 Уншиж ойлгоё.

#### 3 Энэ мэдээ ямар зорилготой вэ? Хэлэлцье.

### “МОРЬТОН МОНГОЛ” АЯЛАЛД ГАРНА

Хүлгийн сайнаар дэлхийг эзэлж явсан эзэн Чингис хааны үр сад морио эмээллэн, эх орноо нар зөв тойрохоор зэхэж буй.

Хагас жил орчим үргэлжлэх энэ аялалд МУБИС-ийн газар зүй, аялал жуулчлалын гуравдугаар дамжааны оюутан М.Батчулуун, Ц.Даваахүү, Н.Ганзориг, “Монгол фото” студийн зурагчин Ч.Ганболд, “ETV” телевизийн зураглаач Д.Нацагдоо нар оролцож, хилийн дагуу 8538 км замыг мориор туулах юм.

Тэд Цонжин болдог дахь Чингисийн морьт хөшөөний өмнө нээлтээ хийж, 5-р сарын 14-нд Өмнөговь аймгийн Шивээ хүрэнгийн боомт, Овоотын отрядаас аяллаа эхлүүлэх ажээ. Энэ аяллаар 16 аймгийн 100 гаруй сумыг дайран өнгөрөхөөр төлөвлөжээ.

Энэ аяллын гол зорилго нь монгол хүн, монгол морины тэсвэр хатуужил, монгол уламжлал, зан заншил, өв соёлыг олон түмэнд сурталчлах, кино хальсанд буулган, баримтжуулах зорилготой юм.

(“Зууны мэдээ” сониноос 2014.5.6 №104)

### Мэдээ бичихэд асуулт чухал.

#### 4 Асуултын дагуу ярья.

**Хэн, хэн** аялалд оролцох вэ?

Тэд **юугаар** аялах болов?

**Хэзээ** аялалдаа гарах вэ?

Аяллаа **хаанаас** эхлэх вэ?

Аяллын зорилго юу вэ?

#### 5 Өөрийгөө энэ гайхалтай аялалд оролцоод ирлээ гэж төсөөлье. Аяллынхаа талаар ангийнхандаа, сургуулийнхандаа юу гэж мэдээлэх вэ?

Ярих зүйлээ **хэн, юу, хаана, хэзээ** гэсэн асуултын дагуу бэлдээрэй.

#### 6 “Сурагч” сонинд “Есөн настай хүү томчуудын хамт монгол орноо мориор тойроод ирлээ” гэсэн гарчигтай мэдээ бичье.



## Зорилгодоо тохируулан мэдээ бичигдээ.

### Бичих санаагаа олж, төлөвлөө.

1. Дараах нөхцөлөөс сонгоорой.

Ангидаа болсон үйл явдлаас

Сургууль дээр болсон үйл явдлаас

Аймагтаа юм уу нийслэлд болсон үйл явдлаас

2. Болсон үйл явдлыг эргэцүүлээд, дараах асуултын дагуу хариулж бичээрэй.

Хэн ? .....	Хэзээ? .....	Юуг? .....
Хаана? .....	Юуны учир, яаж? .....	Яа..(в, сан ..), юу болсон бэ? .....

### Санаагаа цэгцэлж, зөв байрлуулъя.



Мэдээ бичихдээ:

- Гарчиг өгнө.
- Эхний хэсэгт яагаад энэ мэдээг бичих болсноо бичнэ.
- Гол хэсэгт ямар үйл явдал хаана, хэзээ, ямар учраас болсныг, хэн хэн оролцсон тухай бичнэ.
- Төгсгөл хэсэгт юу гайхалтай, бахархмаар санагдсанаа бичнэ.
- Эцэст нь овог нэр, он, сар, өдрөө бичнэ.

### Ноороглон бичье.

#### Бичсэнээ хянаж, засъя.

#### Зассанаа дахин, хичээнгүй хуулж бичье.

#### Өөрийнхөө, найзынхаа бичсэнийг үнэлээрэй.

	Маш сайн	Сайн	Засах шаардлагатай.
Мэдээний зорилго	Юуны тухай мэдээлэх гэж буйгаа илэрхийлсэн	Юуны тухай мэдээлэх гэж буйгаа эхлэлдээ биш, гол юм уу төгсгөл хэсэгтээ бичсэн	Юуны тухай мэдээлэх гэж буйгаа бичээгүй
Мэдээний бүтэц	Үйл явдлын товч мэдээ нь /Хэн, хэзээ, хаана, юуг, /юутай, хэнтэй/, юуны учир, юу болсон яав/ гэх мэт 6 асуултад хариулагдахуйц байсан	Үйл явдлын товч мэдээ нь 6 биш 4-5 асуултад хариулагдахуйц бичсэн	Үйл явдлын товч мэдээ нь 6 биш 3-аас доош асуултад хариулагдахуйц бичсэн
Мэдээг сайжруулсан байдал	Ноороглноо засаж дахин хичээнгүй бичсэн	Ноороглоод засаж бичихдээ зөв бичгийн дүрмийн алдаа 2-3 гаргасан	Ноороглоод дахин бичээгүй
Найруулгын хувьд	Ойлгомжтой, үг давтаагүй бичсэн	Үг давтахын оронд ойролцоо утгатай үг хэрэглэсэн	Үг давтаж, нуршиж бичсэн



## Найруулгын алдааг засаж суръя.

### 1 Бид ямар алдаа гаргасан бэ?

Хүүхдүүд ээ, би “Нарны шил” эхээс хэрэгтэй мэдээгээ ялгаад, багшид үзүүллээ.

Би “**Хөх, цэнхэр** нарны шил хүүхэн харааг томруулж, нүдний болрыг гэмтээдэг” гэж бичсэн юм. Гэтэл багш маань “**Хөх, цэнхэр** нарны шил гэж тэмдэглээд, “Чи үгээ буруу байрлуулсан байна. Засаарай” гэсэн. “**Цэнхэр, хөх** нарны шил хүүхэн харааг томруулж, нүдний болрыг гэмтээдэг” гэж бичээд, үзүүлтэл бас л буруу байна гэж хэллээ. Би ямар алдаа гаргасан бэ?

### 2 Харин Чимгээгийн бичсэн мэдээний хоёр үгийг ингэж тэмдэглэсэн байсан. Санамжийг уншаад, ямар алдаа гаргасныг тайлбарлан яриарай.

Нарны шилийг зориулалтын саванд хадгалаарай. Нарны шилийг тогтмол дулаантай газар хадгалаарай. Нарны шилийг 60 хэмээс илүү халсан газар эсвэл машин дотор байнга хадгалж болохгүй.

### 3 Хэрлэнгийн бичсэн мэдээг ч бас найруулгын алдаатай байна гэсэн. Засъя.

Нарны шилийг хямд үнэ, гоё хэлбэрт хууртаж битгий сонгоорой. Сайн чанарын материалаар хийсэн нарны шил тунгалаг байдаг. Тийм шил хараа муутгадаг.

### 4 Бидний алдааг давтахгүйн тулд дараах өгүүлбэрийн алдааг засаарай. Багшийн бичсэн тэмдэглэгээг ашиглаарай.

**Чанартай** нарны шилийг тусгай материалаар хийдэг.

Нүүх өдрийнхөө **өглөө** гэргий нь **өглөө** эртлэн босож, цайгаа чанана.

#### САНАМЖ

Мэдээ бичихдээ нэг үгийг олон давтах, зарим үгийг илүү хэрэглэх, бас буруу байрлуулах зэрэг алдаа гаргахаас сэргийлээрэй. Найруулгын алдааг ийм тэмдгийн тусламжтайгаар засдаг юм шүү.

Үг давтсан бол: хадгалаарай.

Үг илүүдсэн бол: Нарны шил

Үг дутсан бол: Нарны хөх, цэнхэр <sup>өнгөтэй</sup> шил - нарны хөх, цэнхэр өнгөтэй шил

Үг буруу байрлуулсан бол: очсон

Зэрэгцээ үгийн байр солих бол: “**Хөх, цэнхэр өнгөтэй** нарны шил - нарны хөх, цэнхэр өнгөтэй шил



## Ном, сонин, сэтгүүлийн нэрийг том үсгээр эхлэн бичиж суръя.

### 1 Алдаатай бичсэн 3 үг байгааг олж засъя.

Би “алтан цох” сэтгүүл унших дуртай.

Аав маань “хүмүүс” сонин захиалдаг.

Багш “монгол хэл”-ний номоос дасгал ажиллуулав.

### 2 Өөрийн мэдэх сонин сэтгүүл, уншсан номынхоо нэрээс 5, 5-ыг бичээрэй.



## Би юу сурсан бэ?

Өөрийгөө шалгах асуулт	Хамгийн сайн чаддаг болсон зүйл	Цаашид яаж сайжруулах вэ?
Эхээс баримт, үзэл бодлыг яаж ялгах вэ?		
Хэлэлцэхдээ бусдын яриаг анхааралтай сонсож сурсан уу?		
Мэдээ бичихдээ ямар ямар асуулт хэрэглэдэг вэ?		
Мэдээнийхээ найруулгыг яаж засах вэ?		
Чамд ямар бэрхшээл байна вэ?		

### Өөрийгөө үнэлсний дараа юу хийх вэ?

1. Сайжруулах зүйлээ сонгон, багшаасаа тусламж хүсээрэй.
2. Баримтуудыг хэрэглээд, мэдээг гүйцээж бичнэ үү.

## БАГААРАА ОЛОН УЛСЫН ХОЛБООНЫ ДЭЛХИЙН АВАРГА БОЛЛОО

Та бүхэнд “Оюун ухааны академи”-ийн амжилтын тухай мэдээллийг хүргэе.

.....

.....

.....

### Хэрэглэх баримт:

**Хаана:** БНХАУ-ын Жухай хот

**Юу:** Олон улсын ой тогтоолтын холбооны Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн 1

**Хэзээ:** 1-р сарын 29-нөөс 12-р сарын 01-ны хооронд, 3 өдрийн турш

**Хэн:** 12 орны 167 тамирчид

**Юуны учир, юу болов:** Оюуны гал гарсан өрсөлдөөнийг үзүүлж шилдгүүдээ тодрууллаа.

### Үргэлжлэл:

Манай улсыг төлөөлөн 14 тамирчид багш, дасгалжуулагч нарын хамт амжилттай оролцож, 16 алт, 18 мөнгө, 19 хүрэл буюу боломжит 90 медалиас нийт 53 медаль хүртлээ. Бага насны ангилалд Азийн Мастер Ш.Наранбат 1-р байр (4824 оноо), Азийн Мастер Б.Жамбалбаярням 2-р байрт (4207 оноо) тус тус шалгарлаа.

Эх орноо төлөөлөн оролцсон бүх тамирчдадаа халуун баяр хүргээд тэднийг амжилттай бэлтгэсэн багш, дасгалжуулагч нартаа, зарим тамирчдын маань зардлыг ивээн тэтгэж оюунлаг үйлийг дэмжсэн албан байгууллагуудад тамирчид болон гэр бүлийнхнийх нь өмнөөс талархсанаа илэрхийлье.

3. Мэдээг уншаад үзэл бодлоо илэрхийлж бичээрэй. Яаж, ямар үг хэрэглэж илэрхийлэхээ 45 дугаар хуудаснаас дахин уншаарай.
- 4 “Нүүдэллэх ёс” эх дэх өгүүлбэрүүдийн найруулгын алдааг засъя.  
Нар зөв эргүүлж, гэрээ буулгана.  
Тооноо хамгийн сүүлд ачна.  
Хуучин айлын буурин дээр буудаггүй.




## ҮЙЛ ЯВДЛЫГ ӨРНҮҮЛЭН ЗОХИОН БИЧЬЕ.

Зохиолчийн хэлэх гэсэн санааг тунгаан бодож, гол санааг тайлбарлана. Үйл явдлыг өрнүүлэн, утгын уялдаа холбоотой, холбох үг хэрэглэн, богино өгүүллэг зохиож сурна. Хэлэлцүүлгийн явцад бусдын санаа бодлыг анхааралтай сонсож дүгнэнэ. Ж, ч, ш-ийн дараа “и” бичдэгийн учрыг мэдэж, зөв бичих арга барилтай болно.



### Өгүүллэгийн гол санааг ойлгож, утгыг ярилцъя.

- 1 Эхийг зөв, хурдан, ойлгож унших дасгал хийе. Уншихаасаа өмнө нүдний дасгал хийгээрэй.



### ГЭМШИЛ

Дондог хүү гудамжнаас хөөрхөн халтар гөлөг тэврээд иржээ. Хүү нь хөлд орохоосоо л гөлгөнд хайртай хүүхэд байж. Ээж нь хүүгийнхээ сэтгэлийг бодоод “Хүү минь, гараа л сайн угааж, хоолоо иддэг юм шүү” гэжээ. (Эхлэл хэсэг)

Дондог зав л гарвал гөлөгтэйгөө тоглож, орон дээрээ гарган эрхлүүлж, оровч гаравч дагуулна. Ингээд бүр аягатай хоол хувааж иддэг болов. Ээжийнх нь сэтгэл зовж, гөлгийг нь эзэнд нь өгнө шүү гэнэ. Тэгснээ,

-Хүү минь, нохойтой бүү тогло, өвчин халдварлана гэж учирлана.

-За ээж ээ, нохойтой тоглохгүй ээ, гараа угааж хоолоо иднэ гэж Дондог өгүүлнэ. Ээжийгээ ажилд явмагц амласнаа бүр мартаад гөлөгнийхөө ам хамрыг гараараа илж тоглоно.

Тэгтэл нэг өдөр толгой нь өвдөн, үе үе огиулан, хоол идэх дургүй болжээ. Ээж нь хүүгээ эмчид үзүүлэв. Эмч цээжийг нь чагнаснаа,

-Хүү минь, гараа харуул гэлээ. Гар нь хиртэй байв.

-Хүү минь, нохойтой тоглохоос өмнө, хоол унд идэхийн өмнө гараа савантай бүлээн усаар сайн угаасан уу? гэж асуугаад. “Хүүд бохир гарын өвчин хүрчээ. Одоо эмнэлэгт хэвтэж эмчлүүлнэ” гэж эмч өгүүлэв. Ээжийнхээ үгэнд орж, гараа сайн угаасан бол ийм муухай өвчнөөр өвдөхгүй дээ гэж Дондог бодон ихэд гэмшин уйллаа. Тэгтэл эмч,

-Хүү минь, тайвшир. “Гэм нь урдаа, гэмшил нь хойноо” гэдэг юм. Нохойтой бүү тогло, гараа угааж бай, мөдхөн эдгэнэ” гэлээ. Дондог хүү хориод хоног эмнэлэгт хэвтээд гарчээ. (Гол хэсэг)



Тэрбээр нохойд ойртохоо байж, хоол унд идэхийн өмнө гараа савантай бүлээн усаар тогтмол угаадаг болсон байна. (Төгсгөл хэсэг)

(Д.Төмөр)

- 2 Зөв, хурдан уншсанаа үнэлээрэй. 22 дугаар талд буй хүснэгтийг хэрэглээрэй.

### 3 Уншсанаа ярилцъя.

1. Хүү гөлгийг гэртээ хаанаас авчирсан бэ?
2. Ээж нь хүүдээ юу гэж захив?
3. Ээжийнх нь сэтгэл юунаас болж зовов?
4. Хүү юунаас болж өвчин тусав?
5. Нохойтой тоглохоос өмнө Дондог хүү юу хийх ёстой байсан бэ?
6. Хэрвээ чи Дондогийн дэргэд байсан бол түүнд юу гэж хэлэх вэ?
7. Зохиолыг яагаад “Гэмшил” гэж нэрлэсэн бэ?
8. Зохиолын гол санаа нь эхлэл, гол, төгсгөл хэсгийн алинд нь илэрсэн байна вэ?
9. Тэр сайн хүү мөн үү? Та нар юу гэж бодож байна?
10. Нохойтой тоглож байгаа найздаа та нар юу гэж хэлэх вэ?



1. Үхэр тэрэг гэж ямар тэргийг хэлдэг вэ? Зургийг хараад, тодорхойлж яриарай.
2. Үхэр, туулай хоёрын аль нь хурдан бэ?
3. Үнэнээр явна гэдэг нь үнэнч шударга байхыг хэлж байна. Худлаа ярьдаггүй бол хожигдож байсан ч шударга байснаараа хожно гэсэн санааг илэрхийлжээ.

### 1 Домгийг уншаад, зүйр цэцэн үгийн утгыг эргэцүүлье.

#### ҮНЭНИЙ ТУХАЙ ДОМОГ

Урьд нэг лам шавийнхаа хамт суудаг байжээ. Шавь нь багшийнхаа хэлснийг ёсчлон биелүүлдэг үнэнч шударга юм байжээ. Багш лам нь заллагаар юманд явах болж, шавьдаа гэр орныг сайн сахиж байхыг онцлон захижээ.

- Шавь хүү үнэнч шударга тул багшийнхаа хэлснийг сонсоод юу гэж бодсон байж болох вэ?

Шавь нь ч гэрээс холдохгүй чин сэтгэлийг барьж, багшийн захиасыг биелүүлж байв. Багш нь хэд хоноод иртэл авдрынх нь ёроол цоорчихсон, дотор нь нандигнан хадгалсан эрдэнэ алга болсон байв гэнэ.

- Нэг талаасаа шавиа үнэнч гэдгийг мэдэж гэрээ итгэж үлдээсэн байдаг, нөгөө талаасаа эрдэнэ алга болоход шавиас өөр хүн байгаагүй байдаг. Яг энэ үед багш юу бодсон бол? Бодлыг таамаглая.

Тэгээд:

- Миний ховор эрдэнэ алга болсон байна. Чи л алга болгосон. Гэрт чамаас өөр хэн ч байгаагүй шүү дээ гэж шавьдаа тулгахад шавь нь аваагүй учраа өчиж, яагаад эрдэнэ алга болсныг гайхан, сандарчээ. Багш нь:

- Эрдэнэ олж өг. Энэ насны минь ганц хогшил гэж уурсан, уцаарлаж, хүүг хулгайд сэрдэн, эцэст нь зодож, гэрээс хөөсөнд шавь хүү аргагүйдэн, юмаа үхэр тэргэнд ачив гэнэ.

Багшдаа гүтгэгдсэндээ гомдон, бодолд автан явж байтал тэрэгний нь өрөөсөн



дугуй нүх рүү цөмрөн оржээ. Дугуйг нүхнээс татан гаргатал тэргэнд нь дайрагдан нэгэн туулай үхсэн байв гэнэ. Ажиглавал багш ламын эрдэнэ аманд нь зуулттай байх нь тэр. Эрдэнийн үнэрээр туулай авдрыг цоортол мэрсэн юм байжээ. Үүнээс хойш “Үнэнээр явбал үхэр тэргээр туулай гүйцнэ” гэсэн үг гарчээ.

(Монгол ардын домог)

## 2 Уншсанаа ярилцъя.

1. Лам багш хэнтэй амьдардаг байв?
2. Шавийн тухай эхлэл хэсэгт хэрхэн өгүүлэв?
3. Зохиолыг дахин уншаад, хүүд юу тохиолдсоныг өөрийн үгээр бичээрэй.
4. Хүү багшдаа яагаад гомдсон бэ?
5. Багшийнх нь уурласан нь зөв байсан болов уу?
6. Төгсгөл хэсэгт бичсэн “Үнэнээр явбал үхэр тэргээр туулай гүйцнэ” гэсэн үгийн учрыг тайлбарлаарай.

## Уншихдаа төсөөлье. Төсөөлснөө илэрхийлэн ярья.

### УХААНТ ЭЦЭГ

Цэцэрлэгч өвгөн хөвгүүдээ цэцэрлэгийн ажилд сургах сан гэж хүсдэг байжээ. Насан өөд болохын цагтаа өвгөн хөвгүүдээ дуудан ирүүлж:

- За хүүхдүүд минь, аавыгаа өнгөрсний дараа усан үзмийн цэцэрлэгт нуусан юмыг олж аваарай гэж захижээ.

Хүүхдүүд, аавыгаа өөд болонгуут нуусан эрдэнийг нь олох гэж цэцэрлэгийн бүхий л газрыг онгичин ухжээ.

Ийнхүү усан үзмийн газрыг сайтар сэндийлж ухсаны ачаар жимс их ургав. Хүүхдүүд баян чинээлэг, элбэг хангалуун амьдрах болжээ.

(Л.Н.Толстой)

## 1 Уншсанаа ярилцъя.

1. “Усан үзмийн цэцэрлэгт нуусан юмыг олж аваарай” гэсэн өгүүлбэр аавынх нь ямар санааг гаргаж байна вэ? Яагаад аав нь “нуусан юм” гэж хэлэв?
2. Зохиолч уншигчдад юуг хэлэхийг хүссэн бэ? Зүйр цэцэн үгсийг хэрэглэн, ойлгосноо яриарай.

Тэнэг хүн эд хураана  
Ухаант хүн эрдэм хураана

Ажил хийвэл  
Амьдралд тустай

## 2 Төсөөлөн ярья.

1. Хүүхдүүд аавынхаа захисныг сонсоод, юу гэж бодсон бол? Тэдний царай ямар байсан бол?
2. Жимс ихээр ургасныг хараад, юу бодсон бол?
3. Хүүхдүүдийн бодлыг харьцуулаарай.



## Ж,ч,ш гийгүүлэгчийн дараа “и” бичдэгийн учрыг мэдэж, зөв бичье.

### Дасгал ажиллая.

1. “Гэм нь урдаа, гэмшил нь хойноо” гэсэн хэлц үгийн утгыг та нар хэрхэн тайлбарлах вэ? Хүүгийн хийсэн үйлтэй холбон тайлбарлаарай.
2. Дараах 2 хэлц үгийн утга нь дээрх хэлцийн утгатай ойролцоо байна уу? Утгыг тодруулаад өгүүлбэр зохиоходоо хэрэглээрэй.

“Ниргэсэн хойноо хашхирах”

“Өнгөрсөн борооны хойноос эсгий нөмрөөд гүйх”

3. “Гэмшил нь” гэдэг үгийг “гэмшэл” гэж бичиж болох болов уу? Дараах дүрмийг уншаад, утга учрыг нь хосоороо ярилцаарай.

### **ДЧРЭМ**

Үгийн дунд “ж, ч, ш” гийгүүлэгчийн дараа богино эгшиг бичихээр бол зөвхөн “И” бичдэг.

4. Дараах үгсийн тодруулсан үеийг ажиглаарай. Эдгээр гийгүүлэгч үгийн аль хэсэгт орсон байна вэ?

дам**ж**ин аж**и**гла тон**ш**ихыг мө**ч**ир бү**ж**иглэ

Үгийн I үед орсон гийгүүлэгч .....

Үгийн II үед орсон гийгүүлэгч .....

Үгийн III үед орсон гийгүүлэгч .....

5. Цэгийн оронд тохирох эгшгийг нөхөж бичээд, холбоо үгээс сонгон, гурван өгүүлбэр зохиогоорой.

ш..нага долоон од

хаш..н морь

ж..олоо барих

хож..л хоёр тийшээ

ш..рвог амт

хач..н үзэгдэл

ч...хал ажил

анги дэвш..х

6. Дүрмийг уншаад, хэрхэн зөв бичсэнээ нягтлаарай.

### **ДЧРЭМ**

Эр үгийн эхэнд буй ж,ч,ш гурван гийгүүлэгчийн дараа богино “и” эгшиг бичихгүй, а, о, у гурвын нэгийг бичнэ. Жишээ нь, **ш**ар, **ш**ороо, **ш**угам, **ж**аргал **ч**оно

7. Дараах өгүүлбэрээс буруу бичсэн үгсийг олоод, засаад хуулж бичээрэй. Засахдаа ямар дүрэм баримталсныг найздаа хэлээрэй.

Монгол хүн морио магтна

Байшанд багана түшэг

Модчон хүн хөрөөгөө магтна.

Ядрахад нөхөр түшэг

8. Дараах бодомжоос зөвийг нь сонгож, бичээрэй.

А. Үгийн дунд орсон “ж,ч,ш”-ийн дараа балархай эгшиг бичихээр бол “и” бичиж болно.

Б. Үгийн дунд орсон “ж,ч,ш”-ийн ард зөвхөн “и” бичнэ.

В. Үгийн дунд орсон “ж,ч,ш”-ийн ард “и”-гээс өөр эгшиг бичихгүй.

Г. Үгийн дунд орсон “ж,ч,ш”-ийн ард зөвхөн “э” бичнэ.



## Бусдын санаа бодлыг анхааралтай сонсож, дүгнэн ярьцгаая.

### 1 Үлгэрийн утгыг ойлгон, зөв, хурдан уншаарай.

#### ХУЛГАНЫ СУМО

Эрт урьд цагт нэгэн тосгонд ядуу эмгэн, өвгөн хоёр амьдардаг байжээ. Нэг удаа өвгөн уул руу ширэг өвс авчрахаар явжээ. Тэрээр, ширгээ цуглуулчхаад, амрахаар суутал холгүйхэн часхийх чимээ гарав. Өвгөн гайхан чимээ гарсан зүгт дөхөж очтол ойн цоорхойд тарган, туранхай хоёр хулгана барилдаж байна гэнэ.

Өвгөн модны цаана нуугдан, барилдааныг харж суухдаа, туранхайг нь өөрийнхөө гэрийнх, тарганыг нь баян айлын бөх болгон төсөөллөө. Гэтэл гэрийнх нь бөх туранхай болохоор айлын бөх түүнийг амархан гэгч нь тонгороод хаячхав. Өвгөн өөрийнхөө бөхийг унасанд ихэд харамсав.

Өвгөн гэртээ хариад, ууланд болсон явдлаа эмгэндээ ярьж өгчээ. Эмгэн нь:

- Хөөрхий хулгана яасан ч өрөвдмөөр юм бэ дээ? Түүнийг хүчтэй болгохын тулд хоёулаа моти хийж өгье гэж хэлэв. Тэд мотигоо хийгээд, гал зуухныхаа буланд тавьжээ.

Дараагийн өдөр өвгөн ширэг авчрахаар дахиад л уул руу явлаа. Моддын цаанаас час час хийх чимээ гарангуут ойн цоорхой руу дөхөж очвол өнөөх хоёр хулгана барилдаж байлаа. Урьдын адил тэднийг сэмхэн харвал, гэрийнх нь хулгана тийм ч дорой байсангүй, тарган хулганатай ач тач үзэлцэж байна гэнэ. Тэгтэл баяны хулгана, туранхайгаасаа:

- Чи чинь өнөөдөр яагаад ийм хүч чадалтай болж орхио вэ? хэмээн асуув.

- Өчигдөр орой би уул шиг том моти идсэн болохоор бяр хүч орчихлоо хэмээн өвгөний гэрийн хулгана сэргэлэн цовоо дуугаар хариуллаа.

- Тэгвэл би өнөө орой танайд очъё. Чи намайг мотигоор цадтал нь хооллоно биз дээ? хэмээн баяны хулгана асуужээ.

- Энэ тийм ч амархан биш шүү. Манай өвгөн, эмгэн хоёр сайхан сэтгэлтэй ч гэсэн ядуу болохоор мотигоор тэр болгон дайлаад байдаггүй юм. Хэрэв чи цадталаа хооллоё гэвэл ахиухан мөнгө аваад ир л дээ. Тэгэх юм бол манай эмээ өвөө хоёр чамд уул шиг том моти хийж өгнө дөө гэж гэрийнх нь хулгана зальтай нь аргагүй инээмсэглэн хэлж байна гэнэ.

Тэдний ийнхүү ярилцахыг сонссон өвгөн элгээ хөштөл инээжээ. Тэгээд уулнаас түргэхэн бууж, гэртээ ирээд, эмгэндээ болсон явдлыг ярихад эмгэн нь бас чин сэтгэлээсээ инээв. Тэгээд



тэд, гэртээ байгаа бүх будаагаа хамж, хоёр хулганыг хүч чадалтай болгохын тулд олон моти хийж бэлдээд, өнөөх л буландаа тавьжээ. Бас тэдэнд зориулж, улаан даавуугаар фундоси хийж, нямбай гэгч эвхэн, овоолоостой мотиныхоо дэргэд тавив гэнэ.

Орой нь баяны хулгана ууттай мөнгөө үүрсээр өвгөнийд ирэв. Авчирсан мөнгө нь овоолсон мотитой яг адил хэмжээтэй байв. Хоёр хулгана мотигоо яаралгүй амтархан зооглов. Цадталаа идсэн баяны хулгана:



- Боовоор дайлсанд баярлалаа. Та бүхний энэ халамж тусын ачаар маргааш тэмцээн маань улам ч сонирхолтой болох байх. Баяртай гэж хэлээд явлаа.

Маргааш нь өвгөн уул руу их л сэтгэл хангалуун явав. “Өнөөдрийн барилдаан яаж дуусах бол” гэж догдлон бодсоор, барилдаан болдог ойн цоорхойд очлоо. Фундоси өмссөн хоёр хулгана сумо бөхчүүд шиг л харагдаж байлаа.

Өчигдөр оройн идсэн моти нь тэдний бяр тэнхээг улам бүр нэмсэн нь илт бөгөөд

тэд салж нийлэн барилдаж, ноцолдох юм гэнэ. Тэгснээ ахиад л барьцаа тавилцан, эргээд л барилцаж, хэн хэнийгээ дээш өргөж чадахгүй, хүч тэнцүүхэн барилдсаар л байв.

Тэр өдрөөс хойш өвгөн, эмгэн хоёр хулгануудын авчирсан мөнгөний буянаар сайхан амьдрах болсон гэдэг.

*(Япон ардын үлгэр)*

## 2 Уншсанаа ярилцацгаая.

1. Үлгэрийн гол үйл явдлыг цөөн өгүүлбэрээр товчлон бичээрэй.
2. Үлгэрийг уншиж байхдаа чи юу бодож байсан бэ?
3. Та нар хоёр хулганы хэнийг нь дэмжиж байсан бэ? Яагаад? Юуны хүчээр тэр хоёр хүч тэнцүү болов? Хэн яаж нөлөөлөв?
4. Та нар аль дүрд эергээр хандаж байсан бэ?
5. Зохиолч яаж өвгөн, эмгэн хоёрыг аз жаргалтай болгож бичсэн бэ?
6. Туранхай хулгана “Мөнгө аваад ир” гэхэд баян хулгана юу гэж хэлэх байсан бол?
7. Баян хулганыг ууттай мөнгөө үүрээд ирэхэд нь чи юу бодож байсан бэ?

## 3 Ангиараа хэлэлцье. Хэлэлцэх чадвараа 87 дугаар хуудсанд буй шалгуурын дагуу үнэлээрэй.

Хэлэлцүүлгийн сэдэв: “Мөнгө үү? Сайхан сэтгэл үү?”

- Энэ үлгэрт мөнгө бүгдийг шийдэж байна уу? Эсвэл өөр зүйл үлгэрийг өрнүүлж байна уу?



## Үйл явдлыг өрнүүлэн бичицгээе.

**Зохиолын үйл явдал хэрхэн өрнөх талаар зохион ярья.**


**Сонгож төлөвлөө.**

1. Нямаа, ангийнхаа хамгийн сэргэлэн цовоо сурагч. Тэр бүх хичээлдээ сайн сурдаг. Бас спортоор хичээллэдэг, үнэнч шударга, сайхан сэтгэлтэй учир хүмүүс түүнд сайн байдаг. Нэгэн өдөр Нямаагийн ангид шинэ хүү ирлээ...
2. Наран, Цог хоёр эгч дүүс. Наран сайхан сэтгэлтэй, харин Цог хувиа бодсон зантай. Зуны амралтаараа ууланд жимс түүгээд явж байтал мод түүсэн, үзэшгүй муухай хувцастай хүн “Модыг минь аваачихад туслаач” гэж Наранд хэлжээ. Тэр, үлгэрт гардаг хорон санаатан ч юм шиг...
3. Манай анги 36 хүүхэдтэй. Ангийн багш маань их хөдөлмөрч учраас хүнд тустай ажил хийхийг бидэнд үргэлж захидаг юм. Тиймдээ ч бид багшийн шаардлагагүйгээр ангиа сайхан цэвэрлэж, цэцгээ байнга усалж, ажил хийж сурсан шүү. Гэхдээ манай ангид нэг л дутагдал бий...

**Үргэлжлүүлэн ярих үйл явдлаа төлөвлөө.**

1. Сүүлийн өгүүлбэрээс үйл явдлыг ургуулан зохиож яриарай.
2. Үйл явдлын дэс дарааг төлөвлөөрэй.
3. Баатруудад юу тохиолдож болохыг шугамын дагуу төлөвлөж, гарчиг өгөөрэй.

Тухайлбал:



**Зохиолын үйл явдлыг төлөвлөж ярьснаа бичиж эхэлье.**

**Бичих санаагаа олж, төлөвлөө.**

**Хосоороо ажиллая.**

- Ямар утга санаа илэрхийлэх вэ?
- Баатруудын хооронд ямар яриа өрнөсөн байж болох вэ?
- Баатруудын зан чанар ямар байх вэ?
- Баатруудын хувцас, нүүрний хувирал, нүдний харц, гарын хөдөлгөөн нь ямар байж болох вэ? Төсөөлөн бодоод, үгээр илэрхийлээрэй.
- Үйл явдал ямар орчинд өрнөх вэ?

## Санаагаа цэгцэлж, зөв байрлуулъя.

1. Хэдэн цогцолборт багтаан, утга санаагаа илэрхийлэх вэ?
2. Эхлэл хэсгийг хүүхдүүд та нар сонгосон шүү дээ. Харин гол ба төгсгөл хэсэгт ямар үйл явдал өрнүүлэхээ шийдээрэй.




*Би Нямаагийн тухай бичсэн эхлэл хэсгийг сонгон авсан. Гол хэсэгтээ шинэ хүүтэй яаж танилцаж, юуны тухай ярьдгийг бичнэ. Бас бие биедээ тусалж байгаа нэг үйл явдал зохиоё гэж бодож байна.*

*Тэгвэл тэр хоёрт тусалж байгаа өөр нэг хүүхдийн тухай бичнэ дээ.*

*Надад нэг санаа төрлөө. Хэрэв тэр хоёрын санаа нийлэхгүй байвал яах вэ?*

*Болох юм байна. Төгсгөл хэсэгтээ ангийнхан нь тэр гуравт баярлаж гэнэтийн бэлэг барьж байгаагаар бичвэл ямар вэ?*



Хүүхдүүд ээ, Хүслэн, Тэргэл хоёр шиг санаа бодлоо хэлэлцэж, дээрх зааврын дагуу сайн төлөвлөж, ноороглоорой. Энэ хоёрын хэлэлцсэнийг ажиглавал Хүслэн “Жинхэнэ найзууд бие биедээ туслахаас гадна бусдад бас сайн үйлсээр тусалдаг юм” гэсэн гол санааг илэрхийлэхийг зорьжээ. Харин та нар уншигчдад юу хэлэхийг хүсэж байна вэ?

## Төлөвлөгөөний дагуу ноороглоё.

### Бичсэнээ нягтлан сайжруулъя.

#### Яаж зохиосноо эргэн дүгнэе.

#### Хосоороо уншъя.

Өрнүүлэн бичсэн эхийг дараах шалгуураар шалгая.

1. Сонгон авсан эхний цогцолборын утгыг дараагийн цогцолборт холбож чадсан уу?
2. Уншигчдад хэлэх гэсэн санаа зохиосон үйл явдлаар нь тодорхой илэрч байна уу?
3. Баатруудыг өөрийн төсөөллөөр зохиосон уу?
4. Цогцолборыг догол мөрөөс эхлэн бичсэн үү?
5. Цэг, таслалыг зөв хэрэглэсэн үү?
6. Оноосон нэрийг зөв бичсэн үү?
7. Зөв бичих дүрмийн алдаа байна уу?
8. Үгийг олон давтсан, үгийг буруу газар байрлуулсан зэрэг найруулгын алдаа гаргасан уу?

**Бие биеийнхээ бичсэнийг шалгаад, багштайгаа хамтран засаж сайжруулаарай.**





## Дуудлага ижил үгийг зөв бичье.

### 1 Тодруулсан үгсийн утгыг анзаарч, зөв уншъя.

Бусдад тус **хүргэ**.

Миний тус бүгдэд **хүрэг**.

**Төлөг**, борлон болжмороос цочив.

Мэргэн хүн **төлгө** тавив.

**Хүлэг** морьд наадамд уралдана.

Сансрын **хөлөг** тэнгэрт хөөрөв.

### 2 Утгаар нь зөв холбоё.

Өвөөгийн маань **мэргэ** үнэн.

Бичсэн нь гараа дээш **өргө**.

Гөлөг минь яс **мэрэг** дээ.

Шатрын үе бүхэнд **хожив**.

Шатрын **өрөг** бүрт **хожив**.

Шарга азарга бол **хурдан морь**.

Түрүүлж бичсэн нь гараа **өргө**.

Гөлөг яс **мэрэх дуртай**.

Шарга азарга бол алдартай **хүлэг**.

Өвөө маань **мэргэлдэг**.

### Ийм үгийг зөв бичихийн тулд:

**Үгийнхээ утгыг зөв ойлгож, зөв унш.**

Тоосго өрвөл **өрөг**.  
Баруун гараа **өргө**.  
Хоолоо сайн **болго**.  
Бадрал алиалагч **болог**.  
Цаасан шувуугаа **хөөргө**.  
Өвөөгийн **хөөрөг** том.  
Далайн **түвшин** ихсэв.  
Төлөв **төвшин** зантай хүн.

### НҮДЭЛЖ ТОГТОО.

**мэргэ** төлгө  
**хүлэг** морь  
**хөлөг** онгоц  
**бэлэг** дурсгал  
**бэлгэ** тэмдэг  
**билиг** ухаан  
**отго** жинс  
**отог** аймаг

### 3 Дараах үгсийн утгыг тайлбарлаад, өгүүлбэр зохиож бичээрэй.

- ид, эд
- туйлын, туулийн
- шогол, шогло
- хэр, хир



## Би юу сурсан бэ?

Өөрийгөө шалгах асуулт	Би үүнийг чадна.	Би дахин судалмаар байна.
Зохиолыг зөв, хурдан, ойлгон уншиж сурсан уу?		
Асуултад оновчтой хариулж чадсан уу?		
Хэлэлцэх үедээ бусдын үзэл бодлыг хүлээцтэй сонсож чадаж байна уу?		
Бусдын үзэл бодлыг сонсоод, өөрийнхөөрөө дүгнэсэн үү?		
Үйл явдлыг өөрийн бодлоор яаж өрнүүлж бичсэн бэ?		
Тодорхой утга илэрхийлэн бичиж чадсан уу?		
Зөв бичих дүрмийн алдааг олж чадах уу?		

### Өөрийгөө үнэлсний дараа юу хийх вэ?

1. Сайжруулах зүйлээ сонгон, багшаасаа, найзуудаасаа зөвлөгөө аваарай.
2. Бататгах дасгалыг ажиллаарай.

### ЁГТ ҮЛГЭР



Тогос, богширго хоёр нэг өдөр ойд тааралдаж гэнэ. “Чи бол өрөвдөлтэй, азгүй, жижигхэн, саарал өнгөтэй” гэж тогос хэлээд “Над шиг баян, сэтгэл татам, өнгөлөг, том болмоор байна уу?” гэж асууж гэнэ. “Үгүй, би өөрөө өөртөө сэтгэл хангалуун байдаг” гэж богширго хариулав.

Гэтэл нэгэн орой бүргэд хоол хайн, тэдний дээгүүр эргэлдэж эхэлж гэнэ. Богширго жижигхэн, туранхай болохоор нэгэн мод руу нисэн орж халхлагдаж чаджээ. Тогос ч түүнтэй адил нуугдахыг хичээж, нисэх гэсэн боловч өд сөд нь дэндүү хүнд, дэндүү өнгөлөг болохоор бүргэд түүнийг дор нь олж хараад, нисэн ирж, шүүрээд явчихжээ.



(“Өрнө дахины ёгт үлгэр”-ээс)

1. Ёгт үлгэрийн үйл явдлын цаана байгаа далд утгыг хэрхэн төсөөлж байна вэ? Хэрэв хүн бол ямар зан чанарыг дүрсэлсэн бэ?
2. Тогос, богширготой ярилцаж байхдаа царай зүс, нүднийх нь харц ямар байсан бол?
3. Харин бүргэдэд шүүрүүлээд явж байхдаа царай нь яаж өөрчлөгдсөн бол?
4. Богширгын “Би өөрөө өөртөө сэтгэл хангалуун байдаг” гэж хэлснийг тогос сонсоод, юу бодсон байж болох вэ?
5. Тогос шиг тийм зан араншинтай хүнтэй хөрш амьдрах, эсвэл хамт сургуульд сурах ямар байх бол?
6. Ёгт үлгэрийн үйл явдлыг өрнүүлэн зохиож бичээрэй. Богширго цаашид хэнд юу ярих бол?
7. Та нар үлгэрээс ямар сургамж авснаа илэрхийлээрэй.



# МОНГОЛ АМАН ЗОХИОЛООС СУРАЛЦЬЯ.

Энэ бүлэгт зүйр цэцэн үг, “Ертөнцийн гурав”-ын утгыг тайлбарлаж, өөрт хэрэгтэй санааг бодож, ухаарах болно. Онъсогыг таахдаа адилтган дүрсэлснийг тайлбарлана. Үлгэрээс санаа авч, өөрийн төсөөллөөр үлгэр зохионо. “ж”, “ч”, “ш” гийгүүлэгчийн дараа “и” бичдэг дүрмийг мэддэг болно.



## Зүйр цэцэн үгийн утгыг ойлгож уншицгаая.

### 1 Зүйр цэцэн үгийн утгыг ухаарч ойлгон, тайлбарлая.




Зүйр цэцэн үгийн утгыг ярилцаж бичихдээ:

1. Зүйр цэцэн үгийг тайлбарлан яриарай.
2. Тайлбарлан ярьснаа алдаагүй, зөв бичээрэй. Бусдадаа уншиж өгөөрэй.
3. Зүйр үгсээс сонгон өгүүлбэр зохион бичээрэй.

Хийхэд бүү залхуур  
Сурахад бүү мэдэмхийр  
Ажлыг аргаар  
Хэцүүг эвээр  
Ажил хийвэл дуустал  
Давс хийвэл уустал

Ертөнцийн ухаан хүнд  
Хүний ухаан эрдэмд  
Эрдэнэ ховор ч эрвэл олно  
Эрдэм гүн ч хичээвэл сурна  
Эрдмийн их нь сайн  
Бардмын бага нь сайн

Эвт шаазгай  
Буга барина  
Олны хүч  
Оломгүй далай  
Олны хүч эвэндээ  
Олсны хүч эрчиндээ



### 2 Цэгийн онрд эсрэг утгатай үгийг нөхөж бичье.

- |  |                                    |
|--|------------------------------------|
| 1. Сайныг дагавал сарны гэрэл<br>..... дагавал могойн хорлол | 2. Эвлэвэл бүтдэг<br>..... гутдаг. |
| 3. Хагацашгүй ..... нөхөртөө<br>Марташгүй муу үгийг бүү хэл  | 4. Бурууг хэлж<br>..... сонсох     |

### 3 Дээрх зүйр цэцэн үг тус бүрийн утгыг ярилцаарай.

## Эхийг уншъя.

### ТОРХ

Нэгэн хүү дүүрэн тостой торх гэртээ хүргэхээр өнхрүүлж явжээ. Өөд газар торхоо чүү ай өнхрүүлсээр хөтөл дээр гарч ирвэл гэр нь харагдаж байв. "Ингэж биеэ зовоож байхаар өөрийг нь явуулчихъя. Гэрийн гадаа түвэггүй хүрчих биз" гэж бодоод торхоо газрын уруу түлхчихжээ.

Том торх ойж бууж явсаар гэрээс өнгөрч, гүн жалганд тогтов.

Хүү, жалган дотроос торхоо гаргах гэж өдөржин ноцолдоод дийлсэнгүй.



(Д.Давааням)

#### 1 Утгыг тодруулж, асуулт зохион ярилцъя.

Үлгэрлэвэл: Хүүг торхоо газрын уруу өнхрүүлэх үед чи юу хэлэх байсан бэ?

#### 2 Эхийн утгад тохирох зүйр цэцэн үгийг сонгож бичье.

А. Гэм нь урдаа  
Гэмшил нь хойноо

Б. Олон удаа бод  
Ганц удаа хий

В. Сурсан бүхэн эрдэм  
Сураагүй бүхэн балай

Г. Алдыг нь аваад атга дээр нь  
Атгыг нь аваад чимх дээр нь

#### 3 Яагаад энэ үгийг сонгосноо эхийн гол санаатай холбон тайлбарлаарай.

#### 4 Дуудлага ижил үгийн утгыг тодруулан өгүүлбэр зохиоё.

торх-торох, төрх-төрөх, уруу-руу, чимх-чимэх, атгах-адгах

## Эхийг уншъя.

### ОЛЗ

Оготно нүхнээсээ гарч, "Муужгайд харагдах вий" гэж айж явсаар боовны хэлтэрхий олжээ. Олзоо үүрэндээ хүргэх гэтэл хүч дутаж гэнэ. Дааж ядан ноцолдож байтал аалз хүрч ирээд:

- Чи ингэж биеэ зовоож байхаар нөхдөө дуудаж ирүүлээч, чамд амар биш үү? гэхэд

- Аалз чи учрыг мэдэхгүй байна. Нөхдөө дуудвал олзоо хуваах хэрэгтэй болно. Би энэ сайхан зуушийг ганцаараа идэх ёстой гэж оготно учирлав.

Оготно боовны хэлтэрхийг үүрэндээ аваачих гэж ноцолдсоор ядрахын туйлыг үзжээ. Энэ үеэр элээ нисэн ирж, олзны боовыг шүүрэн оджээ.

(Д.Давааням)

#### 1 Утгыг тодруулж, асуулт зохион ярилцъя.

Үлгэрлэвэл: Аалз, оготно хоёрын яриаг уншаад, чи юу бодож байсан бэ?

#### 2 Дээрх эхийн утгад тохирох зүйр цэцэн үгийг сонгоё.

Яагаад сонгосноо тайлбарлан бичье.

А. Олны хүч  
Оломгүй далай

Б. Санаа нь дэлхий  
Чадал нь мэлхий

В. Өөдөө хаясан чулуу  
Өөрийн толгой дээр

Г. Харамласан юм  
Хар нохойны идэш



## “Ертөнцийн гурав”-ын утгыг ойлгож ярилцъя.

1 Багшийн уншсан эхийг сонсож ярилцъя. Үг нөхөж бичээрэй.



Монгол гэр ..... бүслүүртэй Монгол тулга ..... тотготой Монгол эрийн ..... наадам

2 “Ертөнцийн гурав”-ын утгыг бодъё.

*Ертөнцийн гурван хөнгөн*

Урсахдаа ус хөнгөн  
Хийсэхэд өд хөнгөн  
Өргөхөд өвс хөнгөн

*Ертөнцийн гурван баян*

Эрдэм ном дээд баян  
Үр хүүхэд дунд баян  
Эд хөрөнгө адаг баян

3 Ус, өд, өвс гурвыг хөнгөн гэсний учрыг ярилцъя.

Сурагч Мэндээ “Ус зөвхөн урсахдаа л хөнгөн байдаг. Ус хөлдөхөөрөө хөнгөн биш, хүнд байдаг. Харин энд зөвхөн усны урсах байдлыг онцолж, хөнгөн шинжээр нь нэгтгэсэн байна.

Чи учир шалтгааныг нь юу гэж бодож байна вэ? Ярилцаарай.

Үгийн утгыг тунгаая.

Үгийн утга	Миний бодож байсан утга	Толь бичгийн утга
хөнгөн	хөнгөн жин, хэмжээ хөнгөн хийсвэр	- хэмжээ, хүнд гэдэг үгийн эсрэг утгатай үг
хүнд	хүнд жин, хэмжээ хүнд бэрх	- жинтэй, хүнд - хүнд хүчир, хүнд бэрх
бэрх	бэрх хэцүү бэрхшээл	- хүнд хүчир, бэрх хатуу - шагайны дөрвөн бэрх

4 “Ертөнцийн гурав”-т тохирох үгийг нөхөж бичээрэй. Яагаад бэрх гэсэн бэ? Тайлбарлан бичье.

Хадан дээр ногоо ..... }  
Цасан дээр гал ..... } бэрх  
Эвэр дээр цас ..... }

..... гахай нэг }  
..... тал нэг } хэцүү  
..... од нэг }

**Тохируулж нөхөх үгс:**

гал түлэх ногоо тарих  
гал ноцоох ногоо ургуулах  
гал асаах цас тавих, цас тогтоох

**Тохируулж нөхөх үгс:**

гатлахад, туулахад, туухад, хөөхөд,  
багцаалахад, тоолоход

5 Чамд бэрхшээлтэй хэцүү зүйл байдаг уу? Юу хийхэд бэрх байдаг вэ?

Ертөнцийн гурван бэрхийг зохиож үзье.

.....яахад ? бэрх  
.....яахад ? бэрх  
.....яахад ? бэрх

**САНАМЖ**

“Ертөнцийн гурав”-ыг ямар нэг онцлог шинжээр нь нэгтгэн, гурав болгон зохиодог.

6 Ертөнцийн гурав”-ыг дуурайн зохиоцгооё.

- 1 **Уншихдаа утгыг нь мэдэхгүй үгээ тэмдэглэж уншаарай.**  
Тайлбар толь бичгээс үгийн утгыг мэддэг болоорой.

### ШАГАЙН МАГТААЛ

**Аргаль, угалз уулын эрдэнэ**

**Адуу мал талын эрдэнэ**

**Алтан шагай арвин эрдэнэ**

**Малчин хүүхдийн тоглоом эрдэнэ**

**Хонины шагай ховор эрдэнэ**

**Хотол олны наадам эрдэнэ**

Тэгш тал нь морин эрдэнэ

Эсрэг тал нь тэмээн эрдэнэ

Хондлой тал нь хонин эрдэнэ

Хотгор тал нь ямаан эрдэнэ

Уруу хандвал онго эрдэнэ

Урвуулж хандвал хүмүүн эрдэнэ

Монгол газрын ёсоор

Морь уралдуулж наадъяа.

Хошуу амы нь нийлүүлж

“Хонь холбож” наадъяа

Аз хийморио сорьж

“Алаг мэлхий” наадъяа

Түвшин сайхныг бэлгэдэж

“Дөрвөн бэрх”-ийг наадъяа

Идэр хүрэн говьдоо

“Ингэ ботголуулж” наадъяа

Ижилхэн зүсээр майлалдсан

“Ишиг тоглуулж” наадъяа

Тэсгэм голын талаар

“Тэмээ уралдуулж” наадъяа

Тэнхээ тамираа шалгаж

“Үхэр мөргөлдүүлж” наадъяа

Золбоо хийморио шинжиж

“Зуу орхиж” наадъяа

**Цэнгэл баярын зугаа**

**Цэцэн ухааны ундрал**

**Цаг цагт тоглодог**

**Цагаан сарын наадам**

**Эцэг дээдсийн үеэс**

**Энэ биднээ өвлүүлсэн**

**Эрдэнийн сайхан тоглоомоо**

**Эгнэгт хамгаалж явъя.**

- 2 **Уншсанаа ярилцъя.**

1. Тодруулсан эхлэл хэсэгт шагайг магтахдаа ямар үгийг их хэрэглэсэн байна вэ? Мөр бүрийн төгсгөлийн үгийг анзаараарай.
2. Шагайг 6 талаас нь ямар ямар эрдэнэ гэж хэлэв? Тогтоож цээжлээрэй.
3. Монголчууд шагайгаар яаж, яаж нааддаг гэсэн бичсэн байна вэ? Та нар “Тэмээ уралдуулж” тоглож үзсэн үү?
4. Магтаалын төгсгөл хэсгийг тодруулжээ. Гол санааг бусдадаа хэлээрэй.

### ХЭЛ ЗҮГШРҮҮЛЭХ ҮГ

- 1 **Танил бус үгийг олж тэмдэглээд, тайлбар толь бичгээс утгыг хараарай.**
- 2 **Хэлэхдээ үг бүрийн авиаг тод дуудаарай.**

Зургаан настай бурхи

Зурманд зүүсэн урхи

Зуун модны горхи

Зүүн чихний гархи

Оройн бороонд норсон

Ороо бор морь

Олойроороо оломтой юу?

Омруугаараа оломтой юу?

- 3 **Дасгал ажиллая.**

1. Балархай эгшиг нь зөөлрүүлэх үүргээр орсон үгийг түүж бичээрэй. Эдгээр үгэнд “-ийн, -ын, ы, ийг, ыг, г, аар, ээр, оор, өөр, аас, ээс, оос, өөс, ууд, нар” залгавруудаас зөвийг сонгон залгаж, холбоо үг бүтээгээрэй.



2. “Норсон” гэсэн үгийн “нор” гэсэн язгуурт “в”, “оод”, “ооч”, “уузай”, “ё”, “г”, “жээ”, “но”, “моор” гэсэн залгавруудыг залгаж бичээрэй. Багштайгаа хамтраарай.

### “ӨВӨӨ БИД ХОЁР” оньсогон өгүүллэг

#### 1 Оньсогыг тааж уншъя.

...Өнгөрсөн хавар, зуны турш өвөө бид хоёр хэчнээн их ажил амжуулсан гэж бодно оо. Өвөө нэг өдөр:

За хоёулаа хашаандаа

“Тайраад байхад уртсаад байдаг

Шулаад байхад өргөсөөд байдаг” гаргая гэв. Амархан амжуулчихлаа. Тэгээд

“Уруудахдаа дуулна

Өгсөхдөө уйлна” ажилтай болов. Үүний ачаар бид өнгөрсөн намар

“Өндөг шиг бөөрөнхий

Өөх шиг цагаантай

Мах шиг улаантай

Малгай шиг залаатай”-г таван шуудай хураасан.

Бас “Улаан тахиа

Ногоон залаатай”-г хоёр шуудай,

“Өмссөн дээлийг нь тайлдаг бүхэн

Өөрийн эрхгүй уйлдаг”-ийг нэг шуудай,

“Газар дор

Гахай төрөв”-ийг лав хагас тонн авсан. Харин

“Заадасгүй гавал

Замаггүй ус”-ыг арчлах амаргүй юм билээ. Манайхан “Өвөө та хоёрынхоо гавьяагаар өвөлжин хэрэглэх амин дэмтэй боллоо” гэж магтаад байгаа шүү гэв.

(Ш.Энхбаяр)

#### 2 Энгүүн, Хүслэн хоёр оньсого тааж, хэрхэн тайлбарласныг уншиж ярья.

Тайлбарлахын тулд юуг, юутай адилтгасныг тодруулж яриарай.

Энгүүн оньсогоо тааж тайлбарласан нь	Хүслэнгийн тайлбарласан оньсого	Миний тайлбарлах оньсого
<p>Тайраад байхад уртсаад байдаг Шулаад байхад өргөсөөд байдаг (худаг гаргах)</p> <p>Худаг гаргах үйлтэй адилтгаж дээрх оньсогыг зохиожээ. Худгийг ухахад ухсан хэсэг гүнзгий болдог тэр үйлийг “уртсаад” гэдэг үгээр орлуулж хэлсэн. Харин гарсан шороог нь аваад байх үйлийг “шулаад” гэдэг үгээр төлөөлж бичжээ. Ухсан нүхний хэмжээ өргөсөөд байдгийн учир шалтгааныг “тайрах, уртсах, шулах, өргөсөх” гэж эсрэг утгатай үгээр гаргасан байна гэж ойлголоо.</p>	<p>Уруудахдаа дуулна Өгсөхдөө уйлна (худгаас ус авах)</p> <p>Хоосон хувинг худаг руу шидэхэд гарах “дон дон” гэх чимээг “дуулах” гэдэг үйлтэй адилтгасан бол ус авсан хувинг дээш өргөж татахад ус цалгиж асгардаг. Тэр үйлийг уйлахтай адилтгаж оньсоголжээ.</p>	



## Үлгэрийн утгыг ойлгон уншицгаая.

- 1 Үлгэрийг зөв, хурдан, ойлгож уншаарай.
- 2 1 минутад уншсан зөв үгээ тоолж, ойлгосноо шалгаарай.

### УХНА ГУАЙ

Урьд нэг айлд омог бардам ухна байжээ. Ухна гуай өөрийн сүргийн төлөө ер санаа үл тавин, ганцхан өөрийн биеийн жаргалыг эрхэмлэдэг байжээ. (1 дүгээр цогцолбор)

Нэгэн өвлийн янгинам хүйтэн шөнө тэнгэр зузаан үүлээр бүрхэгдэж, сүрхий хүчтэй цасан шуурга болоход өнөө эвэр ихт ухна бусад хонь ямааг айлган, хурц үзүүртэй эврээр мөргөн хөөж босгосоор хамгийн аятай дулаан газрыг эрж явлаа. (2 дугаар цогцолбор)

Тэгж явсаар хуц гуайн дэргэд очиж гэнэ. Ухна “Ихэмсэг зангаас минь хуц айж, тухтай дулаахан байраа найр тавин өгч, өөр газар очих биз” гэж боджээ. Гэтэл өнөө хуц ер ажиглан анхаарсан шинжгүй, тухлаг хэвтэртээ тавтай хэвтээд зүүрмэглэн байхаар нь ямаан сүргийн тэргүүн ухна гуай омог уур ихэд хүрч, дээш цоройн сүрийг бадруулан, “Хуцыг мөргөө” гээд цоройх гэтэл хашаатай олон хонь ямаа тал талаас шахах учир үл айгч хуцыг мөргөж чадсангүй. Хий л уур омог нь хүрч цухалдан дараа нэг чадал хүчээ үзүүлье гэж бодсоор өөр байр олохоор хавь ойрын бусад хонь ямааг айлгаж, тув тухыг нь алдуулан хашаан дотуур цааш явжээ. (3 дугаар цогцолбор)

Тэр хашааны нэгэн буланд хонин сүргийн дунд хамгийн их настай хөгшин ирэг хэвтэж байжээ. Ухна гуай уурандаа хөгшин иргийг айлгаж, босгон хөөгөөд, унтаж, цасан шуурганы аюулыг мэдэрсэнгүй. Гэтэл шуурганаар хоол эрж явсан өлөн чоно хотонд сэмхэн орж, нэгэн ямааны сүвээнээс үмх мах тасдан авсан нь дээрэнгүй зант ухных байжээ... (4 дүгээр цогцолбор)

(Монгол ардын үлгэр)

### Үгийн тайлбар:

ухна - Эр ямаа. Малчид ямаан сүргийн тэргүүн гэж нэрлэн хэлдэг байна.  
хуц - Эр хонь, эцэг мал  
ирэг - Агталсан эр хонь

- 3 Уншсанаа ярилцъя. Асуултаас сонгож хариулж болно.

1. 1 дүгээр цогцолборт ямар ухны тухай танилцуулсан бэ?
2. 3 дугаар цогцолборт ухна хуцыг хараад юу гэж бодов? Түүний бодсоноор хуц байж чадсан уу?
3. Ухна яагаад хонь, ямааг айлгаад, мөргөн хөөж байв? Түүний бодол болон үйлдэл нь зөв үү?
4. Чадал хүчээ үзүүлье гэхийн оронд “Ямаан сүргийн тэргүүн” ухна юу бодох ёстой байсан бэ?
5. Төгсгөлийн цогцолборт ухна сүүлдээ ямар амьтанд өөрийн мунхаг, дээрэлхүү зангаа гаргасан бэ? Энэ үйлдлээр чи ухны зан чанарыг шүүмжилж чадах уу?
6. Үлгэрийн гол санааг ойлгосноо бичгээр илэрхийлээрэй.

7. Ухна шиг зантай хүн таарвал чи хэрхэн харилцах вэ?
8. Ухныг хүнээр төсөөлбөл ямар зан чанартай хүн гэж хэлэх вэ? Дараах үгсээс сонгоорой.

Бусдыг хүндэлдэг

Дээрэнгүй, омог ууртай

Хүнийг ялгаж харьцдаггүй

Өөрийн хүч чадалд хэт эрддэг

Тайван, хүлээцтэй зантай

Өөрөөс нь сул дорой нэгэнд дээрэлхдэг



## Үлгэрийг сонсоод ойлгоё.

1 Youtube.com сувгаас “ШИДЭТ ХАРАНДАА | үлгэр | үлгэр сонсох | монгол үлгэрүүд” гэж хайгаад үлгэрээ анхааралтай сонсоорой.

2 Сонссоноо ярилцъя.

1. Ямар ажил хийдэг хүний тухай өгүүлж байна вэ?
2. Хүмүүс яагаад Альберт зураачийн зургийг гайхан биширдэг байв?
3. Тэр яагаад төрөлх хотоосоо явахаар шийдэв?
4. Зураач модтой юу ярилцав? Тэр юу хүсэв?
5. Бяцхан дагина түүнд ямар зорилгоор шидэт харандаа өгсөн бэ?
6. Альберт эелдэг бус зантай, бас муу зурдаг байсан бол яаж амьдрах бол?
7. Альбертын зурсан зураг бүр бодит болоод байсан шүү дээ хүүхдүүд ээ. Тэр зөвхөн өөрийгөө бодсон уу, бусдад тус хүргэж чадсан уу?
8. Түүний энэ сайн үйлийн тухай бусдад ярья гэвэл чи юу хэлэх вэ?
9. Хэрвээ чи энэ зураачийн оронд байсан бол юу зурах байсан бэ?
10. Үлгэрийн гол санааг ойлгосноо бичгээр илэрхийлээрэй. Дараах хүснэгтийг хэрэглээрэй.

Үлгэрийн гол санааны тухай бичсэнийг хүлээн зөвшөөрч байна уу? Тийм, үгүй гэсэн хариултаас сонгоорой.	Тийм, яагаад гэвэл үлгэрт ..... ингэж бичсэн байна.	Үгүй, яагаад гэвэл үлгэрт .....ингэж бичсэн байна.
Ямар ч хүнтэй эелдэг харилцаж байх нь чухал.		
Зөвхөн өөрийнхөө төлөө амьдрах биш бусдад тусалж байх нь хамгийн сайхан.		
Авьяастай байх нь хамгийн чухал.		
Авьяастай байхаас гадна сайхан сэтгэлтэй байх нь бас чухал.		
Хүн хийж чаддаг зүйлээрээ бусдад тусалж байх хэрэгтэй.		

3 Хүүхдүүд ээ, сонссон үлгэрүүдээрээ тэмдэглэл хөтөлж, номын танилцуулгаа бичиж заншаарай.



## Үлгэрийн утгыг ойлгон уншицгаая.

### САРЬСАН БАГВААХАЙ ЯАГААД ӨДӨР НИСДЭГГҮЙ ВЭ?

**Эрт нэгэн цагт** ан араатан, жигүүртэн шувуудын хооронд аюулт дайн болж, өд сөд, үс ноос нь өвс ургамал мэт дэлхийг бүрхэж байжээ. Хүчит бүргэд, шалмаг харцага, эрүү цагаан болжмор тэргүүтэн нэг талд, аварга арслан, аймшигт бар, аюулхай цагаан хэрэм гээд бусад амьтад нөгөө талд нь байлджээ.

Ганцхан сарьсан багваахай л алинд нь ч оролцсонгүй. Жигүүртнүүд, ан араатныг дийлэхээр болоход тэдний дунд нисэж очоод, далавчаа дэвэн:

- Би чинь жигүүртэн шувуу шүү гээд “Араатан амьтдыг цоо тоншъё, тас базъя, урагшаа!” гэж хашхирч явж гэнэ.

Гэтэл ан араатан, жигүүртнийг дийлмээр болохтой зэрэг нөгөө сарьсан багваахай тэдний дунд очоод, шүдээ ярзайлган:

- Би чинь шүдтэй араатан амьтан шүү дээ. Жигүүртнийг балба дэлсье, өм хазъя, урагшаа! гэж хашхирч явж гэнэ.

Ингэж ан араатан, жигүүртэн шувууд дээр доороо оролцож, ана мана үзэлцсэний эцэст дайн тулаанаа зогсоон, найрамдал тогтоожээ. Хоёр тал үхэж үрэгдсэн, үлдэж хоцорсон бүхнээ бүртгэн дансалж гэнэ. Харин сарьсан багваахай хоёр нүүр гаргаж, хов жив хөөцөлдөж, худал үнэн ярьж явсан болохоор аль ч тал нь бүртгэж авсангүй гэнэ.

Үүнээс хойш сарьсан багваахай ан амьтан, араатан жигүүртнээс айж зугтан, одоо ч тэдэнд харагдахаас болгоомжилж, өдөрт хадны завсар нуугдан, шөнөдөө хоол унд хайн, нисэж явдаг **болсон юм сан жээ.**

(Монгол ардын үлгэр)

#### 1 Уншсанаа асуултаар тодруулан ярилцъя.

1. Амьтдын хооронд дайн болжээ гэдгийг чи яаж мэдэв?
2. Сарьсан багваахайг аль ч тал нь аваагүй үед тэр юу бодсон бол?
3. Сарьсан багваахайг хоёр талд хов хүргээд л явж байхад чи юу бодож байв?

#### 2 Хэлц үгийн утгыг тайлбарлая.

хоёр нүүр гаргах  
ана мана үзэлцэх

#### 3 Үлгэрт юуны тухай өгүүлсэн бэ? Сонгож тайлбарлана уу.

- |                                |                             |
|--------------------------------|-----------------------------|
| А. Ойн амьтдын тухай           | В. Сарьсан багваахайн тухай |
| Б. Шударга байхыг сургамжилсан | Г. Амьтдын тэмцлийн тухай   |

#### 4 Үлгэрийн баатрууд болон үлгэрийн орчныг хэлэлцээрэй. Тухайлбал:

- Дайнд оролцсон баатруудыг ямар үгээр тодотгож бичсэн бэ?
- Энэ үлгэрт сайн талын баатар дүрслэгдсэн үү? Дайтсан амьтад сайн тал илэрсэн үү?
- Өдөр, шөнийн тухай яагаад бичив? Хэний дүрийг тодруулах гэж байна вэ?



## Үлгэр дуурайн, зохион бичигчээ.

### Бичих санаагаа олж, төлөвлөө.

1. Юуны тухай бичихээ сонгоё. Уншигчдад зориулж, юу хэлэхийг хүсэж байна вэ? Хосоороо ярилцаарай. Гол санаа чухал байдгийг бид мэднэ шүү дээ.

2. Үлгэрийн баатруудаа төсөөлье.

- Гол санаатайгаа уялдуулан, хэдэн баатартай байхаа төлөвлөөрэй.
- Сайн санаат, хорон санаат, эсвэл шидэт хүн гэх зэргээр уншсан үлгэрээсээ төсөөлөн баатруудаа зохиоцгооё.
- Баатрууд хоорондоо юу ярилцах вэ? Тэдний гадаад байдлыг яаж дүрслэхээ бодоорой.

3. Зохиох үлгэрийнхээ орчныг төсөөлье.

- Шидэт агуй
- Тэнгэрийн хаант улс
- Ой шугуй
- Чихрэн галт тэрэг
- Ааруулаар хийсэн гэр гэх мэт өөрийн чинь бодож олсон ямар ч орчин байж болно.
- Бичих зүйлээ төлөвлөн зурж болно шүү.

4. Үлгэртээ ямар нэр өгөхөө ярилцаарай.

### Санаагаа зохиож, байрлуулъя.

1. Үлгэр хэдэн цогцолбороос бүтэх вэ?

- Аль цогцолборт ямар санааг байрлуулахаа шийдээрэй.

1. Нэгдүгээр цогцолбор буюу эхлэл хэсэг

Эрт урьдын цагт ..... энэ цагийн эхэнд, балар эрт цагт, сайн цагийн эхэнд

2. Гол хэсэгт хэд хэдэн цогцолбор байж болно. Баатруудад тохиолдсон адал явдлыг бичнэ.

3. Төгсгөлийн цогцолбор

..... амар сайхан жаргажээ, юу болсон бол .... болсон гэнэ.

### Төлөвлөсний дагуу ноороглоё.

#### Бичсэнээ засаж, нягталъя.

1. Бичсэн үлгэрээ эхлээд өөрөө уншъя.
2. Гол санаа илэрсэн эсэхийг дахин хяная.
3. Цогцолбор тус бүрд утга гаргаж чадсан эсэхээ хяная.
4. Баатруудыг яаж дүрсэлсэнээ эргэцүүлье.
5. Орчныг сонирхолтой төсөөлсөн эсэхийг бодъё.
6. Яаж сайжруулах талаар зөвлөгөө авч, тэмдэглэе.
7. Бичихдээ үгийн сонголтыг анхаарч, найруулгаа цэгцэлье.
8. Зохиосон үлгэрээ найз нартаа яриарай.



## “Ж, ч, ш” гийгүүлэгчийн дараах эгшгийг зөв бичицгээе.

Ажиглан тогтоох үгс

амжИлт, ажИгч, ачИгч, хашИлт, уншИх, ажИлсаг, цочИх, заншил, хөгжИм, бүжИг, жүжИг, ажИлсаг, хүчИт,

Энэ үгсэд яагаад “И” үсэг ороод байгаа юм бол оо?

“Ажилсаг Ариунаа эгчдээ амжалт хүсье” гэсэн өгүүлбэрт нэг алдаа байна гээд байх юм. Засахад минь туслаач, найз аа.

Ажилсаг гэж зөв бичсэн ч амжилт гэсэн үгийг алджээ. Нүдлэх үгээ тогтооё, найз минь

### ДҮРЭМ

Үгийн дунд “ж, ч, ш” гийгүүлэгчийн дараа богино эгшиг бичихээр бол зөвхөн “И” бичдэг.

#### 1 Цэгийн оронд тохирох эгшгийг нөхөж, гүйцээн бичээрэй.

- Зүйр үгийг зөв найруулан бичье.
- Ямар эгшиг бичсэнээ тайлбарлан ярь.
 

Гэм нь хойноо	багана түш.г Ядрахад
урдаа Гэмш.л нь	түш.г Байшинд нөхөр

#### 2 Ажиглаад, дараах жишээтэй адил өгүүлбэр зохион, зөв бичээрэй.

Монголчууд ахмадаа хүндлэх эрхэм заншилтай.  
Монгол ёс заншлаа дээдлэн дагая.  
Ажил хийвэл ам тосодно. Ажлыг аргаар хийдэг.

Залгавар залган өгүүлбэр зохиох үгс нь: бүжиг, зочин, бичиг

“ж, ч, ш”-ийн дараах “и” эгшиг гээгдэнэ. Яагаад?

#### 3 Ажиглаад, дараах жишээтэй адил өгүүлбэр зохион зөв бичээрэй.

Очирын ярихыг сонслоо. Ном уншихаар суулаа.  
Хажидын ярьсан зүйлийн учрыг сая ойлголоо.  
Өдрийн тэмдэглэлээ бичихээр суулаа.

Залгавар залган хэрэглэх үгс нь: Гончиг, Ачит, Балжир, түших

“ж, ч, ш”-ийн дараах “и” эгшиг гээгдэхгүй. Яагаад?

#### 4 Дүрмээ бататгая.

1. Уншсан үлгэрээсээ балархай эгшгийн ялгах болон зөөлрүүлэх үүрэгтэй үгийг олж бичээрэй. Дүрмийг нь тайлбарлана уу.
2. Дараах үгсийг зөв болгож бичээрэй. 70 дугаар талд дахь үлгэрийг дахин уншаарай.  
сарсан багваахай, хүчэт бүргэд, шалмага харцага, аврага арслан, цоо тоншоё, тас базая, шүдээ ярзаалган, балба дэвсье, өм хазьё
3. “Багваахай” гэдэг үгэнд “-ны, -д, -оос, -оор, -той, -луу, -ийг” гэсэн залгавруудыг зөв залгаж бичээрэй.





## ШҮЛГИЙН УТГЫГ ОЙЛГОН УРАН УНШЪЯ.

Шүлгийн утгыг ойлгосноор уран унших арга барилтай болно. Шүлэг дэх адилтган дүрсэлснийг тайлбарлахдаа хоёр зүйлийн ижил төстэй зүйлийг харьцуулан ажиглана. Шүлгийн хэлбэрийг дуурайн, шүлэг зохиож туршина.



### Шүлгийн утгыг ойлгож, уран дүрслэлийг мэдэрч уншицгаая.

Та нарын сэтгэлд  
хоногшсон, унших дуртай  
ямар шүлэг байдаг вэ?  
Ангиараа ярилцана уу.

Тэр шүлгээ хэзээ, хаана  
сурсан бэ? Яагаад өнөөг  
хүртэл мартаагүй вэ?  
Учир нь юунд байна вэ?

### Хамтдаа дуулцгаая.

Үг. Ж.Бадраа

Ая. Ц.Намсрайжав

### ХАЛУУН ЭЛГЭН НУТАГ

Элэг зүрхнээс уяатай  
Энхрий монгол нутаг минь  
Эцэг эхээс заяатай  
Эрдэнийн алтан өлгий минь  
Цэцгийн шимийг тэтгэсэн  
Цэнгэлийн хавар айлчлахад  
Мөрөн гол нь дуугаа дуулж  
Мөнх сарьдаг нь мишээнэ

Сэрүүн салхи сэвсүүлэн  
Хацар нүүрийг үнсэн байж  
Сэтгэл дотрыг ариулсан  
Халуун элгэн нутаг минь

#### САНАМЖ

Энэ дуу эх орны тухай хамгийн сайхан дуугаар шалгарч, XX зууны Монгол улсын “Манлай дуу” болсон билээ.

### 1 Шүлгийн утгыг тодруулъя.

**Шүлэг хэдэн бадгаас бүтсэн байна вэ? Бадаг бүрд юуны тухай өгүүлж байна вэ?**

Нэгдүгээр бадаг:

1. Зохиолчийн сонгосон үгийг ажиглая. Эх орноо гэж бодож бичихдээ ямар ямар үгийг сонгож бичив? Яагаад гэдгийг өөрийн бодлоор тайлбарлаарай.

Яагаад ингэж бичсэн юм бол?	Миний бодлоор...
	а. Элэг зүрхнээс уяатай гэдэг нь...
	б. Эцэг эхээс заяатай гэдэг нь
	в. Эрдэнийн алтан өлгий гэдэг нь...

Хоёрдугаар бадаг:

2. Дараах тайлбарыг ажиглаад, дуурайн ажиллаарай.


Хоёрдугаар бадаг	Үгийн тайлбар	Утга санаа
Цэцгийн шимийг тэтгэсэн	Шим гэдэг нь юмны шүлт шүүс, ашиг, үр тэжээлийг хэлдэг байна.	Хаврын улирал ирэхэд цас мөс хайлж, цэцэг ногоо ургаж эхэлдэг. Өнгө өнгийн сайхан цэцгийг ургуулах шим нь цас мөс байдаг учраас хаврын улирлыг “цэцгийн шимийг тэтгэсэн” гэж бичжээ.
Цэнгэлийн хавар айлчлахад	Цэнгэл, цэнгэх гэдэг нь... Айлчлах гэдэг нь ...	Яагаад “цэнгэлийн” хавар гэж бичсэн бэ? “Айлчлах” гэдэг үгийн оронд “ирэхэд, зочлоход, хүрч ирэхэд” гэж найруулсан бол шүлгийн утга санаа яаж өөрчлөгдөх бол? Эсвэл ялгаагүй байна уу?
Мөрөн гол нь дуугаа дуулж	...	Хавар болоход гол мөрөн дуу дуулдаг уу? Эсвэл зохиолч өөр утга санаа илэрхийлж зохиосон уу? Голыг яагаад дуу дуулж байгаагаар дүрсэлсэн бэ?
Мөнх сарьдаг нь мишээнэ	Мөнх сарьдаг гэж ямар уулыг хэлдэг вэ?	“Өндөр уул мишээдэг” гээгүй, заавал мөнх сарьдаг уулыг сонгож бичсэн нь ямар утгыг илэрхийлж байна вэ? “Мишээдэг” гэдэг нь “баярладаг” гэсэн утгатай байна уу, эсвэл өөр утга илтгэж байна уу? “Мөнх сарьдаг”-ийг яагаад мишээж баясаж байгаагаар дүрсэлсэн бэ?

3. Шүлгийн хоёрдугаар бадгийг дэвтэртээ хичээнгүй хуулж бичихдээ өөрчилсөн үгийн доогуур зураарай. Утга нь өөрчлөгдсөн байна уу, эсвэл ойролцоо утгатай байна уу?

Цэцгийн шимийг тэтгэсэн  
Цэнгэлийн хавар зочлоход  
Мөрөн гол нь дуугаа дуулж  
Мөнх сарьдаг нь инээнэ.

Гуравдугаар бадаг:

4. Тодруулсан үгийн утгын тайлбарыг уншаад, бичээрэй.



## 2 Уншсанаа ярилцъя.

1. Эх орон гэдэг хэнтэй, юутай холбоотой вэ?
2. Дөрвөн улирлаас хаврын улирлыг сонгосны учир юу вэ? Хаврын улирал цэцгийг ургуулж, гол мөрнийг дуулуулж, уулыг баясгасан гэж бичсэн нь ямар учиртай вэ?

3. Эх орон, эх нутгаа бид яаж хайрладаг вэ?

4. Та нар энэ шүлгээс юуг ойлгож авав? Тэрхүү санаа чинь энэ шүлгийн гол санаа болох юм.

Нэгэн сурагч энэ дууны шүлгийн гол санааг дүгнэн бичихдээ 9 үг алдаатай бичжээ. Түүнд тусалж, зөв болгон бичээрэй.

Яаж зөв болгосноо тайлбарлаарай.



Монгол хүн бүхний дуулдаг энэ дууг **сонсхоор** надад үнэхээр сайхан байдаг. Яагаад гэвэл мөр бүрд байгаа үгийн **утгань** надад ямар нэгэн утга учиртай **юмшиг** санагдсан. Эх нутгаа “элэг зүрхнээс уяатай” **гэсэннь** монголчуудын “элгээрээ энх амгалан, төрлөөрөө төвшин амгалан”, “элэг бүтэн **амьдраараа**” гэж хэлэлцдэгтэй ижил юм.

“Эх орон бол хүний сэтгэл дотрыг ариусгадаг, сэтгэлд хамгийн ойр байдаг” гэдэг санааг зохиолч хэлжээ. Энэ нь уг шүлгийн гол санаа гэж бодож байна. Миний өвөө надад “монгол хүний сэтгэлд хамгийн ойр нь эх нутаг юм шүү” гэж үргэлж хэлдэг.

Тиймээс газар нутгаа хайрлаж **яваараа** гэж найзуудаасаа хүсье. Газар **шорооруу** нулимж шүлсээ хаяхгүй, хогоо хогны саванд хийж **хэвшхийг** та нартаа уриалж байна.

Миний эх орон үргэлж “хаврын” **улралшиг** шинэ байгаасай.


Сурагч А.Чингүүн

### 3 Шүлэг дэх адилтган дүрсэлснийг тайлбарлаарай.

1. “Эцэг эхээс заяатай  
Эрдэнийн алтан өлгий” гэсэн 2 хэсэгт алтан өлгий гэж юуг хэлж байна вэ?  
Шүлгийг дахин уншаарай.
2. Нутгийг юутай адилтгасан бэ?
3. Ямар шинжээр нь адилтгасан бэ? Өөрөөр хэлбэл өлгий, нутаг хоёрын ижил төстэй шинжүүдийг хэлээрэй.

Өлгий-нялх хүүхдийн манцуй, төрсөн нутаг

4. Өлгий нутгийг яагаад алттай адилтгасан бэ? Адил төстэй шинж нь юу байна вэ? Тайлбарлаж бичээрэй.



## 1 Утгыг ойлгож, уншъя.



Уншихдаа:

- Байгалийн ямар үзэгдлийг дүрсэлсэн байна вэ? Төсөөлж уншицгаая.
- Дахин уншихдаа адилтган дүрсэлсэн хэсэг (өнгөөр ялгасан)-ийг мэдэрч уншаарай.

## САЛХИ, ТЭНГИС ХОЁР

Салхи, тэнгистэй наадаж  
Сайхан нойрыг нь сэргээнэ  
**Хөх торгон хөнжил**  
**Хөвөлзөж байх шиг харагдана**  
Хөнжил дотроо тэнгис  
Хүрхэрч байх шиг дуулдана  
Салхи тэнгис дээр бүжиглэнэ  
Сайхан хөнжлийг нь гишгэлнэ

Байг гэж тэнгис уцаарлана  
Бас унагах гэж оролдоно.

**Салхи исгэрэн бүжиглэсээр**

Сайрхаж дээр нь гишгэлсээр  
Ингэсгээд тоглоом дууслаа  
Тэнгис уурлаж эхэллээ  
Хоёр найзыг муутгах гэж  
Ховч саран өндийхдөө

**Мөнх хөх тэнгэрээс**

**Мөнгөн таягаа туллаа**

**Тэнгисийн биед хүрэхдээ**

**Тэр таяг нь гулзайна**

Өнөөх эмгэн бүдрэхдээ  
Өндөр уулыг тэвэрнэ  
Саримгар үүлэн дээлээрээ  
Санд мэнд халхална

Салхи, тэнгис хоёр ч  
Тэнцэж ядан үзэлцсээр  
Уурынхаа ихэд тэнгис  
Уулын хясаа мөргөнө  
Салам цохиулаад буцахад нь  
Салхи эрэг өөд үсэрч  
Зуун жилийн царснаас  
Зуурч аваад хоцорлоо

Адал явдалт шөнийг элдсээр

**Алтан нар айсуй гэж**

Үнэгэн харанхуйг нэвтэлсээр

Үүрийн гэгээ ирлээ

Бүхэл шөнөдөө нойргүй

Үхэж болохоор тулалдсан

Салхи тэнгис хоёр

Сая л арайхийн саллаа

Уур манан савсуулан

Уухилж хэвтэнэ, тэнгис

Хөлс нь бас асгарсаар

Хөөс нь сахарч харагдана

Навч цэцэг бүхэнд

Наалдаж хоцорсон салхи

Чийгтэй хөрснөөс зуурсаар

Чичирч байгаа үзэгдэнэ.

(Д.Сэнгээ)

## 2 Уран, тод уншъя.



Уран тод  
уншихдаа:

- Салхи, тэнгис хоёрын тэмцлийг бусдадаа мэдрүүлэхийн тулд уншаарай.
- Унших хурд, дууны өнгөө тохируулахын тулд тэмдэглэгээ хийгээрэй.
- Аль үг, мөр, бадагт унших хурдаа нэмж, хаана нь унших хурдаа сааруулах вэ?
- Аль үгийг хэлэхдээ дууны өнгөө өөрчлөх вэ? (сул, чанга гэх мэт)

### 3 Уншсанаа ярилцъя.

1. Шүлгээс юу сонсогдов? Төсөөлөн ярья.
2. Ямар, ямар үг ингэж төсөөлөхөд чинь тусалсан бэ?
3. Салхи, тэнгистэй наадаж байгааг яаж дүрсэлсэн бэ? Үгийг ажиглана уу.

1. “Ховч саран мөнгөн таягаа туллаа” гэж байгалийн ямар үзэгдлийг дүрслэв?
2. Шөнийн байгалийн үзэгдлийг ямар үгээр тодотгож дүрсэлсэн бэ?
3. Өглөөний нар мандаж байгааг амьдчилж дүрсэлжээ. Ямар үгээр илрэв?

1. Мөр, бадгаас сонгон, зургаар илэрхийлнэ үү.
2. Төгсгөлийн дөрвөн мөр дэх дүрслэлийг өөрийн бодлоор тайлбарлаарай.

### Шүлгийн уран дүрслэлийг тайлбарлая.

#### 1 Шүлэгт салхи, тэнгис хоёрыг амьдчилж дүрсэлжээ. Яаж амьдчилж дүрсэлсэн бэ?

Салхи, тэнгис хоёрын хөдөлгөөнийг дүрсэлсэн үгийг түүж бичье.

салхи	тэнгис
Салхи тэнгистэй наадна	
<ul style="list-style-type: none"><li>• Нойрыг нь сэргээнэ.</li><li>• Дээр нь бүжиглэнэ.</li><li>•</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>• Хүрхэрч байх шиг дуулдана.</li><li>• Байг гэж уцаарлана.</li><li>•</li></ul>

#### Адилтган дүрсэлснийг тайлбарлаж ярьсан нь:

“Наадна” гэдэг үг хүний хийдэг үйлийг заасан үг. Өөрөөр хэлбэл, үндсэн утга нь хүнтэй холбоотой үг юм. Гэтэл энэ шүлэгт хүн тоглож наадна гээгүй, салхи тэнгис наадна гэж бичсэн байна. Салхи, тэнгис хоёрыг хүнтэй адилтгаж, урнаар дүрсэлжээ.

Салхины аясаар тэнгис давлагаалж байгаа байдлыг зохиолч хараад, наадаж тоглож байгаа гэж бодсон байх.

#### 2 Хөнжил, таяг, дээл зэрэг эд юмсыг дүрсэлсэн хэсгийг олж уншъя. Хөнжил, таяг, дээлний тухай бичсэн үү? Эсвэл өөр зүйлийг дүрсэлсэн байна уу?

#### 3 Өгүүлбэр дэх үгсийг утгаар нь зөв холбоё.

1-р өгүүлбэр: салхи, тэнгис хоёрыг, Шүлэгт, дүрслэхдээ, байгалийн үзэгдлийг, амьдчилжээ.

2-р өгүүлбэр: адилтгаж дүрсэлжээ. хөнжлөөр тэнгисийг, таягаар, Түүнчлэн, цахилгааныг, дээлээр, тэнгэрийг

#### 4 Дараах үгсийн ойролцоо утгатай үгсийг олж тогтоон, өгүүлбэр зохиогоорой. Утга нь өөрчлөгдөж байгаа эсэхийг эргэцүүлээрэй.

Наадах	айсуй
Харагдах	хожимдох
Дуусах	элдэх
Хоцрох	үзэгдэх
Хөөх	төгсөх
Ирэх	тоглох



## Ойлгосноо давтъя.

### 1 Утгыг тодруулж, уран тод уншъя.



## БУДАА

Будаанд түүнийг дуртай гэнэ  
Булт хүүхдүүд шоолон ярина.  
Харин зарим нь будаачин гэнэ.  
Хагас хэсэг нь буудаачин гэнэ.  
Хэрэглэж байдаг будаа  
Хэд хэдэн янз байна.  
Хэрэг болгон түүний тухай  
Хэлэх үг надад байна.  
Цагаан, шар, хүүхдийн гээд  
Цаашилбал хар будаа хүртэл  
Хүний хэрэгцээнд олон будаа  
Хүнс тэжээлд ордог тул  
Түүнийг би хувьдаа хамгаалж  
Түрүүнээс хойш зөндөө өмгөөлж  
Нөхрийгөө битгий шоолж бай гэж  
Нөгөөдүүлд нь захидаг байв.  
Гэтэл тэр хүүхдийн маань  
Гэм нь цухуйж, хөг нь илрэв.  
Өмөөрч байсан буруугаа би  
Өөрийн эрхгүй хүлээх болов.

Дэргэдээ суусан нөхрийнхөө  
**Дэвтрэн тавагтай тоон будаанаас**  
Дээгүүр доогуур шагайж байгаад  
Дэлсчхээд байдаг хүүхэд юм сан жээ  
Энэ будаа гайтай будаа  
Идэж хэрэглэж болохгүй будаа  
Эрдэм сурахад хэрэггүй будаа  
Эцэстээ та нарт хортой будаа  
Ийм будаа хамаагүй ихээр  
Идэх дуртай тийм хүүхдийн  
Илэрсэн заримыг нь би бичье.  
Илрээгүй нэгийг нь та нарт захъя.

(Д.Содномдорж)

- 2 Эхийн гол санааг тодруулсан асуулт зохиож, ярилцъя.
- 3 Тодруулсан бадагт юуг юутай адилтгасан бэ? Ямар шинжээр нь адилтгасан бэ?
- 4 Шүлгийг айзам хэмнэлтэй уншихад мөр бүрийн эхний үсэг ижил байгаа нь нөлөөлж байна уу? Эсвэл мөр бүрийн үгийн тоо тэнцүү байгаа нь нөлөөлж байна уу? Эргэцүүлээрэй.





## Хурд, дууны өнгөө тохируулан, уртаар уншъя.

### 1 Эхний удаа шүлгийн утгыг ойлгож, уншаарай.



#### НАМАЙГ САНСАРТ НИСЭХЭЭР...

Намайг сансарт нисвэл  
 Найз нар минь атаархана даа  
 Томчууд ч гэсэн надад сайн болж  
 Толгой илээд үнсэж гарна даа

(*мөрөөдсөн, мишээсэн өнгө аяс*)


Муу тавьдаг Дандар багш  
 Миний дүү уучлаарай гэнэ.  
 Аягүй бол зургийн багш  
 Аваад яваач гэж гуйна.

(*өөрөөрөө бахархсан, онгирсон аяс*)

Тэгэхэд нь би огт тоолгүй  
 Тэдний дэргэдүүр гараа хаялан  
 Сансрын цагаан өмсгөл өмсөж  
 Сарны зурагтай малгай тавиад  
 Хөлгийн зүг тайвуухан алхана  
 Хөөрхөн найзтайгаа хамт ниснэ

(*бахархсан, баярласан, бие тоосон аяс*)

Даалгавраа хий гэж  
 Загнадаг ээж маань  
 Нулимс унагаж  
 Дандаа тоглож байх гэж  
 Зандардаг аав маань  
 Намайг тэвэрч  
 Хамт тоглодоггүй найз маань



Бөмбөгөө өгч  
 Харандаагаа харамладаг дүү маань  
 Үзгээ сарвайна.

Олон хүмүүс сайн болно.  
 Одонд намайг үдэж гаргана.

Томчуудын дотроос ганцхан  
 Тооны багш л осолтой хүн  
 Хөлгийн бүхээгт суучхаад  
 Хөөрөх гэж байтал

Бодлогоо бодсон уу?

Болд оо! гэж

Буудал дээрээс хашхирч мэднэ. (*айсан, эмээсэн, бодсон, болгоомжилсон аяс*)

Харин би шилээ маажин

Хариу үг бодож зогстол

-Тоогоо бодно оо хө, бугаад ир

Томьёо сансарт хэрэгтэй гэнэ.

Тэгэхээр нь би яадаг билээ (*сандарсан, гайхсан, эргэлзсэн аяс*)

Тэнгэрт бодно гэж хариулалтай биш

Одонд томьёо хэрэгтэй бол

Очоод би юу хийнэ ээ!

(*гайхсан, эргэцүүлсэн, асуусан*)



(*Д.Батжаргал*)

### 2 Болд, баатруудын дүр төрхийг яаж илэрхийлж хэлэх бол?

Шүлгийн баатрууд	Илэрхийлэх үгс
томчууд	
Дандар багш	
зургийн багш	
тооны багш	
Болд өөрийгөө яаж илэрхийлж жүжиглэх вэ?	

### 3 Шүлгээ яаж уран унших тухай хэлэлцээрэй.

Үг бүрийн утгыг тунгааж, унших хурд, биеийн хөдөлгөөн, нүүрний хувирал, нүдний харц, дууны өнгөө тохируулж, дохио зангаа хэрэглээрэй.



## Утгыг ярилцъя.

1. Шүлэгт дүрсэлсэн зүйлсийг төсөөлөн зурна уу.
2. Хөдөө нутгийн тухай хөрш айлын найз нь юу юу гэж ярьсан бэ? Хамгийн инээдтэй санагдсан хэсгийг сонгож ярина уу.
3. Ямар үгийг уншаад инээсэн бэ?

## Бичих санаагаа олж, төлөвлөө.

### Сонгон ажиллая.

- Шүлгийн хэсгээс сонгон, хэлбэрийг дуурайн зохиоё.
- Дуурайж зохиоходоо үгийг сольж найруулаарай.

А. "Хөдөө"	Б. "Халуун элгэн нутаг"	В. "Намайг сансарт нисэхээр"
Тухайлбал:		
Нийслэл хотоо маш сайхнаар төсөөлж, өөрийнхөө хүслийг илэрхийлээрэй.	Монгол эх нутгаа ямар байхыг хүсэж байна вэ?	"Намайг... /ямар хүн/ болохоор" гэх мэт
Өөрийн санаа бодлыг тусгаарай.		

## Санаагаа зохиож, байрлуулъя.



Зохиоходоо:

- Шүлгийн хэмнэлийг хадгалан, үгийг сольж найруулж зохиогоорой.
- Мөр бүрийн эхний үгийн эхний үсэг ижил байвал шүлэг хэмнэлтэй болдгийг мартуузай.
- Багаар хамтарч болно.

### Тухайлбал:

Хөдөө	Улсын нийслэл Улаанбаатар
Хөдөө би очоогүй	Хотод би амьдардаг
Хөдөө би үзээгүй	Хотыг би хайрладаг гэх юм уу эсвэл
Хөрш айлын жаал	Хотод би очоогүй
Хөдөө үзсэн бүгдээ	Хотыг би үзээгүй
Хөөр болгон ярилаа...	Хоёр найз маань
... Төрөх дөхсөн малыг	Хотод үзсэн бүгдээ
Түргэн тусламж зөөнө	Хөөр болгон ярилаа...
Түргэний тэргэнд суулгана	...Сургуульд орсон хүүхдийг
Цэвэр агаарт гаргана	Суудлын машинаар зөөнө.
Цэцэрлэгт хүрээлэнд хүргэнэ	Цэвэр агаарт гаргана.
	Цэцэрлэгт хүрээлэнд тоглуулна гэх мэт цааш нь үргэлжлүүлээрэй.

## Төлөвлөснөө ноороглон бичье.

### Бичсэнээ хянаж сайжруулъя.

1. Зохиож бичсэнээ уншиж, өгүүлбэр дэх үгс утгаараа зөв холбогдсон эсэхийг хяная.
2. Ширээний найздаа, багшдаа уншиж өгч, таалагдсан эсэхийг асууя.
3. Багшаараа зөв бичих дүрмийн алдаагаа хянуулж, яагаад алдсанаа тунгаан бодъё.
4. Дахин сийрүүлж хичээнгүй бичье.



## Би юу сурсан бэ?

Өөрийгөө шалгах асуулт	Хамгийн сайн чаддаг болсон зүйл	Цаашид яаж сайжруулах вэ?
Шүлгийн утга санааг тодруулсан асуултад оновчтой хариулсан уу?		
Шүлгийг уншихдаа уншлагын хурд, дууны өнгөө яаж тохируулах вэ?		
Шүлгийн хэлбэрийг яаж дуурайж зохиосон бэ?		
Чамд ямар бэрхшээл байна вэ?		

### Өөрийгөө үнэлсний дараа юу хийх вэ?

1. Сайжруулах зүйлээ сонгон, багшаасаа тусламж хүсээрэй.
2. Амжилтад хүрэхийн тулд холбогдох дасгалыг ажиллаарай.

- ① **Дараах шүлгийн хоосон зайг нөхөж, шүлэг зохиогоорой. Толгой холбож, хэмнэл үүсгэхээ мартуузай.**

### НАР

Нар дээрээс 1..... л байх юм.  
 2.....нэг юм хэлэх гээд байна уу?  
 Амтат зайрмагнаасаа 3.....гэтэл  
 4.....долоочихсон 5.....

(Г.Жамьяндорж)



- ② **Нөхөх үгийг сонгоно уу.**

1. мишээгээд, инээгээд, баясаад, мушилзаад, хөхрөөд, жуумалзаад
2. надад, бидэнд, тэдэнд, чамд, найзад минь, эгчид минь
3. өгье үү, өгье, өгье дөө, өгнө, өгөх
4. аль хэзээний, аль хэдийн, надаас урьтаж
5. байх юм, байсан юм, байв, байжээ

- ③ **“Хэрвээ би бороо сон бол” шүлгийг сонсьё.**

1. Гол санааг бичээрэй.
2. Хүний ямар, ямар зан чанарыг юутай адилтган өгүүлсэн байна вэ?
3. Уран тод уншихдаа аль үг дээр сэтгэлийн ямар хөдөлгөөн илэрхийлж болохыг тэмдэглээрэй.
4. Шүлгийн хэлбэрийг дуурайн, үргэлжлүүлэн зохиогоорой.  
Хэрвээ би салхи бол...  
Хэрвээ би ... бол
5. Өөрийнхөө ямар зан чанарыг яаж гаргаснаа тайлбарлан бичээрэй.

- ④ **Хүний зан чанарыг илэрхийлсэн дараах үгсийн эсрэг утгатай үгийг олж бичээрэй.**

Олон зантай - .....  
 Цухалдуу .....  
 Хүлээцтэй.....  
 Ажилсаг .....

# 10

## УЧИР ШАЛТГААНЫГ ОЛЖ, ТАЙЛБАРЛАХ АРГАД СУРАЛЦЬЯ.

Энэ бүлэгт эхийн учир шалтгааныг баатрын үйл хөдлөлөөр олж сурна. Хэлэлцүүлэгт шинэ санаа нэмж оролцон, бусдын яриаг дуустал хүлээцтэй сонсож сурна. Эх, өгүүлбэр зохиоходоо хэлц үгийг утгаар нь зөв хэрэглэнэ.



### Баатрын үйл хөдлөлөөр учир шалтгааныг олж уншицгаая.

#### 1 Зурагт байгаа хүүхдүүдийн үйл хөдлөлийг ярилцъя.

- Хүүхдүүдийн юу хийж байгааг төсөөлөн ярилцъя.
- Тэд хоорондоо ямар холбоотой байгааг төсөөлөн ярь.



2



3



4



Зохиолыг уншвал дээрх зургаар юу өгүүлснийг мэдэх болно.

#### 2 “Зараа” эхийг сонсож, ойлгож ярилцъя.

- Эхийг сонсож, ойлгоё.
- Хүүхдүүд юу хийснийг бодъё.

#### Ойлгохын тулд асуултаар ярилцъя.

- Ээж аавын захиас юу байв?
- “Дүүгээ харах юухан байх вэ?” гэж бодсоны учир юу вэ?
- “Нүдэнд будгийн өнгө алаглавч, чихэнд хонхон дуу уяатай” гэсэн өгүүлбэр хэний тухай хэлж байна вэ?

#### 3 Эхийн үргэлжлэлийг уншиж ойлгоё.

1. Аль нэг баатрын үйл хөдлөлийг хөөж уншъя.
2. Тэр баатрын үйл хөдлөл юутай холбогдож байгааг мэдье.

**Хүслэн, Сэгсгэр шарын үйл хөдлөлийг хөөж уншихаар боллоо.**

... Тэр агшинд Сэгсгэр шар ч бас зугаатай шинэ тоглоомоо олж чаджээ. Гэрийнхээ гадаа хийлсэн том бөмбөгөөр наадаж байлаа. Бариад авах гэхээр аяндаа гараас мултарч одно. Түүнийг барих гэсээр нэг мэдэхэд гэрээсээ жаахан холджээ. Тэрхэн зуур нэг хар хэрээ хажууд нь нисэн ирж буув. Энэ юу вэ? Нисдэг тоглоом уу? гэсэн ч хүү алаг бөмбөгөө орхисонгүй. Тэгтэл хэрээ нөгөө бөмбөгийг нь цоо тоншиж орхив. Бөмбөгний писхийн хагарах дуунаас хүү цочиж, амаа өмөлзүүлэн уйлах гэтэл хэрээ улам ойртож, далавчаа дэлгэж хумин, аяглаж гарлаа. Хүү гараа сарвайж бариад авахын даваан дээр хэрээ үл ялиг холдов. Нэг нь дөхнө. Нөгөө нь дөлнө. Тэгсээр тэгсээр балчир жаал залхсан ч юм уу эсвэл ам нь цангаж ядарсан ч юм уу, гэнэт дороо лагхийн сууж орхив. Хэрээ “За одоо яадаг билээ?” гэсэн мэт хүзүүгээ гилжийлгэн байснаа гэнэт дон дон дуугарсаар нисэж одлоо...



Сэгсгэр шар юу юу хийсэн бэ?

**4 Хүүгийн хийсэн үйл ба шалтгааныг мэдье.**

- Сэгсгэр шарын хийсэн үйл хөдлөлийг жагсаан бичье.
- Сэгсгэр шарын үйл хөдлөл бүрийн шалтгааныг бичье.

**Энгүүн ингэж бичжээ.**

<i>Сэгсгэр шарын үйл хөдлөл нь</i>	<i>Шалтгаан нь</i>
<ul style="list-style-type: none"> <li>• Бөмбөгөөр наадсан.</li> <li>• Гэрээсээ холдсон.</li> <li>• Хэрээтэй таарсан.</li> <li>• Бөмбөгөө орхиогүй.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Уйдсан учраас</li> <li>• Бөмбөгөө барих гэж хөөсөн учраас</li> <li>• Баригдахгүй байгаа нь сонирхолтой байсан учраас</li> </ul>



Жаахан дутуу байгааг нь гүйцээн хэлж, найздаа тусалъя.

**5 Хэрээний хийсэн үйл хөдлөл ба шалтгааныг бичье.**

- Хэрээний үйл хөдлөлийг жагсаан бичье.
- Хэрээний хийсэн үйл хөдлөлийн шалтгааныг бичье.

<i>Хэрээний үйл хөдлөл нь</i>	<i>Шалтгаан нь</i>
.....	.....
.....	.....





Би яах гэж ингэж  
байгааг мэдэж  
байна уу?

Мэдэхгүй ээ.

**САНАМЖ**

Сайн бодож үзвэл үйл  
хөдлөл бүр шалтгаантай.



**6 Үйл хөдлөл ба шалтгааныг зөв найруулан бичье. Ажиглая.**

Хүүгийн гэрээсээ холдсон  
шалтгаан нь өнхөрч холдсон  
бөмбөгөө хөөн мөлхсөнөөс болсон.

Хүү, өнхөрч холдсон бөмбөгөө  
хөөсөөр гэрээсээ холдсон.



Ажиглахдаа:

- Үйл хөдлөл, шалтгаан хоёрын байр солигдсон ч утга нь ижил байгааг анхаараарай.

**7 Бусад баатрын үйл хөдлөл ба шалтгааныг ялган ярилцъя.**

- Ярилцахын тулд би юу гэж асууж болох вэ?
- Бас надаас асуувал би юу гэж хариулах бэ?



Яагаад?  
Ямар учраас?  
Яах гэж?  
Учир юу вэ?

Ингэж ярилцаж  
болох юм.



Яагаад гэвэл .....  
учраас  
Тийм учраас  
Тэгсэн учраас

**8 Цааш юу болсныг сонирхон уншиж ойлгоё.**

- Үйл хөдлөл ба шалтгааныг ялган мэдье.
- Үйл хөдлөл ба шалтгааныг найздаа ярьж өгье.

(үргэлжлэл)



... Удсан ч үгүй эргээд ирлээ. Амандаа зуусан мөчрөө хүүгийн өмнө хаячихлаа. Мөчир дэх тас хар жимснээс нэгэн товчийг таслан авч амандаа хийтэл хэрээ нөгөө мөчрийг даруй шүүрэн зууж цааш алхав. Амтат жимс хүүг босголгүй яах вэ. Хэрээний бодож олсон нь талаар болсонгүй. Жимстэй мөчрөөр даллан их л маадгар явтал гэнэт нэг зараа гараад ирэв гэнэ. Арзгар зараа, Сэгсгэр шарыг андахгүй. Байн байн тэднийд айлчилж, сүү, шар ус уусаар ижил дасал болчихсон юм чинь.

Бачит хэрээ гиг гиг дуугарахаараа л дандаа аймшгийн юм руу хөтөлдөг. Түүнийг



зараа сайн мэднэ. “Ухаан ороогүй хүний жаахан үр миний муу хэдэн шөнтгөр бөөдийнөөс ялгаа юу байх вэ дээ” гэж бодсон эх зараа, Сэгсгэр шар, хэрээ хоёрын дундуур бөмбөг шиг өнхөрч гарлаа. Түүнийг хүү таньсан ч юм уу, эсвэл түрүүчийн бөмбөг шиг санагдсан ч юм уу араас нь дагалаа. Түүнийг хэрээний аргаар гэр лүү нь эргүүлж хөтөллөө.

Багартлаа хилэгнэсэн хэрээ гуаг гэж ганцхан муухай хашхираад, зарааны өргөст дээлийн өвөр лүү өрөм шиг хурц хошуугаа далд ортол шигтгэж орхив. Зараа муужирчээ. Сэхээ орон өндийвөл нөгөө хэрээ чинь Сэгсгэр шарыг мухар ганганд хашчихсан “Хүр-р-р-ээд ир-р-рээ!” хэмээн нөхдөө дуудаж үзэгдэв гэнэ. Тэд тал талаас нисэж ирсээр, мөдхөн хэрээний найр эхлэх нь бололтой. Хэрээ дагавал хэрэг бишиднэ, зараа дагавал зам зөвдөнө гэдгийг балчир амьтан яаж ч мэдэх билээ дээ. Зараа яах ч учраа олохгүй дэмий л түнтгэнэн бухимдаж байтал Сэгсгэр шарын бойтог харагдав. Зараа түүнийг шөргөн дээлэндээ шигтгэж аваад, хот айлын зүг одлоо...



(Ж.Дашдондог)

**9 Эхийг илүү сайн ойлгохын тулд дахин уншъя.**

- “Нисэх” гэсэн үйл хөдлөлүүдийн ялгааг мэдэхийн тулд шалтгааныг нь олъя.
- Шалтгааныг нь олохын тулд асуулт тавья.

Үйл хөдлөл	Асуулт	Шалтгаан нь
Хажууд нь нисэн ирж буув.	Яах гэж нисэн ирж буув?	Хүүг сонирхож буусан.
Дон дон дуугарсаар нисэж одлоо.	Юуны учир нисэж одов?	Хүүг улам холдуулах юм олж ирэхээр нисэж одсон.
Тал талаас нь нисэж ирэв.	Яах гэж тал талаас нисэн ирэв?	Хүүг ..... ?

Нисэхдээ ч өөр өөр шалтгаантай байна шүү дээ.



Тийм байна. Шалтгааныг олбол сайн ойлгох юм байна.



**10 Эх яаж төгссөнийг мэдэхийн тулд анхааралтай сонсьё.**

- Сонсоод ойлгосноо бичье.
- Асуултаар ярилцъя.

Ямар ямар үйл хөдлөлүүд байсан бэ?	
Дүүгийнх нь бойтог зарааны үсэнд шигтгээстэй байхыг хараад, хүүхдүүд юу гэж ойлгов?	Дүүгийнх нь бойтог зарааны үсэнд шигтгээстэй байсны учир юу вэ?
Эцэг эх нь мориноосоо ч буулгүй давхихад хүүхдүүд юу гэж бодсон бол?	Эцэг эх нь мориноосоо ч буулгүй давхисны учир юу вэ?
...”Хонхтой бойтгоор мэдээ хүргэж ирсэн байна шүү дээ” гэдгийг хүүхдүүд юу гэж ойлгосон бэ?	Аав нь “Зараа хонхтой бойтгоор мэдээ хүргэж ирсэн байна шүү дээ” гэж хэлэхэд хүүхдүүд гэмшсэний учир юу вэ?



## Шинэ санаа нэмж, хэлэлцье.

### Дүрийн хэлэлцүүлэг хийцгээе.

- 1 Зохиолд гарч байгаа дүрүүдийг жагсаан бичээрэй.
- 2 Дүрүүдийг сайн, муу үйл хийснээр нь хоёр хэсэгт хувааж бичье.

Сайн үйл хийсэн дүр	Муу үйл хийсэн дүр	?
эцэг эх	Хэрээ	Ах эгч нарын дүр
Сэгсгэр шар		
зараа		

- 3 Хүүхдүүд ээ, ах эгч нар нь ямар үйл хийсэн бэ?  
Сайн дүр үү? Муу дүр үү? Учир шалтгааныг ярилцан хэлэлцье.
- 4 Хэлэлцэх чадвараа дараах шалгуурын дагуу үнэлээрэй.

Өөрийн үнэлгээний шалгуур	Тийм	Үгүй	Цаашид юуг анхаарахаа бичээрэй.
Би хэлэлцүүлэгт оролцохдоо саналаа нэмэрлэдэг.			
Бусдын ярьсныг дэмжиж ярилцдаг.			
Бусдын яриаг дуустал анхааралтай, хүлээцтэй сонсож чаддаг.			
Бусдын ярьсныг ойлгосон гэдгээ илэрхийлдэг.			

### Зохиолд шинэ орчин, баатар нэмж хэлэлцүүлгийг үргэлжлүүлье.

- 1 **Зохиолын орчныг өөрчлөн хэлэлцье.**
  1. Үйл явдлыг хаана өрнүүлж болох вэ?
  2. Сэгсгэр шарын байсан орчинд ямар үйл хөдлөл болохыг төсөөлөн бодъё.
  3. Төсөөлөн бодсоноо өрнүүлэн бичье.
- 2 **Шинэ баатар нэмбэл зохиол яаж өөрчлөгдөхийг хэлэлцье.**
  1. Сэгсгэр шартай, туулай тааралдвал яах байсан бол хамт тоглох болов уу?
    - Энгүүний бичсэнийг сонирхъё.  
*Туулай дэгдэж үсэрч явахыг хараад, Сэгсгэр шар гайхан ход ход инээнэ.*

*Туулай чимээ гарахаар айж дэгдсэнээ өөртэй нь адил жижигхэн хүүхдийг хараад, бас гайхан сониучирхан харна. Хүүбөмбөгөө өнхрүүлэхэд нь туулай айж дэгдсэнээ мөн л сонирхон эргэж ирнэ. ...*

    - Чи яаж төсөөлөн бичмээр байна вэ?
  2. Сэгсгэр шарыг жимстэй мөчрөөр хуурч, гэрээс нь улам холдуулж байх үед зараа биш, яг тэр газар хургачин хүү хэрээтэй тааралдсан бол яах байсан бол? Төсөөлөн ярьж, бичье.



## Учир шалтгааныг тайлбарлан ярьцгаая.

### 1 Зургийг ажиглая. Ялгаатай ба төсөөтэй талыг ярилцъя.



### 2 Уншиж ойлгоё.



Уншихдаа:

- Баатрууд юу, юу хийснийг тэмдэглээрэй.
- Баатрын үйл хөдлөл юунаас болж өөрчлөгдсөнийг бодоорой.
- Цогцолбор бүрийн утга ямар шалтгаанаар, яагаад холбоотой байгааг тодруулаарай.

## ГОЁ ӨДӨР

Цас лавсан орсоор... Хулгана нүхэндээ унтана. Баавгай ичээндээ нойрсоно. Эмгэн хумс, ясан гэртээ нойрсоно. Хэрэм модны хонгилд унтана. Тарвага газар доорх гэртээ унтана.

Тэгтэл хулганууд нүдээ нээн, ямар нэг зүйл үнэрлэв. Баавгайнууд ч бас тэр үнэрийг мэдрэв. Бяцхан эмгэн хумснууд ч үнэртэж эхлэв. Модны хэрэмнүүд ч шиншилж гарлаа. Тарваганууд ч нүхнээсээ цухуйн, ямар нэг зүйлийн үнэр авав.

Үнэр гарсан зүг рүү хулганууд гүйлдлээ. Баавгайнууд ч тэр зүг хурдаллаа. Эмгэн хумснууд ч ясан гэртэйгээ гүйлдлээ. Хэрэмнүүд ч бас хонгилоосоо дүүлэн гарлаа. Тарваганууд ч нүхэн гэрээсээ гарч, гүйлдлээ. Үнэрлээд л байлаа. Гүйлдээд л байлаа. Гүйлдээд л байлаа. Үнэрлээд л байлаа. Тэгж тэгснээ гэнэт зогслоо. Зогсоод инээлдэв. Инээлдээд бүжиглэв.

Тэгээд цөмөөрөө чангаар “Тэгнэ ээ, тэр. Цасан доороос цэцэг ургажээ” хэмээн хашхиралдав.

(Пут Крауз)

### 3 Уншсанаа ярилцъя.

Эхний цогцолборт	Юуны тухай өгүүлсэн бэ? Амьтдыг дүрслэхдээ ямар үг хэрэглэсэн бэ?	Дүрслэн ярья.
Хоёр дахь цогцолборт	Амьтдад юу мэдрэгдсэн бэ? Анх ямар амьтан яаж мэдэрсэн бэ?	Дэс дараалалтай ярья.
Гурав дахь цогцолборт	Амьтад юуны учир гүйлдсэн гэж бодож байна вэ? Хашаа яах гэж гүйлдсэн бэ?	Өмнөх хэсэгтэй холбон дэс дараалалтай ярья.
Дөрөв дэх цогцолборт	Амьтад юуны учир баярласан бэ? Эхний хэсгээс энэ хүртэл ямар өөрчлөлт гарсан бэ? “Гоё өдөр” гэсний учир нь юу вэ?	Эргэцүүлэн бодож ярья.

### Аливаа хэлц бүхэн утгын хувьд учир шалтгаантай.

- 4 “Гоё өдөр” зохиолд дэлхий дэлэгнэхийг харан баясаж байгаа амьтдын тухай өгүүлжээ” гэсэн өгүүлбэр дэх хэлц үгийн тухай ойлгож уншаарай.

#### “Дэлхий дэлэгнэх” хэлц үгийн тухай

Дэлэгнэх гэдэг нь мал, амьтны төллөх ойртож, хөх дэлэн нь томрохыг хэлнэ. Үнээ дэлэгнэх гэж ярьдаг. Энэ нь үнээ тугаллах дөхөж, хөх дэлэн нь сүү шимээр арвин болохыг хэлж байна. Сүү шим арвин байх тусам дөнгөж төрсөн тугал хурдан, бас эрүүл өсөж бойжно.

Урин дулаан цаг ирж, хур бороо орсноор байгаль дэлхий сэргэн өнгө засаж, өвс ногоо ургаж, газар дэлхий номин ногоон өнгөөр тунаран байх үеийг монголчууд ихэд таашаан өнтэй сайхан жил болж, мал сүргээ тарган тавтай өсгөж, үржүүлэхийн урьтал хэмээн үздэг билээ. Мал амьтан дэлэгнэх нь сүү шим арвин болж, улмаар төл мал хурдан бойжиж, мал сүрэг өсөж үржихийн эхлэл юм. Иймд нар хур тэгширч, урин дулаан болж, өвс ногоо урган дэлгэр сайхан цаг гарахыг монголчууд “дэлхий дэлэгнэх” гэж зүйрлэн хэлдэг байна.

### 5 Уншсанаа ярилцъя.

1. Дэлэгнэх гэж юу гэсэн утгатай үг вэ?
2. “Үнээ дэлэгнэх”, “дэлхий дэлэгнэх” гэсэн хоёр утгыг харьцуулж яриарай. Ижил тал байна уу?
3. Дэлхий дэлэгнэх гэж монголчууд хэлдгийн учир шалтгаан нь юунд байна вэ?
4. Та нар ямар тохиолдолд энэ хэлцийг хэрэглэж ярьж, бичих вэ?
5. Хэлц үгийг хэрэглээд, өгүүлбэр зохиож бичээрэй.





## Хэлц үг хэрэглэн, өгүүлбэр, эх зохион бичье.

- 1 “Хаяа” гэдэг үг оролцсон дараах хэлц үг байдаг аж. Та нар утгыг нь ойлгож цээжлээд, ярихдаа, бичихдээ хэрэглэж хэвшээрэй.

ХАЯА НИЙЛЭХ

ХАЯАГАА МАНАХ



ХАЯАГАА ХАДРАХ

ХАЯАНД ИРЭХ

ХАЯА ДЭРЛЭХ

Үгийн тайлбар:

Хаяа гэдэг нь юмны зах хязгаар, хөвөө. Гэрийн хана, туурганы ёроол талыг хэлнэ. Тэнгэрийн хаяа гэж бас хэлдэг нь тэнгэрийн хязгааргүй зах хэсгийг зааж байна.

### “Хаяа нийлэх” хэлц үгийн тухай

Хөрш айлтайгаа таарамжтай, эвтэй найртай, харилцан бие биедээ тус дэмтэй байхыг хэлнэ. Ялангуяа малчин айлууд адуугаа манах, хонь малаа ялгаж хариулах зэрэг ажилд ээлжилж, бие биедээ туслан, аливаа ажлыг хамтран хийдэг байна.

### “Хаяагаа хадрах” хэлц үгийн тухай

Гахай соёогоороо газрын хөрсийг хүү татахыг хадрах гэнэ. Газрын хөрсийг гэмтээж байгаа үйлтэй адилтган айл зэргэлдээ хүмүүстээ гэм хор хүргэх, адуу малыг нь хулгайлах гэх мэтээр хорлож буйг “хаяагаа хадрах” гэж хэлдэг байна.

### “Хаяагаа манах” хэлц үгийн тухай

Хаширлах болгоомжлох гэсэн утгатай. Монголчууд хүйтэн өдөр гэрийн хаяагаар элс, шороо, эсгий, хулс, модоор тойруулан хаяавч хийж, дулаанаа хадгална. Хаяаг нь сайн манасан гэр салхи шуурганд хөдөлгөөн багатай, хүйтэн жавар орохгүй дулаан сайхан байдаг байна. Үүнтэй нэг адил урьдаас болгоомжлон, муу бүхнээс сэргийлэхийг хаяагаа манах гэж хэлж заншжээ.

### “Хаяанд ирэх” хэлц үгийн тухай

Ямар нэгэн төлөвлөсөн ажил, үйл хэргийн тогтсон хугацаа ойртсоныг “хаяанд ирлээ” гэж ярьдаг. “Нохойн дуу ойртох” гэсэн хэлцтэй ойролцоо утгатай.

- 2 Дээрх хэлц үгийг оролцуулан өгүүлбэр зохиож бичээрэй.
- 3 Дээрх хэлц үгийг оролцуулан эх (30-40 үгтэй) зохиож бичээрэй.

Эхийн гарчгаас сонгоорой.

“Бусдад гэм хор хүргэдэг хүн байхгүй”

“Урлагийн үзлэгтээ бэлтгэсэн нь”

“Манай хөрш айл”

- 4 Хаяа дэрлэх, хаяа түших гэсэн хэлцүүдийн тайлбаруудыг энэхүү номоос уншаарай.







## УРИАЛГА БИЧИЖ СУРЦГААЯ.

Сайн үйл, муу үйлийн тухай хэлэлцэж, хэлэлцэх явцдаа бусдын саналыг анхааралтай сонсож сурна. Хэлэлцүүлэгт саналаа нэмэрлэдэг болно. Зорилгодоо тохируулан уриалга бичиж сурна.



### Зорилгодоо тохируулан уриалга бичицгээе.

#### СЯНАМЖ

Бусдад хандаж, тэднийг сайн сайхан зүйлд уриалж дуудаж бичсэн нь уриалга юм.

Хүүхдүүд ээ! Аав, ээжийнхээ захиж хэлснийг мартаад, дүүгээ орхисон ах эгч нарт, гоё өдөрт баярлан хөгжилдсөн амьтдад хандаж уриалга бичье. Бичихээсээ өмнө уриалга яаж бичдэгийг судалъя.

### 1 Найзуудынхаа бичсэн уриалгыг харьцуулан уншъя.

Намайг дэмжээрэй	Амжилтыг дэмжье
<p>“Зараа” зохиолыг уншаад, би ч гэсэн хааяа ээж аавынхаа хэлснийг мартаад, дүүгээ анзаарахгүй орхидог байсан минь санагдчихлаа. Үүнээс хойш өөрийнх ч гэлтгүй бяцхан дүү нартаа тусалж байя гэж бодсон шүү.</p> <p>Найзууд аа! Ээж аавдаа тусалж, бяцхан дүү нараа халамжлан асарч, үлгэр дуурайлтай сайн ах эгч нь байцгаая.</p> <p>24 дүгээр сургуулийн 4<sup>б</sup> ангийн сурагч Б.Нэмүүлэн</p>	<p>Бид улсын аваргатай болохыг хүсэж байна.</p> <p>4<sup>а</sup> ангийн сурагч П.Отгон-Од шатрын тэмцээнд оролцохоор бэлтгэл хийж байна.</p> <p>Түүнийг амжилт гаргахад нь тусалж, сайхан сэтгэлээр “Чи чадна” гэж дэмжицгээе.</p> <p>4<sup>б</sup> ангийн хамт олон</p>

### 2 Уншсан уриалгаа ярилцъя.

1. Хүүхдүүд хэнд хандаж, юу гэж уриалсан байна вэ?
2. Хүүхдүүд уриалга гаргах болсны учир юу вэ?
3. Чи уриалгыг нь дэмжиж, юу хиймээр байна вэ?
4. Гарчгаа яаж бичсэн бэ?

### Уриалга бичих санаагаа олж, төлөвлөө.

### 3 Дараах асуултын дагуу хэлэлцээрэй.


1. Хүүхдүүд ямар сайн үйл хийдэг вэ? Нэрлээрэй.
2. Томчууд, эсвэл хүүхдүүд ямар ямар муу үйл хийдэг вэ? Хэлэлцээрэй.



Хэлэлцэхдээ:

- Хүүхэд бүр саналаа нэмэрлээрэй.
- Хэлэлцэх явцдаа бусдын ярьсныг дэмжиж, саналаа хэлээрэй.
- Хэлэлцэх явцдаа бусдыг ойлгож, сонсож байгаагаа илэрхийлээрэй.
- Бусдын яриаг дуустал анхааралтай, хүлээцтэй сонсоорой.

3. Багт хуваагдан, муу үйлүүдээс сонгон, сайн сайхан зүйлд уриалж хэлэлцээрэй.



### Санаагаа цэгцэлж, зөв байрлуулъя.

#### 4 Уриалгаа яаж бичихээ төлөвлөө.

1. Уриалга нь гурван хэсэгтэй байна.

Эхлэл хэсэг	Гол хэсэг	Төгсгөл хэсэг
Уриалах зүйл	Уриалга бичих болсон шалтгаан	Хэн уриалснаа бичнэ.

2. Уриалж бичих үгээ төлөвлөөрэй.

Жишээ нь: Ном уншихыг уриалж бичихдээ дараах үгийг сонгож болно.

**Сонгон хэрэглэх үг:** оюун ухааныг, номын, танин мэдүүлэх, дуртай, сайхан сэтгэгдэл, сонирхолтой, хөгжилтэй, их зүйл сурах, хөгжүүлэх, мэдлэг, бэлэглэх, уриалъя, уншихыг, найз нартаа, хамт олноороо

#### 5 Төлөвлөсний дагуу ноороглож бичээрэй.

### Бичсэнээ хянаж, сайжруулъя.

#### 6 Дараах шалгуураар сайжруулаарай.

1. Бусдад хандахдаа сайн сайхан зүйлд уриалсан байна уу?
2. Уриалга бичих шалтгаанаа тодорхой илэрхийлсэн үү?
3. Догол мөрийг зөв гаргасан уу?
4. Зөв бичих дүрмийн алдаа байна уу?
5. Бүтцийн дагуу уриалгаа бичсэн үү?

#### 7 Сайжруулснаа хичээнгүй хуулж бичээрэй.

# 12

## УРИЛГА БИЧИЖ СУРЦГААЯ.

Зорилгодоо тохируулан урилга бичиж сурна. Хатуу, зөөлний тэмдгийн тусгаарлах үүргийг мэдэж, зөв бичиж сурна.



### Зорилгодоо тохируулан урилга бичигдгээ.

1 Хэн, хэнийг юунд урьсныг ярилцацгаая. Ямар үг сонгосныг ажиглаарай.



2 Урилга дээр юу, юу бичиж болохыг жагсааж бичигдгээ.

1

Хэнийг урихаа бичнэ.

2

Юунд урихаа бичнэ.

3


Хаана, хэзээ ирэхийг бичнэ.

4


Хэн эсвэл ямар байгууллага урьсныг бичнэ.

3 Ямар нэгэн үйл ажиллагаанд найзыгаа урьсан урилга бичигдгээ.

•Урилгын үгийг олон янзаар бичиж болно.



оролцохыг  
саатахыг  
морилохыг  
залрахыг  
тухлахыг



сургалтад  
баярт  
цайллагад  
нэвтрүүлэгт  
уралдаанд

4 Бичсэн урилгаа засаарай. Жишээ нь:

*Эрдэнээд  
Найзаа чи миний төрсөн өдөрт  
ирээрэй. Хүлээж байя.  
Хулан*

*Уригла  
Нарт хорвоод мэндэлсэн өдрийн баярын  
цайллагад ирнэ үү.  
2012 оны 10-р сарын 14-ний 15 цагт  
"ИВЭЭЛ" зоолийн газарт болно.  
Оюунаа*

Хатуугийн тэмдэг, зөөлний тэмдгийн тусгаарлах үүргийг мэдье.

1 Дүрмийг ойлгож уншаад, дараах үгсийг ажиглаарай.

нүүе	харь-хар	гэртээ харья	малаа харья	хүрье
саная	барь-бар	гэрээ барья	идэж барья	өсье
оёё	зорь зор	холыг зорьё	мод зорьё	хүсье

**ДЧРЭМ**  
Гийгүүлэгчээр төгссөн эр үгэнд "я, ё"-г залгахдаа өмнө нь "ь", эм үгэнд "е"-г залгахдаа өмнө нь "ь" тэмдэг бичнэ.

**ДЧРЭМ**  
Эгшгээр болон зөөлний тэмдгээр төгссөн үгэнд "я, е, ё"-г шууд залгана.

2 Өгүүлбэрт тохирох үгийг зөв холбон бичээрэй.

- Тариа ногоогоо → урья
- Одоо бүгдээрээ → тарья
- Найзыгаа гэртээ → урья
- Хэрэггүй цаасыг → тарья

3 Дараах өгүүлбэр дэх алдаатай үгийг засна уу.

**Бичсэнээ ярилцъя.**

Ном их уншъя. Уншсан номоо ярилцъя. Тоогоо сайн бодоё. Эрдэмд суралцъя. Ээжийн дээлийг оёоёо. Шинэ хувцсаа өмсөө. Даагаа сургая. Хаалгаа тогший. Ангидаа орьё. Хичээлээ сонсоё. Хувцсаа өмсий. Цэцгээ таръя.

4 Дараах үгсийг ажиглая. Өнгөөр ялгасны учрыг тайлбарлая.

1	нээе	хүрье	хар - харь	малаа харья	гэртээ харья
2	нүүе	хүсье	бар – барь	идэж барья	гэрээ барья
3	саная	үзье	зор – зорь	мод зорьё	холыг зорье
4	бэлчээе	мэдье	сор – сорь	ундаа сорьё	өөрийгөө сорье
5	оёё	сүлжье	бол – боль	найз болъё	хоцрохоо болье
6	хүргэе	хэльье	тар – тарь	хичээл тарья	мод тарья
	.....ээр төгссөн үгэнд “я, е, ё”-г ..... залгана.	.....ээр төгссөн ... үгэнд “е” залгахдаа өмнө нь “...” бичнэ.	Харьцуулан хэлэхэд ..... байна.	.....ээр төгссөн ... үгэнд “я, ё”-г залгахдаа өмнө нь “...” бичнэ.	“...” -ээр төгссөн үгэнд “я, е, ё”-г ..... залгана.

5 “я, е, ё” залгаврыг зөв залган бичээрэй.

хураа	соль	инээ	шид	хуул
тойруул	тохир	гүйлд	уулга	хад
гүйцээ	ороо	хорь	оё	бүрь
урь	өг	аял	асар	уя
тэл	буц	нэмнэ	бич	тэмдэглэ
баримтал	сана	захь	заа	оно

6 “я,е,ё” залгаврыг зөв залган бичиж өгүүлбэрийг гүйцээгээрэй.

Уншсан зүйлээ ярилц.я.	Хэлц үгийг зөв хэрэгл.е.
Хамтдаа үлгэр яр.я.	Хоёулаа оньсого таалц.я
Хурдан морио уя.я.	Шүлэг, магтаал цээжил.е.
Монгол цамц оё.ё.	Тоогоо сайн бод.ё.
Сонин сэтгүүл зах.я.	Цаасаа арвилан хэмн.е
Цонхоо дулаалж наа.я.	Модоо хайрлан хамгаал.я

7 Дараах дүрмийг зөв харгалзуулан сурсан, мэдсэнээ бататгая.

- |  |   |
|--|---|
| <ul style="list-style-type: none"> <li>• Гийгүүлэгчээр төгссөн эм үгэнд “е”-г залгахдаа өмнө нь “ь” тэмдэг бичнэ.</li> </ul>   | <ul style="list-style-type: none"> <li>• хэмнэе, өсгөө, хичээе, гамная</li> </ul> |
| <ul style="list-style-type: none"> <li>• Эгшгээр төгссөн үгэнд “я,е,ё”-г шууд залгана.</li> </ul>                              | <ul style="list-style-type: none"> <li>• сурья, уншья, бодъё, магъя</li> </ul>    |
| <ul style="list-style-type: none"> <li>• Гийгүүлэгчээр төгссөн эр үгэнд “я,ё”-г залгахдаа өмнө нь “ь” тэмдэг бичнэ.</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>• хөгжье, дэмжье, мэдье, бичье</li> </ul>  |
| <ul style="list-style-type: none"> <li>• Зөөлний тэмдгээр төгссөн үгэнд “я,е,ё”-г шууд залгана.</li> </ul>                     | <ul style="list-style-type: none"> <li>• сахья, тахья, урья, барья</li> </ul>     |

## Би юу сурсан бэ?

Өөрийгөө шалгах асуулт	Хамгийн сайн чаддаг болсон зүйл	Цаашид яаж сайжруулах вэ?
Хэлэлцүүлэгт шинэ санаа нэмэрлэж бусдын ярьсныг хүлээцтэй сонсож сурсан уу?		
Зорилгоо тодруулж уриалга яаж бичих вэ?		
Зорилгоо тодруулж урилга яаж бичих вэ?		
“я, е, ё” эгшгийг үгэнд яаж зөв залгах вэ?		
Чамд ямар бэрхшээл байна вэ?		

### Өөрийгөө үнэлсний дараа юу хийх вэ?

1. Сайжруулах зүйлээ сонгон, багшаасаа тусламж хүсээрэй.
2. Амжилтад хүрэхийн тулд холбогдох дасгалыг ажиллаарай.

- 1 Үлгэрийг анхааралтай уншъя.

### БУГА

Буга ус уухаар гол дээр ирж, өөрийнхөө усанд туссан дүрсийг харан том даргар эврээрээ бахархан, хөлөө харж:

- Миний хөл даанч турьгүй, нарийхан, доожоогүй юм гэж үглэж байв.

Гэнэт арслан гарч ирэн, буга руу дайрав. Буга уужим талаар хар хурдаараа зугтаж баригдалгүй явснаа ойд ормогц эвэр нь модонд тээглэн ороолдож, арсланд баригдчихжээ.

Буга амь үрэгдэхийн даваан дээр “Ямар хачин юм бэ? Би эврээ ямар гоё юм бэ? гэж бахдаж байсан юм сан. Голж байсан нарийхан хөл минь аюулаас аварч, бахдан дэнхгэнүүлж байсан даргар эвэр маань намайг аюулд унагадаг байна шүү. Аливаа юмыг үзэгдэх хэлбэр, өнгөөр нь үнэлж цэгнэж болдоггүй юм байна” гэж бодов.

(“Панчатантра үлгэр”-ээс)

- 2 Үлгэрийн утгад тохирох зүйр цэцэн үгийг сонгоно уу.  
Яагаад сонгосноо тайлбарлая.  
А. Зөв олон талтай                      Б. Өөдөө хаясан чулуу  
Буруу ганц талтай                      Өөрийн толгой дээр
- 3 Бугын хийсэн үйл хөдлөлийг жагсаан бичээрэй.
- 4 Буга, арсланд баригдсаны шалтгааныг олж, тайлбарлан бичээрэй. Яаж, ямар аргаар учир шалтгааныг олсон бэ?
- 5 Бугаар ямар хүний зан чанарыг үзүүлсэн гэж бодож байна вэ? Бичье.
- 6 Ангийнхандаа хандан уриалга бичээрэй. Уриалгыг бичихдээ санаагаа хэрхэн төлөвлөж байрлуулдгийг санаарай.
- 7 Шинэ номын нээлтэд зориулсан урилга бичээрэй.
- 8 “я, е, ё” эгшгийг ямар үгэнд яаж залгадаг вэ? Тав, таван жишээ үг олж, дүрмийг тайлбарлан бичээрэй.



# 13

## ЗӨВ, ХУРДАН, ОЙЛГОЖ УНШИХ ЧАДВАРАА ХӨГЖҮҮЛЬЕ.

Зохиолыг зөв, хурдан, ойлгож уншиж сурна. Хэлэлцүүлгийн явцад бусдын санаа бодлыг анхааралтай сонсож дүгнэнэ. Эх, өгүүлбэр зохиохдоо хэлц үгийг утгаар нь зөв хэрэглэнэ.



### Зохиолын гол санааг ойлгож сонсьё, уншъя.

#### 1 Зохиолч В.А.Сухомлинскийн “Бялзуухай гадаа хоносны учир” эхийг сонсоорой.

1. Ямар цаг улирал байсныг анхаарч сонсьё.
2. Өвлийн оройн дүрслэлийг нөхөж бичье.

.....орой ....., тэнгэрт ....., цөөрмийн мөс .....

3. Бялзуухайн хийсэн үйлийг нөхөж бичье.  
Бялзуухай ирэв. Тэд бие биедээ ..... сууцгаалаа. Тэд үүрэнд ..... орцгоов.
4. Бялзуухай хүйтэнд гадаа хоносны учрыг тайлбарлая.
5. Зураглалыг хараад, эхийн гол санааг ярилцъя.




6. Эхийг дахин сонсоод, гол санааг жишээ татан бичье. Ингэхдээ учир шалтгааныг тодруулъя.  
Хар тодлын үүрийг олж харсан ч .....  
Эх бялзуухай гадаа хоцорсон учир .....

#### 2 Анхааралтай сонссоноо үнэлье.

Өөрийн үнэлгээний шалгуур	Маш сайн	Заримдаа	Ойлгож сонсоогүй	Цаашдын зорилго
Багшийнхаа уншсаныг анхаарлаа төвлөрүүлж, ойлгож сонссон				

1 Уншихаасаа өмнө нүдний дасгал хийгээрэй.



2 Үлгэрийн утгыг ойлгож, зөв, хурдан уншаарай.

**ХОВДОГ ЧОНО**

Төөтгөөхөн хүү төө халзан бяруугаа унаад, балт сүхээ бүсэндээ хавчуулаад, түлээ бэлдэхээр ойн захад очжээ. Гэтэл гай газар доороос гахай модон дотроос гэгчээр өлөн чоно гарч ирээд:

- Ходоод гэдэс минь хоосон болохоор хоёр бөөр минь хонхос хонхос хийж байна. Чамайг иднэ гэжээ.

Төөтгөөхөн хүүд юу тохиолдов?

- Ачит буурал чоно гуай минь, амийг минь авар! Төөтгөөхөн хүү би төө халзан бяруугаа өгье гэжээ. Хүү бяруугаа төхөөрөөд, цусыг нь олгойд хийж, чонын нүдийг хариулж байгаад, сэмхэн өвөртөлжээ. Бярууны махыг чоно нүд ирмэхийн зуур залгиж орхиод:

- Төөтгөөхөн минь, бярууны мах юу болох вэ дээ! Шүдний чигчлүүр ч болсонгүй. Одоо чамайг идэж, ов шуналаа дарна гээд ухасхийжээ. Төөтгөөхөн хүү айн сүрдэж, голын мөсөн дээгүүр гүйнгүүтээ халтирсан болоод, олгойтой цусаа хагалаад гоожуулжээ.

Хүүгийн хийсэн үйл хөдлөлийг тоочно уу.

- Хүү чононд:

- Чоно гуай! Долоогоорой, долоогоорой, цус минь гоожлоо гэхэд ховдог чоно долоох гээд хэлээ мөсөнд наалдуулчихжээ.

- Хүү минь! Балт сүхээрээ хэл, мөс хоёрын дундуур цавчаарай гэхэд:

- Аман хүзүү, хатан хүзүү хоёрын заагаар гэж хэлээд цавчжээ. Ингэж ухаант хүү аюулт чонын амнаас амьд мэнд гарч, амар сайхан жаргасан гэдэг. *(Монгол ардын үлгэр)*

Хүү ямар арга хэрэглэсэн бэ? Үйл явдал хаана болсон бэ?

3 Зөв, хурдан уншсанаа 22 дугаар талд байгаа зааврын дагуу үнэлээрэй.

4 Ойлгож уншсанаа үнэлэхийн тулд өгүүлбэр бүрд нэг асуулт зохион бие биедээ тавиарай.

5 Хэлц үгийн утгыг тайлбарлая.

1. Хэлц үгийн утгыг ойлгон уншаарай..

**гай газар доороос, гахай модон дотроос - гэнэтийн саад учрах нүдийг хариулах нүд ирмэхийн зуур**

Гахай газар сэндийлж ухсанаас болж, явах замд гэнэтийн саад гардагтай холбоотой энэ хэлц үг үүсжээ.

2. Эдгээр хэлц үг оролцсон өгүүлбэрийг дахин уншаарай.
3. Хэлц үгийг оролцуулж, өгүүлбэр зохиогоорой.

**6 Уншсанаа ярилцъя.**

1. Хүү балт сүх авч, яах гэж, хаана очсон бэ? Үлгэрийн төгсгөлд юу өөрчлөгдөв?
2. Чоныг бярууны мах идэж байх үед хүү юу бодож байсан бол? Төсөөлөөрэй.
3. Уншиж байхдаа үйл явдлын орчныг яаж төсөөлж байв?

4. Мөсөн дээр үйл явдал өрнөсний учир юу вэ?
  - Ховдог чоноос өөрийгөө аврахын тулд уу?
  - Хүү эртнээс голын мөсөн дээр гүйнэ гэж төлөвлөж байсантай холбоотой юу?
  - Эсвэл мөсөн гол тааралдахаар нь санаандгүй гүйсэн үү?
5. Хүү хэзээ, хаана олгойтой цусаа хагалсан бэ? Энэ үед баатрын ямар зан чанар тодорч байна?
6. Хэрэв чоно байгаагүй бол хүүгийн ямар зан чанар илрэхгүй байх байсан бэ?
7. Хүүгээс өөр хүн байсан бол чоно яах байсан бол?

8. Тулгамдсан нөхцөлд асуудлыг шийдэх арга замаа зөв сонгоход чинь сургамж болж чадахаар байна уу?
9. Үлгэрийн үйл явдлыг хурааж, товчлон бичээрэй.

**7 Тодруулан ярилцъя. Үлгэрийг давтан уншаарай.**

1. Чоныг дийлсэн Төөтгөөхөний үйл хөдлөлд аль нь хамгийн чухал холбоо хамааралтай вэ? Дугаарлая. Яагаад гэдгийг тайлбарлан яриарай.

	Балт сүх авч явсан нь
	Олгойд хийсэн цусыг хагалсан нь
	Голын мөсийг сонгож гүйсэн нь
	Бярууны махаа өгсөн нь
	?
	?

2. Хүүгийн хийсэн үйл нь хаана, хэзээ болсноос шалтгаалж өөрчлөгдсөн үү?

**САНАМЖ**

Зохиолын баатруудын хийж байгаа үйл хөдлөл нь цаг хугацаа, болж байгаа орчинтойгоо холбоотой байдаг юм байна шүү дээ.

## 1 Эхийг зөв, хурдан, ойлгож уншъя.



Уншихдаа:

- Зөв, хурдан уншсанаа 22 дугаар талд байгаа зааврын дагуу үнэлээрэй.
- Утгыг нь мэдэхгүй үгээ толь бичгээс харж тэмдэглэе.
- “Бэлгэшээж ярина, бэлгэшээнэ” гэсэн утгыг та нар хэрхэн төсөөлж байна вэ?

### АМНЫ БЭЛГЭЭС АШДЫН БЭЛГЭ

Ээж маань элдэв бэлгэ дэмбэрэлгүй үг хэлэх бүрийд ингэж сануулдаг байлаа. Хот айлын хэдэн хүүхэд бид нэгэн өдөр хойд голоос ус авахаар хувин сав аваад явцгааж байтал санамсаргүй Довчин гуайтай тааралдчихав. “Хол юманд зорьж байхад ус авахаар яваа хүүхдүүдтэй тааралддаг маань юун аштай вэ дээ. Хэрэг зориг бүтэх нь ээ дээ” гэж ирээд л Довчин гуай өврөөсөө том чихэр гаргаж өгөв. Довчин гуайн хэлсэн үгийг ээждээ хэлтэл:

- Хол юманд явж байгаа хүн аргал түүхээр эсвэл ус авахаар яваа хүнтэй тааралдвал их бэлгэшээж, ажил бүтэх сайны тэмдэг гэдэг юм гэв.

- Яагаад? гэж хүү лавлан асуув.

Араг хоосон үүрч яваа хүн заавал аргаа дүүргээд харьж таарна, усанд сав бариад явж байгаа хүн мөн адил. Тэгэхээр ажил бүтэхийн шинж юм шүү дээ гэжээ. Хүү найз нартайгаа туршихаар шийдэж, араг зэхэж сумын төв орохоор явж байгаа Жаниахүү ахын замыг тостол тэднийг огт тоосонгүй, морио ташуурдан өнгөрч одов. Хүүхдүүд намайг “худалч” хэмээн бид маргалдаж орхилоо. Хүү, ээж дээрээ ирж:

- “Жаниахүү ахтай хоосон араг үүрээд тааралдсан чинь бэлгэшээх байтугай тоосон ч үгүй. Тэрнээс болж хүүхдүүд намайг “худалч” гэлээ” гэхэд ээж:

- Өө, тэр Жаниахүү яаж мэдэх вэ? Одоогийн залуус чинь ёс заншлаа гэж яваа улс даа гээд толгойг минь илснээ “Харин Довчин гуай шиг хуучны хүн мэдэлгүй яах вэ дээ” гэв. Түүнээс хойш ахмад хүмүүсийн бэлгэшээж ярьдаг үгийг их анзаарч сайн тогтоодог болов.

- Замд гарахад чоно тааралдвал үйлс бүтнэ.

- Замд тэмээ туйлбал ачаа хүнд, олз их, сайн явах нь гэж бэлгэшээнэ.

- Агт морь шилгээж, атан тэмээ эвшээхэд эзэн нь заавал бэлгэшээдэг.

- Чанаж буй ходоод хагарах юм бол баяжна гэж бэлгэшээнэ. Энэ бүхнийг эргэцүүлж тогтоодог боллоо.

(Л.Түдэв)

## 2 Үгийн утгыг тайлбарлая.

### “Амны бэлгээс Ашдын бэлгэ”

1. Эхийн утгыг бодож дахин уншаарай.
2. “Бэлгэ” гэсэн үгийн утгыг хэрхэн төсөөлж уншив?
3. Ямар үгс чиний төсөөллийг гаргахад тусалсан бэ?
4. Санамжийг уншаад дүгнэлт гаргаарай.

**САНАМЖ**

- бэлгэ - бэлгэшээж ярих; Сайн зүйл яривал дагаад сайн юм болно.
- бэлэг- гарын бэлэг өгөх; Хүнд бэлэг өгөх сайхан.
- билиг- оюун билиг; Билиг ухаантай хүн

**3 Үгийн утгыг тайлбарлая.**


1. Эхийн утгыг сайн бодож, дахин уншаарай.
2. Утгыг нь мэдэхгүй үгээ тэмдэглэе.

Үгийн утга	Миний бодлоор...	Толь бичгээс харсан нь	Өөрийн бодлыг толь бичгийн утгатай харьцуулсан нь
ашид			
тэмээ туйлах			
агт морь шилгээх			
атан тэмээ эвшээх			
араг зэхэх			

3. Ойлгосноо тайлбарлан ярь. Ярьснаа найруулж бичье.

**4 Зохиолыг үйл явдлын дарааллын дагуу ярь.**

1. Зохиолын баатруудыг нэрлээрэй.
2. Тэд хоорондоо юу ярилцав? Зохиолын үг хэллэгийг хэрэглэж яриарай.
3. Зураглалыг заан, бусдад ойлгомжтой, цэгцтэй ярихад бэлдээрэй.



4. Зохиолоос юуг ойлгов? Ойлгомжтой бичээрэй.



Ярихдаа:

1. Ээж нь хэрэг зориг бүтэхийг бэлгэшээснийг яаж тайлбарлав?
2. Баатруудын хоорондох яриагаар бэлгэшээх ёс яаж илрэв?
3. Хэзээ, хэдийд, ямар үед, хаана бэлгэшээдгийг тодруулаарай.

## 1 Эхийг зөв, хурдан, ойлгож уншъя.

### ЧАВГАНЫ ЯС

Үдийн хоолны дараа ээж нь хүүхдүүддээ өгөхөөр чавга худалдаж аваад, таваглаж тавьсан юм санж.

Ваня хүү чавга идэж үзээгүй байжээ. Амт нь ямар гоё бол гэхээс арааны шүлс асгарна. Дэргэдүүр нь нааш цааш хэд явлаа. Тэсэх аргагүй нь. Зочны өрөө эзгүй байх үеийг тааруулж байгаад, нэг чавга шүүрэн авч, амандаа хийв.

Хоолны өмнө ээж нь чавгыг янзалж байснаа нэг дутуу байгааг ажиглажээ. Тэр тухайгаа аавд нь хэлсэн аж. Аав нь хоолны өмнө “Тэр ганц чавгыг хэн идсэн бэ?” гэхэд бүгдээрээ л “Үгүй, үгүй” гэгцгээв. Ванягийн нүүр чавга шиг улайж “Би ч гэсэн идээгүй” гэв.

Аав нь хүүхдүүддээ “Чавга идсэндээ гол нь биш. Идэж үзээгүй хүүхэд чавганы ясанд хахаж, маргааш нь үхдэг юм. Би түүнээс л эмээж байна” гэхэд Ванягийн нүүр цас шиг цайж, “Үгүй ээ, ясыг нь би цонхоор тургичихсан” гэлээ. Бүгд хөгжилдөн инээлдэж, Ваня харин уйлах нь тэр.

(Л.Н.Толстой)

## 2 Уншсанаа асуултын дагуу ярилцъя.

1. Ванягийн ээж хэзээ, яах гэж чавга авсан бэ?
2. Ээж нь чавгыг хаана тавьсан бэ?
3. Ваня, чавга хаана байгааг яаж мэдсэн бэ?

4. Зохиолч, цаг хугацааг яаж төлөвлөсөн байна вэ?
5. Аавыгаа асуухад Ванягийн царай яагаад улайсан бэ?
6. Ваня гэмшсэн үү? Чи яаж мэдэв?

7. Чамд хүний юмыг зөвшөөрөлгүй авч байсан үе байгаа юу?
8. Энэ зохиолоос ямар сургамж авсан бэ?

## 3 Зохиолын гол санааг илэрхийлсэн хэсгийг сонгоё.

Яагаад сонгосон учраа тайлбарлая.

Найз нарынхаа ярихыг сонсож, тэмдэглэж авъя.

- А. Чавга худалдаж авсан тухай      Б. Үнэнч шударга байхыг сургамжилсан  
В. Ваня хүү айж уйлсан тухай      Г. Ээж аав нь хүүгээ өрөвдсөн тухай

Нүдэлж зөв бичье.

чавга, чавганы, таваглах, тургичихсан  
хахаж, ажиглаж, асгарна

## 4 Зөв, хурдан уншсанаа 22 дугаар талд байгаа зааврын дагуу өөрийгөө үнэлээрэй.





## Хэлц үг хэрэглэн, өгүүлбэр, эх зохион бичье.

1. “Чавганы яс” зохиолын Ваня хүүгийн ихэд айсан байдлыг хэлц үгээр зөв илэрхийлснийг олоорой.
  - А. маш их айж эмээсэн
  - Б. үнхэлцэг нь хагарах шахсан
  - В. хаяагаа манасан
  - Г. толгойгоо ганзагалаад байсан

### “Толгойгоо ганзагалах” хэлц үгийн тухай

Ганзагалах гэдэг нь эмээл дээр богц мэтийн цүнх, уутыг даруулж уяад унжуулан явахыг хэлнэ. Ганзагыг сураар хийдэг. Гунигласан хүн толгойгоо бөхийлгөн, унжуулж явах нь эмээлд богц ганзагалж санжгануулан явах дүр байдалтай төсөөтэй байдгаас зүйрлэн хүний гуниглаж гутарсан байдлыг “толгойгоо ганзагалах” гэж хэлдэг байна.

### “Үнхэлцэг нь хагарах шахах” хэлц үгийн тухай

Үнхэлцэг гэдэг нь зүрхний гадуурх уутыг хэлдэг. Туулайг маш ихээр айлгаж цочоовол үнхэлцэг нь хагардаг гэдэг.

2. Дараах өгүүлбэрийн цэгийн оронд тохирох хэлц үгийг нөхөж бичээрэй.  
 ..... хоосон мөрөөдөөд байвал зорилгодоо хүрэхгүйд хүрнэ.
  - А. Зангууны ноос түүж, эсгий хийхийн адил
  - Б. Харганын унгас түүж, эсгий хийхийн адил

### Үгийн тайлбар:

Зангуу гэдэг нь газарт наалдан ургадаг, хатуу, том өргөстэй жижиг ургамал. Харгана гэдэг нь бутлаг ургамал. Хонины үс ноос, унгас унаж, зангуу, харгана дээр үлддэг. Түүнийг түүж эсгий хийнэ гэдэг хэзээ ч бүтэшгүй ажил болно. Эсгий хийхэд 15-17 кг ноос хэрэглэдэг байна.

3. Зангууны, харганын, хийхийн гэсэн үгсийг үгийн бүтцээр задлаад дүрмийг тайлбарлаж бичээрэй.
4. “Хагарах, ганзагалах, манасан” гэсэн үгсийн балархай эгшгийн үүргийг хэлнэ үү. “Хаграх, ганзаглах, мансан” гэж бичвэл утга нь тодрох болов уу, хэлэлцээрэй.
5. “Хагарах, ганзагалах” гэсэн үгсийн араас “-ыг” залгаврыг залгаж бичээрэй. Яаж бичих вэ? Хэлэлцээрэй.
6. Хүүхдүүд ээ, хоосон мөрөөдөхгүй, зорилгодоо хүрэхийн тулд юу хийж сурах ёстой вэ? Санаа бодлоо хуваалцсаны дараа 40-50 үгтэй эх зохиож бичээрэй.

### Бичихдээ:

1. Бичих санаагаа төлөвлөөрэй.
2. Төлөвлөгөөний санаагаа эхлэл, гол, төгсгөл хэсэгт оруулаарай.
3. Төлөвлөгөөгөө ноороглоорой.
4. Нооргоо засаж хянаарай.
5. Зассанаа дахин бичээрэй.



## Хэлэлцэхдээ бусдын санаа бодлыг анхааралтай сонсож дүгнэе.

### 1 Эхийг ойлгож уншъя.

#### ДЭЛБЭЭТ ЦЭЦЭГ



Нэг шидтэн хүүд 5 дэлбээтэй хүсэл биелүүлэгч цэцэг өгчээ. Цэцэгнээс дэлбээг таслах бүрд чиний нэг хүсэл биелнэ гэжээ. Гэхдээ чи сайн үйлийг хийгээрэй гэв. Хүү их баярлаж, юу хүсэхээ бодсон ч үгүй хамгийн сайхан чихэр, бялуу гээд амттан бүрийг хүсжээ. Хүсэл нь дороо л биеллээ. Дараа нь хүү дэлхийн хамгийн зугаатай тоглоомыг хүсэхэд хүсэл нь бас л биелжээ. Хүү ч улам баярлан, элдвийг хүссээр ганцхан дэлбээ үлдээд, юу гуйснаа бодож, түүний гуйсан зүйл

тийм ч хэрэгтэй биш байсныг ухаарчээ. Хамгийн сүүлд юу гуйхаа бодож гэнэ. Энэ бүх үед ганцаараа байснаа бодож, хамт тоглох найз хайтал түүний ойролцоо нэг охин уйтгарлан сууж байхыг хараад, хамт тоглоё гэсэнд тэр “Миний хөл муу. Би гүйж тоглож чаддаггүй” гэж гуниглан хэлсэнд хүү, охиныг өрөвдөж, хамгийн сүүлийн дэлбээгээ “Тэр охины хөлийг эдгээж өгөөч” гэж хүсэж тасаллаа. Хүү олон дэлбээг сайн үйлд зориулаагүйдээ харамссан ч сүүлийн дэлбээгээрээ охинд аз жаргал бэлэглэсэндээ их л баярлажээ.

(А.Батзаяа)

**Энгүүн:** - Энэ хүү шидтэний олгосон боломжийг ашиглаж чадсан уу? Та нар юу гэж бодож байна вэ? Охины ямар байдал хүүг түүнд туслахад хүргэсэн бэ? Хүү охинд туслах үедээ юуг ойлгож мэдэрсэн бол?

**Хүслэн:** - Харин тийм ээ, эхнээсээ л хүнд хэрэгтэй сайн зүйл хүсэх байж дээ. Хүн өнгөрсөн хойно гэмээ ухаардаг нь харамсалтай ч хүү бусдын төлөө нэг дэлбээг ч гэсэн зориулсан нь юутай сайн хэрэг вэ? Хүнд аз жаргал, эрүүл мэнд бэлэглэсэн байна шүү дээ. Надтай шидтэн тааралдаасай. Ирээдүйгээ ямар байхыг мэдэх юм сан. Бас хүсэх зүйл их байна.

**Бат:** - Тэгвэл найзууд аа, бүгдээрээ ирээдүйнхээ тухай төсөөлж, зөгнөн хэлэлцье.

### 2 Анхааралтай сонсож, дүгнэснээ үнэлье.

Өөрийн үнэлгээний шалгуур	Маш сайн	Заримдаа	Ойлгож сонсоогүй	Цаашдын зорилго
Бусдын санаа бодлыг анхаарлаа төвлөрүүлж, ойлгож сонссон				
Бусдын ярьсныг өөрийнхөөрөө дүгнэсэн				



## Дүрмийг бататгаж, зөв бичье.

### 1 Дараах үгсийн балархай эгшгийн үүргийг тайлбарлаарай.

Жишээлбэл:

нар**ан** балархай эгшиг “н” гийгүүлэгчийг эгшигжүүлэх нэг үүрэгтэй байна.

мэрг**эн** балархай эгшиг “н” гийгүүлэгчийг эгшигжүүлэх, “г” гийгүүлэгчийг ялгах хоёр үүрэгтэй байна.

тугал	хавар	баялаг
тараг	дэвтэр	тэнгэр
булаг	мэдлэг	шугам
иргэн	мөрөн	эрдэм
савхи	сорви	хумхи

### 2 Цэгийн оронд тохирох эгшгийг нөхөн бичиж, холбоо үг зохиогоорой. Тодруулсан үгсийг ажиглаж, утгын ялгааг гарган нүдлээрэй.

зовх.	булг.	анг.	урх.	бар.в
давх.	банд.	занг.	гулг.	хол.х
холх.	бурх.	нуранг.	гарх.	сор.х.
болх.	холб.	цалг.	мор.л	ур.х

### 3 Дараах хэлцийн утгыг тайлбарлан, зөөлрүүлэх үүрэгтэй балархай эгшгийг олж тэмдэглээрэй.

- Борви бохис хийх чөлөөгүй
- Гар хумхих
- Дураараа дургих
- Даарин дээр нь давс хийх
- Номын хурим хийх
- Сураг тавих
- Үнэгний нүд залгих
- Цаасан буу тавих

### 4 Цэгийн оронд тохирох эгшгийг нөхөж, хэлцийн утгыг тайлбарлаарай.

- Амны хиш.гтэй
- Өрөвдөхөд өр лүү өш.глөх
- Өөх ч биш булч.рхай ч биш
- Тэмээ туйлч.хсан юм шиг
- Тархиа гаш.лгах
- Сугыг нь түш.х
- Долоон булч.рхайгаа тооч.х
- Буруу иш.лсэн сүх шиг

### 5 Хэлц үгийг хэрэглэн өгүүлбэр зохиогоорой.

#### **Дүрмээ-сэргээн-санья**

Үгийн дунд “ж, ч, ш” гийгүүлэгчийн дараа богино эгшиг бичихээр бол зөвхөн “и” бичдэг.

## Би юу сурсан бэ?

Өөрийгөө шалгах асуулт	Би үүнийг чадна.	Би дахин судалмаар байна.
Эхээ сонсоод, утгыг ойлгож ярьж чадах уу?		
Асуултад оновчтой хариулсан уу?		
1 минутад уншиж байгаа үгийнхээ авиа бүрийг зөв дуудаж чадсан уу?		
1 минутад хурдан уншсан хэсгийнхээ утгыг ойлгож байна уу?		
Ойлгосноо алдаагүй зөв бичиж чадсан уу?		
Хэлц үгийн утгыг ойлгосны үндсэн дээр өгүүлбэрээ ойлгомжтой зохиож чадсан уу?		
Чамд ямар бэрхшээл байна вэ?		

### Өөрийгөө үнэлсний дараа юу хийх вэ?

1. Сайжруулах зүйлээ сонгон, багш болон найз нараасаа зөвлөгөө аваарай.
2. Амжилтад хүрэхийн тулд бататгах дасгалыг ажиллаарай.

- ① Үлгэрийн орхигдсон үгийг нөхөж бичье.

### АРСЛАН, ХУЛГАНА ХОЁР

Араатны хаан арслан ойд явж байгаад, ихэд ядарсан учир үүрэндээ ирээд унтаад өгчээ. Тэгтэл нэг хулгана дээгүүр доогуур нь яваад унтуулсангүй гэнэ. Арслан сэрээд, хулганыг бариад авав. Уурандаа хулганыг базахын даваан дээр хулгана өршөөл эрэн гуйж гэнэ.

- Намайг битгий алаач. Магадгүй нэг өдөр чамд тус болох ч юм билүү гэв. Арслан хулганы үгийг сонсоод, инээд нь хүрч:

..... Гэхдээ яах вэ, чамайг амьд үлдээе гэв.

Тэр явдлаас хойш хэсэг хугацаа өнгөрөв. Харин нэг өдөр арслан анчдын тавьсан торонд орчихжээ. Хэчнээн үсэрч цовхчин хашхирсан ч торноос гарч чадсангүй. Харин тэгтэл нөгөө амийг нь өршөөсөн хулгана тэр хавиар явж байгаад, арсланг олж харав. Тэгээд шууд л торыг шүдээрээ хэмлэсээр байгаад, арсланг торноос чөлөөлөв. Хулгана, арсланд хандан:

- Чи намайг жижиг гэж голж байсан. Харж байгаа биз дээ, би амийг чинь аварч чадлаа шүү дээ гэв.

Арслан үүнээс хойш ..... гэж итгэдэг болжээ.

(Монгол ардын үлгэр)

- ② Ямар утгатай үг нөхсөн бэ? Яагаад ингэж таамаглав?

- ③ Үйл явдлын утгыг тодруулсан асуулт зохиогоорой.

- ④ Дараах дуудлага ижил үгийг зөв уншаад, утга гарган өгүүлбэр зохиогоорой.

Галын үнс, ээжийгээ үнс, дүрмийг чанд мөрдөхийг, хилийн чанадад, саарьтсан гар, голын сайр, байцай ногоо, байцаагчийн ажил, хууль дүрэм, хуйлсан цаас, аргалын утаа, аргалийн нутаг, эвсэг айл, ааль сайтай, ууль шувуу, битгий уйл, Буйр нуур, гэрийн буурь

# 14

## ТӨСӨӨЛӨН БОДОЖ, ҮЛГЭР ЗОХИОЁ.

Уншсан зохиолынхоо баатрын гадаад дүр байдлыг төсөөлнө. Үлгэр зохиохдоо баатрын гадаад дүр байдлыг тодорхой дүрсэлж сурна. Баатрын харилцан ярианы утгыг ойлгосноор дүрд тоглоно.



### Баатрын гадаад дүр байдлыг ялган уншицгаая.

- 1 Зүйр үгсийн утгыг ярилцъя. Аль баатарт зориулан хэлэхийг бодож уншъя.

*Нөхрийн сайнаар хүн өөдөлнө  
Жуурын сайнаар загас амьдарна*

*Нэг өдөр танилцаж  
Мянган өдөр нөхөрлөнө*

*Нөхрийн сайныг ханилан  
байж таньдаг  
Моринь сайныг унан  
байж мэддэг*

Барбос уу?  
Жулька юу?



- 2 Эхийг зөв, хурдан, ойлгож уншъя.

### БАРБОС ЖУЛЬКА ХОЁР

Барбос, давжаа биетэй ч чийрэг хүдэр нохой. Сагсгар урт үс нь саван, сам, хайч огт хүргүүлж үзээгүй пудель нохойн хамаатан болохыг илтгэнэ. Толгойноос сүүлний үзүүр хүрсэн даахин навтсаа тэр чигээр нь зунжин чирнэ. Хоёр чих нь үргэлж “ширүүн тулалдааны” ул мөр тээж явна. (1)

Жулька бол нарийхан богино хөл, тачирхан гөлчгөр үс, цээжиндээ ов товхон бидэртэй хаа ч байж л байдаг нохой. (2)

Уян наалинхай ааштай, бүрэг дорой амьтан. Гэхдээ хүний бараа харангуутаа шарваганан, хэл амаа долоож маягладаг олон зантай зуйгар нохойноос өөр шүү. Тохитой томоотой хүнийг бол төрөлхийн зоримог зангаараа шууд тулж очоод, өвдгийг нь самардан, хошуугаараа шөргөөж эхэлнэ. Жулька ерөөс гэрт л байхад таарсан нохой. (3)

Харин Барбос тийм биш. Цацагт хяруулын бүхэл бүтэн өрөөлийг нэг суурин дээр зулж орхихоо юман чинээ санахгүй. Тэгээд бас шавар шавхай туулж ирээд, ээжийн цасан цагаан бүтээлэгтэй орон дээр тоохгүй хэвтээд өгнө. Томчуул түүнийг үзэж чадахгүй, зодож хөөхөд хүүхэд бид дотроо их л өмөөрч өрөвддөг сөн. (4)

Хаа очиж Жулька тэр хоёр эвтэй. Магадгүй Жулька түүний танхай зан, ой гутам завааныг нь битүүхэн тунгаах боловч ил гаргадаггүй байх. Тэр ч бүү хэл Барбос өөрийнхөө хоолыг дор нь сорчхоод, өлөв долов хийж таваг руу нь хоншоороо хийхэд ч Жулька тэсээд л өнгөрөөдөг юм. Орой нь хоёулаа хашаан дотор хөөцөлдөн наадаж, архирагдан хэмлэлцэж буй дүр үзүүлнэ. (5)

Нэг удаа манай хашаанд галзуу нохой ороод ирлээ. Барбос огт хөдөлж чадахгүй чичирч, өрөвдмөөр гаслав. Айсан улс дэмий л хашхичин, ам амандаа шуугина. Өнөөх галзуу чинь хоёр гахай, хэдэн галуу барьж орхилоо. (6)

Нэг харсан чинь хаанаас гараад ирснийг бүү мэд, бяцхан Жулька туяхан хөлөө жирэлзүүлэн хурдалж, тэр галзууг хар эрчээрээ дайрч орхив. Тэгнэ чинээ санаагүй байсан улс гайхан дуу алдацгаав. Жулька хүчтэй мөргөсөн хар эрчиндээ харуулдан унаад, тээр хол гулсаад явчихлаа. Галзуу нохой ч арилж өгөв. (7)

Жулькад ганц ч шүдний ор байсангүй. Гэвч Жулька ганцхан өдрийн дотор танигдахын аргагүй болтлоо турж эцэн, нүднээс гарч, энд тэнд шургалан хэвтэнэ. Ухаалаг гялалзах нүднийх нь харцанд зовлон шаналал тодорно. Барбос, Жулькаг үнэрлэж, аяархан гасалж, гийнан байснаа нүд, чих, хамрыг нь долоож гарав. Жулька өндийх гэж оролдовч чадсангүй.

Нохдын хагацал элэг эмтрэм байж билээ. (8)

(А.И.Куприн)

**Нүдэлж зөв бичье.**

төрөлхийн, зоримог, бидэртэй, гийнаж, наалинхай, шарваганан, маягладаг, цацагт хяруулын

### 3 Уншсанаа ярилцацгаая.

1. Барбос, Жулька хоёрын нөхөрлөлийн тухай ярина уу.
2. Зохиолыг уншиж байхад аль хэсэгт чиний сэтгэл хөдөлсөн бэ? Ямар үг нөлөөлөв?
3. Жулька, Барбост сайн ханддагийг ямар үгээр илэрхийлсэн байна вэ?
4. Зохиолч хоёр баатрын эвтэй харьцааг яаж гаргаж бичсэн бэ?
5. Жулькаг найзынхаа төлөө тулалдсаныг чи яаж мэдэв?
6. Зүйр үгсийг аль баатарт зориулан хэлмээр байна вэ?
7. Энэ зохиолыг уншаад, хэнийг өрөвдөв? Зохиолч уншигчийг яаж уйтгартай болгож байна вэ?
8. Энэ зохиолоос ямар үг, ямар дүрслэл таалагдаж байна вэ? Үүнтэй төстэй бичиж чадах уу?



## Баатрын гадаад дүр байдлыг ялгая.

### 4 Сонгож ажиллая.

А. Та нарыг сайн зурдаг гэдэгт итгэж байна. Жулька, Барбос хоёрын гадаад дүр байдлыг зуръя. Тодруулбал:

1. Сагсгар урт үс эсвэл тачирхан гөлчгөр үсийг яаж зурах вэ? Бодоорой.
2. Даахин навтсаа зунжин чирсэн гэвэл зургаар яаж илэрхийлэх вэ? Төсөөлөөрэй.
3. Ямар өнгөөр будах бол? Зохиолоо дахин уншаад, зөвлөн ярилцаарай.

Б. Зургаас хоёр нохойны гадаад төрхийг дүрслэн ярья. Ярихдаа зохиол дахь үгээс хэрэглээрэй.



*Биеийг харьцуулж харъя, ямар ялгаа байна вэ?*

*Хөл нь адилхан биш юм байна. Хоёулаа үстэй боловч ялгаатай байна даа. Өөр ямар ялгаа байна вэ?*

*Үснийх нь өнгө өөр юм байна. Аль нь зоригтой нохой билээ? Дахин уншиж сайн ойлгоё. Зан аашаараа ялгаатай болов уу?*

*Жулькаг гаднаас нь харахад бүрэг дорой амьтан гэж бодож байсан шүү дээ. Гэтэл түүнээс ямар их зориг гарч, нөхрөө хамгаалж байна вэ?*

1. Асуултад хариулагдах үгийг дэвтэртээ бичээрэй.

- Барбос **ямар** биетэй вэ? Ямар? .....
- Жулька **ямар** хөлтэй вэ? .....
- Жулькагийн үс **ямар** вэ? .....
- Барбос **ямар** үстэй вэ? .....

2. Нохойны ямар байдлыг дүрслэн бичсэн байна вэ?

### 5 Утгыг нь мэдэхгүй үгээ тодруулан, дахин уншъя, бичье.

Үгийн утгыг толь бичгээс харан тайлбарлаж бичээрэй.

1 Зургийг ажиглаад, үгийн утгыг тайлбарлан, ярилцъя.



Үг	Миний бодлоор
чөдрийн хаа	
чөдрийн алга	
чөдрийн суман	
чөдрийн чагт	
чөдрийн гогцоо	

2 Эхийг зөв, хурдан, ойлгож уншъя.



Уншихдаа:

- Зохиолын баатрын гадаад дүр байдлыг дүрсэлсэн хэсгийг сонгоё.
- Хоёр баатар юугаараа ялгаатай байгааг бодож уншъя.

### ӨВӨӨГИЙН ГЭЭСЭН ЧӨДӨР

Тулга, Бат хоёр саяхан бэлчсэн хониныхоо хойноос явлаа. Нас бие чацуу энэ хоёр хүүд төстэй зүйл бараг үгүй шахам. Нэг нь монгол дээлтэй, савхин гуталтай, нөгөө нь эрээн цамц, хилэн өмдтэй, улаан шаахайтай. Тулга хөдөөнийх, Бат хотынх.

Гэрээсээ нэлээд холдсон хойно Тулга:

- Ногооны шүүдэр их байна. Хоёулаа гутал, шаахайнуудаа энд орхих уу? гэж Бат найздаа хэлэв. Бат, шинэ шаахайгаа норгочихвол дорхноо муухай болно гэдгийг мэдэх учир:

- Тэгье. Хөл нүцгэн явъя гэж дуртай зөвшөөрлөө. Гэвч Бат, Тулга найзынхаа бов бор хөлийг, өөрийнхөө цав цагаан хөлтэй жишиж хараад “Хэрэггүй ч хөл нүцгэн явъя гэж хэлэв үү дээ” гэж бодов. Хөл нүцгэн явах сонин ажээ. Улан дороос нь чийг дааж, сэрүү татаад, гижиг хүрч байгаа ч юм шиг, хорсож байгаа ч юм шиг нэг л хачин санагдана. Тулга найз нь гуталтай явснаасаа илүү харайж цовхчин, замд таарсан царцааг шилбүүрийнхээ хуйваар шавхран, нэлээд зайтай гүйж явлаа. Бат хойноос нь жигтэйхэн эв хавгүй бөгцгөнөн дагаж явав.

Тэгтэл нялцгас хийсэн юман дээр гишгэж орхив. Огло үсрэн зайлуутаа ажвал яах аргагүй могой, тэгэхдээ бүр хоёр толгойтой аймаар эрээн могой атиралдан хэвтэнэ.

- Тулга аа! Хүү-е, Тулга аа! гэж хашхирах гэтэл олигтой дуу гарч өгсөнгүй.

Дахиад Бат:

- Тул-гаа! Най-заа! гэж хүчлэн хашхирав. Тулга гүйж ирлээ. Нэг гартаа жижиг чулуу атгачихсан, уснаас сая гаргасан загас шиг амаа ангалзуулж, нүдээ бүлтгэнүүлэн зогсож байгаа Бат найзаа хараад, Тулга хүү их гайхлаа.

- Яав аа?

- Ээ-ээ-энд! Мо-могой! Хо-хо-хо-хоёр толгой-той...

- Хаана?

- Энд! Энд хойд са-са-сахлаг өвсөн дотор! Тулга заасан өвс рүү дөхсөнд Бат ханцуйнаас нь татаад:

- Хүүе, болиоч! Хатгачихвал яана гэж хэлэв.

- Зүгээр! гэж өгүүлээд Тулга мөнөөхөн өвсөн дундуур туучин явснаа учир зүггүй хөхрөв. Бат их гайхав. Тэгтэл:

- Найз минь, энэ чинь өвөөгийн гэсэн чөдөр л байна шүү дээ гэж Тулгын хэлэх дуулдлаа. Тулга “Хоёр толгойтой могойг” багалзуурдах мэт дээр өргөсөөр гүйж ирэв.


- Чөдөр гэнээ!

- Тийм ээ! Үүнийг чинь чөдөр гэдэг юм. “Могой эрээн биетэй, модон гурван хумстай” гэсэн оньсого дуулаагүй юу. Тэр чинь энэ шүү дээ.

- Аа, энэ юм уу. Ёстой их айлаа шүү гэж хэлээд, Бат хэзээ шүүрч авсныг мэдэхгүй, гар дахь жижиг чулуугаа өвсөн дунд сэмхэн хаялаа. Тулгыг шоолох байх гэсэнд ер үгүй. Харин:

- Чи чөдрийг яаж мэдэх вэ? Энэ сүлжсэн хэсгийг нь “суман” гэдэг юм. Зангилаанаас нь урагш байгаа энэ хоёр хэсгийг “чөдрийн хаа” гэдэг юм. Морины хөлд бэхэлдэг энэ хэсгийг “чөдрийн алга” гэдэг. Үүнийг ч яах вэ, “чагт” гэнэ. Чагт ордог энэ гогцоог “чөдрийн хөх” гэдэг юм гэхчлэн яриад, хааг нь дарж чөдөрлөх, өрөөлдөх, туших гэгч юу болох тухай тайлбарлаж өглөө. Хоёр хүү өвөөгийнхөө гэсэн чөдрийг олсондоо их л баярлан, хониныхоо хойноос гангар гунгар ярилцсаар явжээ. (С.Надмид)

### 3 Хүслэнгийн хийсэн оюуны зураглалд тулгуурлан, үйл явдлыг ярья.



Ярихдаа:

- Баатруудын дүр байдлыг нүдэнд харагдтал дүрслээрэй.
- Тулга, Бат хоёрын хэлсэн үг, харилцан яриаг хэрэглээрэй.

**Ярихдаа хэрэглэх үгс:** нас чацуу, ногооны шүүдэр, цав цагаан хөл, сэрүү татах, шилбүүрийнхээ хуйв, хоёр толгойтой могой, багалзуурдах мэт дээр өргөх, шоолсонгүй, өвөөгийн чөдөр, суман, чөдрийн хаа, чөдрийн алга, чөдрийн хөх, чөдрийн алга, эв хавгүй бөгцгөнөн, “Ээ-ээ-энд! Мо-могой! Хо-хо-хо-хоёр толгойтой...”

4 **Баатрын дүр байдлын ялгааг тодруулан бичье.**

Догол мөр	Тулга	Бат	Юу дүрсэлсэн бэ?
1	монгол дээлтэй, савхин гуталтай		
2		эв хавгүй бөгцгөнөн	явдал хөдөлгөөнийг
3	гайхсан, доогтой инээмсэглэн хөхрөх		

5 **Бат, Тулга хоёрын гадаад дүрийг үгээр зураглан, тоочиж бичье.**

1. Бичсэнээ дүрслэн зураад, өнгө ялган будъя.
2. Хэн, яаж зурсныгаа бусдадаа тайлбарлаарай.

6 **Баатрын хувцас болон дүр байдлыг тодруулсан үгсийг ажиглая.**

1. Асуултын утгыг ажиглаарай.
  - Бат ямар цамцтай, ямар өмдтэй, ямар шаахайтай байв?
  - Тулга ямар дээлтэй, ямар гуталтай байсан бэ?
  - Гутлаа тайлтал Батын хөл ямар, Тулгын хөл ямар харагдсан бэ?

**САНАМЖ**

Аливаа юмсын шинж чанар, тоо хэмжээ, өнгө зүс заасан үгс нь “ямар?” гэсэн асуултад хариулагдана.

2. Баатрын гадаад дүр байдлыг төсөөлье.

Бат, Тулга хоёртой өөр нэг хүүхэд явж байжээ гэж бодъё. Түүний хувцас, нүүр царай, дүр байдал, хөдөлгөөн, үг яриа нь ямар байх бол? Тухайлбал:

Ноосон цамц

Урт ханцуйтай ноосон цамц

Ээжийнхээ авчирсан урт ханцуйтай ноосон цамц гэх мэтээр дэлгэрүүлээрэй.

7 **Чөдрийг могойтой хэрхэн адилтгасныг тайлбарлан бичье.**



Эрээн өнгө, мушгиж эрчилсэн нарийн урт бие нь төстэй, харин могой 1 толгойтой атал чөдөр нь 2 толгойтой юм шиг харагддагаараа ялгаатай.



“Могой эрээн биетэй Модон гурван хумстай” гэж юуг, юутай адилтган оньсоголсон байна вэ? Учир шалтгааныг тодруулан тайлбарлаарай.

**Нүдэлж зөв бичье.**

бэлчсэн, чацуу, хилэн өмд, ногооны шүүдэр, хэлэв үү дээ, туучин явах, чөдөр л байна, үүнийг ч яах вэ



## Дүрмийг бататгаж, зөв бичье.

- 1 “Өвөөгийн гэсэн чөдөр” эхээс “ъ, ь” тусгаарлах үүрэгтэй орсон үгсийг түүж бичээрэй.

....., ....., .....

- 2 Тодруулсан үгсийн балархай эгшгийн үүргийг тодорхойлоорой.  
Тулга монгол дээлтэй савхин гуталтай, харин Бат эрээн цамц, хилэн өмдтэй, улаан шаахайтай.

- 3 Тодруулсан үгсийн ойролцоо утгатай үгийг бичээрэй.  
Нас бие чацуу энэ хоёр хүүд төстэй зүйл бараг үгүй шахам.

- 4 Батын дүр байдлыг илэрхийлсэн утгад тохирох хэлцийг сонгоорой.  
“Бат нэг гартаа жижиг чулуу атгачихсан, уснаас сая гаргасан загас шиг амаа ангалзуулж, нүдээ бүлтгэнүүлэн зогсож байв.”

А. аргаа барах

Б. гар мухардах

В. барьц алдах

Г. цаасан буу тавих

- 5 Дараах үгсэд “ийг, ыг” тохирох залгаврыг залгаарай. Балархай эгшгийг гээгдэх, гээгдэхгүй байгаа тохиолдлыг ярилцаарай.

хөшиг

хогшил

тогших

бичих

мөчир

хөгжим

хожил

хужир

ачих

учир

Уужим

Должин

- 6 “Я, е, ё” залгаврыг зөв залган бичиж өгүүлбэрийг гүйцээгээрэй.

Малаа сайн өсгө.е

Хоёулаа гэртээ хар.я

Хийснээ сайн шалга.я

Ах адуугаа хураа.я

Дүүгээ сайн хар.я

Настай хүнд тусал.я

Хоёулаа морио уя.я.

Хэлцийн утгыг мэд.е.

Баярын мэнд хүрг.е

Сурсан дуугаа дуул.я

Хичээлдээ сайн бэлд.е.

Аз жаргал хүс.е

- 7 Өгүүлбэрт утга тохирох үгийг зөв холбон бичээрэй.

- Гэртээ эртхэн харъя
- Хонь малаа тарья
- Хүн бүр мод харья
- Одоо бүгдээрээ тарья

### **~~ДЧРМЭЭ-СЭРГЭЭН-САНЯА~~**

Гийгүүлэгчээр төгссөн эр үгэнд “я, ё”-г залгахдаа өмнө нь “ъ”, эм үгэнд “е”-г залгахдаа өмнө нь “ь” тэмдэг бичнэ.

### **~~ДЧРМЭЭ-СЭРГЭЭН-САНЯА~~**

Эгшгээр болон зөөлний тэмдгээр төгссөн үгэнд “я, е, ё”-г шууд залгана.



## Баатрын харилцан ярианы утгыг ойлгон, дүрд тоглоё.



Уншихын  
өмнө:

1. Чи юу мөрөөдөж байна вэ?
2. Бусдын тусын тулд юу хийж чадах вэ?
3. Чиний хийх дуртай, хийж чаддаг зүйл юу билээ?

### 1 Үлгэрийг уншаад, бусдадаа ойлгомжтой, цэгцтэй яриарай.

#### БЯЦХАН ХУЛУУНЫ МӨРӨӨДӨЛ

Бөөрөнхий хулуу байжээ. Анхандаа самар мэт жижигхэн байв. Бяцхан хулуу дараа нь өндөг шиг болов. Аажим аажмаар томорсоор сар шиг том боллоо. Бяцхан хулуу сарыг харж өссөн болохоор сар болохыг хүсжээ.

Гэнэт салхи гарав. Сар улам том болсон байлаа.

- Сар гуай гэж бяцхан хулуу дуудлаа.
- Яасан бэ? гэв.
- Би сар таныг дуурайсан байгаа биз дээ? гэхэд
- Тэгсэн байна гэжээ.
- Гэхдээ яагаад надаас гэрэл гарахгүй байна аа?

гэж хэлээд хулуу уйллаа. Сар зөөлнөөр инээмсэглэж, бяцхан хулуунд “Нэгэн охин маш сайхан дуулдаг хүнийг хараад, би дуучин болмоор байна гэжээ. Бас гоё зурдаг хүнийг хараад, би зураач болно гэжээ” гээд ярьтал хулуу:

- Тэгээд юу болсон бэ? гээд сонирхон асуутал сар:
- Тэр маш сайхан үлгэр бичдэг хүн болсон гэлээ.
- Яагаад?
- Тэр охин юм бичих дуртай, бас авьяастай байж л дээ. Харин чи өөрийнхөө дуртай, бас хийж чаддаг зүйлээ ол гэхэд бяцхан хулуу толгой дохилоо.

Тэр “Миний дуртай, бас сайн хийдэг зүйл юу юм бол оо? гэж нэлээд удаан бодлоо. Нэгэн орой бяцхан хулуу жаахан охин саванд ус хийгээд, ууж байхыг хараад, өөрийнхөө хийх ажлыг оллоо. “Би бат бөх сав болох хэрэгтэй юм байна” гэж саранд хэллээ. Сар “Миний хийж чадахгүй зүйлийг хийх нь ээ” гэж хулуугаар бахархав. Бяцхан хулуу өөрийгөө “Гал тогоонд сарнаас илүү би хэрэгтэй” гэдгийг ойлгов. Бяцхан хулуу боловсорсоор байлаа.



(Солонгос ардын үлгэр)

### 2 Уншсанаа ярилцъя. Асуулт зохиоё.

1. Бяцхан хулуу, сар хоёр юу ярилцав? Сарны ярьсан ярианаас чи юу гэж ойлгосон бэ?
2. Хулууны бодолтой чиний санал хэр нийцэж байна вэ?
3. Хулуу өөрийгөө танихад юу тусалсан бэ?



3 **Үлгэрийн баатруудын гадаад дүр байдлыг ялган бичье.**



4 **Дүгнэн ярилцъя.**

- Аль баатрын гадаад дүр байдлыг дүрсэлсэн байна вэ?
- Ямар үгээр, яаж дүрсэлсэн байна вэ?

5 **Үлгэрийн баатруудын гадаад дүр байдлыг төсөөлөн зохиоё.**

Баатрын гадаад дүр байдлыг яаж зохиох вэ?	сар	хулуу	охин
Нүүр царай, харц болон хувцас нь ямар байх бол?			+
Өнгө, хэлбэр дүрс, нүүрний хувирал, биеийн хөдөлгөөн, нүдний харцны өөрчлөлт нь ямар байх бол?	+	+	
Баатрын зан байдлыг яаж дүрсэлж болох вэ?	+	+	+



Дүр байдлыг зохиохдоо:

- Хэлж байгаа үг, ярилцаж байгаа байдлыг дахин уншаарай.
- Нүдэнд харагдтал дүрслэн яриарай.
- Шинж чанар, тоо хэмжээ, дүр байдал, өнгө зүс заасан үгсээр дэлгэрүүлж бичээрэй.

6 **Үлгэрийн баатруудын зан байдлыг илэрхийлэн, дүрд тоглоё.**

1. Баатраа сонгон, үлгэрийг дахин уншъя.
2. Баатрынхаа гадаад байдлыг төсөөлөн зохиосноо бодъя.
3. Зохиолын гол санааг илэрхийлэх үг хэллэгийг цээжлэн бэлдье.
4. Баатрын зан байдал, гадаад дүрд тохируулан ямар үгийг, яаж хэлэхээ бодъя. Тухайлбал:

**Туяа, сарны дүрээр ярив.**

Инээмсэглэн, үлгэр бичдэг охины тухай зөөлөн намуун дуугаар ярьж өгнө.

**Дорж, хулууны дүрээр ярив.**

“Гэрэл гаргахгүй байна” гэж гоморхож атаархсан байдалтай уйлагнан ярина.

7 **Нөхдийнхөө ярьсныг үнэлэн тэмдэглэе.**

Баатрын дүр байдлыг илэрхийлсэн нь	Үнэлгээ	
	Тийм	Үгүй
Баатрын хэлж байгаа үгийн утгад тохируулан дууны өнгөө өөрчилсөн үү?		
Үйл хөдлөл хийсэн үү? Үгээ тод хэлсэн үү?		
Баатрын төрх байдал, биеийн хөдөлгөөн, нүүрний хувирлыг гаргасан уу?		

**Нүдэлж зөв бичье.**

боловсорсоор, охиныг, дуурайсан, авьяастай



1. Ямар амьтны зураг вэ?
2. Уул, амьтан хоёрын өнгө нь төстэй байна уу?
3. Монголчууд амьтан, уул хоёрын гадаад дүрийн төстэй байдлыг ажиглаад, домог зохиожээ. Хэрхэн домоглов?



1 Бусдад ойлгогдохоор уншъя.

**ЗОРГОЛ ХАЙРХАН УУЛ**

Нутгийнхан нь Зоргол хайрхан уулыг хүзүүгээ нугалаад хэвтэж байгаа согооны хэлбэртэй гэж ярьдаг.

Эрт урьд цагт илээ дагуулсан нэгэн согоо энэ нутагт амьдардаг байжээ. Гэтэл согоог идэш тэжээлээ олох гээд явсан хойгуур илийг нь чоно барьж идчих гээд байдаг байв. Иймд эх согоо нь арга хайж, илээ чулуу болгон үлдээж, бэлчээрээс ирэхдээ дээрээс нь сүүгээ дусаагаад, хуучин хэвэнд нь оруулдаг байв. Ингээд айх аюулгүй, амар тайван явдаг байжээ.

Гэтэл нэг удаа хэрээ илийн дээгүүр нисэхдээ сүүдрээ тусгачихжээ. Эх нь ирээд, чулуун дээр сүүгээ дусаан, үрээ босгох гэтэл хэрээний сүүдэрт бузартсан тул чулуу хэвээр үлдэв. Энэ нь одоогийн Зоргол хайрхан уул юм сан жээ.

*(Монгол ардын домог)*

2 Энэ уул аль аймгийн нутагт байдаг вэ?

3 Дараах үгс ямар утгатай байж болохыг бодоод, саналаа хэлээрэй.

Зоргол хайрхан - хэвэнд нь - бузартсан -  
ил - согоо - бэлчээр -

4 Домгийн утга санааг тодруулсан асуулт зохион ярилцъя.

5 Баатруудын гадаад дүр байдлыг төсөөлөн бичье. Домгоо дахин уншаарай.

Баатрын гадаад дүр байдал	Согооны дүр	Чонын дүр
Чих нь ямар бол?		
Хөл нь ямар бол?		
Нүдний харц, хөдөлгөөн нь ямар бол?		

6 Өөр юуг онцолж дүрсэлмээр байна вэ? Багаараа ярилцаарай.



- Нүдэнд харагдтал дүрслээрэй.
- Шинж чанар, тоо хэмжээ, дүр байдал, өнгө зүс заасан үгсээр дэлгэрүүлж бичээрэй.



## Баатрын гадаад дүр байдлыг дүрслэн бичицгээе.


### Бичих санаагаа олж, төлөвлөө.

#### 1. “Нэг эзний хоёр зарц” үлгэрийг сонсьё.

1. Үлгэрийн баатруудын гадаад дүр байдлын ялгааг олоорой.
2. Үлгэрийн баатруудын зан чанарын ялгааг ойлгож мэдээрэй.

#### 2. Сонсож ойлгосноо ярилцъя.

#### 3. Хэрвээ үлгэрт гарч байгаа данх, домбо, халуун сав гурав хүн байсан бол...



	данх	домбо	халуун сав
гадаад төрх			
зан ааш			
нас			
нүүрний хувирал			
үйл хөдөлгөөн			
үг хэл			

### Санаагаа цэгцэлж, зөв байрлуулъя.

Эхийг дахин сонсьё.

- Эхийн бүтэц (эхлэл, гол, төгсгөл) бүрд юуны тухай өгүүлж байгааг сонсоод бичье.
- Сонссон эх хэдэн цогцолбороос бүтсэнийг саная.
- Цогцолбор бүрд ямар утга санааг гаргасныг тайлбарлаж бичье.
- Данх, домбо, халуун савны хэлсэн үгээс ургуулан, дүр байдлыг төсөөлье. Бас зохион бичье.
- Төгсгөлийн цогцолборт уншигчдад хандан, ямар сургамж авч болохыг бичээрэй.

### Төлөвлөгөөний дагуу ноороглон бичье.

#### Бичсэнээ хянаж, сайжруулъя.

Найруулгыг засах шалгуурын дагуу бичсэнээ сайжруулаарай.

1. Өгүүлбэр дэх үгс утгын хувьд зөв холбогдож байна уу?
2. Нэг үгийг олон давтсан уу?
3. Баатраа дүрслэхдээ “Ямар” гэсэн асуултад хариулагдах үгээр дэлгэрүүлж бичсэн үү?
4. Сонгосон үгс нь оновчтой байна уу?
5. Сонгосон үгийн утга сонсогчийн сонирхлыг татахаар байна уу?
6. Цэг, таслалыг зөв хэрэглэсэн үү?
7. Оноосон нэрийг зөв бичсэн үү?

#### СНАМЖ

Баатрын нас, зүс царай, гадаад дүр төрх, зан аашийг «Ямар?» гэсэн асуултад хариулагдах үгээр дүрслээрэй.

## 🏠 Би юу сурсан бэ?


Өөрийгөө шалгах асуулт	Хамгийн сайн чаддаг болсон зүйл	Цаашид яаж сайжруулах вэ?
Эхээс баатрын гадаад дүр байдлыг яаж ялгах вэ?		
Баатрын гадаад дүр байдлыг яаж дүрслэн ярьж, бичих вэ?		
Баатруудын харилцан яриаг ойлгосны үндсэн дээр дүрд тоглож чадсан уу?		
Чамд ямар бэрхшээл байна вэ?		

### Өөрийгөө үнэлсний дараа юу хийх вэ?

1. Сайжруулах зүйлээ сонгон, багшаасаа тусламж хүсээрэй.
2. Амжилтад хүрэхийн тулд холбогдох дасгалыг ажиллаарай.

### ЯНЗАГА

...Янзага ишигтэй зэрэгцэн, **урд хоёр хөлөө нугалан бохирч ховдоглон хөхнө. Турь муутай урт цүүцгэр хөл, дэлдгэр том чих, тугал хар нүд, шөмбөгөр хошуутай, бор цоохор толботой сонин содон хөөрхөн** нэгэн амьтан тэдний хонин дотор явдаг болсныг нутгийн хүмүүс шохоорхон өхөөрдөнө.



Болд, Долгор хоёр түүнд Цоохондой гэж нэр өгөөд, дуудахад нь хүрч ирээд, **том нүднээсээ нулимс унагахад** тэр хоёрын зүрх шимширдэг байв. Цоохондой томрох тусмаа хониноос холдон ганцаараа явах нь олшроод, сүүл сүүлдээ модны зах руу орчихдог болов. Гэвч Цоохондой гэж дуудахад **бөн бөн шогшоод** ирдэг байжээ.

Намар орой болж, өвсөн толгой ганхаж, тэнгэр бүрхэн, салхи сэвэлзэн шувууд хошууран ганганан буцаж байсан тэр нэгэн өдөр Цоохондой алга болов. Болд гүн ойн дунд Цоохондой, Цоохондой гэж дуудсаар явна....

(Ц.Уламбаяр)

- 1 Тодруулсан үгс нь баатрын ямар шинжийг хэрхэн дүрсэлснийг ялган бичээрэй.
  - а. гадаад төрх байдал
  - б. үйл хөдлөл
- 2 Янзагын зан байдлыг тодруулан бичээрэй.
- 3 Намар оройн байдлыг яаж дүрсэлсэн бэ?
- 4 Цэгийн оронд дүрсэлсэн хэсгийг нөхөн бичье.
 

Цоохондой гэж дуудахад ..... шогшоод ирдэг байжээ.  
Шувууд ..... буцаж байсан.
- 5 Дараах үгсийн зөв бичих дүрмийг тайлбарлан ярилцаарай.
  1. Тодруулсан эгшиг ямар үүргээр орсныг тайлбарлаарай.
  2. Үгэнд залгаврыг залган, дүрмээр зааглан бичье.
 

уншдаг+аа, сонин+оос, дуудах+д, хужир+аар, нутаг+ийн, тугал+аа, баатар+ын, намар+ын

    - а. эгшиг нь гээгдэхгүй
    - б. эгшиг нь гээгдэнэ

# 15

## СЭТГЭГДЭЛ, МЭДРЭМЖЭЭ ИЛЭРХИЙЛЭН БИЧЬЕ.

Энэ бүлэгт баатрын харилцан ярианаас зан чанарыг тодорхойлж, жүжиглэн үзүүлж сурна. Эхийг уншаад, сэтгэгдэл, мэдрэмжээ илэрхийлж сурна. Хэлц үгийг зөв хэрэглэж эх зохионо.




**Баатрын зан чанар өөрчлөгдсөнийг харьцуулан уншицгаая.**

1 Шүлгийн утгыг ойлгож, уншъя.

### ТУУЛАЙН БЯЦХАН БӨЖИН

Соёо цагаан шүдтэй  
Соотон чихтэй бөжин байжээ.  
Үг дуулдаггүй бөжингийн  
Үүдэн хэдэн шүд нь  
Зогсоо зайгүй өвдөж  
Зовоон шаналгаж эхэлжээ.

1. Эхлэл хэсэгт ямар зантай бөжингийн тухай өгүүлэв?
2. Түүний юу нь өвдсөн бэ?



3. Гол хэсэгт огло харайсан, олны дунд орилж чарлаж байгаа бөжинг дүрсэлжээ. Та нар түүнийг ямар зантай гэж хэлэх вэ?
4. Эмч дээр дахиад очих шалтгаан нь юу байв?

Өвчилсөн шүдийг нь эмчлэх гэтэл  
Өнөөх бөжин огло харайв.  
Олны дундуур зүсэн дэгдэж  
Орилон чарласаар зугтан арилав.  
Зугтаан зайлж амжсан ч  
Зовиурт шүд нь янгинасаар

Тухтай ч амарч болдоггүй  
Тавтай ч тоглож чаддаггүй  
Ахин эмчид очиж  
Эмчилж өгөхийг гуйжээ

Улаан шар луувангаа  
Угааж цэвэрлэж иддэг болжээ  
Оо, сойз хоёуланг нь  
Одоо үргэлж хэрэглэдэг болжээ.

5. Төгсгөл хэсэгт бөжингийн зан байдал яаж өөрчлөгдөв?
6. Тэр юунаас болоод оо, сойз хэрэглэдэг болов?
7. Бөжин шиг оо сойзоо хэрэглэдэг сурагч танай ангид хэр их байгаа вэ? Талархал илэрхийлж ярилцаарай.

(Ч.Лувсандэндэв)



## Баатрын зан чанар өөрчлөгдсөнийг харьцуулан уншицгаая.

1 Уншаад, ойлгоё. Гарчгийг гүйцээе.

### ЗАЛХУУ ОХИН ... БОЛСОН НЬ

(Орчин үеийн үлгэр)



Эрт урьдын цагт Гэдгэрмаа хэмээх нэгэн залхуу охин амьдран суудаг байжээ. Аав ээж нь түүнд Гэрэлмаа гэдэг сайхан нэр хайрласан боловч хүмүүс хойрго залхуугаар нь элэглэж, Гэдгэрмаа гэж дууддаг болжээ. Гэвч тэр гэмшиж ухаарсангүй. Ажил хий гэхээр л уруулаа унжуулаад суучихна. Уруулаа цорвойлгон, хоол ундаа ч идэхээс залхуурна. Хамгийн гайхалтай нь залхуурах тусам түүний уруул улам сунаад байдаг боллоо. Гэдгэрмаа идэх, суух хоёроос өөр юу ч хүсэхгүй.

Охины уруул сүүлийн хэдхэн хоногт тохой илүү сунажээ. Тэгтэл нэг өдөр тэр бяцхан сууринд мэргэн ухаантан ирж гэнэ. Гэдгэрмаагийн ээж мэргэн хүнийг гэртээ урьж, учир зовлонгоо тоочжээ.

Мэргэн хүн, охиныг их өрөвдөж, шидэт толио гарган, нүүр царайг нь харуулахад Гэдгэрмаа гутрахын ихээр гутарч, эхэр татан уйлав гэнэ.

Мэргэн хүн ээжид нь хандан:

- Хэрэв охиноо сайн сайхан эрүүл саруул болгоё гэвэл надтай хамт явуул гэв. Тэдний хэн нь ч татгалзсангүй.

Мэргэн хүний гэр уулсын дунд, агуйн гүнд оршдог мөнгөн дээвэрт ордон ажээ. Ордонд ороод, хэсэг хугацаа өнгөрсний хойно мод мэт хатуу, тэвэр илүү зуурсан гурилыг охинд авчирч өгөөд:

- Энэ гурилыг мяндас мэт зөөлөн болтол нух. Нухалт нь ханахаараа гурил өөрөө амилан “Би чамд тус больё” гэж гурвантаа хэлэх болно гэлээ. Охин гурилыг нухах гээд бүх хүчээрээ дарвал булбарай цагаан гар нь үе мөч бүхнээрээ янгинан өвдөж, дотор нь харанхуйлах шиг болжээ.

Охин:

- Мэргэн ах минь, та намайг гэрт минь хүргээд өгч үз. Би энэ гурилыг яагаад ч зөөлрүүлж дийлэхгүй юм байна гэв. Мэргэн хүн юу ч эс хэлээд, өнөөх хатуу гурилаас таслан авч, хоромхон зуур зөөлөн болтол нухаад, охины урт хошууг яг дуурайлган урлалаа. Тэгээд гурилан хошуунаасаа эрхий дармыг тасдан хаяв. Тэгтэл юу болсон гэж санана. Яг энэ мөчид Гэдгэрмаа охины газар шүргэм урт хошуунаас эрхийн чинээ нь бас тасран, шалан дээр подхийн унав.

Энэ мөчөөс охины харцанд итгэл найдвар, урам зоригийн гал бадран асаж эхэллээ. Туяхан биеэ ядрахыг умартаж, турьхан гараа өвдөхийг тэсвэрлэж, хад чулуу мэт хатуу гурилыг нухсаар гурван өдөр, гурван шөнө өнгөрөв.

Тэгтэл дөрөв дэх өдрийн үүрээр мяндас мэт зөөлөн болсон гурил “Охин минь, би чамд тус больё” гэж дуу алдах нь тэр.

Мэргэн хүн охины нухсан гурилаар түүний хошууг дуурайл-





ган, ерэн есөн хошуу хийж эгнүүлэн тавилаа. Тэгээд ерэн есөн хошууны үзүүрээс эрхий дарам гурилыг тасдан хаянгуут Гэдгэрмаагийн урт хошуу өөрөө аяндаа тасран уналаа.

Баярлаж хөөрсөн охин:

- Ах аа, та л намайг аз жаргалтай минь эргэн учрууллаа гэхэд:

- “Охин минь, чи өөрийн тэсвэр хатуужлын хүчээр амьтан болж хувирах аюулаас мултарлаа. Одоо гар чинь уян зөөлөн, ажилсаг, сэтгэл чинь өөдрөг сайхан болсон шүү” гэлээ.

Энэ цагаас эхлэн залхуу Гэдгэрмаа, ажилсаг Гэрэлмаа болон хувирч, ээж аавдаа эгнэгт баяр баясгалан бэлэглэжээ.

(О.Сундуй)

### Юуг харьцуулах вэ?

1 Гэдгэрмаа охины гадаад төрхийг зуръя.

Үлгэрийн эхэнд

Үлгэрийн дунд хэсэгт

Үлгэрийн төгсгөлд

2 Хэсэг бүрд Гэдгэрмаа охины зан ааш ямар байв? Ямар үг хэлж байсан бэ?

Эхийн хэсэг	Охины зан ааш	Охины хэлсэн үг
Эхлэл хэсэг		
Гол хэсэг		
Төгсгөл хэсэг		

3 Зохиолд гарч буй өөрчлөлтийг харьцуулъя.

Юуг харьцуулах вэ?	Гэдгэрмаа	Гэрэлмаа
Гадаад төрх		
Зан чанар		
Сэтгэл санаа		
Аав ээжийнх нь сэтгэл		

### Яаж харьцуулах вэ?

1 Үлгэрийн төгсгөл дэх Гэрэлмаа, эхэнд гарч байсан Гэрэлмаагаас огт өөр болсон гэдэгтэй санал нийлэх үү? Хэлэлцье.

2 Ажилсаг Гэрэлмаа, залхуу Гэдгэрмаад юу гэж хэлэх бол?

Залхуу охин	Ажилсаг Гэрэлмаа юу гэж хэлэх бол?
Ажил хий гэхээр л уруулаа унжуулаад суучихна. Уруулаа цорвойлгон, хоол ундаа ч идэхээс залхуурна.	
Би энэ гурилыг яагаад ч зөөлрүүлж дийлэхгүй юм байна.	
Идэх, суух хоёроос өөр юуг ч үл хүснэ.	



## Зохиолын баатрын харилцан яриаг жүжиглэж үзүүлье.

- 1 “Залхуу охин заан болсон нь” зохиолын баатрын зан чанарыг илэрхийлж, тоглолт хийж туршъя.



Жүжиглэж үзүүлэхдээ:

- Дүрдээ тохируулан, дууныхаа өнгийг өндөр нам болгоно.
- Нүүрний хувирал, нүдний харц, хөдөлгөөнийг тохируулна.
- Биеийн хөдөлгөөнийг ажиглан, дуурайна.
- Гарын дохио зангааг тааруулна.

- 2 Хэн нь дүрээ сайн илэрхийлсэн бэ? Бичье.

Дүрээ ажиглая.	Миний хийсэн тоглолт	Найзын хийсэн тоглолт
Нүүрний хувирал		
Дууны өнгө		
Биеийн хөдөлгөөн		
Гарын дохио зангаа		

- 3 Харилцан яриаг төлөөлөн уншъя.

Уншихаас өмнө утгыг ярилцъя.

1. “Ургах наран”, “үдийн наран”, “үдэш”, “харанхуй шөнө” гэж цаг хугацааг заасан үгийн утгыг хэрхэн ялгаж байна вэ?
2. Ямар насанд эрдэм сурвал сайн бэ? Эхэд яаж бичсэнийг бодож уншаарай.



Нарны гэрэл хурц болоход  
Үүлгүй бол нэн сайн  
Насны багад эрдэм сурахад  
Залхуугүй бол тун сайн

Д.Равжаа

(“Сэтгэлийг амраагч” шүлгээс)

**өчүүхэн нас** - бага залуу нас  
**дунд нас** - идэр нас  
**их болсон** - нас ахисан  
**өтөл** - хөгширсөн

**Багш:** Өчүүхэн насанд эрдэм сурваас юутай адил вэ?

**Хөвгүүн:** Өчүүхэн насанд эрдэм сурваас шинэ ургах наран мэт.

**Багш:** Дунд насанд эрдэм сурваас юутай адил вэ?

**Хөвгүүн:** Дунд насанд сурсан эрдэм үдийн наран мэт.

**Багш:** Их болсон хойно эрдэм сурваас юутай адил вэ?

**Хөвгүүн:** Их болсон хойно эрдэм сурваас үдэш мэт.

**Багш:** Өтөл насанд эрдэм сурваас юутай адил вэ?

**Хөвгүүн:** Өтөл насанд эрдэм сурваас харанхуй шөнө мэт.

(“Хар үхэрт хөвгүүний тууж” сургаалын зохиолоос)



Харилцан уншихдаа:


- Үг бүрийн утгыг бодоорой.
- Асуултын тэмдэг болон цэгээр төгссөн өгүүлбэрийн хэлэх аялгыг тохируулаарай.
- Ярих хурд, дууны өнгө, гарын хөдөлгөөнөө тохируулаарай.

1 Ёгт үлгэрийг төлөөлөн уншицгаая.

**СОНО, ШОРГООЛЖ ХОЁР**

**Хөтлөгч:**

1. Дэгдгэнүүр соно зуны сайхныг  
Дэмий дуулсаар өнгөрөөжээ.  
Хаа сайгүй идэш, байр элбэг  
Халуун зун хоромхон зуур өнгөрч  
Өргөн тал анир чимээгүй  
Өвлийн хүйтэн улирал ирлээ.  
Өлсөх даарахын зовлон
2. Өнөөх сонотой учирч  
Уянгалан дуулахтай манатай  
Уйтгар гунигт дарагдаж  
Хоргодох дулаан байр  
Ходоодонд хийх хоол гуйхаар  
Ажилч шоргоолжийнд очиж  
Ам нээж ингэж хэлжээ.
3. Хаврын урь ортол  
Халамжилж аваач, намайг  
Хоол ундаар тэтгэж  
Хоргодуулж гэртээ байлгаач  
Хавар дулаан оронгуут л  
Хариу тус хүргэнэ, чамд
4. Аагим зуны сайханд  
Ажил хийгээгүй юм уу, чи  
Өвөлд юу ч бэлдэлгүй  
Өөр юу хийсэн юм бэ гэж  
Сонирхон гайхаж шоргоолж  
Соноос хариуд нь асуув гэнэ.
5. -Өө, найз минь, би чинь  
Өвөлд бэлдэхтэй манатай  
Зуны сайхан цагт  
Зугаа цэнгэлд толгой эргээд  
Өдөр шөнөгүй дуулсаар байтал  
Өвөл хаяанд ирчихжээ  
Өрөвдөж хайрлаач, намайг.
6. -Зунжин дуулсан юм чинь  
Өвөлжин бүжиглээд  
Өнгөрөөхгүй юу гэж  
Ажилч шоргоолж тэр сонын  
Амыг нь таглажээ.



(А.И.Крылов)

(Зургийг О.Иванов, А.Иванова нарын уран бүтээлээс авав.)

Нүдэлж зөв бичье.	<b>Буруу</b>	<b>Зөв</b>
	гаднах дийлэнхи дараахь олонхи	гаднах дийлэнх дараах олонх

**Жүжиглэн тоглохын тулд:**

2 **Баатрын зан байдлыг тодорхойлъё.**

1. Соно, шоргоолж хоёрын хувцсыг цаг улирлын байдалтай холбон харьцуулна уу. Зураач яагаад ийнхүү зурав?





## Дүрмийг бататгаж, зөв бичье.

- 1 “Соно, шоргоолж хоёр” ёгт үлгэрийг дахин уншихдаа балархай богино эгшиг нь гээгдсэн үгийг түүж бичнэ үү.
- 2 “Үйлт нэрийн “х” гийгүүлэгчийн өмнөх эгшиг нь гээгдэхгүй” гэсэн дүрмээр бичсэн үгийг ялгана уу.  
хоромхон, өлсөх, даарахын, өнөөх, дуулахтай, хоргодох, гуйхаар, сайханд, сонирхон, гайхаж, өнгөрөөхгүй юү, бэлдэхтэй, ирчихжээ
- 3 “Өчүүхэн насанд эрдэм сурбаас шинэ ургах наран адил” гэсэн өгүүлбэрээс алдаатай нэг үгийг олно уу. Олохдоо дараах дүрмийг уншаарай.

### ДҮРЭМ

#### Б, В үсгийг ялгаж бичих дүрэм

Үгийн дунд орсон л,м,н,в үсгийн дараа “б”, бусад гийгүүлэгч ба эгшигийн дараа “в” гийгүүлэгчээр эхэлсэн залгавар залгана. Жишээ нь,  
Хэлбэл, олбог, хамбал, авбал, хэн бэ?

- 4 Тавь, хийс, тайлбарла, нэм гэсэн үгсэд тохирох залгаврыг залгаж бичээрэй.  
- бал - вал - вэл - бэл
- 5 бод, унш, тогло, дуул, халамжил, тохир гэсэн үгсэд үйлт нэрийн “х” залгаврыг, дараа нь “ыг” залгаврыг залгаж зөв бичнэ үү. Жишээ нь,  
бод+х+ыг= бодохыг
- 6 4 мөрт дэх ялгах эгшигтэй үг, зөөлрүүлэх үүрэгтэй орсон үгсийн доогуур зурна уу. Танил бус үгээ тайлбар толь бичгээс олж бусдадаа хэлээрэй.

“Шарга шарга мориндоо  
Чарга, чарга хөллөнө дөө  
Бараг борог хүнээс нь  
Арга чарга сурна даа”

Намирын тунгалаг ус  
Тамирыг тэтгэх шидтэй  
Намрын идэрмэг сэвшээ шиг  
Хамрын самсаа сэнгэнүүлнэ.

(Д.Жаргалсайхан)

“Намрын” гэхийг гэсэн мөртлөө “намирын” гэхийг яагаад гээхгүй бичсэн бэ? Учрыг тайлбарлаж бичээрэй. 35 дугаар хуудсан дахь дүрмийг дахин уншаарай.

- 7 “Соно, шоргоолж хоёр” ёгт үлгэрийн тухай ойлгосноо бичихдээ дараах тодруулсан хэлц үгийг хэрэглээрэй.

Ташуур алдам- Маш хүйтэн, их жавар салхитай

Гуяа ганзагалах- Хоосон, юу ч үгүй

Биеэ оторлох, гараа хумхих, биеэ нөөх- Ажлаас зугтаах, залхуурах

Гүзээнд наалдсан дэлүү шиг- Огт салахгүй, бусдын дэм тусаар амьдрах



## Мэдрэмжээ илэрхийлэн ярьцгаая.

### 1 Уншаад ойлгоё.



Уншихдаа:

- Цэгийн оронд ямар үг байж болохыг тодруулсан өгүүлбэрээс бодож олоорой.
- Мэдэхгүй үгээ сонгоорой.
- Хэрвээ чи далдын хар малгай өмсөөд Мэдэмхий бор болон хулгануудын хажууд байсан бол юуг мэдрэх бол?
- Аль хэсэгт сэтгэл чинь ямар болж байгааг, зургаас сонгон зураарай.



### МЭДЭМХИЙ БОРЫН ҮЛГЭР

Оготнууд машин зам дээрээс шуудай дүүрэн олз олов. Будаа юм болов уу, гэтэл биш. Хоёр тал нь тэгшхэн бөөрөнхий хэлбэртэй юм байлаа.

- ..... гэдэг чинь арай биш байгаа даа?

- Биш байх аа. Энэ чинь арай хөнгөхөн юм.

- Чи .....мэддэг юм уу?

- Өнгөрсөн жил ой хамгаалагчийн хаяагаар орж, яг тийм шуудайтай юм байхаар нь цоолоод мэрж үзсэн. **Шороотой, нойтон, гашуун эд байсан.** Түүнийг лав ..... гэдэг байх.

Оготнуудыг ийн ярилцаж байтал Мэдэмхий бор хүрч ирэв.

- Та нар чинь юун дээр овоороод байна аа?

- Мэдэхгүй ээ. Энд нэг шуудайтай юм байна. Юу ч гэсэн идэх юм бололтой.

Бор оготно шуудайны амаар асгарсан мөнөөх олзыг харангуутаа “Өө, энэ чинь боорцог байна. Үүнийг чинь боорцог гэдэг юм. Ямар амттайхан гэж санана аа” гэж хашхирав.

Оготнууд тал талаас нь:

- Боорцог гэж юу байдаг юм бэ? Чи ийм амттаныг хэзээ, хаанаас амталж үзээ вэ? гэж шалгаав. Мэдэмхий бор:

- Ноднин өвөл ой хамгаалагчийн хаяагаар орж, шүүгээнд нь байсан боорцогноос нь иддэг байсан юм. Нэг тийм боорцог идэхэд бүтэн долоо хоногийн өл даана. Тэжээлтэй, бас өегийг нь яана” гэв. Оготнууд:

- Тэгээд тэр чинь чухам юу юм бэ? Боорцог гэдэг чинь ургамал юм уу? гэхэд:

- Боорцог л байхгүй юу?

- Ээ чааваас, бо-бо-орцог гэдэг чинь ургамал юм уу?

- Үгүй ээ. Зөвхөн хүн л хийдэг байх. Үнэр нь хачин сайхан, жигтэйхэн гоё амттай, зөөлхөн.

Оготнууд энэ үгийг сонсоод, мөнөөх олзноосоо нэг нэгийг өнхрүүлэн авч мэрэв.

- Сайхан амттай байгаа биз дээ? гэж Мэдэмхий борыг асуухад:



- Ай мэдэхгүй. Модны хатаасан холтос шиг л амтагдаж байна.
- “Хазахад эвгүй, чихар чихар гэж байна. Хатуу юм. Худлаа гэвэл чи өөрөө мэрээд үзээч” гэж оготнууд шуугилдав.

Мэдэмхий бор мэрж үзлээ. Нээрээ арай ч боорцог биш шиг. Ой хамгаалагчийнд байдаг хүүдийтэй амттаны үнэр ч алга байлаа. Гэтэл өнгө нь адилхан, хэлбэр нь гайхалтай ижилхэн бөөрөнхий ажээ.

Энэ үед Мэдэмхий борын царай ямар байсан бол?

Мэдэмхий бор хэд тамшаалснаа “Боорцог л байна” гэв.

Мэдэмхий борыг ингэж хэлэхэд сэтгэл чинь ямар байна вэ?

- Нээрээ юү?
- Яалаа гэж худлаа хэлэх вэ?
- Үнэн бол гоё доо. Ядахдаа энэ намар өвс ногоо муу ургалаа. Өвөл идэх хөөө алга. Хэрэв боорцог гэдэг үнэхээр мөн бол хойтон хавар болтол мэрэх хоолтой болжээ. - Ээ гялай. “Хөөө, та нар одоо үүнийг идэхгүй шүү” гэх Мэдэмхий борын дуугаар оготнууд өмнөх олзноосоо гурав гурван алхам холдов.

Энэ үед оготнуудын царай яаж хувирсан бол?

- Боорцог мөн нь мөн. Надад итгэх хэрэгтэй. Харин эргэлзэж, хардаж байхын оронд зөөсөн нь дээр гэж маадгархан хэлэв.
- Яаж зөөх вэ? Үүрээд даахгүй, чирээд дийлэхгүй том юм байна.
- “Нэг нэгээр нь өнхрүүлэхгүй юү. Залхуураад байвал би нүхэндээ зөөө. Дүн өвлөөр гуйгаад ирцгээв дээ” гэж Мэдэмхий бор ихэрхэв.

Та нар оготнуудад юу гэж хэлмээр санагдаж байна вэ?

Оготнууд энэ үгнээс айжээ.

- Та минь өнхрүүлцгээе. Нэг нэгээр нь өнхрүүлцгээе.
- “Ура! Өнхрүүлцгээе. Амттайхан, тэжээлтэйхэн хүнсээ өнхрүүлэнхэн, бөмбөрүүлэнхэн зөөцгөөө” гэж шуугилдлаа.

Оготнуудын ер бусын сонин ажил нэгэнт эхэлжээ. Шуудайнаас дөрвөн зүг, найман зовхист бяцхан жим гарлаа...

Мэдэмхий бор шуудай дээр урд хоёр хөлөө өргөн, ихэмсэг зогсоно. Тэр:

Ганцхан ширхэг нь долоон өдрийн өл даадаг

Гайхалтай сайхан боорцог доо

Өгөөмөр ачтай хэн гэгч нь энд хаяж

Өвлийн идэштэй болгов доо

Намайг таниагүй бол та нар мэдэхгүй

Намаржин хөөө зөөж ядарна даа

Зөөгөөрэй, найзууд минь, зөөгөөрэй

Зөөлхөн зөөлхөн өнхрүүлээрэй



Мэдэмхий борын ихэмсэг дүрийг илэрхийлье.

Илүү ч үгүй, дутуу ч үгүй нэг л оготно  
Идэх боорцогноос тав тавыг авна шүү гэж дуулна.

Оготнууд олзоо зөөсөөр, арай чамай дуусав. Сүүлийн боорцгийг өнхрүүлэн түрж оруулсны маргааш л хяруу унажээ. Хөөгөө ч базааж амжсангүй. Тэр өвөл ер бусын их цас орж, хүйтэн болжээ.

Оготнууд:

Ганцхан ширхэг нь долоон өдрийн өл даадаг

Гайхалтай сайхан боорцог доо

Ачтай борын минь олж өгсөн

Амттай сайхан боорцог доо гэж дуулалдсаар, үүцээ задлав. Гэтэл хоол болсонгүй...

Боорцог биш, үйсэн бөглөө байсан болохоор яаж хоол болох билээ? Мэдэмхий борын л гай шүү дээ.

(С.Надмид)

2 “Мэдэмхий борын үлгэр”-ийн үйл явдлаар дүрийн тоглолт хийе.

Эхлээд дүрээ сонгоё. Тэгээд хэлэх үгээ тогтооё. Харилцан яриа зохиоё.

Би зохиолч  
больё.

Би Мэдэмхий  
бор больё.

Бид оготнууд  
больё.

3 Хэний баг дүрээ сайн илэрхийлсэн бэ?

	Манай баг	... багийн тоглолт	.... багийн тоглолт
Нүүрний хувирал			
Дууны өнгө			
Биеийн хөдөлгөөн			
Гарын дохио зангаа			

4 Жүжгээс баатрын зан чанарыг тодорхойлж ярилцъя.



Ярилцах-  
даа:

- Тухайн баатраас асуух асуултаа хосоороо боловсруулаарай. Юу асууж болох вэ?
- Асуултад хариулахдаа сэтгэл хөдлөлөө нүүрний хувирал, нүдний харц, биеийн хөдөлгөөнөөр илэрхийлээрэй.

**Тухайлбал:**

**Мэдэмхий бороос асуух асуулт:**

1. Чи үйсэн бөглөөг “Боорцог мөн” гэж хэлж байхдаа өөртөө итгэлтэй байсан уу?
2. Боорцог биш үйсэн бөглөө гэдгийг мэдсэн тэр мөчид чиний сэтгэл ямар байсан бэ?
3. Мэдэмхий бор оо, чи худлаа ярьж байхдаа дараа нь юу болохыг бодсон уу?
4. ...

### Бусад оготноос асуух асуулт:

1. Мэдэмхий борыг худлаа ярьж байгааг мэдэх боломж та нарт байсан уу?
2. Та нарын хоолгүй болсон нь зөвхөн Мэдэмхий борын буруу юу? Чи юу гэж бодож байна вэ?
3. ...

### Үзэгч хүүхдүүдээс асуух асуулт:

1. Мэдэмхий борын хэлснийг няцаах хэн нэгэн гараад ирсэн бол та нар яах вэ?
2. Мэдэмхий бор шиг хүүхдэд чи юу санал болгох вэ? Нөхөрсөг зурвас бичээрэй.
3. Мэдэмхий борын юуг ч эргэцүүлдэггүй, шууд тааж ярьдаг гэдгийг ямар өгүүлбэрээр илэрхийлсэн байна вэ?
4. ...

### Зохиолчоос асуух асуулт:

1. Та энэ үлгэрээр бидэнд юу хэлэхийг хүссэн бэ?
2. “Мэдэмхий” гэдэг үг таныхаар ямар утгатай вэ?
3. ...

### 5 Мэдрэмжээ илэрхийлэн ярья.

Зохиолын аль хэсэгт юуг, яаж мэдэрснээ илэрхийлж яриарай.

1. Оготнуудын оронд “Шороотой, нойтон, гашуун эд”-ийг амссан бол юу гэж хэлэх байсан бэ? Түүнийг яагаад ингэж тодорхойлсон бэ?
2. Мэдэмхий бор болон оготнуудын яриаг сонсоод, юу мэдрэв? Хэнд нь юу гэж хэлмээр санагдаж байна вэ?
3. Үйсэн бөглөөг хоол биш гэдгийг мэдсэн оготнуудыг хараад чи юу бодов?
4. Мэдэмхий бор ба оготнуудын дүрээр ямар зан чанартай хүнийг үзүүлсэн бэ? Тэдэнд ямар сайн, муу, ижил тал байна вэ?
5. Мэдэмхий бор болон оготнуудын дүр төрхийг төсөөлөн ярья.



Ярихдаа:

- Баатруудын дууны өнгө, нүүрний хувирал, үйл хөдөлгөөнийг хэрхэн төсөөлснөө илэрхийлээрэй.
- Мэдэмхий бор, оготно гэдэг үгийг олон давтахгүйн тулд “энэ, тэр, тэд, нөгөө, өнөөх чинь” гэдэг үг хэрэглээрэй.
- Хэлэх, ярих зэрэг үгийн оронд “ингэнгүүт, тэгэнгүүт, тэгсэн чинь, тэгэхлээр нь” зэрэг үгийг хэрэглэж болно шүү.

### САНАМЖ

Нэг үгийг олон давтахгүйн тулд төлөөний үгийг хэрэглэдэг. Жишээ нь: **Оготнууд** үйсэн бөглөө олжээ. **Тэд** түүнийг боорцог гэж итгэсэн нь буруу юм.



## Мэдрэмжээ илэрхийлэн бичицгээе.

### 1. Зохиолч Ж.Саруулбуянгийн “Хөвийн булагийн хөх тогоруу” зохиолыг сонсьё.



Сонсохын өмнө:

1. Зохиолоос юуг мэдрэх бол?
2. Ганцаардсан тогорууны тухай яаж өгүүлсэн бол?
3. Хүүгийн тухай юу гэж өгүүлсэн бол?
4. Ямар үг, ямар дүрслэлийг сонсоод, сэтгэл чинь хэр хөдлөх бол?

### Зохиолоо сонсьё.

### 2. Бичих санаагаа олохын тулд юу мэдэрснээ ярилцъя.

Асуултаас сонгон, бодлоо хуваалцъя.

Хэн нэгнийг буруутгах сэтгэл төрж байна уу?

Тогоруу, хүү хоёрыг өрөвдөж байна уу?

Зохиолоос юу мэдрэв?  
Сонсож байхад чинь юу хамгийн тод төсөөлөгдсөн бэ? Яагаад?

Лонхон хөх, хүүтэй дахин уулзахгүй гэдгээ яаж илэрхийлсэн бэ?

Хүн, шувуу хоёрын нөхөрлөл ямар санагдав?

### Бичих санаагаа олж, төлөвлөө.

### Өгүүлбэрээс сонгоё.

“Тогоруу вөөл, тогоруу вөөл  
Тогоруу хөөрхөн, тоодог муухай  
Цам харай, цам харай” гэж хүүгийн аялгуулан хэлэхийг сонсоод...

Лонхон хөхийг зунжин,  
намаржин хүлээсэн хүүг хараад....

Лонхон хөх, хүү хоёрын нөхөрлөлийг хараад...

Лонхон хөхийн ганцаардсан түүхийг сонсоод...

Хүү, лонхон хөх хоёрын дэргэд байсан бол...

### Санаагаа цэгцэлж, зөв байрлуулъя.

1. Эхний цогцолборт энэ өгүүлбэрийг яагаад сонгох болсноо бичнэ.
2. Дараагийн цогцолборт юу мэдэрснээ бичнэ.
3. Төгсгөлийн цогцолборт ямар сургамж авснаа, хэнд юу гэж хэлмээр байгаагаа бичнэ.
4. Нэг үгийг олон давтахгүйн тулд төлөөний үг хэрэглэнэ.

## Бичсэнээ хянаж сайжруулъя.

### 1. Бичсэнээ шалгах шалгуур:

1. Санаагаа догол мөрөөр зааглан, зөв илэрхийлсэн үү?
2. Юуг мэдэрснээ онцолж бичиж чадсан уу?
3. Нэг үгийг олон дахин давтахгүйн тулд төлөөний үгийг хэрэглэсэн үү?

### 2. Хүслэнгийн бичсэнийг уншаад, сайжруулан засъя.

1. Давтсан үгийн оронд төлөөний үг сонгон бичээрэй.
2. Догол мөр гарган, эхийн бүтцийн дагуу зөв болгон засаарай.

**Лонхон хөхийн** ижлийг нь хороосон хүмүүсийг би буруутгаж байлаа. Яагаад гэвэл **лонхон хөхийн** махыг идэхгүй, өд сөдийг нь ашиглахгүй байж, буудчихсанд их харамсаж байна. Ижлээ алдсан **лонхон хөх** ямар их ганцаардсаныг сайн мэдэрч, бас өрөвдөж байна. Хэрвээ Лонхон хөх жаргалтай байсан бол хүүтэй тийм дотно нөхөрлөхгүй байсан. **Лонхон хөх**, хүү хоёр хоорондоо дассаныг зохиолд бичихдээ “Хүү “цам харай” хэмээн аялгуулж эхлэв. Тогоруу цам харайсангүй. Зүгээр л хүүг ширтэн зогсоход нь эхлээд ихэд гайхаж байснаа сүүлдээ өрөвдөн уйлж гарав. Тогоруу хүүгийн уйлахыг мэдэв бололтой, түүнийг тойрон явгалан гүйж, гурвантаа эргэлдсэнээ нисэв” гэжээ. Энэ хэсгийг уншаад, тэднийг өрөвдөж, тогорууг ганцаардуулсан **тэр хүмүүст** дургүйцэж байлаа. **Тэр хүмүүст** дахиж амьтны ижлийг битгий хороогоорой гэж хэлмээр санагдлаа.

## Би юу сурсан бэ?

Өөрийгөө шалгах асуулт	Хамгийн сайн чаддаг болсон зүйл	Цаашид яаж сайжруулах вэ?
Харилцан яриаг яаж жүжиглэн үзүүлсэн бэ?		
Харилцан яриаг үзүүлэхийн тулд баатрын зан чанарыг тодорхойлох нь чухал уу? Яагаад?		
Эхийг унших явцад юуг мэдэрч, сэтгэл чинь яаж хөдөлж байв?		
Мэдрэмжээ илэрхийлж ярьж, бичиж чадсан уу?		
Чамд ямар бэрхшээл байна вэ?		

### Өөрийгөө үнэлсний дараа юу хийх вэ?

Сайжруулах зүйлээ сонгон, багшаасаа тусламж хүсээрэй.

1. Асуултад хариулан ярилцъя.
  1. Дээрх чадварыг эзэмшихийн тулд чи юу хийх вэ? Төлөвлөөрэй.
  2. Зохиолоос Юуг сонсов? Юу харав? илэрхийлж бичээрэй.
  3. Жүжиглэн тоглохдоо чи өөрийгөө хэрхэн мэдрэв?
  4. Мэдрэмжээ хөгжүүлэхийн тулд үг бүрийг ойлгож уншаарай.



## Хэлц үг хэрэглэн, өгүүлбэр, эх зохион бичье.

- 1 Дараах хэлц үгийн утгыг ойлгож уншаад, эх зохиож бичээрэй. Дараах сэдвүүдээс сонгож болно.

### Сонгох сэдэв 1.

Дэм дэмэндээ  
Дээс эрчиндээ

**Утгын тайлбар:** Олс дээсэнд хэчнээн олон ширхэг байлаа ч эрчилсний сайнаар дээс болдогтой адил олонхүн эв нэгдэлтэй байж бие биеийнхээ дэмжлэг тусламжаар ажил үйл бүтдэг гэсэн утгаар хэлж хэрэглэдэг үг юм. Ганц нэгээрээ хийж бүтээж чадахгүй зүйлийг олон хүн хүчээ нэгтгэн хийсний эцэст энэ үгийг хэлнэ.



Бичихдээ:

1. Эхлэл хэсэгт ангиараа юм уу найз нөхдөөрөө, эсвэл гэр бүлээрээ нийлж хийсэн ямар нэгэн ажлын тухай танилцуулах
2. Гол хэсэгт тэрхүү ажлыг хийж байх үеийн сэтгэгдлээ бичих
3. Төгсгөл хэсэгт бусдын дэмжлэгээр ажлыг хурдан, сайн хийж болдог гэдгийг бусдад уриалах
4. Эхлэл, гол, төгсгөлд хэсгийн аль нэгэнд нь дээрх хэлцийг хэрэглээрэй.
5. Ноороглох
6. Ноороглосны дараа найруулгын болон зөв бичгийн дүрмийн засвар хийх
7. Алдаагаа засан дахиж хичээнгүй бичих

### Сонгох сэдэв 2.

Ууж идэхдээ уургын морь шиг  
Урагшаа гишгэхдээ ургаа хад шиг

**Утгын тайлбар:** Уургын морь нь эр зоригтой, огцом хөдөлгөөнтэй, олон адуу руу хурдтай ордог. Ургаа хад гэдэг нь угаасаа ургасан, угаасаа байсан хад чулууг хэлнэ. Ажил хөдөлмөрт ургаа хад мэт хөдөлгөөнгүй хойрго атлаа хоол унд идэж зооглох үед уургын морь шиг ухасхийн хамгийн түрүүнд явдаг хүнийг шүүмжилж хэлдэг. Мах гэхээр ухасхийгээд, мал гэхээр манасхийдэг гэсэн зүйр үг ч бий.



Бичихдээ:

1. Эхлэл хэсэгт залхуурдаггүй хүний сайн үйлийг жишээ татаж бичих
2. Гол хэсэгт залхуу байхын хор уршгийн тухай, залхуу хүний муу үйлийг жишээ татаж бичих
3. Төгсгөл хэсэгт залхуурахгүй байхыг уриалж бичих
4. Эхлэл, гол, төгсгөлд хэсгийн аль нэгэнд нь дээрх хэлцийг хэрэглээрэй.
5. Ноороглох
6. Ноороглосны дараа найруулгын болон зөв бичгийн дүрмийн засвар хийх
7. Алдаагаа засан дахиж хичээнгүй бичих

- 2 Хэрхэн бичсэнээ ярилцаж, 140 дүгээр талд буй шалгуурын дагуу үнэлээрэй.





## Сэтгэгдлээ илэрхийлэн уншъя.


### 1 Зохион ярилцъя.



Хоёр хүүхдэд нэр өгье.  
Хүүхдүүд юу ярилцаж  
байгаа бол?



Нэг нь яагаад  
сандарсан бэ?



Хүүхдүүд загасаа яасан бэ?  
Хоёр хүү, загасаа буцааж  
авсан болов уу?

### 2 Асуултад хариулахын тулд ойлгож уншаарай.


1. Зохиолын үйл явдлыг цэгцтэй, ойлгомжтой ярина уу.
2. Отгон яагаад жараахайг усанд нь буцааж тавьсан бэ?
3. Жараахай шилэн хоргонд удсан бол яах байсан бэ?
4. Бяцхан Тулгаа хүү уйлсны учир шалтгаан нь юу вэ?
5. Отгон, Тулгаагийн тухай юу гэж бодсон бэ? Яагаад?
6. Тулгаа, Отгоныг зөв юм хийсэн гэж бодсоныг яаж дүрслэв?
7. Байгаль дэлхийгээ хамгаалсан үйл явдлыг зохиолч бидэнд яаж мэдрүүлэв?
8. Чамд ийм явдал тохиолдсон бол яаж шийдэх байсан бэ?
9. Отгоог тийм шийдвэр гаргана гэж бодож байсан уу? Яагаад ийм юм болно гэж бодож байсан бэ?
10. Отгон, Тулгаа нарт талархсан сэтгэлийн үг бичээрэй.



Уншихдаа:

- Эхэд юуны тухай өгүүлснийг ухаарч уншаарай.
- Баатрууд хоорондоо хэрхэн харилцаж байгааг бодож уншаарай.

### 3 Эхийг зөв, хурдан, ойлгож унших дасгал хийе. Уншихаасаа өмнө нүдний дасгал хийгээрэй.



## ГОЛЫН ЖАРААХАЙ

Нэг удаа би хаяандаа суугаад, Сонинхангай уулыг харж байлаа. Цэлмэг сайхан өдөр гэрийнхээ сүүдэрт адасга дэвсчхээд, дээр нь хөл нүцгэн сууж, цэцгийн үнэртэй агаар залгилан, уул харж байна гэдэг ямар сайхан гэж санана. Яг тэгж байтал манай айлын Тулгаа хүрээд ирлээ. Тэр:

- Чи юу хийж байгаа юм бэ? Би:

- Уул харж байна гэлээ.

- Өө-хөө, уул хараад яадаг юм бэ?

- Сайхан л байдаг юм даа. Тулгаа миний хажууд сууж:

- Хүүш, би чамд нэг гоё юм үзүүлэх үү?

- Юу юм бэ?

- Ёстой нэг гоё ... гэснээ босон гүйж, гэрээсээ жимсний шилтэй юм аваад ирлээ. Ус.

Усан дотор гурван хөөрхөн жараахай байна.

- Чи үүнийг хаанаас олоов?

- Урд голоос барьсан юм.

- Яах нь вэ?

- Тэжээхгүй юү.

- Болдоггүй юм аа.

- Болдог юм, мэдэв үү! Түдэвдорж ахынд зөндөө жараахай бий.

- Тэр чинь загас байхгүй юу. Жижигхэн загас. Москвагаас авчирдаг юм. Шилэн хоргонд байх ёстой амьтан. Энэ чинь Нүдэнгийн голд л амьдарна. Гэрт болохгүй.

- Худлаа!

- Нээ-рээн!

Тулгаа гомдоод, надаас дөлж суув. Бид хоёрын дунд, жимсний шилэн дотор гурван алтанхан жараахай цовхчино...Би жаахан бодож байгаад “Чи үүнийгээ надад өгчих” гэв.

Тулгаа:

- Чи яах нь вэ? гэж асуулаа.

- Хэрэг байна. Чи өгчих л дөө. Би чамд оронд нь нэг хар чавга, хоёр боорцог өгье.

- Хар чавга, жараахай хоёр тэнцэнэ гэж бодож байна уу?

- За яах вэ, будгийн харандаагаа өгье. Бүр өгнө шүү. Тэгэх үү? Тэр жаахан

бодолхийлснээ:

- Болох л юм гэлээ.

- Харин чи энэ гурван жараахайг яг хаанаас барьснаа заагаад өгчих.

- Чи дахиад нэмж баримаар байна уу?

- Юу ч гэсэн заагаад өг...

Тулгаа бид хоёр Нүдэнгийн гол дээр очлоо. Тэр нэгэн чулууны ёроол руу хуруугаараа заан:

- Яг л эндээс барьсан юм даа! гэж байна. Би тэр л чулууны ёроол руу өнөөх шилтэй усыг хийчихлээ. Жараахайнууд алтран, гялтганан сэлж одов. Тулгаа ухасхийн, усанд гараа дүрснээ уйллаа. Бас:

- Чи, яагаад жараахайг тавьчхав аа? гэж үглэнэ. Би юу ч хэлсэнгүй. Ус руу жараахайнуудын араас харж зогслоо. Удаан харав. Гурван жараахай үзэгдэхгүй болжээ... Тулгаа маань аяархан санаа алдав. ...Энэ чинь сургуульд ороогүй жаахан хүүхэд шүү дээ. Одоо ч нулимс нь хатаагүй л явна. Хөөрхий минь жараахайны хойноос харамсаж байгаа даа гэж би бодов. Нэлээд явсан хойно Тулгаа:

- Отгон оо! Чи жараахайнуудыг яагаад заавал тэр чулууны тэнд тавьж байгаа юм бэ? гэж асуулаа. Би:

- Гэр нь тэр хавьд л байдаг байлгүй. Өөр газар тавьчихвал төөрчихнө шүү дээ! гэлээ. Бид явсаар гэрийнхээ хаяанд ирэв. Тулгаа:

- За яах вэ, жараахайнууд нээрэн гэртээ хариг. Тийм ээ? Би чамаас будгийн харандааг чинь авахаа больё доо гэж аяархан хэллээ.

(3.Түмэнжаргал)

4 **Зохиолын талаар сэтгэгдлээ илэрхийлээрэй. Жишээ нь:**

Зохиолын санаанд тохирох зүйр цэцэн үгийг сонгоё.	Сурагч Алтайгийн сэтгэгдэл
<ul style="list-style-type: none"> <li>• Тус болох гээд ус болох</li> <li>• Хүн хүнийхээ хүчинд Загас усныхаа хүчинд</li> <li>• Гар хөдөлбөл ам хөдлөх</li> <li>• Гэм нь урдаа Гэмшил нь хойноо</li> <li>• Санаа сохор бол нүд сохор</li> </ul>	<p>Би бүх загас усанд л байвал амьдарч чадна гэж бодож байсан. Үнэхээр загас бүрийн амьдрах орчин өөр юм байна гэдгийг мэдэж авлаа. Отгон хүү Тулгаад туслаагүй бол Нүдэнгийн голын гурван хөөрхөн жараахай амьд байхгүй байх байсан. “Хүн хүнийхээ хүчинд, загас усныхаа хүчинд” гэдэг шүү дээ.</p> <p>Тулгаа хүү гэмээ ухаарсанд би баярлаж байна.</p>



Сэтгэгдлээ илэрхийлэхдээ:

Сэтгэгдлээ илэрхийлж ярьж бичихдээ баярласнаа, догдолсноо, гомдсоноо, өрөвдсөнөө, жигшсэнээ, бахархсанаа, уйлснаа, инээснээ, уулга алдсанаа, гайхсанаа ... гэх мэт олон өнгө аясаар илэрхийлээрэй. Ингэхдээ ямар үг хэллэг, ямар дүр, ямар үйл явдлаас болж байгаагаа тодруулж, жишээ татаарай.

5 **Дараах хэлц үгийг хэрэглэн, зохиолын талаар сэтгэгдлээ илэрхийлж бичээрэй.**

**Эр үхэр сааж, элгэн тараг бүрэх** – Огт боломжгүй зүйлийг сэдэх гэсэн утгатай.

**Үнхэлцэг хагарах шахах** – Маш их айх гэсэн утгатай.

**Тэмээ гэхэд ямаа гэх** – Зөрүүдлэх, тэс өөр, ондоо гэсэн утгыг илэрхийлнэ.

**“Тэмээ гэхэд ямаа гэх” хэлц үгийн тухай тайлбар**

Тэмээ, ямаа гэдгийн учир нь том, жижгийг харьцуулж ярьдагтай холбоотой.

Монголчууд аливаа том, овор хэмжээ ихтэй зүйлийг тэмээгээр, бага, жижиг, дорой буурай зүйлийг ямаатай зүйрлэн хэлдэг бөгөөд их бага, том жижгийн хоёр туйл гэж үздэг. Энэ үзлээрээ огт ондоо, өөр гэсэн утгаар тэмээ, ямаа хоёрыг эсрэгцүүлэн, харилцан ярьж буй хүнийхээ хэлж ярихыг сонсолгүй, тоолгүй, өөрийнхөөрөө зүтгэх, зөрүүдлэх үед “тэмээ гэхээр ямаа гээд” хэмээн хэлдэг үг юм.

(С.Энхжаргал, “Монгол хэлцийн тайлбар толь”, 2019 он)

6 **Баатрын зан чанар өөрчлөгдсөнийг ярилцъя.**

1. Зохиолын эхэнд Тулгаа ямар байдалтай байв?
2. Харин төгсгөл хэсэгт Тулгаагийн үзэл бодол өөрчлөгдсөн үү? Түүнд хэн нөлөөлөв?

### 1 Ойлгож уншъя.



Уншихын  
өмнө:

1. Хэрвээ чи булаг байсан бол усыг чинь бохирдуулж байгаа хүнд юу гэж хэлэх вэ?
2. Харин чамайг хайрлаж, хамгаалж байгаа хүнд юу гэж хэлэх вэ? Ярилцъя.

### БУЛАГ

Гурван аянчин нэгэн булгийн дэргэд очтол “Надаас үлгэр жишээ ав!” гэсэн бичиг байхыг үзжээ.

Булаг юуг үлгэр жишээ ав гэж хэлсэн бол? Чи юу гэж бодож байна вэ?

### Зохиолоо үргэлжлүүлэн уншицгаая.

Тэд ямар учиртай бичиг болохыг өөр өөрийнхөөрөө тайлбарлаж гэнэ. Эхний хүн “Гол горхи энэ булгаас эх авч, өргөн хөндийгөөр урсахдаа бусад голтой нэгдсээр их мөрөн болдог. Тийм учраас хэрэв баян болъё гэж бодож байвал тасралтгүй ажилла хэмээн сургаж байна” гэв. Хоёр дахь хүн “Энэ бичиг өөр санааг илэрхийлж байна. Булгийн ус ирсэн бүхний цангааг тайлдаг. Тэгэхлээр хүнд тустай зүйл хийж бай! гэж хэлж байна” гэв. Гурав дахь аянчин “Бид усыг хамгийн цэвэр тунгалаг булгаас нь уудаг. Булингартай усыг хүн байтугай амьтан ч уудаггүй биз дээ? Тэгэхээр надаас жишээ авч сэтгэлдээ булингаргүй, сэтгэлээ цэвэр ариун байлга гэж байгаа юм биш үү?” гэжээ.

(Болгарын хүүхдийн зохиолч Елин Пелин)

### 2 Уншсанаа ярилцъя.

1. Булгийн дэргэд юу гэж бичсэн байв?
2. Аянчин гэж юу хийдэг хүмүүсийг хэлдэг вэ?
3. “Үлгэр жишээ ав” гэдэг өгүүлбэрийн утгыг та нар юу гэж бодож байна вэ?
4. Гурван хүний тайлбарыг харьцуулаарай.
5. “Сэтгэлдээ булингаргүй, сэтгэлээ цэвэр байлга” гэснийг уншаад юу бодож байна вэ?
6. Хэрэв чи тэдний дэргэд байсан бол юу гэж хэлэх вэ?

### 3 Сэтгэгдлээ илэрхийлэн ярья.

1. Гурван хүний хэнийх нь тайлбарыг гайхсан бэ? Эсвэл биширсэн үү?
2. Санал нийлэхгүй тайлбар байсан уу?
3. Булгийн усны булингаргүй тунгалаг байдаг шиг муу муухай зүйл боддоггүй, сэтгэлдээ булингаргүй тийм ямар хүн мэдэх вэ? Тийм хүнтэй таарч байсан уу? Сэтгэгдлээ хуваалцаарай.

4 Сэтгэгдлээ илэрхийлэн ярих чадвараа үнэлээрэй.

Өөрийгөө үнэлэх шалгуур	Маш сайн	Сайн	Дунд зэрэг	Цаашид ... сурна.
Уншсан зохиолын хүрээнд өөртөө төрсөн сэтгэгдлээ илэрхийлсэн				
Илэрхийлэхдээ өөртөө итгэлтэй, цэгцтэй, тодорхой, ойлгомжтой ярьсан				
Бусдын ярьсныг дуустал хүлээцтэй, анхааралтай сонсдог				

5 Зөв бичгийн дүрмийн дасгал ажиллая.

1. “Булгийн” гэсэн үгийг үгийн бүтцээр задалсныг ажиглаад, яагаад эр үг атлаа эм үгийн “-ийн” гэсэн залгаврыг залгасныг тайлбарлаарай.

Булаг+ийн

2. Булаг гэсэн үгэнд “аас, т, ийг, ыг, тай, тэй, оос, руу, рүү, уруу” залгавруудаас зөвийг сонгон бичээрэй.
3. Гол, горхи, булаг, мөрөн, далай, тэнгис, ус, нуур, тойром, бүрд гэсэн үгсийн утгыг тайлбар толь бичгээс хараарай. “ын, ийн, н, ы” залгавруудаас аль тохирохыг нь сонгон, дүрэм баримтлан бичээрэй.
4. Дараах өгүүлбэрийн хоосон зайд тохирох үгийг олж, хичээнгүй бичээрэй.
  - а. Эмээ өвөө маань төрсөн ..... (1) энх ..... (2) амьдран сууж байна.  
(1) нутагтаа, нутагтай  
(2) тунх, тунах
  - б. ....(1) гүнжтэй нэгэн ..... (2) хатан хоёр уулын оройд байх шидэт шилтгээнд зарц ..... (3) хамт амьдран суудаг байжээ.  
(1) эрх, эрэх, эрх  
(2) хаан, хаана  
(3) нартайгаа, нартаа
  - в. Голын ..... (1) зохиолын Тулгаа шиг би боддог байсан ..... (2) буруу байжээ.  
(1) жараахай, жараахаа  
(2) маань, маана

5. Дараах холбоо үгийг хэрэглэн өгүүлбэр зохиогоорой. Тодруулсан үгийн дүрмийг тайлбарлаж ангидаа хэлэлцээрэй.

Хавх тавих, дээл хавах

**Хавхны** уут, дээл **хавахын** тулд

Хулсан савх, ноос савах

Хулсан **савхаар**, ноосоо **савахаар**

Бүлх залгих, айраг бүлэх

Айраг **бүлэхээс**, бүлх залгичихсан юм шиг (хэлц үг)



## Сэтгэгдлээ илэрхийлэн бичицгээе.

### 1 Зөв, хурдан, ойлгож уншъя.



Уншихдаа:

- Хүүхдүүд уулын оргил руу явах болжээ. Тэд хүрч чадсан болов уу?
- Чадаагүй бол юунаас болсон бол? Эргэцүүлэн бодоорой.

### ОРГИЛ



Мянган уулсын наахантай, манхан элсний цаахантай, туурайт морь туулж баршгүй, тураг шувуу нисэж хүршгүй тийм өндөр оргил байжээ. Индиан тосгоны эрчүүдээс хамгийн их зориг цөстэй нь тэмцэн гарах тул тэрхүү оргилыг үл хүсэх хүүхэд гэж байсангүй.

Тэр нь ч аргагүй. Омгийн ахлагч нэгэн өдөр тосгоныхоо хүүхдүүдэд хандан “За, та нараас эр чадал, самбаа зоригоо шалгах хүн байна уу? Байвал тэр оргилд гарцгаа. Харин алжааж ядраад буцах болбол яг тэр газраасаа навч ч юм уу, мөчир ч юм уу, ямар нэгэн юм авчраарай” гэжээ. Хүүхэд бүхэн эр зориг хүсдэг болохоор цөмөөрөө л явъя гэлцэж, оргилыг зорьсон аян замдаа гарав гэнэ. Удсан ч үгүй

нэг мяраалаг хүү кактусын навч барьсаар тосгондоо буцаж иржээ.


Омгийн ахлагч жуумалзан инээж, “Чи уулын барааг харах нь байтугай манхан элсийг ч гаталж чадалгүй иржээ” гэв. Тэгж байтал бас нэг жаал агь өвс барьсаар ирэхэд “За чи, ууланд мацаж зүрхлэлгүй дөнгөж бэлд нь хүрээд буцжээ” гэв. Гурав дахь хүүхэд тооройн мөчир барьж ирэхэд омгийн ахлагч “Овоо явжээ. Булаг хүрсэн байна шүү” гэжээ.

Төдөлгүй бас нэг хүүхэд нэгэн модны мөчир барьсаар ирэхэд ахлагч инээмсэглэн, “Чи ч харин тэр уулын энгэрийн хамгийн доод талын чулуун нурлага хүрээ шив дээ!” гэв. Оройхон нэг хүүхэд гацуурын мөчир барьсаар ирэхэд ахлагч таашаасан янзтай толгой дохиод, “Харин чи оргилд хүрэх замын тэг дундаас буцсан байна” гэв.

Тэрхүүхдээс цагийн дараа нэг жаалнарсны мөчир барьсаар ирэхэд омгийн ахлагч түүнийг магтах янзтай “Сайн байна. Чи хүрэх замынхаа дөрөвний гурвыг туулчихсан байна шүү дээ!” гэж хэлжээ. Хамгийн сүүлийн хүүхэд нар жаргахын өмнөхөн ирэв. Харин тэр жаал харин юу ч авчирсангүй. Гэвч нүдэнд нь баяр баясгалан гэрэлтэн байлаа. Тэр хөвгүүн “Аав аа! Тэр оргил дээр юу ч ургадаггүй юм байна. Харин би алсын цэнхэр далайг тэндээс харлаа” гэхэд омгийн ахлагчийн нүүрэнд баярын



мишээл тодорч “Чи оргилд гарч чаджээ. Царайнаас чинь илт байна. Тэнд юу ч ургадаггүйг би мэднэ. Ялалтын жавхаа нүүрнээс чинь цацарч, баярын солонго нүдэнд чинь туяарч байна. Хүү минь, чи анхныхаа оргилд хүрч чадлаа. Оргилын цаана олон оргил бий. Амжилт хүсье!” гэж шүлэг унших шиг аялгуулан хэлсэн гэдэг.



(Канадын хүүхдийн зохиолч Сетон Томпсон)

## 2 Уншсанаа ярилцъя.

1. Оргил руу авирсан хүүхэд бүрийн сэтгэл ямар байсан бол? Эхний, дараагийн хүүхдүүд бүгд “Би хүрэх газраа л хүрч чадлаа” гэж бодсон болов уу?
2. Эхийн үйл явдлыг зураг харж ярихдаа уулын бэл, уулын хормой, ам, нуруу, таг, орой гэх мэтээр нэрлэн заагаарай.
3. Оргил дээр гарсан хүүхдийг ямар мод авчрах бол гэж төсөөлж байсан бэ?
4. Омгийн ахлагч хүүхэд бүрд тайлбар хэлж байхдаа сэтгэл нь ямар байсан бол? Хэнийг ирэхэд сэтгэл дундуур, хэнийг ирэхэд сэтгэлээр унаж, хэнийг ирэхэд сэтгэл хангалуун байсан бэ?
5. Оргилд гарч чадсан хүүхдээс бусад нь яагаад ямар нэгэн тайлбар хэлээгүй вэ?
6. Хэн ч хүрч чадахгүй оргил атал нэгэн хүүхэд гарсан тухай зохиолч бичжээ. Хүүхдийн ямар зан чанарыг онцлов? Зохиолч бидэнд юу хэлэхийг хүссэн бэ?
7. Зохиолын гол санаа аль өгүүлбэрт илэрч байна вэ? Дүгнэн бичээрэй.

## 3 Сэтгэгдлээ илэрхийлэн бичье.

“Ялалтын жавхаа нүүрнээс чинь цацарч, баярын солонго нүдэнд чинь туяарч байна. Хүү минь, чи анхныхаа оргилд хүрч чадлаа. Оргилын цаана олон оргил бий. Амжилт хүсье!” гэсэн өгүүлбэрийг уншаад, ямар сэтгэгдэл төрж байна вэ? Юу бодогдож байна вэ?



Бичихдээ:

- **Эхлэл хэсэгт:** Эхийг уншихад сэтгэл чинь хэрхэн хөдөлсөн тухай бичээрэй. Бахархсан уу? Баярласан уу? Найзуудынхаа сэтгэлийн хөдөлгөөнийг харьцуулан бичиж болно шүү.
- **Гол хэсэгт:** Хэрвээ та нар тэдний нэг байсан бол хаа хүртэл явах байсан бэ? Чи өөрийгөө зорилгодоо хүрэх эрмэлзэл, сэтгэлийн тэнхээтэй гэж боддог уу? Өөрт тохиолдсон явдлаар жишээ татан бичээрэй.
- **Төгсгөл хэсэгт:** Эхээс юу ухаарснаа дүгнэн бичээрэй.



## Хэлц үг хэрэглэн, эх зохион бичье.

- 1 Дараах хэлц үгийн утгыг ойлгож уншаад, эх зохиож бичээрэй. Дараах сэдвүүдээс сонгож болно.

### Сонгох сэдэв 1.

Олны хүч эвэндээ  
Олсны хүч эрчиндээ

**Тайлбар нь:** Олс гэдэг нь өндөр ургадаг ургамлаар эрчилж хийдэг уяаг хэлнэ. Олсны сайн нь хэр зэрэг эрчилснээр хэмжинэ. Олсыг хэр сайн эрчилнэ төдий чинээ чанга, хатуу, хүчтэй болохын адил хүмүүс хоорондоо эв нэгдэлтэй байвал хүчтэй байдаг гэсэн утгатай.



Бичихдээ:

1. Эхлэл болон гол хэсэгт юуг бичихээ төлөвлөөрэй.
2. Төгсгөл хэсэгт хоорондоо эв найрамдалтай, бие биеэ хүндэтгэвэл хүчтэй байж чаддаг гэдгийг бусдад уриалах
3. Эхлэл, гол, төгсгөл хэсгийн аль нэгэнд нь дээрх хэлцийг хэрэглээрэй.

### Сонгох сэдэв 2.

Алдыг нь аваад дэлэм дээр  
Атгыг нь аваад чимх дээр

**Тайлбар нь:** Алд гэдэг нь хоёр гарыг хөндлөн сунгаж хэмжих уртын хэмжүүр. Нэг алд нь ойролцоогоор 1 метр 60 см-тэй тэнцэнэ. Дэлэм гэдэг нь нэг гарыг сунган, нөгөө гарыг нугалан хурууны үзүүрийг цээжинд хүргэсэн хэмжээ. Ойролцоогоор 80-88 см. Атга гэдэг нь нэг гарын атгахтай тэнцэх хэмжээ. Чимх гэдэг нь хоёр хурууны үзүүрээр хавчсан төдий хэмжээ. Алд бол урт, дэлэм бол богино, атга нь их, чимх нь бага. Аливаа ажлын ихэнхийг хийхэд дуусахын үед залхуурч, хойш тавьж болохгүй гэсэн утгатай. Эхэлсэн бол дуусгах учиртай юм.



Бичихдээ:

1. Эхлэл болон гол хэсэгт юуг бичихээ төлөвлөөрэй.
2. Төгсгөл хэсэгт аливаа ажлыг хийхдээ залхуурч хойш тавьж болохгүй гэдгийг бусдад уриалах
3. Эхлэл, гол, төгсгөл хэсгийн аль нэгэнд нь дээрх хэлцийг хэрэглээрэй.
4. Ноороглох
5. Ноороглосны дараа найруулгын болон зөв бичгийн дүрмийн засвар хийх
6. Алдаагаа засан дахиж хичээнгүй бичих

- 2 Хэрхэн бичсэнээ үнэлээрэй.

Өөрийгөө үнэлэх шалгуур	Маш сайн	Сайн	Дунд зэрэг	Цаашдын зорилго
Эхлэл, гол, төгсгөл гэсэн бүтэцтэй бичсэн				
Бичихдээ хэлц үгийг хэрэглэсэн				
Ноороглосон				
Нооргоо засаж, дахин хичээнгүй бичсэн				
Ойлгомжтой бичсэн				

- 1 Уншлагын хурдаа сайжруулах дасгал ажиллая. Зөв, хурдан, ойлгож уншаарай.

## НӨХӨРЛӨЛИЙН ТУХАЙ ҮЛГЭР

Урьд бамбар, тугал хоёр ижилдэн дассан байжээ. Нэг өдөр бамбар нь зам дээрээс хонх олоод, тугал найзынхаа хүзүүнд зүүж өгөөд,

-Намайг байхгүйд чамд аюул учирвал дуугаргаарай. Би хонхны дуунаар ирж, чамайг хамгаалж байя гэжээ. Нэг өдөр бамбар ан хийж явтал хонхны дуу гарчээ. Сандран хүрч ирвэл тугал зүгээр л өвс идэж байв.

-Юу болов? Юунд намайг дуудав? гэсэнд тугал,

-Хамар дээр минь хөх түрүү суухаар нь айгаад чамайг дуудсан юм. Тэгээд нисээд явчихлаа гэжээ.

-Үүнээс хойш ийм дэмий юманд намайг дуудах хэрэггүй гээд бамбар ан хийхээр явлаа. Тэгтэл удалгүй дахиад л хонх жингэнэн дуугарав. Бамбар яаран хүрч ирвэл тугал аанай л зүгээр өвс идэж байжээ.

-Юу болов? Юунд намайг дуудав? гэсэнд тугал,

-Зүгээр, би оодгоноод толгойгоо сэжилж байсан юм гэлээ. Бамбар дахиад ан гөрөөндөө явж байтал хонх жингэнэв.

“Толгой дээр нь шумуул суугаад үргээж байгаа биз” гээд бамбар энэ удаа очсонгүй. Орой байдаг газраа эргээд ирсэнд тугалыг чоно идчихсэн байжээ. Бамбар “Надаас болж нөхөр минь амь эрсдэв” гэж ихэд харамсаж гэнэ.



(Монгол ардын үлгэр)

- 2 Уншсанаа ярилцъя.

1. Ямар амьтад ижилдэн дассан бэ?
2. Бамбар тугалын хүзүүнд юу зүүж өгөв? Өгөхдөө юу гэж хэлсэн бэ?
3. Зураглалыг хараад, үйл явдлыг дарааллаар нь ойлгомжтой яриарай.

Эхний удаа дуудахад нь

Дараагийн удаа дуудахад нь

Гурав дахь удаа дуудахад нь

4. Бамбар юунаас болж харамсав?
5. Найзуудыг хагацахад юу нөлөөлөв?
6. Найздаа туслах гээд чадаагүй тохиолдол та нарт бий юу? Туслахын тулд юу хийх ёстой вэ?

- 3 Сэтгэгдлээ илэрхийлэн бичээрэй. Бичихдээ дараах хэлц үгийг хэрэглээрэй. Бамбар “Номхон морины ногт, догшин морины чөдөр болж” чадсан уу?

## 1 Үлгэрийг зөв, хурдан, ойлгож уншаарай.



Уншихын  
өмнө:

- Найзууд юунаас болж муудалцдаг вэ? Санаа бодлоо хуваалцъя. Хэрэв ийм тохиолдол мэддэг бол жишээ татан яриарай.
- Дараах хоёр үлгэрт хүний зан чанарыг амьтдаар төлөөлүүлэн өгүүлжээ. Чухам ямар хүний тухай дүрсэлснийг бодож уншъя.

### ХЭВРЭГХЭН НӨХӨРЛӨЛ

Нэг үнээ тосгоноосоо хол явж байгаад, ойд төөрчихжээ. Тэнд нэг эрслэнтэй уулзав. Тэр хоёр найзууд болж, хамтдаа жаргалтай амьдарч байлаа. Хэсэг хугацааны дараа үнээ эр тугал төрүүлж, эрслэн эр зулзага төрүүлэв. Тугал, гүен хоёр хамтдаа тоглон өсөж, салшгүй сайн андууд болжээ.

Хааны модчин ойд явж байгаад арслан, бух хоёрыг тоглож байхыг хараад, маш их гайхаж, ер бусын юм үзсэнээ хаандаа очиж хэлжээ.

Хаан, модчины үгийг сонсоод, “Тэр хоёртой хамт гурав дахь амьтан үзэгдвэл надад хэлээрэй” гэжээ. Хэд хоногийн дараа модчин ойд дахин очтол бух, арслан хоёрын хажууд нэг цөөвөр байхыг үзээд, хаандаа очиж илтгэв. Хаан:

- Тэр цөөвөр, хоёр андыг хооронд нь дайсагнуулна. Бух, арслан хоёр хоорондоо үзэлцэх нь. Хурдан явъя гэв.

Хааны үг үнэн байлаа. Цөөвөр эхлээд арслан дээр очиж “Энэ бух чиний найз биш. Тэр чамайг эзгүйд чиний тухай маш муухай юм ярьдаг” гэжээ. Дараа нь бух руу явж очоод “Энэ арслан чиний найз биш. Тэр чамайг эзгүйд чиний тухай маш муухай юм ярьдаг” гэжээ.

Бух, арслан хоёр цөөврийн үгэнд итгэж, бие биенээ дайсагнах болов. Тэр хоёр, сайхан нөхөрлөлөө хайрлаж, бие биедээ итгэхийн оронд хорон санаат цөөврийн үгэнд орж, хоорондоо дайсагналцсаар байв. Эцэст нь тэр хоёрын андын харилцаа бүрмөсөн тасарч, аймшигт ширүүн тулалдаанаар төгсөв. Цөөвөр үүнийг л хүсэж байсан учир шүлсээ залгин харж байлаа.

Бух, арслан хоёр хоёул үхлийн шарх авч, газарт зэрэг унахдаа л хөөрөн баясаж, бас тавлан тохуурхаж буй цөөврийг хараад, учрыг ойлгосон боловч нэгэнт оройтсон байв.

Үнэндээ цөөвөр чоно арслан, бухын мах хэзээ ч идэж байгаагүй учир ийм хорон санаа агуулсан нь энэ байжээ.

Хааныг ойд ирэхэд цөөвөр чоно үхсэн бух, арслан хоёрын махыг алинаас нь эхэлж идэхээ шийдэж ядан байлаа.

Хоёр сайхан анд хорон санаатны үгэнд орж, бие биеэ хөнөөсөнд хаан туйлын ихээр харамсжээ. Тэгээд салшгүй хоёр найзыг эвлэршгүй дайсан болгосон цөөвөрт асар ихээр хилэгнэж, нумаа татан, сумаа онилов. Цөөвөр чоно бух, арслан хоёрын махыг зэрэг идэхээр ухасхийтэл онилсон сум байндаа туслаа. Хаан ордон руугаа буцахдаа бух, арслан хоёрын нөхөрлөл тасарсанд харамссаар байв гэнэ.

*(Энэтхэгийн “Таван сургамж” үлгэрээс)*

2 Зөв хурдан уншсанаа 22 дугаар талд байгаа зааврын дагуу үнэлээрэй.

3 Уншсанаа ярилцъя.

1. Ямар ямар амьтад сайн андууд болсон бэ?
2. Эрслэн, гүен гэсэн амьтны тухай юу мэдэх вэ?
3. Цөөвөр юу хийв? Түүний хийсэн үйлдэл хэр зөв бэ?

4. Цөөврийн тухай хааны таамаглал үнэн байсан уу?
5. Бух, арслан хоёр юунаас болж дайсагналцав?
6. Цөөврийн хорон санаа агуулсан нь юутай холбоотой байв?
7. Бух, арслан хоёр дайсагналцахгүй байх боломжтой байсан уу?

8. Бух, арслан хоёрын ширүүн тулалдааны үед цөөвөр ямар байдалтай байв? Энэ хэсгийг уншаад та нар юу бодов?
9. Бух, арслан хоёр шиг, цөөвөр шиг хүмүүс хэр их байдаг вэ? Өөрийнхөө зан чанартай харьцуулж ярилцаарай.

4 Сэтгэгдлээ илэрхийлэн бичээрэй.

**Бичих санаагаа олж, төлөвлөө.**

1. Үлгэрээс аль хэсэг нь таалагдсан бэ? Аль хэсэг нь таалагдаагүй вэ?
2. “Үхэр хэлнийхээ уртаар өвс ороодог  
Ховч хэлнийхээ уртаар толгойгоо ороодог” хэлц үгийг хэрэглэж бичээрэй.  
**Хэлцийн тайлбар:** Бусдад муучлан ярьдаг муу зантай бол амь насаа хүртэл алдах эрсдэлтэй гэдэг утгатай.

**Төлөвлөсний дараа ноороглоорой.  
Нооргоо найруулгын хувьд засаарай.**



Засахдаа:

**Найруулгаа шалгах өөрийн үнэлгээний шалгуур:**

1. Бичсэн сэтгэгдэл нь уншихад ойлгомжтой байна уу?
2. Ямар нэгэн үг, өгүүлбэр хасмаар байна уу?
3. Ямар нэгэн үг, өгүүлбэр нэммээр байна уу?
4. Үгийн байрлалыг солимоор байна уу?
5. Үгийг солимоор байна уу?

**Зөв бичгийн дүрмийн алдаа гаргасан эсэхийг засаарай.  
Зассанаа дахин хуулж, хичээнгүй бичээрэй.**

5 Сэтгэгдлээ илэрхийлэн бичих чадвараа үнэлээрэй.

Өөрийгөө үнэлэх шалгуур	Маш сайн	Сайн	Дунд зэрэг	Цаашид ... сурна.
Уншсан зохиолын хүрээнд өөртөө төрсөн сэтгэгдлээ илэрхийлсэн				
Илэрхийлэхдээ ойлгомжтой бичиж, үгийг оновчтой сонгосон.				
Бичихээсээ өмнө ноороглосон.				
Илэрхийлж бичихдээ зөв бичгийн дүрмийн алдаа гаргаагүй				



## Дүрмийг бататгаж, зөв бичье.

- 1 Үгсийг загварын дагуу бичээд, дүрмийг тайлбарлаарай. Жишээ нь:

Нөхөрлөл + ийн = нөхөрлөлийн

Бамбараас, учирвал, хааны, нөхөрлөлөө, цөөврийн, учрыг, хугацааны

- 2 Дараах хэлц үгийг холбож зөв бичээрэй.

Нойр + оос морь + оо

Чөмөг + өөс хутга + аа

**Хэлц үгийн тайлбар:** Хээр хөдөө явж буй хүн нойрондоо дийлдэн нам унтаад унаж явсан морио алдах, хээрийн амьтанд идүүлэх зэргээр мориноосоо салж явгарах үе бий. Мөн богтос чөмгийг хутганы мөрөөр цохиж хагалан чөмгийг гаргаж иддэг. Эвийг нь тааруулж, хийг нь олж цохихгүй бол зарим тохиолдолд богтос хагарахгүй, харин ч хутгаа хугалах нь бий. Иймд ямар нэгэн зүйлд хэт автаж, шохоорхон шунавал морио алдаж, хутгаа хугалах мэт хохирол амсана гэдгийг сануулж хэлдэг зүйр үг юм.

(С.Энхжаргал, “Монгол хэлцийн тайлбар толь”, 2019 он)

- 3 Дүрмийг уншаад, нойрноос, чөмөгнөөс гэсэн үгийг яаж бичсэнийг тайлбарлаж бичээрэй.

### ДЧРЭМ

“ын”, “ийн”, “ы”, “д”, “т”, “аас”, “оос”, “өөс” зэрэг залгаврыг нэр үгэнд залгавал зарим тохиолдолд тогтворгүй “н” үсэг гаргаж бичдэг. Жишээлбэл, мод+ы=модны, морь+ы=морины, морь+оос=мориноос, морь+д=моринд

Харин амжилтад, амжилтын, амжилтаас, сургалтад, сургалтын, сургалтаас, номоос, номд, номын гэж бичдэг үгс бий.

- 4 “ын”, “ийн”, “ы”, “д”, “т”, “аас”, “оос”, “өөс” зэрэг залгавраас сонгон, унь, мод, тэрэг, торго, тоо, хад, хадаас, ширээ, хамаатан, амьтан, ажил, амьд, хана, харгана гэсэн үгсэд залгаж бичээрэй.
- 5 “Нөхөрлөлийн тухай үлгэр”-ээ дахин уншаад, дээрх дүрэмтэй холбоотой үгийг түүж бичнэ үү.
- 6 Дараах бодомжоос зөвийг нь сонгоорой.
- А. Тогтворгүй “н” үсэг нь дэвтэр гэдэг үгэнд “ийг” гэсэн залгаврыг залгахад хэрэглэнэ.
- Б. Тогтворгүй “н” үсэг нь дэвтэр гэдэг үгэнд “ыг” гэсэн залгаврыг залгахад хэрэглэнэ.
- В. Тогтворгүй “н” үсэг нь дэвтэр гэдэг үгэнд “ийг” гэсэн залгаврыг залгахад хэрэглэхгүй.
- Г. Тогтворгүй “н” үсэг нь дэвтэр гэдэг үгэнд “ээс” гэсэн залгаврыг залгахад хэрэглэнэ.



## Шүлэг, өгүүллэгийн утгыг ойлгож уншъя.

### 1 Зургийг ажиглаад, дүгнэлт гаргая.

- Хүү яагаад гүүрийг доороос нь тулаад зогсож байна вэ?
- Гүүрийг өргөх хүч чадал хүүгийн хаанаас гарч байна?

### 2 Дараах хоёр зохиолыг уншаад, аль нь энэ зурагтай холбоотой болохыг олъё.

#### МОДОН ГҮҮР

Зуурхан салхинд  
Бургас шуугина.  
Зуун хэлээр  
Шувууд жиргэнэ.  
Мөрөн гол  
Шаагин урсана.  
Модон гүүр л  
Чимээгүй дүнсийнэ.

Модон гүүр яагаад  
Чив чимээгүй байна вэ?  
Хэн хүнд тусалснаа  
Хэлж ярихгүй яагаа вэ?

Голын урсгалыг сөрөөд  
Холын аянчдыг тээгээд  
Үргэлж тэр ажилтай гэнэ.  
Өөрийгөө магтах завгүй гэнэ.



(О.Сундуй)

#### ЭХ ХҮҮ ХОЁРЫН ГҮҮР

Эрт урьдын цагт нэгэн тосгонд Паньвань гэдэг хүүтэй, хөгшин эх амьдран суудаг байжээ. Тэдэнд алга дарам газар ч үгүй тул ээж нь уулнаас модны гишүү түүж зардаг бөгөөд хүү нь бусдын малыг хариулдаг гэнэ.

Хүү их сэргэлэн цовоо ажээ. Тэр гүйж, үсэрч харайх дуртай бөгөөд мод еод сайн авирч чаддаг, том чулууг өргөж даадаг, бас гүйж байхдаа годройтон эргэж чаддаг байлаа.

Нэгэн удаа үхэр сүргээ хариулж явтал хоёр бух нь мөргөлдөж эхлэв. Тэдний нүд улаанаараа эргэлдэж, толгойгоо доош болгон, бие биеэ эврээрээ мөргөн, бүр салж чадахааргүй болтлоо эврээрээ орооцолдчихов.

Паньвань хүү яасан гэж санана?

Хүү, хоёр бухны эврээс нь барьж байгаад, хоёр тийш нь шидэж орхитол эвэр нь далжийчихжээ.Тэгээд хүү, амьсгаадаж аахилах хоёр бухаа харан:

- Дахиад ингэж зодолдох юм бол эврийг чинь бүр хугалж орхино шүү хэмээн хэлэв.

Тэдний тосгоны ойролцоо нэг том гол урсдаг байлаа. Тэр гол дээр саравчтай чулуун гүүр байдаг бөгөөд доороос нь таван том чулуу тулж байдаг ажээ.

Хаврын хүйтэн нэгэн өдөр хүчтэй шуурга шуурч, том том моддыг үндсээр нь сугалан хаяж эхлэв. Хүү үхэр сүргээ туусаар чулуун гүүрээр гартал гүүр яг л хулсаар хийсэн аятай ганхаж байв. Сандран доош хартал нэг чулуун багана нь юу юугүй нурж унах нь ээ. Энэ гүүр нурвал тосгоныхон гол гаталж чадахгүйд хүрэх тул хүү нэг арга сэдэв.

Хүү юу сэдсэн гэж бодож байна вэ?

Нэг их удаан бодсонгүй, өмднийхөө шуумгийг дээшлүүлээд, ус руу үсэрч орлоо.

- Ий тий, тий гэж, ийм хүйтэн устай бил үү? гэсээр гүүрэн доогуур шурган орж, толгойгоороо доороос нь тулан, хөдөлгөөнгүй зогсов гэнэ. Гар нь цуцавч тэссээр байв. Гараа тавих л юм бол гүүр нь нурах байлаа.

Энэ үеэр хөгшин эх нь гишүүгээ үүрэн буцаж явж байв. “Гүүр мөдхөн нурах нь. Дараа нь яаж засах билээ дээ?” гээд ус руу үсрэн ортол хүү нь зогсож байх нь тэр. Хүү, ээждээ:

- Та яв. Би ганцаараа л барьж байя гэж хашхирав. Хүүгээ удаан зогссоныг мэдсэн ээж нь:

- Үгүй дээ, хүү минь. Чи ганцаараа барьж дийлэхгүй. Ээж нь чамд тусалъя гэв.

Ингээд эх, хүү хоёр толгойгоороо гүүрийг тулан, мөс шиг хүйтэн усан дотор зогссоор байлаа.

Хэдэн өдрийн дараа гүүрний дэргэдүүр завиараа хөвж явсан загасчин эр, гүүрэн доор хүнтэй адил хоёр чулуун багана байхыг олж харав. Гайхсан загасчин лавлан хартал Паньвань, түүний эх хоёр гүүрийг тулсан хэвээр чулуун багана болж хувирсан байлаа. Загасчин тосгон руугаа яаран гүйж очоод, хүмүүсийг цуглуулав. Тосгоныхон чулуужсан баатруудыг харан, нулимс дуслуулан байлаа. Түүнээс хойш тэр гүүрийг “Эх, хүү хоёрын гүүр” гэж нэрлэх болж гэнэ.

*(Хятад ардын үлгэр)*

### **Эхийн үйл явдал, гол санааг харьцуулъя.**

- ① **Үйл явдлын дэс дарааллыг харьцуулаарай.**
- ② **Дараах өгүүлбэрүүдээс аль нь үлгэрийн аль нь шүлгийн гол санааг тодорхойлж байна вэ? Ялгаарай.**
  - Бусдын төлөө завгүй ажилладаг нэгэн гүүрний тухай өгүүлсэн.
  - Их хүч чадалтай, сайхан сэтгэлтэй хүний тухай өгүүлсэн.
  - Бусдын хөдөлмөрийг хайрлаж байгаа хүний тухай гарсан.
  - Өөрийнхөө биш бусдын төлөө байх сайхан байдгийг харуулсан.
  - Хүнд хэрэгтэй гүүрний тухай өгүүлсэн.
  - Хүмүүст хэрэгтэй гүүрийг аварч байгаа хүмүүсийн тухай өгүүлсэн.
  - Хүмүүсийн төлөө гүүрийг аварч байгаа хүний тухай гарсан.
  - Маш их ажил хийсэн ч гэсэн бусдад сайрхдаггүй даруу төлөв хүний тухай өгүүлжээ.

- Хүний хүч чадал сэтгэлдээ байдаг гэдгийг харуулсан.
- Бусдын төлөө юугаа ч хайрлахгүй тэмцэж байгаа хүний тухай өгүүлсэн.

**3 Дээрх тодорхойлолтуудаас ойролцоо утгатай өгүүлбэрийг багцлаарай.**

**4 Багцалсан өгүүлбэрүүдээ дахин уншиж, хамгийн чухал гол санааг тэмдэглээрэй.**

Дараах үгсийг утгаар нь зөв холбоорой. Зохиол тус бүрийн гол санаа тодрох болно.

**Үлгэрийн гол санаа:**

сайхан сэтгэлээ

амь насаа

чаддаг

Энэ үлгэрт

өгүүлжээ.

зориулж

хүртэл

хүмүүсийн тухай

Хүн, чулуун гүүрийг дааж байгаа гэж хэтрүүлэн өгүүлсэн ч үнэхээр бахархмаар үйл явдлыг бичсэн байна.

**Шүлгийн гол санаа:**

шүлэгт

амьдчилж

дүрсэлжээ

гүүрийг

гүүрний тухай

хүнд

хэрэг болдог

зохиолч бичихдээ

**5 Дараах холбоо үгийн ойролцоо утгатай үгийг олж хэлээрэй.**

<i>үндсэн утга</i>	<i>ойролцоо утга</i>
сэргэлэн цовоо хүү	..... хүү
сайхан сэтгэлтэй	.....сэтгэлтэй
Хэлж ярихгүй яасан юм бэ?	.....гүй яасан юм бэ?

**6 Өгүүлбэрийг бичихдээ ойролцоо утгатай үгсийн доогуур зурж тэмдэглээрэй.**

Паньвань хүү айлын өвсийг зөөж, түлээг тээсээр өдий хүрсэн тул уул давааг ч андахгүй, энхэл донхлыг ч эндэхгүй, нисэн өнгөрөх шувууг ч бараг мэдэх бөгөөд нүхнээсээ гарч тоглох амьтдыг ч таних тийм сэргэлэн хүү юм.

**САНАМЖ**

Бичлэг дуудлага нь өөр боловч утгаараа ойролцоо үгсийг ойролцоо үгс гэнэ. Жишээ нь: инээх - хөхрөх, зовлон - гуниг, хайр - энэрэл...

**7 Бичсэн өгүүлбэрээ дахин уншаад, “Эх хүү хоёрын гүүр” зохиолын хэддүгээр догол мөрийн утгатай холбоотойг олоорой.**



## Сэтгэгдлээ илэрхийлэн бичье.

### Бичих санаагаа олж, төлөвлөө.

1. Эхийг уншъя. Та нарт ийм зүйл тохиолдож байсан уу?
2. Тодруулсан үгийг хаалтан дотор байгаа үгээр сольж уншъя. Утга нь өөрчлөгдөж байна уу?

### ХЭН ЭРГЭВ?

Би хатгалгаа аваад, эмнэлэгт хэвтлээ. Хэвтсэн өдрөө л хэн хэн намайг эргэж ирэхийг хуруу даран тооллоо. Лав арван хүүхэд ирэх юм байна. Охидоос одон бөмбөг хамт тоглодгоороо Цэцэгээ л ирж магадгүй дээ гэж **бодож байлаа**. (санаж байлаа)

Маргааш нь **хэн ч ирсэнгүй**. (хэн ч үзэгдсэнгүй) Нөгөөдөр нь найз нараас маань **сураг алга**. (хэл чимээ алга) Би тэдэнд **гомдож эхэллээ**. (тунирхаж эхэллээ) Хамгийн дотно **найз** (анд) Цэцэгээг хүүхэд хүүхдээс илүү хүлээж байв. Гэтэл сайхан зантай сувилагч Дулмаа гуай **тасалгаанд** (өрөөнд) орж ирээд:

- Ганболд оо! Ангийн чинь нэг хүүхэд ирээд, үүнийг өгүүллээ гэхэд би **тэсгэлгүй их баярлаж**: (магнай хагартал баярлаж, хөл газар хүрэхгүй баярлаж)

- Цэцэгээ гэж нэг шар охин байна уу? гэж **лавлав**. (асуув)

- Хэн гэв ээ? Байз. Цэцэгээгээс тэс өөр **нэр** (алдар) хэлдэг шүү гэж Дулмаа гуай хэлэв. Нандигнан боосон цаастай юмыг **задалбал** (онгойлговол) жижигхэн гялгар **хүүдий** (уут) дүүрэн алим, нэг ширхэг **иштэй чихэр** (модтой чихэр) байлаа.

“Хойчийг залгамжлагч” сонины шинэ дугаарыг дугтуйд хийж, **зурвас** (захиа) бичсэн байв.

“Хэн намайг эргэж ирсэн гэж **санана?** (бодно) Миний хамгийн их **зэвүүцдэг** (дургүйцдэг) Ойдов эргэж ирсэн байлаа. Ойдовт би өөрийн эрхгүй **их баярласан юм**. (чин сэтгэлээсээ баярласан юм) Дараа нь манай ангийнхан нэг удаа эргэж ирсэн. Харин Цэцэгээ маань сураггүй. Би эмнэлгээс гаран гартлаа түүнийг **хүлээсээр л байв**. (харуулдсаар л байв)

(Ж.Хорлоо)

### СЯНАМЖ

Ойролцоо утгатай үгсээс тухайн өгүүлбэрт аль тохиромжтойг сонгох нь чухал.

Жишээ нь: **ачийг** хариулах, **тусыг** хариулах

“Ээжийнхээ тусыг хариулна” гэж хэлэхгүй, харин “Ээжийнхээ ачийг хариулъя” гэх нь зөв юм. Найруулан бичихдээ аль үгийг сонговол илүү тохиромжтойг сайн тунгаан бодоорой.

### 3. Цэцэгээ, яагаад эргэж ирээгүй юм бол?

Түүний бие өвдсөн байж болно шүү дээ.

Тэр тэмцээнд орохоор явсан байж болно шүү дээ.

Харин чи юу гэж бодож байна.

#### 4. Өгүүлбэрээс сонгож, сэтгэгдлээ илэрхийлье.

Муу санаатны үгэнд итгэж, сайхан үерхлээ бусниулсан гүен, тугал хоёрыг хараад...

Багшийнхаа ярьсан үерхлийн түүхийг сонсоод...

Найзуудынхаа ярьсан үнэнч үерхлийн түүхийг сонсоод...

“Хэн эргэв?” эхэд гарч буй Цэцэгээ, Ойдов хоёрын тухай бодоод...

#### Санаагаа цэгцэлж, зөв байрлуулъя.



Уншихдаа:

- Эхний цогцолборт яагаад энэ өгүүлбэрийг сонгож авснаа бичнэ. Эхлэл өгүүлбэрээс ямар сэтгэгдэл төрснөө бичнэ.
- Дараагийн цогцолборт хэнийг хэнтэй, юуг юутай харьцуулснаа бичнэ.
- Төгсгөлийн цогцолборт ямар сургамж авснаа, хэнд юу гэж хэлмээр байгаагаа бичнэ.
- Нэг үгийг олон давтахгүйн тулд төлөөний үг хэрэглэнэ.
- Ойролцоо утгатай үгээс хамгийн тохиромжтойг сонгоно.

#### Бичсэнээ хянаж, сайжруулъя.

##### Бичсэнээ дараах шалгуураар засаарай.

1. Бичих санаагаа зөв сонгосон уу?
2. Санаагаа цэгцтэй илэрхийлж чадсан уу?
3. Төлөвлөсөн цогцолбортоо багтааж бичсэн үү?
4. Эхлэл, гол, төгсгөл хэсэгтэй байна уу?
5. Нэг үгийг олон давтсан, үг илүү хэрэглэсэн, үг буруу байрлуулсан алдаа байна уу?
6. Нэг үгийг олон давтахгүйн тулд төлөөний үгийг хэрэглэж чадсан уу?
7. Ойролцоо утгатай үгээс оновчтойг сонгож чадсан уу?
8. Эсрэг утгатай үгийг зөв сонгож чадсан уу?



#### Би юу сурсан бэ?

Өөрийгөө шалгах асуулт	Хамгийн сайн чаддаг болсон зүйл	Цаашид яаж сайжруулах вэ?
Баатруудын зан чанарыг ойлгож уншдаг.		
Баатруудын зан чанарыг эхлэл, гол, төгсгөл хэсэг бүрт өөрчлөгддөгийг мэддэг болсон.		
Зохиол уншаад сэтгэгдэл, мэдрэмжээ илэрхийлэхдээ өөртөө итгэлтэй, тодорхой ярьж сурсан.		
Зохиол уншаад мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлэхдээ хэлц үг хэрэглэн, алдаагүй, ойлгомжтой бичиж сурсан.		
Миний хамгийн сайн мэддэг дүрэм бол ...		
Чамд ямар бэрхшээл байна вэ?		

1 Шүлгийг ойлгож уншаарай.

ЗУН

Цагийн сайханд зуны эхэнд  
Газрын сайхан хангайн нуруунд  
Хөхөө шувуу урьхнаар донгодоход  
Энэ дэлхий юутай тааламжтай вэ?  
Ногооны униар огторгуйд тулж, зэрэглээ мяралзаад  
Хүлэг морь урт янцгааж, төрсөн нутгийг зүглэнэ.  
Цэцгийн хур дэлхийн нүүрийг угаахад  
Залуу хүмүүсийн сэтгэл бүр ч сэргэж хөгжинө.  
Үзэсгэлэнт уул, тунгалаг ус зуны цагт тэгш  
Эрийн гурван наадам Монгол газрын баясгалан  
Хүүхэд багачуудын гийнгоолох нь хөндий талд яруу  
Хурдан морь яралзах нь хүн бүхний бахдал  
Уудам талд наадмын аялгуу зөөлнөөр цуурайтна  
Хээр хөдөөд мал сүрэг дураар бэлчинэ  
Өрх бүрийн үүдэнд айргийн үнэр сэнгэнэнэ  
Ийм сайхан баясгалантай, тийм сайхан жаргалтай.

(Д.Нацагдорж)

2 Танил биш үг таарвал яаж мэддэг болсон бэ? Дараах бодомжоос сонгоорой.

- А. Мэдэхгүй үгээ олоод, ойр орчмын үг, өгүүлбэрийн утгаас нь таамагладаг. Дараа нь тайлбар толь бичгээс мэддэг.
- Б. Унших явцдаа утгыг нь мэдэхгүй үгийг орхидог
- В. Мэдэхгүй үгээ олоод, ойр орчмын үг, өгүүлбэрийн утгаас нь таамагладаг.
- Г. Тайлбар толь бичгээс шууд хардаг.

3 Ж,ч,ш-ийн дараа “и” бичих дүрэмтэй холбоотой хэдэн үг шүлэгт байна вэ?

- А. 1            Б. байхгүй            В. 2            Г. 3

4 “Зүглэ, хөгж, бэлч, гийнгоол” гэсэн үгсэд “я, е, ё”-г хатуу, зөөлний тэмдгийн дүрмээр зөв залгаж бичсэн хэсгийг олоорой.

- А. зүгэлье, хөгжье, бэлчэе, гийнгоольё
- Б. зүглэе, хөгжье, бэлчье, гийнгоольё
- В. зүглэе, хөгжий, бэлчье, гийнгоолё

5 “Эрийн гурван наадам” гэсэн үгсийн эхний үгэнд эм үгийн “ийн” залгавар залгах нь зөв үү?

- А. Эм үг учраас зөв
- Б. “Эр” гэсэн утгатай үг байгаа учраас буруу
- В. Мэдэхгүй

6 “Гийнгоолох” гэдэг үгэнд үйлт нэрийн “х” залгавар орсон.

- А. Ороогүй
- Б. Үйл үг учраас төгсгөлд байгаа “х” нь үйлт нэрийн “х” мөн.
- В. Мэдэхгүй

7 Зуны улиралд хийх ажлынхаа, сурах зүйлийнхээ талаар жагсааж бичнэ үү. Жишээ нь, цэцэг тарих, дугуй унаж сурах, цагаан оймс угааж сурах, усанд сэлж сурах, англи хэлээр хүүхэлдэйн кино үзэх гэх мэт бичээрэй.



## ҮГИЙН УТГЫН ТАЙЛБАР

### А

**агт**- 1. агталсан морь; (*агт морь шилгээх*);  
2. адуун сүрэг (*агтны даамал*); II. агт араа

**адасга**- дэвсгэр болгон хэрэглэдэг малын хатсан шир, арьс; (*адасга дэвсэн суух*)

**алимад**- аливаа гэдэг үгтэй ойролцоо утгатай; (*Алимад мэргэд эрдэм сурахад өчүүхэн зовно*)

**аюулхай**- өвчүүний хоёр урт сүврэг ясны хооронд аймхай мөгөөрсний тус газар; (*аюулхай дээр хатгаж өвдөх*)

### Б

**баринтаг**- торго, дурдан, даавуугаар хийсэн ном боох ваадан; (*номыг баринтаглан боох*)

**бидэр**- амьтны биед тогтсон өөр өнгийн толбо буюу зурвас (*Хулан бидэртэй байдаг.*)

**бэлгэ дэмбэрэл**- 1. учрал ерөөл; 2. сайн ёр; (*сайн зүйл яривал дагаад сайн юм болно гэсэн утга*); **амны бэлгэ** (сайхан үг яриа)

**бэл бэнчин**- хөрөнгө; (*бэлтэй айл, хөрөнгөтэй айл*)

**бэлчих**- амьтны идэшлэхээр явах; (*хонь бэлчих*)

### Г

**гашлах**- ямар нэг юмны чанар хувирч, ялзран муудах; (*сүү гашлан эздэх, хоол гашлах*)

### Д

**даалимба**- нэгэн зүйл бүдүүн нэхээстэй даавуу; (*даалимбан дээл*)

**даахин навтас**- 1. ширэлдсэн үс хялгас; (*дахан доор эр, даахин доор хүлэг*);  
2. хүүхдийн нялхын үс; (*даахь авах*);

### Ж

**жалга**- 1. байгалиас тогтсон суваг, гуу; (*баруун жалганд хунгар тогтох*); 2. жалга дов;

**жороо**- нэгэн алхамдаа зүүн хоёр хөл, нөгөө алхамдаа баруун хоёр хөлийг тус тус зэрэг гишгэж алхах; (*жороо морь*)

### З

**загсах**- 1. халуун юмны хөрж царцанги болох; (*өрөм загсах, мах загсах*); 2. амуу тариа чанахад өтгөн болох үйл; (*будaa загсах*)

**зуйгар**- зусар бялдууч; (*зуйгар хүн зулгаа барна, зуудаг нохой соёогоо барна*)

### О

**оньс**- 1. түгжээ; (*үүдний оньс, оньсоор түгжих*); 2. машин, багажийг хөдөлгөх дотоод төхөөрөмж; (*оньсон хөдөлгүүртэй тэрэг*)

### Ө

**өөдөх**- амьтны турж ядарснаас болж хөдөлж ядах, байн байн унах

**өлгий**- 1. нялх хүүхдийг манцуйлан боодог хэрэгсэл; 2. төрсөн орон нутгийг энхрийлэн хэлэх

**өрөөл**- 1. бүхэл юмыг голоор нь таллаж хуваасны нэг хагас тал; (*өрөөл мах*); 2. морины нэг талын өмнө хойд хоёр хөлийг холбож торгох хэрэглэл; (*өрөөлтэй морь*)

### Т

**торх**- шингэн юм агуулах торх сав; (*усны торх, айргийн торх*)

**туйлах**- тэмээ морь эрэг малын булгих, ачаа тэрэг зэргийг хөглөрүүлэн чирч давхих

**туурга**- 1. гэрийн хажуу этгээдэд нөмөргөн бүтээх эсгий даавуу; туурга тусгаар (*бие даасан тусгаар тогтносон улс*); 2.

байшингийн хажуу талын хана  
**тутарга**- цагаан будаа

### Х

**хорго**- юм хорьж агуулан хадгалах сав (*хувцасны хорго, шувуу загас зэргийн шилэн хорго сав*)

**хөдөс**- 1. элдсэн нэхийний өөдөс; (*хөдөс чанаж, цавуу хийх*); 2. элдсэн нэхийний хуучирсан нь; (*хөдсөн дээл, оймс*)

**хясаа**- 1. уулын ирмэг, голын эрэг мэтийн хүн явахад бэрхтэй газар; 2. далайн амьтан

### Ш

**шилгээх**- 1. морь малын биеэ сэгсэрхийлэх; 2. хүний хүзүүгээ хөдөлгөх үйл; 3. юмыг сажиж хөдөлгөх (*морь ачаагаа шилгээж унагах*)

**ширэг**- зүлэг өвс

**шогол**- ном хадгалдаг модон хайрцаг

**шүүдэр**- өвс, модны навчинд тогтсон агаараас бууж ирсэн маш жижиг усан дусал

## ХЭЛЦ ҮГИЙН ТАЙЛБАР

ЭХ ЗОХИОЛ	ХЭЛЦ ҮГС	ТАЙЛБАР
<b>Оюунтөгс хүүгийн үлгэр</b>	цээжээ хавтаслах хөл нь дөрөөнд гар нь ганзаганд хүрэх	эрдэм ном сурах өсөж том болох
<b>Дэвтрийн гомдол</b>	тэмээ туйлчихсан юм шиг үнхэлцэг нь хагарах үг сүггүй	эмх замбараагүй айх сандрах үг хэлэх чөлөөгүй
<b>Бусдын тус багадахгүй</b>	магнай тэнийх	баярлах
<b>Тагтааны бэлэг</b>	гар сунгах хөл нь газар хүрэхгүй	бие биедээ туслах маш их баярлах
<b>Цэцэггүй ваар</b>	яс амрах	сэтгэл амрах
<b>Хулганы сумо</b>	зоосны нүхээр харах мөчөөгөө өгөхгүй	мөнгөөр цэгнэх, үнэлэх бусдаас дутахгүй
<b>Торх</b>	мордохын хазгай	эхнээсээ бүтэхгүй
<b>Олз</b>	ямааны мах халуун дээрээ толгой ганзагалах нарийндаа хатах	цаг алдалгүй хийх уруу царайлах харамлах
<b>Сарьсан багваахай яагаад өдөр нисдэггүй вэ?</b>	өөх ч биш булчирхай ч биш алтан хошуу хүргэх	хоёрын хооронд туйлбаргүй бусдад үг дамжуулах, хов хэлэх
<b>Хөдөө</b>	элэг хөших	инээх
<b>Зараа</b>	тэнгэрээс унасан мэт ул шагайх	гэнэт бусдын мууг харах
<b>Ховдог чоно</b>	гэдэс гарах	цадах
<b>Амны бэлгээс ашдын бэлгэ</b>	амны бэлгэтэй учрыг олж, хужрыг нь тунгаах	юмыг сайн сайхнаар ярих хэцүү зүйлийн учрыг олох
<b>Өвөөгийн гэсэн чөдөр</b>	зүрх гаргах	зориглох, шийдэх
<b>Голын жараахай</b>	дөрөө нийлэх	санаа сэтгэл нэгдэх
<b>Соно, шоргоолж хоёр</b>	гар хумхилгүй хамраа сөхөх борви бохисхийх чөлөөгүй	зогсолтгүй ажиллах, амрахгүй биеэ тоох, ихэрхэх амран суух завгүй
<b>Мэдэмхий борын үлгэр</b>	сүүлээ сэрвээн дээрээ тавих бүлх залгисан юм шиг хагархай хэнгэрэг хамраа сөхөх цаасан буу тавих чулуу хөөлгөх	онгирах сагсуурах дуугүй байх чалчаа олон үгтэй биеэ тоох, ихэрхэх худлаа хэлэх мэхлэх, хуурах
<b>Оргил</b>	хөл газар хүрэхгүй явсан нохой яс зуух	баярлах хийснийхээ үр дүнг үзэх
<b>Залхуу охин заан болсон нь</b>	буруу ишилсэн сүх шиг хөлөөрөө толгой хийх	юмны эсрэг зүтгэх, зөрүүдлэх дураараа аашлах
<b>Хэврэгхэн нөхөрлөл</b>	яс хаях шуудайд хийсэн үхрийн эвэр шиг	хутган үймүүлэх эв түнжингүй
<b>Хэн эргэв?</b>	урмыг нь хугалах	гомдоох, хүч тэнхээгүй болгох
<b>Нөхөрлөлийн тухай үлгэр</b>	савангийн хөөс шиг	амархан хялбар эвдрэх